



МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗАР  
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН ЯАМ



МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗАР  
ЖЕНДЭРИЙН  
ҮНДЭСНИЙ ХОРОО




Japan  
Fund for  
Poverty  
Reduction



From  
the People of Japan

# МОНГОЛ УЛСЫН ЖЕНДЭРИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ: 2005 ОНООС ӨНӨӨГ ХҮРТЭЛХ ОЛОЛТ АМЖИЛТ БА СОРИЛТ, СУРГАМЖ



УЛААНБААТАР ХОТ  
2019 он

© 2019

**Монгол Улсын Засгийн газар  
Жендэрийн Үндэсний Хороо**

*Дүн шинжилгээний тайлан бичсэн:*

*“Салбар орон нутгийн хөгжлийн жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаа”*

техник туслалцааны төслийн жендэрийн зөвлөх баг:

Олон улсын зөвлөх:	Жэйми Шабалина	
Үндэсний зөвлөх:	Т.Амгалан	Ц.Ундрах
	Б.Онон	Ж.Жаргалсайхан
	О.Оюунцэцэг	С.Цэцгээ
	Д.Энхжаргал	Т.Энэбиш
Төслийн зохицуулагч:	Б.Алтанцоож	

*Дүн шинжилгээний тайланг хянасан:*

Монгол Улсын Ерөнхий сайдын жендэрийн зөвлөх **Д.Сүхжаргалмаа**

*Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба:*

*Дарга*

*Мэргэжилтэн*

Т.Энхбаяр

С.Батцэцэг

О.Буянаа

*Үндэсний статистикийн хороо:*

*ХАНСГ-ын дарга*

*ХАНСГ-ын статистикч*

А.Амарбал

Э.Билгүүн

*Азийн хөгжлийн банк:*

*Монгол улс дахь Суурин төлөөлөгчийн газрын*

*Дэд захирал бөгөөд Суурин төлөөлөгчийн орлогч*

**Деклан Магий**

*Монгол улс дахь Суурин төлөөлөгчийн газрын*

*Нийгмийн хөгжил, жендэрийн асуудал хариуцсан*

*ахлах мэргэжилтэн*

**Б.Цолмон**

*Зүүн Азийн газрын Нийгмийн хөгжлийн*

*мэргэжилтэн (жендэр ба хөгжил)*

**Вероника М. Жоффре**



## ӨМНӨХ ҮГ

Монгол Улс нь жендэрийн тэгш байдлыг хангах эрх зүй, бодлогын орчин бүрдүүлэх, үр ашигтай үндэсний тогтолцоог хөгжүүлэх чиглэлээр сайн ахиц дэвшил гаргаж буй орон билээ. Монгол Улсын Их хурлаас Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг 2011 онд баталж, Засгийн газраас тус хуулийг хэрэгжүүлэх үе шаттай арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна.

Сүүлийн арван дөрвөн жилд Монгол Улсад жендэрийн тэгш байдлын хувьд гарсан өөрчлөлт, өнөөгийн нөхцөл байдлыг шинжлэн харуулсан энэ тайлан нь өнгөрсөн хугацаанд олсон ололт, сургамж төдийгүй цаашид тулгарч буй сорилтыг онцлон харуулсан ач холбогдолтой юм.

Япон Улсын Засгийн газраас Ядуурлыг бууруулах Япон сангаар дамжуулан санхүүжүүлж, Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хамтран хэрэгжүүлсэн “Салбар орон нутгийн хөгжлийн жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаа” техник туслалцааны төслийн хүрээнд энэхүү дүн шинжилгээний тайланг боловсуулахад жендэрийн зөвлөх баг “Хөгжлийн замнал сан” ТББ нь мэргэжлийн дэмжлэг үзүүлсэн юм. Тус тайланг боловсруулахад идэвх санаачлага гарган дэмжиж ажилласан жендэрийн үндэсний шинжээчид, төрийн ба төрийн бус байгууллагууд, судлаачид болон АХБ-ны ажилтнуудад талархал илэрхийлж ажлын амжилт хүсье.

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР,  
ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ ХОРОО**



ГАРЧИГ

<b>ӨМНӨХ ҮГ</b>	<b>3</b>
<b>ДҮРСЛЭЛ, ХҮСНЭГТ, ШИГТГЭЭНИЙ ЖАГСААЛТ</b>	<b>6</b>
<b>ТОВЧИЛСОН ҮГС</b>	<b>8</b>
<b>ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ</b>	<b>9</b>
<b>ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ЗОРИЛГО БА АРГАЧЛАЛ</b>	<b>13</b>

## **БҮЛЭГ - 1**

<b>ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ БА ЖЕНДЭР</b>	<b>15</b>
А. Өмч хөрөнгө эзэмшилт	17
Б. Хөдөлмөр эрхлэлт	19
В. Бизнес эрхлэлт	29
Г. Дэд бүтцийн хөгжил	30
Эдийн засгийн хүрээнд жендэрийн тэгш байдлыг хангахад чиглэсэн зөвлөмж	33

## **БҮЛЭГ - 2**

<b>НИЙГМИЙН ХӨГЖИЛ БА ЖЕНДЭР</b>	<b>37</b>
А. Өрх, гэр бүл	38
Б. Боловсрол	40
В. Эрүүл мэнд	46
Г. Улс төр, шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн манлайлал	52
Д. Жендэрт суурилсан хүчирхийлэл	55
Нийгмийн хүрээнд жендэрийн тэгш байдлыг хангахад чиглэсэн зөвлөмж	64

## **БҮЛЭГ -3**

<b>БАЙГАЛЬ ОРЧИН БА ЖЕНДЭР</b>	<b>69</b>
А. Хөдөөгийн байгаль орчны асуудал	71
Б. Хотын амьдрах орчны асуудал	73
Байгаль орчны хүрээнд жендэрийн тэгш байдлыг хангахад чиглэсэн зөвлөмж	74

## **БҮЛЭГ-4**

<b>ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫГ хангах ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦОО</b>	<b>77</b>
А. Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний тогтолцооны хөгжил, ололт амжилт ба сургамж	78
Б. Хуулийн дагуу үүрэг хүлээгчид болон түншлэгчдийн оруулж буй хувь нэмэр, анхаарах асуудал	83
Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний тогтолцоо, түншлэл хамтын ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөмж	85

<b>АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ</b>	<b>87</b>
<b>ХАВСРАЛТ 1. Улаанбаатарын тунхаглал</b>	<b>91</b>

## ДҮРСЛЭЛ, ХҮСНЭГТ, ШИГТГЭЭНИЙ ЖАГСААЛТ

### Дүрслэл

Дүрслэл 1.	Эдийн засгийн өсөлт 2005-2018 онд, хувиар	Дүрслэл 17.	Улсад болон улс орнууд дахь орлогын түвшнээр Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид, хүйс, боловсролын зэргээр, дүнд эзлэх хувиар
Дүрслэл 2.	Нэг өрхийн сарын дундаж орлого ба зарлага, улсын дунджаар	Дүрслэл 18.	Техникийн болон мэргэжлийн боловсролын байгууллагад суралцагчид 2008-2018 онд, хүйсээр
Дүрслэл 3.	Эдийн засгийн өсөлт 2005-2017 онд, тэргүүлэх салбараар (ДНБ-д эзлэх хувь)	Дүрслэл 19.	Эхийн эндэгдлийн түвшин 2005-2017 онд, бүсээр
Дүрслэл 4.	Ажиллах хүчний оролцооны түвшин 2005-2018 онд, хүйсээр	Дүрслэл 20.	Дундаж наслалт 1992-2018 онд, хүйсээр
Дүрслэл 5.	15 ба түүнээс дээш насны ажиллагчдын тоо 2005-2018 онд, хүйсээр	Дүрслэл 21.	Үр хөндөлтийн тоо 2005-2017 онд, насны бүлгээр
Дүрслэл 6.	Эдийн засгийн тэргүүлэх дөрвөн салбарт ажиллагчдын тоо 2006-2018 онд, хүйсээр	Дүрслэл 22.	Улсын Их Хуралд нэр дэвшигчид болон сонгогдсон гишүүдэд эмэгтэйчүүдийн эзлэх хувь, сонгуулийн жилээр
Дүрслэл 7.	Ажилгүйдлийн түвшин 2005-2018 онд, хүйсээр	Дүрслэл 23.	Аймаг, сум, нийслэл, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргад эмэгтэйчүүдийн эзлэх хувь, 2016-2020 оны сонгуулийн жилүүдэд
Дүрслэл 8.	Ажилгүйдлийн түвшин 2017 онд, насны бүлэг, хүйсээр	Дүрслэл 24.	Төрийн захиргааны тэргүүн, эрхэлсэн түшмэл 2005-2017 онд, хүйсээр
Дүрслэл 9.	Хөдөлмөр эрхлэгчдийн нас, хүйсийн бүтэц 2008 ба 2018 онд	Дүрслэл 25.	Гэр бүлийн хүчирхийллийн бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, 2006-2018 он
Дүрслэл 10.	Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 2008 ба 2018 онд, хүйсээр	Дүрслэл 26.	ХЭҮТ-өөр үйлчлүүлэгчдийн тоо (анх удаа хандсанаар), 1995-2018 онд
Дүрслэл 11.	Долоо хоногийн ажлын нэг өдөрт хүн амын хөлстэй, хөлсгүй ажил эрхлэх үйл ажиллагаанд зарцуулсан дундаж цаг 2007, 2011, 2015 онуудад, хүйсээр, хот хөдөөгөөр	Дүрслэл 27.	Бие махбодийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн хувь, насны бүлгээр
Дүрслэл 12.	Эмэгтэйчүүдийн дундаж цалингийн эрэгтэйчүүдийнхэд эзлэх хувь, 2005-2018 онд	Дүрслэл 28.	Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн хүн худалдаалах, биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийн тоо, 2000-2017 он
Дүрслэл 13.	Барилга, хот байгуулалтын салбарын жендэрийн мэдрэмжтэй бодлогын цикл	Дүрслэл 29.	Хүн худалдаалах гэмт хэргийн шийдвэрлэлт, 2000-2017 он
Дүрслэл 14.	1000 гэрлэлтэд ногдох цуцлалтын тоо 2005 ба 2018 онд, бүсээр	Дүрслэл 30.	Хүйсийн тэгш эрхийн төвөөр үйлчлүүлсэн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн тоо, 2003-2018
Дүрслэл 15.	Зургаан настай хүүхэд сургуульд орох нь малчин өрхүүдэд хэрхэн нөлөөлөх талаар судалгаанд оролцогчдын үнэлгээ		
Дүрслэл 16.	Их дээд сургуульд элсэгч эмэгтэй эрэгтэйчүүдийн харьцаа, Монгол		

Дүрслэл 31. Жендэрийн мэргэжилтний жендэрийн чиг үүргээ хэрэгжүүлж буй байдал

### Хүснэгт

Хүснэгт 1. Гэрлэлт ба гэр бүл цуцлалт 2005 ба 2018 онд, бүсээр

Хүснэгт 2. Сургууль завсардсан хүүхэд, насны бүлэг, шалтгаанаар, 2017/2018 оны хичээлийн жилд

Хүснэгт 3. Эхийн эрүүл мэнд, нөхөн үржихүйн үзүүлэлтүүд Монгол Улсад болон олон улсад

Хүснэгт 4. Хүүхдийн эндэгдэл дэх жендэрийн зөрүүтэй байдал 2017 онд

Хүснэгт 5. Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүү 2005 ба 2018 онд, аймгаар

### Шигтгээ

Шигтгээ 1. Газар өмчлөл дэх жендэрийн тэгш байдлыг дэмжсэн сайн туршлага

Шигтгээ 2. Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал

Шигтгээ 3. Орон нутаг дахь эрэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал

Шигтгээ 4. Барилгын салбар дахь эмэгтэйчүүдийн хөдөлмөр

Шигтгээ 5. Орон нутгийн бизнес эрхлэлт дэх жендэрийн асуудал

Шигтгээ 6. Хөдөөгийн бизнесийн хөгжилд тулгарч буй сорилт эмэгтэйчүүдийн нүдээр

Шигтгээ 7. Дэд бүтэц ба эмэгтэйчүүд хүүхдүүдийн аюулгүй байдал

Шигтгээ 8. Сайн туршлага: Эрчим хүчний үр ашиг төслийн жендэрийн үр нөлөө

Шигтгээ 9. Ундны усны аюулгүй байдал, ариун цэврийн байгууламжийн асуудал ба жендэр

Шигтгээ 10. Боловсролын бодлого ба малчин өрхийн жендэрийн харилцаа

Шигтгээ 11. Насан туршийн боловсрол ба хэвшмэл

Шигтгээ 12. ойлголт

Шигтгээ 13. Архины хэрэглээ ба эрэгтэйчүүд Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн үйлчилгээний хэрэгцээ

Шигтгээ 14. Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хоёр дахь давалгаа

Шигтгээ 15. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн эмгэнэлт кейс

Шигтгээ 16. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн малчин эмэгтэйчүүдийн асуудал

Шигтгээ 17. Гэр бүлийн хүчирхийлэл ба хүүхэд

Шигтгээ 18. Ажлын байрны бэлгийн дарамтын хохирогч хамгааллын асуудал

Шигтгээ 19. Ажлын байрны бэлгийн дарамт ба ХЭҮК

Шигтгээ 20. Ажлын байран дахь бэлгийн дарамтыг Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад тусгахаар хэлэлцүүлэгдэж буй хувилбар

Шигтгээ 21. Байгаль орчны доройтол ба уур амьсгалын өөрчлөлт

Шигтгээ 22. Уур амьсгалын өөрчлөлтийн гэрч Марушийн ярианаас

Шигтгээ 23. Малчин өрхүүдийн ноолуураас олох орлогын зарцуулалт

Шигтгээ 24. Малчин залуусын боловсролын ялгаатай хэрэгцээ

Шигтгээ 25. Монгол Улсын Үндсэн хууль (1992) ба жендэрийн тэгш байдал

Шигтгээ 26. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, 2011

Шигтгээ 27. Сайн туршлага: Жендэрийн тэгш байдлыг дэмжсэн төсвийн хуваарилалт

Шигтгээ 28. Сайн туршлага: Орон нутгийн жендэрийн бодлого төлөвлөлт дэх ИНБ-ын оролцоо

Шигтгээ 29. Сайн туршлага: “Тогтвортой хөгжлийн зорилт: Жендэр ба Хөгжил” олон улсын бага хурал ба “Улаанбаатарын тунхаглал”, 2018

**ТОВЧИЛСОН ҮГС**

АХБ	Азийн хөгжлийн банк	МОНЭС	Монголын эмэгтэйчүүдийн сан
АНУ	Америкийн нэгдсэн улс	МУИС	Монгол Улсын их сургууль
АШУУИС	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль	МУБИС	Монгол Улсын боловсролын их сургууль
АББД	Ажлын байран дахь бэлгийн дарамт	МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
БОНХЯ	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам	МХЗ	Мянганы хөгжлийн зорилт
БСШУ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан	НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
БСШУС	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спорт	НҮБХХ	Нэгдсэн үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөр
БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам	НҮБХАС	Нэгдсэн үндэсний байгууллагын хүн амын сан
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс	НЭМС	Нийгмийн эрүүл мэндийн сургууль
БНЧУ	Бүгд Найрамдах Чех Улс	ОУБ	Олон улсын байгууллага
ГБХ	Гэр бүлийн хүчирхийлэл	ОУВС	Олон улсын валютын сан
ГОУХАН	Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг	ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ДБ	Дэлхийн банк	ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн	СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага	ТББ	Төрийн бус байгууллага
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль	ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилго
ЖАЙКА	Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага	УИХ	Улсын их хурал
ЖДҮ	Жижиг, дунд үйлдвэр	УБ	Улаанбаатар
ЖСХ	Жендэрт суурилсан хүчирхийлэл	ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ЖМ	Жендэрийн мэргэжилтэн	ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ЖҮХ	Жендэрийн үндэсний хороо	ХХГХ	Хүн худалдаалах гэмт хэрэг
ЖҮХАА	Жендэрийн үндэсний хорооны ажлын алба	ХХК	Хязгаарлагдмал харицлагатай компани
ЖЭТБХТХ	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль	ХЭҮК	Хүний эрхийн үндэсний комисс
ЖЭТБХҮХ	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр	ХЭҮТ	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв
ЗГДХС	Засгийн газрын дунд хугацааны стратеги	ШХА	Швейцарийн хөгжлийн агентлаг
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага	ЭЗС	Эдийн засгийн сургууль
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	ЭМХГ	Эрүүл мэндийн хөгжлийн газар
КОЙКА	Бүгд найрамдах Солонгос улсын олон улсын хамтын ажиллагааны байгууллага	ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЛГБТ	Лесбиян, гей, бисексуал, трансжендэр	ЭЯГБХУТК	Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенц
		ЮНЕСКО	Нэгдсэн үндэсний байгууллагын боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага

МӨНГӨНИЙ ХАНШ  
 (2019 оны 5 дугаар сарын 1-ний байдлаар)  
 Мөнгөн нэгж – МТ: Монгол төгрөг  
 МТ1.00= \$0.000378547  
 \$1.00 = 2641.68

ТЭМДЭГЛЭЛ  
 Энэ тайланд "\$" гэдэг нь АНУ-ын долларыг хэлж байгаа болно.



## ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ

**2005 оноос хойшхи ололт амжилт:** 2005 оноос хойш Монгол Улсад жендэрийн тэгш байдлыг хангах эрх зүй, бодлогын орчин сайжирч, үндэсний тогтолцоо амжилттай хөгжиж ирлээ. 2011 онд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуультай болж, уг хуулийн хэрэгжилтийг дэмжих зорилгоор Засгийн газрын дунд хугацааны стратеги (2013-2015) болон Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрүүд (2002-2015), (2017-2021) батлан хэрэгжүүлж ирсэн нь Монгол Улсын Засгийн газар, иргэний нийгэм, олон улсын түншлэгч байгууллагуудын хамтын хүчин чармайлтын үр дүн юм.

Дээрх хугацаанд Монгол Улс жендэрийн бодлого төлөвлөлтийн хувьд шилжилтийн үед эмэгтэйчүүдэд тулгамдсан асуудлыг шийдэх зорилгоор баримталж байсан “Эмэгтэйчүүд ба хөгжил” хандлагаас эмэгтэй эрэгтэй хүмүүс, нийгмийн бүлгүүдэд хөгжлийн тэгш боломж, сонголт бий болгоход чиглэсэн, монголын нийгмийн онцлог, хөгжлийн өнөөгийн хэрэгцээнд илүүтэй нийцсэн “Жендэр ба Хөгжил” хандлага руу шилжлээ. Өнөөдөр Монгол Улсын Ерөнхий сайдаар ахлуулсан Жендэрийн үндэсний хороо, түүний Ажлын алба тогтвортой ажиллан, төрийн захиргааны төв байгууллагуудад жендэрийн салбар зөвлөл, аймгуудад жендэрийн салбар хороод байгуулагдан, жендэрийн асуудлыг тодорхой мэргэжилтнүүд хариуцаж, салбар, орон нутгийн хэрэгцээнд суурилсан жендэрийн бодлого төлөвлөлт хийх туршлага хуримтлуулж байна.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль батлагдсаны үр дүнд УИХ-ын дэргэдэх Хүний эрхийн үндэсний комисс, Төрийн албаны зөвлөл, Үндэсний статистикийн хороо нь үндсэн чиг үүргийнхээ хүрээнд жендэрийн асуудлыг тусган хэрэгжүүлж буйн дотор жендэрийн сэдэвчилсэн судалгаа, тайлан гаргах, жендэрийн үзүүлэлт, хүйсээр ангилсан мэдээллийг бүрдүүлэхэд анхааран ажиллаж байна. Жендэрийн тэгш бус байдал, жендэрт суурилсан хүчирхийлэл, түүний дотор гэр бүлийн хүчирхийллийн талаарх мэдээлэл нийгэмд нээлттэй боллоо. Улс орны эдийн засгийн нөхцөл байдал хүнд байгаа ч жендэрийн бодлого төлөвлөлтийг дэмжсэн төсвийн хуваарилалт нэмэгдсээр байна.

Хүний эрх, жендэрийн шударга байдлын төлөө тэмцэгч иргэний нийгмийн байгууллагууд, ялангуяа эмэгтэйчүүдийн хөдөлгөөн улам хүчирхэгжиж, эмэгтэйчүүдийн эсрэг аливаа хүчирхийлэл, тэр дундаа гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүн худалдаалах гэмт хэргийг таслан зогсоох, улс төрийн шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог хангахын төлөө өрнөж буй үйл явцад манлайлах үүргийг гүйцэтгэж байна.

**2005 оноос хойшхи сургамж, өнөөгийн тулгамдсан асуудал:** Хэдийгээр эрх зүй, бодлогын орчин сайжирч, тогтолцоо бий болсон ч жендэрийн тэгш байдлын талаарх ойлголт мэдлэг бүх түвшинд дутмаг, ЖҮХАА-ны хүний нөөц, чадавхи хүрэлцээгүйгээс жендэрийн асуудлаар салбар хоорондын зохицуулалтыг хийж чадаагүй, 2002-2015 онд хэрэгжсэн Жендэрийн тэгш байдлыг хангах тухай үндэсний хөтөлбөрт санхүүжилт хийгдээгүй, 2013 онд батлагдсан Байгаль орчны салбарын жендэрийн бодлого мэдлэг ойлгоц, улс төрийн хүсэл зориг, зохион байгуулалт дутмагаас хэрэгжихгүй байна. Жендэрийн асуудлаар олон улсын байгууллага, донорууд судалгаа хийж тайлан гарган, санхүүгийн дэмжлэг үзүүлсээр ирсэн боловч үр өгөөжийг нь бүрэн дүүрэн ашиглаж чадсангүй. Жендэр, эмэгтэйчүүдийн, мөн эрэгтэйчүүдийн асуудлаар ажилладаг ТББ-уудын жендэрийн талаарх үндэсний бодлого төлөвлөлтийг дэмжихүйц чадавхи бүрдээгүй, хамтын ажиллагаа хөгжөөгүй байна.

Монгол Улсын Жендэрийн хөгжлийн индекс 2005 онд 0.717 байсан бол 2017 онд 1.043 болж сайжирсан нь зөвхөн эмэгтэйчүүдийн дундаж наслалт болон боловсрол эзэмшилт эрэгтэйчүүдийнхээс илүү байгаатай холбоотой.

Эдийн засаг, нийгэм, байгаль орчны хүрээнд дараах тулгамдсан асуудлыг анхаарах шаардлагатай байна. Үүнд:

Эдийн засгийн хүрээнд: Улс орны, аймаг, нийслэл, дүүргийн эдийн засаг, нийгмийн бодлого төлөвлөлтийн шатанд жендэрийн дүн шинжилгээ хийж, үр нөлөөг тооцох, нөлөөлж залруулах чадвар, нөөц байхгүйгээс жендэрийн ялгаатай байдлын суурь шалтгааныг арилгахад ахиц гаргаж чадаагүй, хүрэн эдийн засгаар баримжаалсан төсөвлөлт нийгэм дэх тэгш бус байдлыг, түүний дотор хөдөлмөрийн зах зээл дэх жендэрийн зөрүүг ихэсгэсээр байна. Нийгмийн халамжийн хавтгайрсан арга хэмжээ нь өрх толгойлсон эхчүүд, ядуу иргэдийн хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэхгүй, эрэгтэйчүүдийг хорт зуршлаас ангижруулахад нөлөөлж чадахгүй байна.

Эдийн засаг төрөлжихгүй, ялангуяа хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрийн салбарт зохистой ажлын байр

хангалттай бий болохгүй, жижиг дунд, бичил бизнесийн орчин сайжрахгүй байгаагаас өнөөдөр хот, хөдөөгийн орлого багатай эмэгтэй, эрэгтэйчүүд, өрх толгойлсон эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн зах зээл дэх боломж, сонголт нэмэгдэхгүй байна. Энэ нь орлогын ялгаа гүнзгийрэх нөхцлийг бүрдүүлж, улмаар Монгол Улсад тохиож буй хүн ам зүйн цонхны боломжийг бүрэн дүүрэн ашиглаж чадахгүй, нийгэм дэх зөрчил, стресс, түүний дотор жендэрт суурилсан хүчирхийлэл нэмэгдэх суурь шалтгаан болох төлөвтэй байна.

Эдийн засгийн уналт эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтэд илүү нөлөөлж, ажиллах хүчин дэх эмэгтэйчүүдийн оролцооны түвшин буурсны зэрэгцээ эмэгтэйчүүдийн дундаж цалингийн эрэгтэйчүүдийнхэд эзлэх хувь нэмэгдээгүй байна. Хүчин чармайлт гаргахгүй бол цаашид эмэгтэйчүүдийг ажилд авахад нөхөн үржихүйн үүргээр нь ялгаварлан гадуурхах явдал гарсаар, эмэгтэй эрэгтэйчүүдийн ажиллах салбар, ажил мэргэжлийн зааг ялгаа болон эмэгтэйчүүдийн албан тушаал дэвшихэд тулгарах саад бэрхшээл хадгалагдсаар байх хандлагатай байна.

Эрэгтэйчүүд зонхилсон, ялангуяа эрэгтэйчүүд жасаагаар болон удаан хугацаагаар гэр бүлээсээ тусдаа ажиллаж буй салбаруудад, ажил-ар гэрийн амьдралын тэнцвэр, эрүүл мэнд, аюулгүй байдлыг анхаарах шаардлагатай байна. Малчин эмэгтэйчүүд бага насны хүүхдээ сургахаар сум, аймгийн төвд амьдарч, эрэгтэйчүүд нь дангаар мал маллах үзэгдэл түгээмэл болж байгаа нь тэдгээр эрэгтэйчүүдийн эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдлийг нэмэгдүүлээд зогсохгүй, гэр бүлийн харилцаанд сөргөөр нөлөөлж байна. Ялангуяа орон нутагт газар тариалан, аялал жуулчлал зэрэг улирлын үйл ажиллагаатай салбаруудад эрэгтэйчүүдийн тогтвортой орлого бүхий хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зохицуулалт шаардлагатай байна.

Эмэгтэйчүүд Жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийн дунд дийлэнх болж байгаа ч гэр бүлээсээ хамааралтай, цөөн ажиллагчтай, жижиг бизнесийн түвшинд төвлөрч, хөрөнгө оруулалт санхүүгийн дэмжлэгийг тэгш хүртэж чадахгүй, дотоодын бүтээгдэхүүний зах зээл хамгаалалтгүй, төрийн болон орон нутгийн худалдан авалтад шударгаар өрсөлдөж чадахгүй байна. Ялангуяа оёдол, ноос ноолуур, нэхмэл, газар тариалан, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхэлж буй эмэгтэйчүүдэд эдгээр нь нэн тулгамдсан асуудал болж байна. Түүнчлэн эмэгтэйчүүдийн бизнес эрхлэлтэд тэдний газар, бусад өмч хөрөнгө эзэмшигчдийн цөөнх болж байгаа нь мөн сөргөөр нөлөөлж байна. Жижиг, дунд, бичил бизнесийг дэмжсэн санхүү, зээлийн арга хэмжээ, төсөл хөтөлбөрийн хугацаа богино, ажлын байран дахь сургалт, маркетингийн дэмжлэг дутагдаж байна.

Дэд бүтэц, хот төлөвлөлт нь ялангуяа залуу гэр бүлүүдэд бие даан амьдарч, хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, хөдөлмөр эхлэх таатай боломж бүрдүүлэхгүй байна. Хөдөөгийн айл өрхүүд болон сургуулийн дотуур байрны усны хангамж, ариун цэврийн байгууламж сайжрахгүй байна.

Нийгмийн хүрээнд: Боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийн үзүүлэлтүүд гол төлөв ахиц дэвшилтэй байгаа ч боловсролын чанар, агуулга жендэрийн тэгш байдлын үнэт зүйл, хүчирхийллийг үл тэвчих хандлагыг төлөвшүүлэх болон жендэрийн хэвшмэл ойлголтыг арилгахад ахиц гаргахгүй, эрэгтэйчүүдийн ялгаатай хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн үйлчилгээ хөгжөөгүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй эрэгтэй хүмүүс, охид хөвгүүдийн боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хэрэгцээ хангагдаагүй хэвээр байна. Гадаадад ажиллагчдын дийлэнх нь залуу эрэгтэйчүүд, хотод ирж суралцагчдын дийлэнх нь залуу эмэгтэйчүүд болж, хот хөдөөгийн аль алинд хүйсийн тэнцвэр алдагдаж байна.

СӨБ-ийн хүртээмж хангалтгүй, СӨБ-д хамрагдах боломж хотын захын хорооллын, малчдын, казах орлого багатай ядуу өрхийн хүүхдүүдэд бага байна. Бага ангид суралцагчдын дотуур байр хүртээмжгүй, ариун цэврийн нөхцөл байдлыг бүрэн хангаагүй гадаа жорлонтой сургуулиуд байсаар байна. Сургуулийн орчин дахь хүчирхийллийг арилгах, аюулгүй орчныг бүрдүүлэхэд хангалттай анхаарч чадахгүй байна.

Дунд боловсролын түвшинд анги дэвших тусам хөвгүүдийн тоо буурдаг чиг хандлага хадгалагдсаар байна. Дээд сургуульд суралцагчдын дунд эмэгтэйчүүд тооны хувьд давамгайлж хүйсийн тэнцвэр хэт алдагдсанаас гадна тэд боловсрол, эрүүл мэнд, хүмүүнлэгийн чиглэлээр голлон суралцаж байна. Харин эрэгтэйчүүд инженерийн болон байгалийн шинжлэх ухааны чиглэлээр илүүтэй суралцаж байна. Энэ гажуудалд эцэг эхчүүдийн хандлагаас гадна дээд боловсролын салбарт давамгайлж буй хувийн хэвшлийн байгууллагуудын үйл ажиллагаа нөлөөлж, залуу эмэгтэйчүүд хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдаагүй, чанаргүй боловсролын үйлчилгээний хохирогч болж байна.

Техникийн болон мэргэжлийн боловсролын сургуулиудад суралцагчдын дунд эрэгтэйчүүд зонхилж, суралцагч эмэгтэйчүүдийн тоо сүүлийн жилүүдэд илүүтэй буурч байна. Цаашид их дээд сургууль ба техникийн

болон мэргэжлийн сургуулиудад суралцагчдын тоог зохистой харьцаанд хүргэхгүй бол дээд боловсролын өгөөж ялангуяа эмэгтэйчүүдийн хувьд улам буурч болзошгүй. Мөн 40-өөс дээш насныханд шинэ мэргэжил эзэмших, хөрвөх боломж бага байгаагаас хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцэж чадахгүй, орхигдоход хүрч байна.

2018 оны байдлаар эрэгтэйчүүдийн дундаж наслалт эмэгтэйчүүдийнхээс 9.67 жилээр богино байгааг тэдний хорт зуршил, амьдралын буруу хэв маягаар тайлбарлаж байгаа ч нийгмийн хүчин зүйлсийн шалтгаант, стрессийн гаралтай сэтгэцийн эмгэгийн нөлөө, түүнийг үүсгэж буй нийгэм соёл, улс төр, эдийн засгийн хүчин зүйлсийг орхигдуулж байна. Эх, нялхсын, болон бага насны хүүхдийн эндэгдэл буурсан ч үйлчилгээний чанар, зохион байгуулалтыг сайжруулах, хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, бэлгийн цөөнхийн онцлог хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн үйлчилгээг хөгжүүлэх, охид хөвгүүдийн эрүүл мэндийг хамгаалах талаар эцэг эхчүүдэд мэдлэг олгох, агаар, хөрсний бохирдлыг ихэсгэж буй ахуйн дадал зуршлыг халах талаар мэдээлэл сурталчилгаа хийх хэрэгтэй байна. Бэлгийн ба нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн талаар мэдлэг боловсрол олгох тогтолцоо, тусламж үйлчилгээ ялангуяа алслагдсан хөдөө орон нутгийн хүүхэд залууст хүртээмжгүй байна.

Улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо хангалтгүй хэвээр, төрийн өндөр албан тушаал, аймаг, нийслэлийн болон ИТХ-ын даргын албан тушаалд нэг ч эмэгтэй томилогдон ажиллаагүй байна. Бизнесийн удирдах түвшин, төрийн захиргааны түшмэлийн түвшинд эмэгтэйчүүд олноор ажиллаж байгаа ч улс төрийн шийдвэр гаргах түвшинд хүрч чадахгүй байна. Тиймээс эмэгтэйчүүдийг чадавхжуулахад анхаарахын зэрэгцээ сонгуулийн санхүүжилт болон тогтолцоог жендэрийн хувьд тэгш шударга болгох, УИХ-ын болон орон нутгийн сонгуульд нэр дэвшүүлэх, суудал хадгалах, болон намын бүтэц зохион байгуулалтын бүхий л шатанд эмэгтэйчүүдийг дэмжих квот тогтоох шаардлагатай байна.

Гэр бүл цуцлалт нэмэгдэж, гэр бүлийн тогтвортой байдал алдагдаж, хүчирхийллийг тэвчих хандлага өөрчлөгдөхгүй байгаагийн зэрэгцээ, гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хамгаалал, өртөгчдөд чиглэсэн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж сул, түүний дотор малчин эмэгтэйчүүдийн онцлог нөхцөл байдалд нийцсэн тусламж үйлчилгээ дутагдаж байна. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчдэд зориулсан албадан сургалтын агуулга, чанар хангалтгүй байна. Ажлын байрны бэлгийн дарамтаас сэргийлэх арга хэмжээг Монгол Улс дахь нийт ажиллагчдад хүртээмжтэй байдлаар хэрэгжүүлэх сорилт тулгарч байна. Мөн бэлгийн мөлжлөгийн хэлбэр зонхилж буй хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнийг таслан зогсоох нь тулгамдсан асуудал болж байна.

Байгаль орчны хүрээнд: Малчин өрхүүдийн хувьд бэлчээрийн доройтол, усны хомсдол тулгамдсан асуудлын нэг болж, дотоодын шилжих хөдөлгөөн ихэсч, бэлчээр, газрын маргаанд хүргэж байна. Гэтэл малын тоо толгой нэмэгдэж байгаа ч малын ашиг шимийг бүрэн ашиглаж чадахгүй, малчин эмэгтэй эрэгтэйчүүд бэлчээрийн доройтлыг бууруулахад, цөлжилтийг сааруулахад өдөр тутмын ажил үүргээрээ болон орон нутгийн шийдвэр гаргах үйл явцад бодитой хувь нэмэр оруулж чадахгүй байна. Хариуцлагагүй уул уурхай эрхлэгчдийн бохирдуулсан гол мөрөн, худгийн уснаас тухайн нутгийн төдийгүй урсгал дагуу амьдарч буй эмэгтэй эрэгтэй хүмүүс, охид хөвгүүд хэрэглэснээс гарах үр дагаврыг жендэрийн өнцгөөс судлан шинжилж дүгнэх шаардлагатай байна.

Хотын гэр хорооллын эзлэх талбайн хэмжээ нэмэгдэж, амьдрах орчин сайжрахгүй утаа, тоосжилт, орчны бохирдол ноцтой асуудал болж байна. Агаарын бохирдлын улмаас амьсгалын замын өвчлөл огцом нэмэгдэж урагт нөлөөлөн, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг ихэсгэж байна.

Цаашдын алхмууд: Монгол Улс дахь жендэрийн өнөөгийн нөхцөл байдлаас үүдэн эдийн засаг, нийгэм, байгаль орчны хүрээнд жендэрийн тэгш байдлыг хангах болон жендэрийн үндэсний тогтолцоог хөгжүүлэх чиглэлээр урт, дунд, богино хугацаанд өгч буй зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхдээ УИХ, түүний дэргэдэх байгууллага, Засгийн газар, ИНБ, ОУБ, донорууд дараах асуудлыг харгалзан үзэх нь зүйтэй байна. Үүнд:

#### Судалгаа, дүн шинжилгээнд:

- Бүх хүрээнд хүйсээр ангилсан мэдээллийг сайжруулахын зэрэгцээ жендэрийн дүн шинжилгээ, судалгаанд ялгаатай байдлыг үүсгэж буй суурь шалтгаан, хүчин зүйлсийг илрүүлэх замаар салбар хоорондын хамтын ажиллагааны гарцыг олох; Жишээ нь дээд боловсрол дахь жендэрийн зөрүү, дундаж наслалтын зөрүүг эдийн засаг, нийгэм соёл, амьдарч буй орчны талаас цогц байдлаар судлах;
- Ийнхүү судлан шинжлэх чадавхийг дээшлүүлж, мэдээллийн нэгдсэн сан үүсгэн ашиглаж, үндэсний статистикийн байгууллагын жендэрийн мэдрэмжтэй статистик, мэдээллийн баазыг сайжруулахад хувь нэмэр оруулах.

### Бодлого төлөвлөлтөд:

- Үндэсний, салбар, орон нутаг, байгууллагын бодлого төлөвлөлтөд Жендэр ба хөгжил хандлагыг тууштай баримтлахын зэрэгцээ, бодлого төлөвлөлт нь гэр бүлийн харилцаанд нөлөөлөх байдлыг анхаарч тооцох, гэр бүлийн хамтын амьдралыг дэмжих;
- Хувь хүн, айл өрхийн жендэрийн нөхцөл байдлыг өөрчлөх эдийн засаг, нийгмийн үндсэн хөшүүрэг, арга хэмжээг тодорхойлж, салбар бүрийн бүх түвшний бодлого төлөвлөлтөд, ялангуяа улс орны хөгжлийн бодлогод тусгах хүн төвт, гэр бүлд ээлтэй хандлагыг, эмэгтэй эрэгтэйчүүдийн оролцоонд түшиглэн нэвтрүүлэх;
- Олон улсын байгууллагууд, доноруудын хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн дизайны шатнаас эхлэн жендэрийн бүрэлдэхүүн хэсгүүдийг Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр, салбарын жендэрийн бодлого стратегиудтай уялдуулах;
- Бодлого төлөвлөлт, төсөвлөлтийн хүрээнд жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн арга зүйг ашиглахыг дэмжих.

### Хэрэгжилтэд:

- Салбаруудын жендэрийн бодлого, стратеги, орон нутгуудын жендэрийн бодлого төлөвлөлтийн хэрэгжилтийг мэргэжил арга зүйгээр тогтмол дэмжих;
- Салбар, орон нутгуудад гарч буй сайн туршлагауудыг жендэрийн тэгш байдлыг хангах тогтолцоо, түншлэлийн хүрээнд тогтмол түгээн дэлгэрүүлэх;
- Жендэрийн, эмэгтэйчүүдийн төдийгүй, нийт ИНБ-ыг үндэсний жендэрийн бодлого төлөвлөлтийг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулахад чадавхижуулах;
- Жендэрийн сургалтын тогтолцоог үндэсний жендэрийн бодлого төлөвлөлтийн агуулга, чиг хандлагатай уялдуулан бий болгох.

### Мониторинг үнэлгээнд:

- Жендэрийн тэгш байдлыг хангах хүчин чармайлтын явц, үр дүнг үнэлэхдээ хувь хүн, айл өрхөд гарсан бодит өөрчлөлтийг хэмжих үзүүлэлтүүдийг түлхүү ашиглах;
- Мониторингийн үнэлгээг хөндлөнгийн багаар хийлгэх, үүнд үндэсний болон орон нутгийн ИНБ-ыг татан оролцуулах.

### Түншлэл, хамтын ажиллагаанд:

- Жендэрийн тэгш байдлыг хангахад түншлэгчдийн гаргаж буй хүчин чармайлтыг илүү үр өгөөжтэй ашиглахын тулд тэдний төлөвлөж, зарцуулж буй санхүүгийн нөөцийн талаарх мэдээллийг нэгтгэн, тогтмол шинжлэн дүгнэж, харилцан зөвшилцөж байх;
- Монгол Улсын санаачилсан Улаанбаатарын тунхаглал, Хөдөөгийн эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах тухай НҮБ-ын тогтоолыг хэрэгжүүлэхэд түншлэл хамтын ажиллагааг чиглүүлэх, олон улсын түвшинд өрнүүлэх;
- Жендэрийн хэвшмэл ойлголтыг өөрчлөх, жендэрт суурилсан хүчирхийллийг таслан зогсооход чиглэсэн мэдээлэл сурталчилгаа болон нөлөөллийн ажлын сайн туршлагауудыг үндэсний болон олон улсын түвшинд судлан гаргаж түгээх.

## ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ЗОРИЛГО БА АРГАЧЛАЛ

### Дүн шинжилгээний зорилго

Энэхүү жендэрийн дүн шинжилгээ нь а) 2005 оноос хойш Монгол улсад жендэрийн тэгш байдлыг хангах чиглэлээр гаргасан ололт болон сургамжийг нэгтгэн дүгнэж, өнөөдөр тулгамдаж буй жендэрийн гол асуудлын талаар үндэсний болон олон улсын түншлэгчдэд мэдээлэл өгөх, б) эдийн засаг, нийгэм, байгаль орчны хүрээнд жендэрийн тэгш байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, хамтын ажиллагааны чиглэл, цар хүрээг тодорхойлсон зөвлөмж гаргахыг зорьсон.

### Мэдээлэл цуглуулах, нэгтгэн шинжлэхэд ашигласан аргачлал

Дүн шинжилгээнд үндэсний, салбар, орон нутаг, байгууллагын хүйсээр ангилсан мэдээлэл, олон улсын үзүүлэлтүүдийг ашиглахдаа Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны эх үүсвэрт түшиглэсэн. Дүн шинжилгээнд хөндсөн сэдвийн хүрээнд 2005 оноос хойш гарсан бодлогын баримт бичиг, тайлан, судалгаа, үнэлгээ, хэвлэл мэдээллийн эх үүсвэрийг баримтын судалгаанд ашиглав.

Хүйсээр ангилсан мэдээлэл болон баримтын судалгааг “Салбар орон нутгийн жендэрийн мэдрэмжтэй хөгжлийн бодлого төлөвлөлт” техникийн туслалцааны төслийн хүрээнд хийгдсэн салбарын болон орон нутгийн бодлого боловсруулах, нөлөөллийн үйл ажиллагаа явуулахад зориулан хийсэн ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлагуудаар баяжуулсан. Ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагуудад 200 гаруй хүн хамрагдсан. Мөн салбар, орон нутгийн 30 жендэрийн мэргэжилтэн болон нийслэл, орон нутгийн жижиг, дунд үйлдвэр эрхлэгч 1200 хүнээс авсан асуулга судалгааны үр дүнг нэгтгэн дүн шинжилгээнд ашигласан.

Дээрх аргуудаар цуглуулсан мэдээллийг нэгтгэн шинжлэхэд “Жендэр ба Хөгжил” хандлагыг баримталсан бөгөөд зөвлөмжийг боловсруулахад а) Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай Монгол Улсын хууль, Жендэрийн үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих, б) эдийн засаг, нийгэм, байгаль орчны хүрээнд хэрэгжих бодлого төлөвлөлт, хэрэгжилт, хяналт үнэлгээнд жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг нэгтгэх замаар Тогтвортой хөгжлийн зорилгыг хангахад хувь нэмэр оруулах, в) жендэрийн тэгш байдлыг хангахад чиглэсэн салбар хоорондын зохицуулалт, түншлэл хамтын ажиллагааг хөгжүүлэхэд анхаарсан.

Жендэрийн дүн шинжилгээний хүрээний урьдчилсан үр дүнг танилцуулах 6 удаагийн хэлэлцүүлэгт жендэрийн асуудлаар мэргэшсэн төр, төрийн бус, олон улсын байгууллагын 137 хүн оролцон санал бодлоо тусгасан болно.





**1**  
БҮЛЭГ

# ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ БА ЖЕНДЭР


## ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ БА ЖЕНДЭР

Монгол Улсын эдийн засаг зах зээлийн шилжилтийг туулан өнгөрүүлсэн 20 гаруй жилд 20 дахин тэлж<sup>1</sup>, нэг хүнд ноогдох ДНБ 2000 оноос 2016 онд 8.4 дахин өссөн байна. 2005 онд АХБ-наас Монгол Улсын жендэрийн нөхцөл байдлын үнэлгээг хийх үед эдийн засгийн өсөлт 7.3 хувь байж (Дүрслэл 1), хөгжлийн урт хугацааны зорилгоо уул уурхайн салбарын хөгжлийн үр дүнд тулгуурласан өөдрөг төсөөллөөр тодорхойлж байжээ. Эдийн засгийн өсөлт оргил үедээ байсан 2011 онд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай Монгол Улсын хууль батлагдсан бөгөөд уг хуулийн 5-р зүйлд жендэрийн тэгш эрхийн зарчмыг “эрэгтэй, эмэгтэй хүн бүр улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, гэр бүлийн ба бусад харилцаанд тэгш эрхтэй байх, нийгмийн амьдралд адил оролцох, хөгжлийн үр шим, нийгмийн баялгаас тэнцүү ашиг хүртэх боломж, нөхцөлийг хангах” хэмээн тодорхойлсон.

Дэлхийн эдийн засгийн форумын үнэлснээр<sup>2</sup> Монгол Улс эдийн засгийн оролцоо, боломжийн хүрээн дэх жендэрийн үзүүлэлтээр 2006 онд 0.704 оноогоор 21-р байранд орж байсан бол 2018 онд 0,780 оноогоор 20-р байранд байгаа нь эдийн засаг, боловсрол, эрүүл мэнд, улс төрийн хүрээнд хэмждэг 4 үзүүлэлтээс цорын ганц ахицтай үзүүлэлт болсон байна. Үндэсний хэмжээнд ядуурал буурч 2003 онд хот суурин газарт 30.34 хувь, хөдөө орон нутагт 43.4 хувь байсан бол 2016 онд тус тус 27.1 хувь ба 30.34 хувь болжээ.

Хэдийгээр Монгол Улсын эдийн засаг 2008-2009 оны азийн эдийн засгийн хямралыг даван туулж, 2011 онд 17.3 хувийн өсөлт үзүүлсэн боловч дэлхийн санхүү, эдийн засгийн хүндрэл, түүний дотор олборлох салбарын түүхий эдийн үнийн уналтын нөлөөгөөр 2018 онд 5.0 хувь болоод байна. Хэдийгээр ядуурал хөдөөд илүү байгаа боловч нийслэлд илүү гүнзгийрч байна. Мөн хот суурин газарт эмэгтэй тэргүүлэгчтэй өрх ядууралд илүү өртөж байгаа бол хөдөөд эрэгтэй тэргүүлэгчтэй өрх илүү ядууралд өртөж байна<sup>3</sup>.


Дүрслэл 1. Эдийн засгийн өсөлт 2005-2018 онд, хувиар



Эх үүсвэр: ҮСХ. 1212.mn

Монгол Улс орлогын тэгш бус байдлаар хөрш зэргэлдээ орнуудаас дээгүүр үзүүлэлттэй байгаа ч орлогын ялгаа буурахгүй байгаагийн зэрэгцээ өрхийн сарын дундаж зарлагын орлогоос хэтэрсэн хэмжээ сүүлийн жилд нэмэгдсээр (Дүрслэл 2) монголчууд зээлийн эдийн засаг руу шилжих төлөвтэй байна. Хотод хэрэглээний тэгш бус байдал илүү өндөр байна.

Дүрслэл 2. Нэг өрхийн сарын дундаж орлого ба зарлага, улсын дунджаар




Эх үүсвэр: ҮСХ. 1212.mn

2005 оны байдлаар Монгол Улсын эдийн засгийн өсөлтөд уул уурхай, олборлолтын салбар, хөдөө аж ахуй, ойн аж ахуй болон загас, ан агнуурын салбар тэнцүү хувь нэмэртэй байсан бол 2017 оны байдлаар хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас, ан агнуур боловсруулах үйлдвэрлэлийн салбарын эзлэх хувь бараг 2 дахин унасан байна



(Дүрслэл 3). Боловсруулах үйлдвэрийн оруулах хувь нэмэр 2005 оноос хойш бараг нэмэгдээгүй, харин бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ эдийн засгийн өсөлтийн оргил үед уул уурхайн салбартай адил хувь эзэлж байсан ч сүүлийн 7 жилд аажим буурч байна.

**Дүрслэл 3. Эдийн засгийн өсөлт 2005-2017 онд, тэргүүлэх салбараар**  
(ДНБ-д эзлэх хувь)



Эх үүсвэр: YCX. 1212.mn

Ийнхүү боловсруулах үйлдвэрлэл хөгжихгүй, малын тоо өссөөр байхад хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний эдийн засагт эзлэх хувь буурсаар байгаа нь хувь хүн, айл өрхүүдийн эдийн засгийн хөгжилд оролцох боломж бараг нэмэгдэхгүй байна гэсэн үг юм. Албан бус салбарт ажиллагчдын тоо сүүлийн жилүүдэд нэмэгдэх хандлагатай, тухайлбал 2016 онд 159.7 мянга байсан бол 2018 онд 219.8 мянга болж өссөн нь дээрх дүгнэлтийг бататгаж байна.

Иймд эдийн засгийн өсөлтийн загварыг шинэчлэх, эдийн засгийн гол салбар боловч ажиллах хүчний 5 хүрэхгүй хувь ажиллаж байгаа уул уурхайгаас бусад салбарыг түлхүү хөгжүүлэх нь тулгамдсан асуудал болж байна. Эдийн засгийн төрөлжилт нь хөдөлмөр эрхлэх, түүнийхээ үр шимийг хүртэхэд эмэгтэй эрэгтэй хүмүүст, нийгмийн бүлгүүдэд үүсч буй ялгаатай байдал буурахад нөлөөтэйг ОУВС-ын судалгаа ч харуулж байна<sup>4</sup>. Мөн эдийн засгийн бодлого, шийдвэр гаргахад иргэдийн, түүний дотор эмэгтэй эрэгтэйчүүдийн оролцох боломжийг нэмэгдүүлж, арга замыг тодорхой болгох асуудал тулгамдсан хэвээр байна.

Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг нэвтрүүлэх чиглэлээр Засгийн газар болон олон улсын түншлэгчид хүчин чармайлт гаргаж буйн дотор Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамрагдах байгууллага, агентлагуудад хэрэгжих жендэрийн стратеги (2016-2024) батлагдан хэрэгжиж байна. Тус стратегийн "Сангийн сайдын болон зарим төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн үйл явцыг үе шаттайгаар жендэрийн мэдрэмжтэй болгох" 3-р зорилтын хүрээнд төлөвлөгдсөн үе шаттай арга хэмжээг хэрэгжүүлэхэд салбар дахь улс төрийн хүсэл зоригоос гадна жендэрийн тэгш байдлын төлөөх түншлэгчдийн дэмжлэг шаардлагатай байна.

**А Өмч хөрөнгө эзэмшилт**

Өмч хөрөнгө эзэмшилт, түүний дотор газар эзэмшилт нь нүүдлийн мал аж ахуйд суурилсан соёл болон социалист нийгмийн тогтолцооны ахуй уламжлалтай Монгол Улсын хувьд 1990-ээд оноос хойш өрнөж буй харьцангуй шинэлэг ойлголт, шинэ үйл явц билээ. 2005 он гэхэд мал, орон сууц айл өрхүүдийн өмч болж, төрийн өмчит үйлдвэрийн газрууд хувийн хэвшилд шилжин хувьчлалын эхний шат дуусч, газар хувьчлал эхэлж, боловсрол, эрүүл мэндийн салбарт хувийн өмчийн хэлбэр үүсч эхэлж байлаа.

Айл өрхүүд хувийн өмчтэй болсноор өмч хөрөнгийн эзэмшилтэй холбоотой шинэ харилцаа өрхийн эмэгтэй эрэгтэй гишүүдийн хооронд үүсч эхэлсэн тул уг харилцааг жендэрийн хувьд тэгш шударга байлгах талаар эрх

<sup>4</sup>Romina Kazandjian; Lisa L. Kolovich; Kalpana Kochhar; Monique Newiak. 2016. Gender Equality and Economic Diversification. IMF Working Paper 16/140. July. <https://www.imf.org/en/Publications/WP/Issues/2016/12/31/Gender-Equality-and-Economic-Diversification-44091>

зүйн орчин, засаглалын тогтолцооны хүрээнд анхаарах шаардлагатайг 2005 онд хийсэн Жендэрийн нөхцөл байдлын үнэлгээний тайланд зөвлөсөн байдаг. Энэ үеэс хойш өмч эзэмшлийн талаарх ойлголт харьцангуй төлөвшин, эрх зүйн орчин хөгжиж ирсний дотор Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулинд төрийн болон бусад хэвшлийн аж ахуйн нэгж байгууллага нь “газар, бусад үл хөдлөх ба хөдлөх эд хөрөнгө, төсвийн хөрөнгө, санхүүгийн актив, санхүүгийн зээл болон эдийн засгийн бусад нөөц баялгийг эрэгтэй, эмэгтэй хүнд адил нөхцөлөөр тэгш, хүртээмжтэй хуваарилах үүрэг хүлээнэ” хэмээн зааж өгсөн.

Мөн Тогтвортой хөгжлийн зорилгын 1.4 ба 2.3-т эдийн засгийн нөөц бололцоо, газар болон бусад хэлбэрийн эд хөрөнгө өмчлөх, захиран зарцуулах, өв залгамжлахад тэгш боломж бүрдүүлэх талаар тодорхой тусгасан. Энэ зорилгын хэрэгжилтийг үнэлэх тоон мэдээлэл хангалтгүй байгаа ч сүүлийн үеийн зарим судалгаагаар зөрүүтэй байдал байгаа нь харагдаж байна. 2018 онд АХБ-наас Монгол, Гүрж, Филиппин улсад харьцуулсан туршилтын судалгаа хийхэд эдгээр орнуудад орон сууц, газар эзэмшигчдийн дунд эрэгтэйчүүд дийлэнх байсны дотор жендэрийн зөрүү Монгол Улсад хамгийн их байна.

Монголын айл өрхүүдийн хувьд өнөөдөр хамгийн ач холбогдолтой байгаа үндсэн сууцны эзэмшлийг авч үзвэл нийт эрэгтэйчүүдийн 60 хувь, эмэгтэйчүүдийн 33 хувь нь сууцаа өөрсдөө өмчилдөг, харин өмчлөлөө баримтжуулсан байдал нь эрэгтэйчүүдийнх 55 хувь, эмэгтэйчүүдийнх 27 хувь байна<sup>5</sup>. Сууц өмчлөлөө баримтжуулсан эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс хотод 1.5 дахин, хөдөөд 3 дахин олон байна.

Хөдөөд илүүтэй ажиглагдаж буй жендэрийн энэ ялгаатай байдал хөрөнгийн бусад бүх хэлбэрт ч түгээмэл байна. Уг судалгаанд оролцсон хөдөөгийн эрэгтэйчүүдийн 65 хувь, эмэгтэйчүүдийн 42.8 хувь малаж ахуй эзэмшдэг, эрэгтэйчүүдийн 6.4 хувь, эмэгтэйчүүдийн 0.6 хувь том оврын тоног төхөөрөмж эзэмшдэг гэж хариулжээ. Харин санхүүгийн хөрөнгө эзэмшлийн хувьд эмэгтэйчүүд хот хөдөөгийн аль алинд эрэгтэйчүүдээс бага зэрэг дээгүүр хувьтай байна. 2015 онд ШХА-аас малчдын дунд хийсэн судалгаанаас үзэхэд малчин өрхийн аж ахуйн 58.5 хувь нь эрэгтэйчүүдийн, 10.7 хувь нь эхнэр нөхрийн хамтын, 8.5 хувь нь эхнэрийн нэр дээр бүртгэгдсэн байна. Мал, өвөлжөө, хаваржаа, мотоцикл болон бусад тээврийн хэрэгсэл гол төлөв эрэгтэйчүүдийн нэр дээр бүртгэлтэй, мөн нутгаасаа гадна байрлах өмч хөрөнгөө гол төлөв хүүгийнхээ нэр дээр бүртгүүлдэг байна<sup>6</sup>.

Газрыг эрэгтэйчүүдийн нэр дээр бүртгэх, эрэгтэйчүүдэд өвлүүлэх хандлага ялангуяа хөдөөд түгээмэл байна.<sup>7</sup> 2013 онд хот, хөдөөгийн 800 өрхийг хамруулан хийсэн үнэлгээгээр газрын зөвхөн 27.2 хувийг эмэгтэйчүүд өвлөж байгаа нь тогтоогджээ.<sup>8</sup> Газар тариалан эрхлэгчидтэй хийсэн бүлгийн ярилцлагаас үзэхэд эрэгтэйчүүд том хэмжээний газар эзэмшин үр тариа, төмсний үйлдвэрлэл эрхэлж, эсвэл давхар түрээслэх нь элбэг, харин эмэгтэйчүүд гол төлөв жижиг талбайд хүнсний ногоо тариалж байна.

Өмч хөрөнгө эзэмшил дэх жендэрийн ялгаа нь бизнес эрхлэх шийдвэр гаргах, санхүүгийн үйлчилгээ авахад ялгаатай байдлыг үүсгэж байна. Жишээлбэл хүнсний ногоо тариалагч, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч эмэгтэйчүүд барьцаа хөрөнгө байхгүйгээс банкны зээлд хамрагдах боломжгүй байна. Мөн хөдөөгийн айл өрхүүдийн сууц, хашааны газрын үнэлгээ хэт доогуур байгаа нь ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх болсон эмэгтэйчүүдийн эдийн засгийн үйл ажиллагааг хязгаарлаж байгааг анхаарах шаардлагатай байна.

Өрх гэрийн болон компанийн өмч хөрөнгийн бүртгэлтэй холбоотой хүйсээр ангилсан мэдээллийг тогтмол бүрдүүлэх, жендэрийн үр дагаврыг судлан, эрх зүйн орчныг сайжруулахад ашиглах чиглэлээр холбогдох байгууллагууд санаачлага гаргах хэрэгтэй байна. Жишээлбэл гэрлэсний дараа бүртгүүлсэн эд хөрөнгө гэр бүлийн гишүүдийн хамтын өмч байхаар Монгол Улсын иргэний хуулинд заасан боловч албан ёсоор өөрийн нэр дээр өмч хөрөнгө бүртгүүлсэн этгээд гэр бүлийн бусад гишүүдээс зөвшөөрөл авалгүй худалдах боломжтой байгаа нь өмч хөрөнгийн эзэмшилд аль нэг хүйс давамгайлж байгаа тохиолдолд жендэрийн сөрөг үр нөлөөтэй байна. Мөн эмэгтэйчүүд гэр бүлийн бизнест албан ёсоор хувь эзэмшилгүй ажиллаж, гэр бүл салах үед компанийн бүртгэлтэй өмчөөс хувь авч чадахгүй хохирох нь түгээмэл байна.

Өмч хөрөнгийг өвлүүлэхэд мөн жендэрийн ялгаварлал гарч байна. Газар үл хөдлөх хөрөнгийг хөвгүүддээ өвлүүлэх хандлага хүчтэй байсаар байна. Тухайлбал 2014 онд хийсэн фокус бүлгийн ярилцлагад оролцогчдын 72,4 хувь нь хашаагаа хүүдээ өвлүүлнэ гэсэн бол 17,6 хувь нь охиндоо өвлүүлнэ гэж хариулсан байна. Ийм хандлага нь цаашид эмэгтэйчүүдийн газар, өмч хөрөнгө эзэмших боломжийг хязгаарлах хүчин зүйл болж байна. Харин эцэг эхчүүд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэддээ хүйсээс нь үл хамааран өв залгамжлахад давуу боломж олгодог байна.<sup>9</sup> Өмч хөрөнгө өрхийн тэргүүний нэр дээр бүртгэгдэх ёстой гэсэн уламжлалт хандлага хүчтэй байгаагаас гадна ялангуяа хөдөөд хүүгээ гэрлүүлж буй эцэг эхчүүд залуу хосын амьдрах сууцыг нь бэлтгэх уламжлал өмч хөрөнгийн эзэмшилд жендэрийн ялгаа гарахад нөлөөлж байна.

**Шигтгээ 1.****Газар өмчлөл дэх жендэрийн тэгш байдлыг дэмжсэн сайн туршлага**

Монголын Мянганы Сорилтын Сангийн Хөрөнгийн эрхийн төсөл нь Газрын харилцаа, геодези зураг зүйн газар, Улсын бүртгэлийн хэлтэс, аймгийн Засаг даргын тамгын газар, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллаж газрын мэдээллийг хүйсээр ангилах сайн туршлага нэвтрүүлэн, эмэгтэйчүүдийн газар өмчлөх эрхийг дэмжих чиглэлээр үндэсний болон орон нутгийн түвшинд хэлэлцүүлэг, форум, сургалтуудыг хийсэн байна. Эдгээр үйл ажиллагааны үр дүнд 2 жилийн дотор төслийн зорилтот бүлэг дэх газар эзэмшигч эмэгтэйчүүдийн хувь 35-аас 41 хувь хүртэл нэмэгдсэн байна.

Эх үүсвэр: Монголын мянганы сорилтын сан. *Mongolia compact gender summary report: Best practices and lessons learned, 2013*

Өмч эзэмшлийн асуудлыг өрхийн насанд хүрсэн эмэгтэй эрэгтэйчүүдийн тухайд авч үзэхээс бус хүүхдийн эрх ашгийн талаас төдийлөн судалж, мэдээлэхгүй байна. Ялангуяа гэр бүл салахад эмэгтэйчүүдээс гадна хүүхдийн өмчлөлийн асуудал хөндөгддөг, мөн өнчирсэн хүүхдүүдийн өв залгамжлах эрхийг хамгаалах асуудал орхигдож байгааг анхаарч судлах, эрх зүйн орчныг жендэрийн өнцгөөс үнэлэх шаардлагатай.

Өрх гэр бүлд өмч хөрөнгийг хэн эзэмшиж, захиран зарцуулж байгааг анхаарахаас гадна макро түвшинд гарч буй өөрчлөлт дам байдлаар жендэрийн хувьд сөрөг үр дагавар авчирч болохыг өнгөрсөн хугацаанд өрнөсөн зарим үйл явц харууллаа. Боловсролын салбарт хувийн өмч давамгайлах болж, хөрөнгө оруулалт бага шаардах мэргэжлүүдээр түлхүү сургахын зэрэгцээ сургалтын чанар, стандарт буурснаар зах зээлийн эрэлтэд мэргэжил, мэдлэгээр нийцэхгүй, эмэгтэйчүүд зонхилсон дээд боловсролтой хүмүүсийн тоо огцом нэмэгдсэн нь үүний нэг тод жишээ юм. 2005 онд төрийн өмчийн 49, хувийн өмчийн 125 их дээд сургууль, коллеж ажиллаж байсан бол дээд боловсролын шинэтгэлийн бодлогын нөлөөгөөр энэ тоо буурч, өнөөдөр төрийн өмчийн 50, хувийн өмчийн 88 их дээд сургууль, коллеж үйл ажиллагаа явуулж байгаа ч суралцагчдын тоо болон хүйсийн харьцаа дорвитой өөрчлөгдөөгүй байна. Монголчуудын боловсролыг эрхэмлэх үнэлэмжид түшиглэсэн боловсролын бизнес нь ялангуяа малчин болон орлого багатай өрхүүдийн эдийн засагт сөргөөр нөлөөлөөд зогсохгүй, хөдөөгөөс хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөнийг нэмэгдүүлж, малчдын хүйсийн харьцаа алдагдах нэг нөхцөл болжээ.

Мөн газар эзэмших, ашиглахтай холбоотой зөрчил маргаан малчдын хооронд төдийгүй Ховд, Сэлэнгэ, Хэнтий, Төв зэрэг газар тариалан хөгжсөн орон нутагт газар тариалан, мал аж ахуй эрхлэгчдийн хооронд, уул уурхай ашиглаж буй орон нутгуудад албан ба албан бус уул уурхай эрхлэгчид, нутгийн оршин суугчдын хооронд ихэсч байгаа бөгөөд үүнд хүн бүл цөөтэй ахимаг насныхан, өрх толгойлсон эмэгтэйчүүд илүү эмзэг байна.

**Б Хөдөлмөр эрхлэлт**

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай Монгол Улсын хуулийн хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаан дахь жендэрийн эрх тэгш байдлын баталгааны тухай 11-р бүлэгт эмэгтэй эрэгтэйчүүд хөдөлмөрийн зах зээлд ялгаварлагдахгүй, тэгш эрхтэй байх талаар заасан. Гэвч хөдөлмөр эрхлэлтийн хүрээнд жендэрийн ялгаа байсаар байна.

**Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн хөдөлмөр эрхлэлт.** Ажиллах хүчин дэх эмэгтэйчүүдийн оролцооны түвшин нь улс орны эдийн засгийн өсөлт, нэг хүнд ноогдох орлогын хэмжээтэй шууд холбоотой<sup>10</sup> бөгөөд салбарууд дахь жендэрийн тэгш оролцоог дэмжсэнээр дэлхийн нийт ДНБ 2025 он гэхэд өнөөгийнхөөс 26 хувиар өсөх боломжтой<sup>11</sup> гэж судлаачид үзэж байна. ОУХБ-ын тооцоогоор<sup>12</sup> энэ нь нийт 5.8 их наяд долларын өсөлтийг дэлхийн эдийн засагт авчрахаас Зүүн Азид 1 их наяд нь ноогдох ажээ. Үндэсний статистикийн мэдээнээс үзэхэд Монгол Улсад 2006 онд 64.3 хувь байсан эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин 2018 онд 53.4 хувь болж буурсан байна.<sup>13</sup> Энэ нь эдийн засгийн уналт эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтэд илүүтэй нөлөөлсний (Дүрслэл 4) дотор нийслэлийн эмэгтэйчүүдэд илүү нөлөөлсөн нь 2018 оны байдлаар тэдний ажиллах хүчин дэх оролцооны түвшин (44.8 хувь) хөдөөгийн эмэгтэйчүүдийнхээс (60.5 хувь) нилээд доогуур байгаагаас харагдана.


<sup>10</sup> Christian Gonzales, Sonali Jain-Chandra, Kalpana Kochhar and Monique Newiak. 2015. *Fair Play: More Equal Laws Boost Female Labor Force Participation*. IMF Working Paper. February.

<sup>11</sup> Jonathan Woetzel. 2015. *The Power of Parity: How Advancing Women's Equality can add \$12 Trillion to Global Growth*. McKinsey & Company. [https://econpapers.repec.org/paper/esswpaper/id\\_3a7570.htm](https://econpapers.repec.org/paper/esswpaper/id_3a7570.htm)

<sup>12</sup> ILO. 2017. *World Employment and Social Outlook: Trends for women 2017*. Geneva: ILO. [https://www.ilo.org/global/research/global-reports/weso/trends-for-women2017/WCMS\\_557245/lang-en/index.htm](https://www.ilo.org/global/research/global-reports/weso/trends-for-women2017/WCMS_557245/lang-en/index.htm)

<sup>13</sup> Bock, F. 2015. *Water Supply, Sanitation and Hygiene in Mongolia: An Institutional Analysis*. Ulaanbaatar: Action Contre La Faim.


**Дүрслэл 4. Ажиллах хүчний оролцооны түвшин 2005-2018 онд, хүйсээр**



Эх үүсвэр: YCX. 1212.mn

15 ба түүнээс дээш насны ажиллагч эмэгтэй эрэгтэйчүүдийн тоо 2005 оноос хойш 27 хувь өссөн ч 2008-2009 онуудад эмэгтэй ажиллагчдын тоо 9 хувиар огцом унасан байна (Дүрслэл 5). Сүүлийн 13 жилд цалин хөлстэй ажиллагч эрэгтэйчүүдийн тоо илүү өссөн байна.


**Дүрслэл 5. 15 ба түүнээс дээш насны ажиллагчдын тоо 2005-2018 онд, хүйсээр**



Эх үүсвэр: YCX. 1212.mn

Эдийн засагт хамгийн их хувь нэмэр оруулж буй үйл ажиллагааны дөрвөн салбарын ажиллагчдыг авч үзвэл 2005 -2018 оны хооронд эрэгтэйчүүдийн тоо хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас, ан агнуурын болон уул уурхай, олборлолт, бөөний болон жижиглэн худалдааны салбаруудад нэмэгдэж, харин эмэгтэйчүүдийн тоо голчлон бөөний ба жижиглэн худалдааны салбарт өсчээ (Дүрслэл 6). Үүнээс үзэхэд хөдөлмөрийн зах зээл дэх жендэрийн хэвтээ ялгарал цаашид арилахгүй, харин ч улам ихсэх хандлагатай байна.

Дүрслэл 6. Эдийн засгийн тэргүүлэх дөрвөн салбарт ажиллагчдын тоо 2006-2018 онд, хүйсээр




Эх үүсвэр: YCX. 1212.mn

Дэлхийн эдийн засгийн форумын үнэлснээр 2018 оны байдлаар мэргэжлийн болон техникийн ажилчдын дунд эмэгтэйчүүд зонхилж (хүйсийн харьцаа 1.82) байна. 2005 онд эмэгтэйчүүд менежерийн түвшинд 35 хувийг эзлэн ажиллаж байсан бол өнөөдөр энэ хэмжээ 38.9 хувь болсон ахицтай байна. Гэвч эмэгтэйчүүд тооны хувьд илт давуу ажилладаг боловсрол, эрүүл мэндийн салбаруудад хүртэл удирдах ажилтны дунд эмэгтэйчүүд цөөнх хэвээр байгаагаас үзэхэд хөдөлмөрийн зах зээл дэх жендэрийн босоо ялгарал байсаар байна.

2006 онд Төрөөс албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого баталж, албан бус хөдөлмөр эрхлэгчдийн талаарх статистик мэдээллийг гаргах болсон. Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн эгнээнд сүүлийн 2 жилд шинээр нэмэгдэн орогчдын 43.6 мянга нь эрэгтэйчүүд, 19.7 мянга нь эмэгтэйчүүд байна. Өнөөдөр албан бус салбарт эрэгтэйчүүд зонхилж, хүйсийн харьцаа 1.6:1 байна. Эрэгтэйчүүд гол төлөв барилга, бөөний, жижиглэн худалдаа, машин мотоциклын засвар үйлчилгээ, тээвэр зуучлал, урлаг үзвэр, тоглоом наадмын салбарын албан бус ажилд шилжиж, харин эмэгтэйчүүд боловсруулах үйлдвэрт албан бусаар ажиллах нь нэмэгдсэн байна. Гэхдээ л эмэгтэйчүүд бөөний болон жижиглэн худалдааны салбарт голлон ажилласан хэвээр байна. Албан бус хөдөлмөр эрхлэлт дэх жендэрийн зөрүү Улаанбаатар болон бусад бүсүүдэд нэгэн адил ажиглагдаж байна.

**Ажилгүйдэл.** Эдийн засгийн хямралын үед буюу 2008-2009 онуудад ажилгүйдлийн түвшин хамгийн өндөр байсан бөгөөд ажилгүйдэлд эмэгтэй, эрэгтэй хүмүүс адил хэмжээгээр өртөж байсан бол 2016 онд эрэгтэйчүүдийн ажилгүйдэл харьцангуй илүү нэмэгдсэн байна. Ажил хайж буй эмэгтэйчүүдийн тоо эрэгтэйчүүдийнхээс илүү байж ирсэн боловч сүүлийн 3 жилд эрэгтэйчүүдийн тоо нэмэгдэн жендэрийн зөрүү багасч байна (Дүрслэл 7).


Дүрслэл 7. Ажилгүйдлийн түвшин 2005-2018 онд, хүйсээр



Эх үүсвэр: YCX. 1212.mn

Хөгжиж буй ихэнх орнуудад гол төлөв боловсрол доогуур буюу боловсролгүй хүн ам ажилгүй байдаг бол Монгол Улсад боловсролтой иргэд илүү ажилгүй байх хандлагатай байна<sup>14</sup>. 2018 оны байдлаар нийт ажилгүй 104.1 мянган иргэд байгаагийн 22.3 хувийг 15-24 насны залуучууд эзэлж байгаа ба үүний дотор эмэгтэйчүүд дийлэнх байна (Дүрслэл 8). Харин 34 наснаас хойш энэ байдал өөрчлөгдөж эмэгтэйчүүд ажилгүйчүүдийн цөөнх болж байна.


**Дүрслэл 8. Ажилгүйдлийн түвшин 2017 онд, насны бүлэг, хүйсээр**



Эх үүсвэр: YCX. 1212.mn

Залуу эмэгтэйчүүдийн ажилгүйдэл юуны өмнө хүүхэд төрүүлэх, асрахтай голцуу холбоотой бөгөөд 35 наснаас хойш хөдөлмөрийн зах зээлд эргэн ордог нь статистикаас харагдаж байна (Дүрслэл 9). Хүүхэд асрах шалтгаанаар эдийн засгийн идэвхигүй байгаа эмэгтэйчүүдийн эзлэх хувь 2012-2016 оны хооронд 1.8 дахин нэмэгдсэн байгаа нь 2005 оноос хойш төрөлт огцом нэмэгдсэн цаг үед таарч байна. Гэвч хүүхэд асрах үйлчилгээ хангалтгүй байгаагийн улмаас залуу эмэгтэйчүүд хүүхдээ сургуульд орох хүртэл, түүнээс ч цааш өөрсдөө асрах сонголт хийхээс өөр аргагүй болж, ажлаасаа урт хугацаагаар завсардах байдал түгээмэл байна. Тиймээс залуу эмэгтэйчүүдийн хүүхэд асрах үеийн нийгмийн хамгааллыг сайжруулах, эргэн ажилд орохдоо ажил мэргэжлийн хувьд хоцрогдолгүй байх боломж бүрдүүлэхэд илүү анхаарах шаардлагатай.

**Дүрслэл 9. Хөдөлмөр эрхлэгчдийн нас, хүйсийн бүтэц 2008 ба 2018 онд**



Эх үүсвэр: YCX. 1212.mn

Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэхэд садаа болж байгаа өөр нэг хүчин зүйл бол ажил олгогчид эмэгтэйчүүдийн хүүхэд төрүүлэхийг байгууллагын үйл ажиллагаанд хохиролтой, эдийн засгийн хувьд дарамттай гэж үзэж байгаа явдал юм. Хүүхэд төрүүлэх, асрах хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөх үүргийг хуулиар ажил олгогч хүлээж байгаа нь тэдний дээрх хандлагын гол шалтгаан болж байна.

**Шигтгээ 2.****Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал**

*Нэгэн банкны хөдөлмөрийн дотоод журамд "... шинээр ажилд орсон эмэгтэй ажилтны гэр бүл төлөвлөлтийг нарийн тооцоолж, ажилд томилогдсоноос хойш хоёр жилийн хугацаанд жирэмсний амралт эдлэхгүй бөгөөд хэрэв зөрчвөл ажилтан өөрийн санаачлагаар хөдөлмөрийн гэрээг цуцлах үүрэгтэй" гэж заан үйл ажиллагаандаа мөрдөж байсан нь тогтоогдсон.*

*Эх үүсвэр: Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх ХЭҮК-ийн 13 дахь илтгэл. 2014*

Хөдөлмөрийн тухай хуулиар ажил олгогч нь эмэгтэй хүний хүүхэд төрүүлснээс хойш 3 жилийн хугацаанд ажлын байрыг нь хадгалах үүрэгтэй ч байгууллагууд ажлын байрыг нь 6 сар л хадгалах явдал гарч байна. Мөн эмэгтэйчүүдийг ажилд авахдаа гэрлэлтийн байдал, хүүхэд төрүүлэх эсэхийг нь асууж лавлах явдал түгээмэл байна. 2014 онд хийсэн судалгаанд хамрагдсан ажил олгогчид шинээр ажилд орох гэж буй ажилтнаас нөхөн үржихүйн эрхийн талаарх асуултыг огт асуудаггүй гэсэн бол харин ажилтнуудын 41 хувь нь "Ажил олгогч ажилд авах үедээ гэрлэсэн болон жирэмсэн эсэхийг нь асууж байсан" гэжээ<sup>15</sup>. Залуу эмэгтэйчүүдийг ажилд авах заруудад гадаад үзэмж заах, мөн залуу эрэгтэйчүүдийг, эсвэл гадаад ажиллагчдыг ажил олгогчид илүүд үздэгээс цалин хөлс багатай, биеийн хүчний ажил хийдэг 40-өөс дээш насны эрэгтэйчүүд ялгаварлан гадуурхалд илүүтэй өртөж байгаа<sup>16</sup> нь ажилгүйдэлд нэрмээс болж байна. Дэлхийн банкнаас 2018 онд хийсэн чанарын судалгаанд оролцсон эмэгтэйчүүд 40-өөс дээш насны эмэгтэйчүүдийг худалдагч, дэлгүүрийн туслах ажилтан зэрэг ажлын байранд авахаас "хэтэрхий хөгшин харагдаж байна" гэсэн шалтгаанаар татгалздаг, ажлын зарууд голцуу 20-оос 32 хүртэлх насныхныг авахыг хүссэн байдаг талаар ярьсан байна. Бүлгийн ярилцлагад оролцогчид ажил олгогчид хүнийг ажилд авахдаа гадаад үзэмжийг ихээхэн харгалздаг, энэ нь эмэгтэйчүүдэд илүү хүнд тусдаг талаар мөн ярьсан байна.<sup>17</sup> Мөн сүүлийн үед амьдрах байршлаар ялгаварлан гадуурхах явдал гарч, хотын захын хорооллуудад амьдардаг хүмүүсийг хотын төвийн байгууллагууд ажилд авах сонирхолгүй болсон талаар гэр хорооллын оршин суугчид ярих боллоо.

50-иас дээш насны эрэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин өндөр байгаа ч, ажилгүйдлийн шалтгааныг насны бүлгээр харуулсан мэдээлэл байхгүй тул дүн шинжилгээ хийх боломжгүй байна. Зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш 40-өөс дээш насныхныг, түүний дотор тэтгэврийн насныхныг нас, эрүүл мэндийнхээ байдалд тохирсон шинэ мэргэжил эзэмших, түүгээрээ ажиллахыг дэмжсэн бодлого, үйл ажиллагаа хангалтгүй явж ирлээ. ХНХЯ-наас хэрэгжүүлж буй ахмад настны зөвлөх үйлчилгээний хөтөлбөрийн үр шимийг зөвхөн дээд боловсролтой цөөн өндөр настнууд хүртэж байна. Гэтэл тэтгэвэрт гарсан эмэгтэйчүүд асран халамжлах ажилд цаг заваа зориулсаар байгаа нь Төв аймагт хийсэн бүлгийн ярилцлагаас харагдсан юм. Хүүхэд асрах үйлчилгээ хангалтгүй байгаа нөхцөлд сургуулийн өмнөх насны хүүхдийг асарч буй тэтгэврийн насны эмэгтэйчүүдэд нарт хувьсах зардал олгох зэрэг шинэлэг, үр өгөөжтэй арга хэмжээ хэрэгжүүлбэл сургуулийн өмнөх боловсролын байгууллагын ачааллыг бууруулахын зэрэгцээ тэтгэврийн эмэгтэйчүүдийн ядуурлыг бууруулахад хувь нэмэр оруулна.


Ажилгүйдлийн дүр зургийг газар зүйн байршлаар авч үзвэл сүүлийн 10 жилд нийслэлд ажилгүйдэл ихэсч, хөдөө орон нутагт буурчээ. Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо улс даяар буурах хандлагатай байгаа (Дүрслэл 10) нь ажилгүйдэл буурсантай биш, харин шилжих хөдөлгөөний улмаас Улаанбаатарт ирсэн эмэгтэй эрэгтэйчүүд бүртгүүлэх боломжгүй байгаатай холбоотой байж болох талтай.

<sup>15</sup>ХЭҮК. 2014. Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 13 дахь илтгэл. Улаанбаатар.

<sup>16</sup>Singh, G. 2017. *Urban Poverty in Ulaanbaatar: Understanding the Dimensions and Addressing the Challenges*. Washington, D.C.: World Bank. <http://pubdocs.worldbank.org/en/459481506972842865/Urban-Poverty-in-Ulaanbaatar-Final-20170810.pdf>

<sup>17</sup>World Bank. 2018. *Perceptions of Precariousness: A Qualitative Study of Constraints Underlying Gender Disparities in Mongolia's Labor Market*. <https://www.worldbank.org/en/country/mongolia/publication/perceptions-of-precariousness-a-qualitative-study-of-constraints-underlying-gender-disparities-in-mongolia-labor-market>

**Дүрслэл 10. Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 2008 ба 2018 онд, хүйсээр**



Эх үүсвэр: ҮСХ. 1212.мн

Гэвч эмэгтэй эрэгтэйчүүдийн ажилгүйдлийн зураглалыг орон нутаг, байршлаар нарийвчлан харуулсан тоо мэдээлэл хангалтгүй байна. Ажилгүйдлийн дүр зураг/зураглал орон нутаг бүрт харилцан адилгүй байж болзошгүй байна. Жишээ нь 2014 онд хийсэн судалгаагаар Увс аймагт сумын төвд ажилгүйдэл их байгаа нь<sup>18</sup> харагдсан бол Баянхонгор аймгийн бүртгэлтэй ажилгүйчүүдийн 89.5 хувь нь аймгийн төвд<sup>19</sup> байжээ. Бүлгийн ярилцлагуудаас үзэхэд суурин газарт эмэгтэйчүүдэд төрийн болон хувийн хэвшлийн байгууллагад үйлчилгээний ажил олдох нь арай элбэг байдаг бол эрэгтэйчүүдэд ажил олдохгүй байна. Нөгөө талаас эрэгтэйчүүд орон нутагт шинээр гарч буй хөдөлмөр эрхлэх боломжийг ашиглахгүй байна.

**Шигтгээ 3.**

**Орон нутаг дахь эрэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал**


Орон нутагт ноос угаах үйлдвэрүүд баригдаж ажлын байр гарсан. Гэтэл одоо орон нутгийн эрэгтэйчүүдийг татаж ажиллуулах хамгийн хэцүү асуудал болж байна. Цалин асуугаад л бильярд тоглоод, ажилгүй байцаадаг. Ажиллагчдын дунд эрэгтэйчүүдийн тоо жилээс жилд буурч байна. Ажилд орсон ч удаан тогтодоггүй, нэг хялгас самнах үйлдвэрт хагас жилийн дотор 1000 хүн орж гарсан тооцоо байна.

Эх үүсвэр: Орон нутаг дахь ноос угаах үйлдвэрийн захиралтай хийсэн ярилцлага

Эмэгтэй эрэгтэйчүүдийн хөдөлмөрийн хуваарь, түүнд гарч буй өөрчлөлтийн талаарх чухал мэдээллийг агуулсан Цаг ашиглалтын судалгааг ҮСХ-ноос 2007, 2011, 2015 онуудад хийж тайлагнасан нь эдийн засгийн хүрээнд хийх жендэрийн дүн шинжилгээнд ашиглах мэдээллийн чухал эх үүсвэр болж байна. Эдгээр тайлангаас үзэхэд найман жилийн хугацаанд Монгол Улсад эмэгтэй эрэгтэйчүүдийн хөлстэй ажилд зарцуулах цаг нэмэгдэж, харин хөлсгүй ажилд зарцуулах цаг нь багасгах хандлагатай байна. Хөлсгүй ажил буюу өрх гэрийн ажил, өрхийн гишүүдийг асрах, бусдад туслахад зарцуулж буй цаг 8 жилийн хугацаанд хотын эмэгтэй эрэгтэй хүмүүсийн хувьд адил хэмжээгээр буюу 0.3 цагаар хорогдсон бол хөдөөгийн эрэгтэйчүүдийн хувьд 0.5, харин эмэгтэйчүүдийн хувьд 1 цагаар хорогдсон байна. Энэ нь гэр орны хөдөлмөр хөнгөвчлөх цахилгаан хэрэгслийн хэрэглээ нэмэгдсэний эерэг үр нөлөө байж болох ч нөгөө талаас хөдөөд малын түүхий эдээ боловсруулан хэрэглэх байдал нь багассантай холбоотой байж болзошгүй тул цаашид нарийвчлан судлах шаардлагатай байна.



**Дүрслэл 11.** Долоо хоногийн ажлын нэг өдөрт хүн амын хөлстэй, хөлсгүй ажил эрхлэх үйл ажиллагаанд зарцуулсан дундаж цаг 2007, 2011, 2015 онуудад, хүйсээр, хот хөдөөгөөр




Эх үүсвэр: ҮСХ. 1212.мн

**Цалин хөлс.** Монгол Улс нь Тэгш шан хөлс олгох тухай НҮБ-ын 100-р конвенци (1969) –д нэгдэн орсон орны нэг бөгөөд Хөдөлмөрийн тухай Монгол Улсын хуулинд адил хөдөлмөр эрхэлж байгаа эрэгтэй, эмэгтэй ажилтанд адил хэмжээний цалин хөлс тогтооно (49.2) хэмээн заасан ба Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулинд ч энэ заалт бий. ОУХБ-аас адил (ижил) үнэ цэнэ бүхий өөр төрлийн ажил хийсэн хүмүүсийн хөдөлмөрийг адил тэгш үнэлэх тухай конвенцийн зарчимд нийцүүлэхийг зөвлөдөг.<sup>20</sup>

Монгол Улсын нийт ажиллагчдын сарын дундаж цалин 2005 онд тухайн үеийн ханшаар 83.9 ам доллар байснаа 2018 онд 379.3 ам. доллар болж өссөн боловч эмэгтэйчүүдийн дундаж цалин эрэгтэйчүүдийнхээс доогуур байж ирсэн. Эмэгтэйчүүдийн дундаж цалин 2018 онд эрэгтэйчүүдийн дундаж цалингийн 82.1 хувь байгаа нь дэлхийн дундажаас (72 хувь) дээгүүр боловч (Зүүлт тайлбар 2) 2005 оныхтой харьцуулахад доошилсон байна (Дүрслэл 12).

**Дүрслэл 12.** Эмэгтэйчүүдийн дундаж цалингийн эрэгтэйчүүдийнхэд эзлэх хувь, 2005-2018 онд



Эх үүсвэр: ҮСХ. 1212.мн

<sup>20</sup> ILO. 2014. Application of International Labour Standards 2014 (I). Report III (part 1A). Reports Convention 103rd Session App of International Standards 2014-103-1A. Geneva: ILO. [https://www.ilo.org/wcmsp5/groups/public/--ed\\_norm/--relconf/documents/meetingdocument/wcms\\_235054.pdf](https://www.ilo.org/wcmsp5/groups/public/--ed_norm/--relconf/documents/meetingdocument/wcms_235054.pdf)

Энэ хугацаанд эрэгтэйчүүд зонхилж буй уул уурхайн салбарт цалингийн өсөлт голлож ирсэн бөгөөд сүүлийн 3 жилд боловсруулах үйлдвэрийн цалин эрчимтэй өсөх хандлагатай байна. 2016-2017 оны хооронд мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагааны салбарынх 23.9 хувь буюу хамгийн их өссөн байхад эмэгтэйчүүд зонхилон ажиллаж буй боловсролын салбарт ажиллагчдын дундаж цалин 1.1 хувь буюу хамгийн бага өсжээ.<sup>21</sup> Уул уурхайн салбарт захиргааны ажил, хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас агнуурын салбарт мэргэжлийн өндөр ур чадвар шаардсан ажил хийж, үйлдвэрийн оператор, угсрах төхөөрөмж ажиллуулж буй, мөн олон улсын байгууллагад ажиллаж буй эмэгтэйчүүдийг эс тооцвол бусад бүх салбарт тэдний дундаж цалин эрэгтэйчүүдийнхээс доогуур байна.<sup>22</sup> Цалин хөлсний ийм ялгаа мэдээлэл технологийн салбарт (86 хувь), мөн санхүү, даатгалын салбарт (78 хувь) хамгийн их байна (Зүүлт тайлбар 13). Аж ахуйн нэгжийн хэмжээгээр авч үзвэл 200 ба түүнээс дээш ажиллагчтай байгууллагуудад цалин хөлсний жендэрийн зөрүү хамгийн их, харин 10-49 ажиллагчтай байгууллагуудад хамгийн бага байна. Улаанбаатар хотод 100-гаас дээш ажилтантай байгууллагуудын цалин хөлсний жендэрийн зөрүү илүү өндөр буюу эмэгтэйчүүдийн цалин эрэгтэйчүүдийн цалингийн 77.2 хувь байна (Зүүлт тайлбар 22).

Цалин хөлсийг тогтмол, цагт нь олгож буй эсэх нь ялангуяа хувийн хэвшлийн ажиллагчдын хувьд цалингийн хэмжээнээс дутахгүй чухал асуудал болж байна. Жишээ нь барилгын компаниуд нэг талаас санхүүжилтийн графикаас, нөгөө талаас борлуулалтын хэмжээнээс шалтгаалан цалингаа тогтмол олгож чадахгүй байгаа нь барилгын салбарын ажил олгогчидтой болон барилгад улирлын ажил хийдэг гэр хорооллын эрэгтэйчүүдтэй хийсэн фокус бүлгийн ярилцлагуудаас харагдлаа. Цалин хөлс тогтмол олгогдохгүйгээс айл өрхүүд хэрэглээний зээлийн тойрогт орж, гэр бүл дэх зөрчил маргаан нэмэгдэн өрх гэрээ тэжээх үүрэг хүлээж буй ажиллагчид илүү дарамт стрессэд орж байгаагийн дотор өрх толгойлсон ганц бие эцэг эхчүүд хамгийн хүнд байдалд ордог байна.

Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн чухал хэсгийг бүрдүүлж буй газар тариалан, барилга зэрэг салбарууд, мөн эдийн засгийн чухал салбар болгон хөгжүүлэхийг зорьж буй аялал жуулчлалын салбар дахь улирлын ажлыг жендэрийн өнцгөөс нарийвчлан судлах шаардлагатай байна. Жишээ нь барилгын салбарт эрэгтэйчүүдэд өвлийн улиралд өөр ажил олдох нь элбэг бол эмэгтэйчүүд голцуу халагддаг байна. Энэ асуудлыг мөн аялал жуулчлалын хөгжилд анхаарч орон нутгийн ажиллагчдыг жилийн турш тогтвортой орлоготой байлгах арга замыг олох шаардлага тулгарч байна.

### Шигтгээ 3.

#### Улирлын ажил ба шилжих хөдөлгөөн

*Би Хөвсгөл аймгийн Хатгал сумаас ирсэн. Манай нутаг сайхан ч ажил олдохгүй болохоор Улаанбаатарт ирээд таксинд явж байна. Сүүлийн үед Хатгалд жуулчны баазууд олишрч ажлын байр гарсан. Өөр ажлын байр гарахгүй байна. Жуулчны бааз зуны 2-3 сар л ажиллуулдаг. Улаанбаатарт агаар бохир, байхад хэцүү ч өөр аргагүй болохоор ирсэн*

*Эх үүсвэр: Хувиараа таксийн үйлчилгээ эрхэлж буй залуу эрэгтэйтэй хийсэн ярилцлага*

**Өндөр насны тэтгэвэр:** Өндөр насны тэтгэвэр нь хөдөлмөр эрхлэлтээс хүртэх шууд үр өгөөж бөгөөд өндөр настан эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн амьдралын гол төлөв цор ганц эх үүсвэр байдаг. Эмэгтэйчүүдийн эрт тэтгэвэрт гаралт болон тэтгэврийн хэмжээ нь ахимаг насны эмэгтэйчүүдийн ядуурлын шалтгаан болж байна.<sup>23</sup> Эмэгтэйчүүдийг албан тушаал дэвшихэд саад бологч "шилэн тааз" мөн эмэгтэйчүүдийн тэтгэврийн хэмжээнд нөлөөлж байна. 2015 оны байдлаар эмэгтэйчүүдийн дундаж тэтгэврийн хэмжээ эрэгтэйчүүдийнхээс 18.6 хувь доогуур байжээ.<sup>24</sup> Эмэгтэйчүүдийн бодит тэтгэвэр ийнхүү доогуур байгаагаас гадна тэжээгчээ алдсаны тэтгэвэр нь өчүүхэн бага байна.<sup>25</sup> 2018 оны байдлаар нийт өндөр насны тэтгэвэр авагчдын 29 хувь нь эрэгтэйчүүд, 71 хувь нь эмэгтэйчүүд<sup>26</sup> байгаагаас эмэгтэйчүүд илүү удаан хугацаагаар, нийт дүнгээрээ илүү тэтгэвэр авч байна гэх ойлголт байдаг. Гэвч эдгээр эмэгтэйчүүдийн олонхи нь гэр бүлдээ асран халамжлагчийн, тэр ч байтугай тэжээгчийн үүрэг гүйцэтгэсээр байдгийг анхаарах нь зүйтэй.

Хятад, Вьетнам, Тайланд, Индонези, Өмнөд Солонгос, Малайз, Филиппин болон Монгол Улс дахь эмэгтэй эрэгтэйчүүдийн тэтгэврийн харьцуулсан шинжилгээгээр Монгол Улсад тэтгэврийн зөрүү харьцангуй бага, хамрах хүрээ хамгийн өргөн байна. Харин Монгол Улсад тэтгэврийг олон жилээр индексжүүлээгүй нь инфляцийн нөхцөлд эмэгтэйчүүдийг илүү эрсдэлд оруулж байгааг уг баримтад онцолжээ. Мөн хөдөлмөр эрхлээгүй

<sup>21</sup> YCS. 2018. Аж ахуйн нэгж байгууллагын ажиллагчдын дундаж цалин-2017. Улаанбаатар

<sup>22</sup> Bradley, O. 2017. Education in Mongolia. The Blog. The Borden Project, October. [www.bordenproject.org/education-in-mongolia/](http://www.bordenproject.org/education-in-mongolia/)

<sup>23</sup> Suren, U. 2014. Gender equality and decent work priority and capacity review of ILO constituents and gender and human rights organizations in Mongolia. ILO Consultant Report. Ulaanbaatar.

<sup>24</sup> MLSP. 2017. The Law on the Promotion of Gender Equality, National Program on Gender Equality and its Action Plan (2017-2021). Ulaanbaatar.

<sup>25</sup> O'Keefe, P.B. and A. Chłoń-Domińczak. 2016. The "gender pension-gap" in the aging societies of East Asia: a policy note from the East Asia and Pacific umbrella facility for gender equality. Washington, D.C.: World Bank Group.

<sup>26</sup> YCS. 2018. Ахмад настны нийгэм эдийн засгийн зарим үзүүлэлтийн судалгаа. Улаанбаатар.

эмэгтэйчүүдийн тэжээгчээ алдсаны тэтгэвэрийн хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатайг зөвлөсөн байна.<sup>27</sup>

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулинд 2018 онд орсон өөрчлөлтийн дагуу эмэгтэй, эрэгтэй хүмүүс 65 нас хүртлээ ажиллах боломж нээгдэхийн зэрэгцээ 20-иос доошгүй жил шимтгэл төлсөн бөгөөд 60 нас хүрсэн эрэгтэй, 55 нас хүрсэн эмэгтэй даатгуулагч өөрөө хүсвэл өндөр насны тэтгэвэр авч болох сонголт бүрджээ. Энэ нь ахимаг насныхны, түүний дотор эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, орлогын түвшинд эерэг нөлөөтэй. Харин эмэгтэйчүүд өөрийн сонголт, хүслээр биш, ажил олгогчдын шахалтаар эрт тэтгэвэрт гарах үзэгдэл цөөнгүй байгааг цаашид анхаарч, сэргийлэх арга хэмжээ авах шаардлагатай.

**Ажлын орчин.** Эмэгтэй эрэгтэй хүмүүсийн ажиллах орчин тэдний ялгаатай хэрэгцээнд нийцсэн, ажил-ар гэрийн амьдралын тэнцвэрийг дэмжсэн байх нь ажлын үр бүтээмжид төдийгүй гэр бүл, нийгмийн сайн сайханд тустай. Гэтэл өнөөдөр ажлын байр баталгаагүй, эрүүл мэнд, нийгмийн даатгалд хамрагдаж чаддаггүй байдал хувийн хэвшлийн салбарт нийтлэг байна. Эмэгтэй ажиллагчид ажлын цаг нь хангалттай уян хатан биш гэж үзэх нь нийтлэг<sup>28</sup> байгаагаас гадна 2010 онд хийсэн судалгаагаар<sup>29</sup> төсөвт байгууллагад илүү цагаар ажилласан эмэгтэйчүүдийн тоо эрэгтэйчүүдийнхээс 2.6 дахин их байжээ. Энэ нь төсвийн байгууллагуудад эмэгтэйчүүд гол төлөв гүйцэтгэх албан тушаалд ажиллаж байгаагаас улбаатай боловч мөн ажлын ачааллын хуваарилалт жигд бус, “хийж чадаж байгаа ажилтанд илүү их ажил хуваарилах” бичигдээгүй дүрэм үйлчилж байгаатай холбоотой.

Харин долоо хоногт дунджаар 60-аас дээш цаг ажиллагчдын хувьд хот суурин газарт үйлдвэрлэлийн салбарт ажиллагчид илүү байгаа бөгөөд голцуу эрэгтэйчүүд байна.<sup>30</sup> Ажил-ар гэрийн тэнцвэр алдагдах нь эмэгтэй эрэгтэй хүмүүсийн хэн хэнд хохиролтой ч үр дагавар нь ялгаатай. Тухайлбал эмэгтэйчүүдийн гэр орны ажилд зарцуулах цаг багасч ажлын ачаалал нэмэгддэг бол эрэгтэйчүүдийн гэр бүлийнхээ амьдралд оролцох боломж хязгаарлагддаг. Сүүлийн жилүүдэд уул уурхай, тээврийн салбарт эрэгтэйчүүд жасаагаар буюу тодорхой хугацаанд гэр бүлээсээ хол ажиллах болсноор эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн эрсдэл нэмэгдээд зогсохгүй гэр бүлийн харилцаанд сөргөөр нөлөөлөх үзэгдэл ажиглагдаж байна.

Уул уурхай, барилга, тээврийн салбарт ажиллагч эмэгтэйчүүдийн эзлэх хувь нэмэгдэхгүй байгаа нь нэг талаас тэдгээр салбарыг эрэгтэйчүүдийнх гэж тооцдог хэвшмэл ойлголт, ажил олгогчдын эрэгтэйчүүдийг авч ажиллуулах сонирхол нөлөөлж байгаа ч, эмэгтэйчүүдэд зориулсан бие засах газар, хувцас солих өрөө зэрэг наад захын орчин нөхцөл бүрдээгүйтэй мөн холбоотой байна.<sup>31</sup> Компаниудын 60 хувь нь ажиллагчдын аюулгүй ажиллагаа болон нийгмийн халамжийн асуудлыг бодлогодоо тусгадаггүй нь дээрх байдлын үндэс болж байна.<sup>32</sup>

Эрэгтэйчүүд зонхилсон салбарт ажиллаж буй эмэгтэйчүүдийн ажлын орчин нөхцөл анхаарлаас гадна үлддэгийг “эрэгтэйчүүдийн” гэж уламжлал ёсоор тооцогддог барилгын салбарын жишээ харуулж байна. Бодит байдал дээр тус салбарт ажиллагчдын 40 орчим хувийг эмэгтэйчүүд бүрдүүлж, гол төлөв дотоод заслын багууд байгуулан ажиллаж байна. Бараг дан эмэгтэйчүүдээс бүрдсэн тэдгээр багууд барилгын гүйцэтгэгч компанитай гэрээ байгуулан ажилладаг ч ажлын хөлсөө бүрэн авч чадахгүй өнгөрөх нь түгээмэл болохыг бүлгийн ярилцлагад оролцсон барилгачин эмэгтэйчүүд ярьсан юм.

#### Шигтгээ 4.

##### Барилгын салбар дахь эмэгтэйчүүдийн хөдөлмөр



*Би сантехник, салхивчийн инженер мэргэжилтэй, анх барилгын цэргээс эхлээд барилгад 33 жил ажиллах хугацаандаа 27000 км нимгэн төмөр цохисноо тооцсон. Үүнийг надаас өөр хэн ч мэдэхгүй. Хөдөө жуулчин шиг л явж ажилладаг. Цагаан зээр шиг л нутаггүй юм шиг явдаг. Би цас орж байхад траншей ухаад мөлхөж, худаг дотор ганцаараа холболт хийж л явлаа. Эмэгтэйчүүд хөнгөн ажил хийдэг гэж боддог, гэтэл үнэндээ барилгын дотор гадар ялгаагүй ажиллаж таардаг.*

*Эх үүсвэр: Дотоод заслын багийн ахлагч, инженер эмэгтэйтэй хийсэн ярилцлага*

<sup>27</sup> EAP Gender. 2018. *The Gender Pension Gap in the Aging Societies of East Asia*. <https://openknowledge.worldbank.org/handle/10986/26422>

<sup>28</sup> Sureн Ахим Шмилэн, Нина-Вейман Сандиг. 2018. *Хөдөлмөр эрхлэлтийн баталгаагүй байдлын дүр зураг: Монгол Улсын хөдөлмөрийн зах зээл дэх жендэрийн тэгш бус байдлын талаарх чанарын судалгаа*. Вашингтон. Дэлхийн банк.


<sup>29</sup> УСХ, НХХЯ, ОУХБ. 2010. *Цалин хөлсний бүтцийн туршилтын судалгаа*. Улаанбаатар.

<sup>30</sup> Улсын бүртгэл статистикийн ерөнхий газар. 2016. *Хөдөлмөрийн зах зээлийн үндсэн үзүүлэлтүүд*. Улаанбаатар.

<sup>31</sup> MoH and WHO. 2017. *Mongolia-WHO Cooperation Strategy 2017-2021*. World Health Organization. Ulaanbaatar.

<sup>32</sup> Санхүүгийн зохицуулах хороо, Монгол Улсын Компанийн Засаглалын үндэсний зөвлөл. 2015. *Монгол улсын компанийн засаглалын үндэсний тайлан*. Улаанбаатар.

### Дүрслэл 13. Барилга, хот байгуулалтын салбарын жендэрийн мэдрэмжтэй бодлогын цикл



Эх үүсвэр: Барилга, хот байгуулалтын салбарт жендэрийн талаар баримтлах бодлого (2018-2025)

Ажлын орчин нөхцөл жендэрийн мэдрэмжтэй байхын тулд эмэгтэй эрэгтэйчүүдийн ялгаатай хэрэгцээнд нийцсэн, гэр бүлд ээлтэй байхаас гадна дарамтгүй, нээлттэй, олон янз байдлыг хүлээн зөвшөөрсөн байгууллагын соёл бүрэлдэхийг шаарддаг. Олон хүмүүс өөрийн ажлын байрыг хэт хуучинсаг, уламжлалт, олон шат дараалалтай, заримдаа бүр захиргаадалтын ёс зүй, хэм хэмжээнд баригддаг гэж үзжээ. Менежерүүд, ажил олгогчдоос айх, тэдэнд үл итгэх байдал түгээмэл байна (Зүүлт тайлбар 29). 2017 онд худалдаа үйлчилгээ, ноос ноолуурын салбарт хийсэн судалгааны дүнгээс харахад хүйсийн хувьд эмэгтэйчүүд, насны хувьд 18-30 насны залуучууд, мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэд илүүтэй дарамтад өртдөг байна.<sup>33</sup>

ЖЭТБХХөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд “Хувийн хэвшлийн байгууллагад жендэрийн тэгш байдлыг хангах төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх удирдамж” боловсруулан нэвтрүүлж, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн тэнхимийн онцлох аж ахуйн нэгж шалгаруулахад жендэрийн тэгш байдлын талаарх үзүүлэлт тусгахаар ажиллаж байна.

Монгол Улсаас гадаад улс оронд ажиллагчдын дийлэнх нь 30 хүртэлх насны эрэгтэйчүүд байгаа ба сүүлийн жилүүдэд ажиллах хүч гэрээлэн авах чиглэлээр хамтран ажиллаж буй улс орнууд эрэгтэйчүүдийг авч ажиллуулах сонирхолтой байгаа нь хөдөлмөр эрхлэлт дэх жендэрийн тэгш бус байдлыг гүнзгийрүүлээд зогсохгүй нөхөн үржихүйн насны хүн амын хүйсийн тэнцвэрийг алдагдуулах, гэр бүлийн харилцаанд сөргөөр нөлөөлөх хор хөнөөлтэй байна.

Малчдын ажил амьдралын хэв маягт мөн жендэрийн хувьд сөрөг үр дагавар бүхий өөрчлөлт гарч байна. 2007 оноос 6 настай хүүхдийг сургуульд авдаг болсноор малчин гэр бүлийн олон эмэгтэйчүүд хүүхдээ сургахын тулд аймаг, сумын төвд амьдарч, эрэгтэйчүүд дангаар малаа маллах байдал хөдөөд түгээмэл болоод байна. Сүүлийн жилүүдэд малчдын хүүхдийн сургуульд орох насыг 6-8 байж болохоор зохицуулалт хийсэн ч энэ нь нэгэнт сургуульд орсон хүүхдийн гэр бүлд гарсан өөрчлөлтийг хэрхэн залруулах болон цаашид малчдын сонголтод хэр нөлөөлөх нь тодорхойгүй байна.

Салбаруудын жендэрийн бодлогод ажиллагчдын ажлын орчин нөхцийг сайжруулах, жендэрийн мэдрэмжтэй болгох асуудлыг тусгай зорилт болгон дэвшүүлж байгаагийн дотор жишээлбэл хувийн хэвшил давамгайлсан барилга, хот байгуулалтын салбарт жендэрийн талаар баримтлах бодлогын хүрээнд хүн төвт, нийгмийн хариуцлагат удирдлагын арга барил, стандартыг нэвтрүүлэх нь жендэрийн мэдрэмжтэй ажлын орчныг бий болгох гарц хэмээн үзсэн байна (Дүрслэл 13).

Хэдийгээр ЖЭТБХТ хууль, түүнийг дагалдан гарсан Засгийн газрын дунд хугацааны стратегид хөдөлмөр эрхлэлтэд жендэрийн тэгш байдлыг хангах талаар тусгасан боловч төр, хувийн хэвшлийн байгууллагууд тэдгээр заалтыг мэдэхгүй хэвээр байна. Ажил олгогч, ажиллагчид хамгийн сайн мэдэж, ойлгодог бөгөөд хэрэгжилтэд нь мониторинг хийгддэг Хөдөлмөрийн тухай хууль, мөн Нийгмийн халамжийн тухай хуулийг ЖЭТБХТХ-тай уялдуулах хэрэгцээ байсаар байгаа ба одоогоор Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд ЖЭТБХТХ-ийн зарчмуудыг тусгахаар санал оруулсан байна.

## В Бизнес эрхлэлт

Монгол Улсын дотоодод үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний нэр төрөл олшрон чанар дээшилж, бизнесийн байгууллагуудын тоо нэмэгдсээр байна. Бизнес эрхлэлтийн хүрээнд жендэрийн хувьд ЖДҮ хамгийн их анхаарал татсан бизнесийн хэлбэр юм. Нийт аж ахуйн нэгжийн 98 хувийг, ДНБ-ний 25 хувийг ЖДҮ бүрдүүлж, ажиллах хүчний тал хувийг ажлын байраар хангаж байгаа ба үйлчилгээ (34 хувь), худалдаа (37 хувь), үйлдвэрлэлийн (21 хувь) салбарт голлон үйл ажиллагаа явуулж байна.<sup>34</sup> Бизнесийн томоохон байгууллагад эрэгтэйчүүд давамгайлж, харин жижиг дунд үйлдвэрлэлийн (ЖДҮ) 64 хувийг эмэгтэйчүүд эзэмшиж байна.<sup>35</sup>

*Дараах үзүүлэлтүүдийн дор хаяж нэгийг хангасан бизнесийг ОУВС-аас эмэгтэйчүүд эзэмшиж буй бизнес хэмээн тодорхойлж байна. Үүнд: нэгдүгээрт, эмэгтэйчүүд бизнесийн дор хаяж 50 хувийг эзэмшиж буй, хоёрдугаарт, ахлах менежерүүдийн дор хаяж 60 хувь нь эмэгтэйчүүд, гуравдугаарт, гэрээ бүхий ажиллагчдын дор хаяж 50 хувь нь эмэгтэйчүүд байх.<sup>36</sup> Харин эмэгтэйчүүд оролцсон бизнесийн байгууллагад зээлийн хөнгөлөлт үзүүлэх туршлагыг анхлан нэвтрүүлж буй Хас банк нь зээл хүсэгч байгууллагын 51-ээс дээш хувийг эмэгтэйчүүд эзэмшдэг байх, удирдлагын багт эмэгтэй захирал ажилладаг байх, байгууллагын удирдлагын шийдвэр гаргахад 30-аас доошгүй хувьд нь эмэгтэйчүүд оролцдог байх гэсэн тусгай шалгуурууд ашиглаж байна.*

Нийт ЖДҮ-ийн 80 хувь нь бичил бизнес бөгөөд талаас илүү нь нийслэлд төвлөрч, харин хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрийн салбарт ажиллаж буй ЖДҮ-гийн эзлэх хувь бага, 15 хувиас хэтрэхгүй байна. ЖДҮ-ийн 50 орчим хувь нь банкны зээлтэй байгаагаас тэдний зөвхөн 13 хувь нь хөрөнгө оруулалтын зориулалтаар зээл авсан байна.<sup>37</sup> ЖДҮ нь эдийн засгийн өсөлт, ажлын байр бий болгох, ядуурлыг бууруулахад чухал үүрэгтэйг олон судалгаа нотолж байна. ЖДҮ-д 1 долларын хөрөнгө оруулалт хийхэд 10-12 долларыг эдийн засагт бий болгогчийг 2004 оны судалгаа харуулж байна.<sup>38</sup> Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь нэмэгдэж, 2005 онд 31 хувь байснаа 2018 онд 67.7 хувь болжээ. Өнөөдөр нийт ажил олгогчдын дунд эмэгтэйчүүд 30.8 хувийг эзэлж байна. Мал аж ахуй эрхлэгчдийн дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь 2012 оноос хойш буурсаар 2018 онд 42.8 хувь болоод байна.

Ерөнхийдөө Монгол Улсын бизнесийн орчин дорвитой сайжрахгүй байгааг 2017 онд хийсэн Монголын бизнесийн орчны үнэлгээгээр боломжит 7 онооноос 3.1 оноо авснаас харж болно. Үүнийг илүү нарийвчлан харвал Улаанбаатар хот болон баруун бүсэд бизнесийн орчин хамгийн таагүй байна.<sup>39</sup> ОУВС өндөр татвар, банкны үйлчилгээ авахад зарцуулах цаг урт, түрээс өндөр, ур чадвартай ажилчид байхгүй, санхүүгийн боломж хязгаарлагдмал, зээлийн нөхцөл тааламжгүй гэсэн түгээмэл бэрхшээл ЖДҮ-д тулгарч байна гэж үзэж байна.<sup>40</sup> Зохицуулалт хангалтгүй, засаглал сул байгаагаас банкууд өндөр барьцаа шаарддаг бол хувийн хэвшлийн банк санхүүгийн байгууллагуудын зээлийн хүү хэт өндөр байна.<sup>41</sup> Түүний дотроос бизнес эрхлэхэд эмэгтэйчүүдэд тулгарч буй бэрхшээлийн талаар сүүлийн судалгаа шинжилгээнд гаргасан дүгнэлтүүдэд бизнесийн болон удирдлагын арга туршлага, мэдээлэл, танилын сүлжээ эмэгтэйчүүдэд дутмаг, цагийн хомсдол их, эмэгтэйчүүдийг хувийн хэвшилд манлайлахад соёлын хэм хэмжээ садаа болж<sup>42</sup> байгаагаас гадна барьцаа үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө байхгүйн улмаас санхүүгийн үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байна гэж үзэж байна. Мөн банкууд эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн үүргээс үүдэн тэдэнд хийх хөрөнгө оруулалтын эрсдлийг өндөр гэж үзэх хандлагатай байдаг нь мөн саад бэрхшээл болж байна.<sup>43</sup> ЖДҮ-д хийх хөрөнгө оруулалт санхүүгийн дэмжлэг хүртээмжгүй байгаагийн нэг шалтгаан нь ЖДҮ-гийн цар хүрээ хэт өргөн байгаа явдал юм.

Орхон, Сэлэнгэ аймагт газар тариалан эрхлэгчид эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдтэй хийсэн бүлгийн ярилцлагуудаас газар тариалан эрхлэлтийг дэмжих сангийн дэмжлэг эмэгтэйчүүд болон залуучуудад хүртээмж багатай байгаа нь харагдсан.<sup>44</sup> Эмэгтэйчүүдийн бизнес илүү жижиг, эргэлт багатай, цөөн ажилчинтай байна. Эдгээр бизнес нь мөн дэд бүтэц буюу ус, ариун цэврийн төхөөрөмж, цахилгаан, халаалтаас ихээхэн хамааралтай, гэтэл хотын гэр хороолол болон хөдөөд эдгээр нь хязгаарлагдмал байна.

<sup>34</sup> УСХ. 2017. *Аж ахуйн нэгж, байгууллагын тоо, бүтцийн өөрчлөлтийн дүн шинжилгээ*. Улаанбаатар.

<sup>35</sup> OPIC. 2017. "OPIC, IFC, and XacBank. Supporting Women-owned Businesses in Mongolia. Opic Media. June. <https://www.opic.gov/press-releases/2017/opic-ifc-and-xacbank-supporting-women-owned-business-es-mongolia>

<sup>36</sup> ADB. 2014. *Gender Toolkit for Micro, Small, and Medium-Sized Enterprise Finance and Development*. Manila.

<sup>37</sup> Хүний хөгжил судалгаа сургалтын төв ТТБ. 2018. *Монгол Улсын хөгжлийн санхүүжилтийн үнэлгээ: Тогтвортой хөгжлийн санхүүжилтийг төрөлжүүлэх нь*. Улаанбаатар.

<sup>38</sup> M. Makhene. 2010. *Honey Pot in Africa's Missing Middle- Investing in SMEs*. Skoll Foundation Archives, September 23. <http://archive.skoll.org/2010/09/23/honeypot-in-africas-missing-middle-investing-in-smes/>

<sup>39</sup> МХАҮТ. 2017. *Монголын бизнесийн орчны үнэлгээ*. Улаанбаатар.

<sup>40</sup> ADB. 2016. *Technical Assistance on Gender-responsive Sector and Local Development Policies and Actions, financed by the Government of Japan*. Manila

<sup>41</sup> JICA. 2013. *Country Gender Profile: Mongolia. Final Report*. JICA and Intem Consulting

<sup>42</sup> European Bank for Reconstruction and Development (EBRD). 2017. *Strategy for Mongolia*. EBRD.

<sup>43</sup> Олон улсын санхүүгийн корпорац. 2013. *Монгол дахь зөвлөх үйлчилгээ. Компанийн засаглалын үнэлгээний тайлан 2011*. Улаанбаатар.

Гэвч сүүлийн үед бизнес эрхлэлтийн хүрээнд, ялангуяа орон нутгийн түвшинд тулгамдаж буй асуудал бол эрэгтэйчүүдийн оролцооны асуудал юм. Монгол Улсад эмэгтэйчүүдийн бизнес эрхлэлт нь голцуу гэр бүл, түүний дотор нөхөр, хамтран амьдрагчаасаа хамааралтай байгаа нь бүлгийн ярилцлагуудаас харагдсан. Жендэрийн хэм хэмжээ өөрчлөгдөөгүй тохиолдолд зөвхөн эмэгтэйчүүдийн бизнес эрхлэлтийг дэмжих нь гэр бүлийн харилцаанд сөргөөр нөлөөлдгийг 1990 оны эхээр өрх толгойлсон эмэгтэйчүүдэд олгосон зээлийг авахын тулд гэр бүл салах хүртэл үзэгдэл гарч байсан сургамж харуулдаг. Тиймээс ялангуяа өрхийн үйлдвэрлэл, бичил үйлдвэрлэлийн түвшинд бизнесийн өмчлөл, үйл ажиллагаанд нэг гэр бүлийн эмэгтэй эрэгтэйчүүдийг хамтран оролцохыг дэмжих нь зүйтэй байна.

### Шигтгээ 5.

#### Орон нутгийн бизнес эрхлэлт дэх жендэрийн асуудал

*Баялаг бүтээгчдийн чуулганд 300 хүн цуглахад 2-3 эрэгтэй хүн ирсэн. Орон нутагт эрэгтэйчүүд идэвхигүй байна. Гараараа юм хийх, амьдралаа өөрөө авч явахад эрэгтэй хүүхдүүдийг гэр бүл, сургууль ч сургахгүй, төр засаг, орон нутгийн бодлогод ч энэ талаар байхгүй байна уу гэж санагддаг. Амжилттай сайн яваа эрэгтэйчүүд олон ч боловсролоор хоцрогдсон эрчүүдийг хүн болгодог жишээ нь урьдын арми шиг зүйл дутагдаад байна.*

*Эх үүсвэр: Дорноговь аймгийн өрхийн үйлдвэрлэл эрхлэгч эмэгтэйн ярилцлага*

Мөн ЖДҮ-ийн хөгжилд садаа болж буй макро түвшний хүчин зүйлсийн нөлөөг жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлтийн хүрээнд анхаарах хэрэгцээ тулгамдаж байна. Жишээлбэл өрх толгойлсон эмэгтэйчүүд олноор ажиллаж буй үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын бизнесийг татваргүй орж ирж буй төмс, хувцас зэрэг бүтээгдэхүүнтэй өрсөлдөх шаардлага, хөрш орнуудын гааль татварын бодлого ихээхэн хязгаарлаж байна гэж хүнс хөдөө аж ахуйн салбарын мэргэжилтнүүд үзэж байна. Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд чанар биш хямд үнийг илүүд үзсэн байдал нь нийслэл болоод орон нутгийн дундаж, түүнээс доош давхаргын эмэгтэйчүүд олноор ажиллаж буй оёдол, ноос ноолуур, нэхмэлийн салбарын хөгжлийг хязгаарлаж байна гэж бүлгийн ярилцлагад оролцогчид үзэж байлаа.

### Шигтгээ 6.

#### Хөдөөгийн бизнесийн хөгжилд тулгарч буй сорилт эмэгтэйчүүдийн нүдээр

*Жижиг, дунд үйлдвэр хөгжүүлэх боломжийг сүүлийн 5 жилд хэрэгжүүлсэн жилийн 8 хувийн хүүтэй ЖДҮ-ийг хөгжүүлэх сан, жилийн 2 хувийн хүүтэй Сум хөгжүүлэх сан, жилийн 8 хувийн хүүтэй Чингис бонд, мөн малчны хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлийн хөдөлмөр, нийгмийн хамгааллын хөнгөлөлттэй зээл, зарим төсөл хөтөлбөрийн үйл ажиллагаа санаачлагууд л бий болгож байна. Гэвч эдгээр арга хэмжээнүүд нь богино хугацаанд хэрэгждэг, урт хугацааны бодитой дэмжлэг бараг байхгүй байна. Тиймээс тогтвортой хөгжил, үр дүнг авчирч чадахгүй байна. Орон нутагт бизнесийн таатай нөхцөл бүрдүүлэх шаардлагатай байна Зах зээлд борлуулах боломжтой бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг кластераар хөгжүүлэх, жишээ нь сарлагийн сүү, ингэний сүү, ямааны сүү бэлтгэн нийлүүлэх, боловсруулах, маркетингийн төслүүдийг боломжтой газар хэрэгжүүлж загварчлах, нэг технологи, нэг загварын үйлдвэрийн байшин, хувийн секторын санаачлага, орон нутгийн засаг захиргааны дэмжлэг, эх оронч худалдан авалт, хэрэглээг дэмжсэн сурталчилгаа, үзэсгэлэн, худалдаа, мэргэшүүлэх, дадлагажуулах богино хугацааны сургалтууд зохион байгуулах нь зүйтэй.*

*Эх үүсвэр: Орон нутагт сүүний үйлдвэрлэл эрхлэгч эмэгтэйн ярилцлага*

## Г Дэд бүтцийн хөгжил

Эдийн засгийн хөгжлийг хүртээмжтэй болгох гол хүчин зүйл болсон дэд бүтцийн хөгжил нь хүн ам сийрэг суурьшсан өргөн уудам нутагтай монгол орны хувьд онцгой ач холбогдолтой бөгөөд эмэгтэй, эрэгтэйчүүдийн бизнес эрхлэлтийг дэмжин, амьдралын чанарыг сайжруулахад чухал үүрэгтэй. Монгол Улсын хувьд нийт ачаа тээвэрлэлтийн 57.8 хувийг, зорчигч тээвэрлэлтийн 98.4 хувийг авто замын тээврээр гүйцэтгэдэг. Ийм учраас Засгийн газраас 2020 он хүртэл 21 аймгийн төвийг нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбох стратегийн зорилтыг амжилттай хэрэгжүүлж байгаа нь хөдөө, орон нутгийн иргэдийн амьдралд ихээхэн хувь

нэмэр болж байгаагийн дотор жирэмсэн эмэгтэйчүүд, хүүхэд өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдралын чанарт өөрчлөлт орж байна. 2005 онд сайжруулсан авто замын нийт урт 6126,7 км, хатуу хучилттай авто замын урт 2278,6 км байсан бол байсан бол 2018 онд тус тус 10835.8 км, ба 9023.0 км болсон байна.

Гэсэн хэдий ч дэд бүтцийн хөгжил жигд бус, хүн амынхаа хэрэгцээг бүрэн хангахгүй хэвээр байна. Тухайлбал хүн ам хамгийн ихээр төвлөрсөн Улаанбаатар хот зам тээврийн салбарын төсвийн 30 хувь, эрчим хүчний салбарын төсвийн 20 хувь оногдож байгаа нь Улаанбаатарт тээврийн хэрэгслийн хурд сүүлийн 10 жилд хоёр дахин буурч, өвлийн улиралд гэр хорооллын оршин суугчид нүүрс галласаар агаарын бохирдол аюултай түвшинд хүрэх шалтгаан болсон гэж 2013 оны Дэлхийн банкны судалгаанд дүгнэжээ.<sup>46</sup>

Хотын нийтийн тээврийн үнэ, аюулгүй байдал, хүртээмж нь жендэрийн тэгш байдалд чухал нөлөөтэй. Тогтвортой хөгжлийн зорилго 11-д хотыг “хүртээмжтэй, аюулгүй, амар амгалан, тогтвортой” байлгахад тээврийн бодлогыг чухал ач холбогдолтой гэж үзсэн байдаг бөгөөд (11.2) 2030 он гэхэд “эмзэг бүлгийн хүн ам, эмэгтэйчүүд, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй болон өндөр настай хүмүүсийн хэрэгцээ шаардлагыг онцгой анхааран замын аюулгүй байдал, тухайлбал нийтийн тээврийг өргөжүүлэн сайжруулах замаар аюулгүй, хямд үнэтэй, хүртээмжтэй, тогтвортой тээврийн системийг хүн бүрт хүргэх”-ээр заажээ. ТХЗ 11-д мөн эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийн хотоор зорчих цаг, шалтгаан, арга хэлбэр ялгаатай, санхүүгийн нөөц боломж эмэгтэйчүүдэд хязгаарлагдмал байдгийг онцолсон байна.<sup>47</sup>

Энэ нь өрхийн төсвийн дунджаар 24-36 хувийг тээврийн зардалд зарцуулдаг хотынхон, нийтийн тээврийн хэрэгсэл хязгаарлагдмал цагаар үйлчилдэг хотын захад оршин суугчдын хувьд анхаарал татсан асуудал юм. Улаанбаатар хотын төв хэсгээр байрладаг үйлчилгээний газруудад залуу эмэгтэйчүүд олноор, шөнө оройн цагаар ажилладаг. Гэтэл алслагдсан дүүргүүдэд нийтийн тээвэр зөвхөн оройн 9 цаг хүртэл үйлчилж байгаа нь тэдэнд аюултай байдал үүсгэхээс гадна ийм байршилд амьдардаг хүмүүсийн хөдөлмөр эрхлэхэд садаа болж байна. Гэр хорооллын залуучуудтай хийсэн бүлгийн ярилцлагаар хувийн хэвшлийн байгууллагууд ажилд ороход алслагдсан хэсэгт амьдардаг бол татгалзсан хариу авах нь элбэг гэсэн юм.

Дэд бүтцийн хөгжил, хот төлөвлөлт, түүний дотор гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд нийтийн орон зай дахь эмэгтэйчүүд, хүүхдийн аюулгүй байдлын асуудлыг анхаарах шаардлагатай байгааг АХБ-наас 2017 онд гэр хороолол дахь жендэрт суурилсан хүчирхийллийн асуудлаар хийсэн шуурхай үнэлгээ харуулж байна.<sup>48</sup> Хүнсний зах, сургууль, дэлгүүр, мөн эрэгтэйчүүд цугларан архи уудаг газруудыг АХБ-ны үнэлгээнд оролцогчид аюултай гэж нэрлэсэн байна. Охид эмэгтэйчүүд гэр хорооллын дунд, нийтийн орон зайд, нийтийн тээврийн хэрэгслээр зорчих үедээ хүчирхийлэлд өртөх эрсдэл их байгаа тул гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд гудамж руу орох гарах нэмэлт гарцууд бий болгох, нарийн гудамжуудыг өргөтгөх, гэрэлтүүлгийг сайжруулах болон зарим шаардлагатай газрыг камержуулахын зэрэгцээ холбогдох салбарын эрх зүйн актуудад эмэгтэйчүүд охидыг хүчирхийллээс хамгаалах талаар тусгахыг АХБ-наас гаргаж буй баримт бичигт онцолсон байна.<sup>49</sup>

## Шигтгээ 7.

### *Дэд бүтэц ба эмэгтэйчүүд хүүхдүүдийн аюулгүй байдал*

*Хойноос дагаж мөшигч асуудал байдаг. Намайг хүртэл дагадаг. Би гар утасныхаа гэрлийг асааж чанга ярьдаг. Өөрийгөө ингэж л хамгаалдаг. (46-55 настай эмэгтэй)*

*Миний охин 57-р сургуульд сурдаг. Сургуулиасаа ирэхдээ холуур тойрч алхдаг. Учир нь товч зам нь гэрэлгүй харанхуй. Одоо зун болохоор гайгүй. Өвөл эрт харанхуй болоход л хэцүү (46-55 настай эрэгтэй)*

*Эх үүсвэр: ADB. 2017. Rapid Assessment of Gender-Based Violence in Urban Ger Area Communities. TA Consultant's report. Ulaanbaatar.*

Улаанбаатар хотын гэр хорооллыг гэрэлтүүлэгтэй болгох ажил сүүлийн жилүүдэд эрчимтэй хийгдэж, гудамжны эргүүл, хяналтын камертай болсноор амьдрах орчин сайжирч байна. Гэвч хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөн буурахгүй, хот улам хаяа тэлсээр байгаа тул зах хэсэгт гэрэлгүй гудамжууд байсаар байна.

Уул уурхайн ашиглалтын оргил үед орон нутагт хөдөлгөөнт хүн ам ихсэж, гэмт хэрэг, хүчирхийллийн эрсдэл

<sup>45</sup> Хөгжлийн замнал сан. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт жендэрийн талаар баримтлах бодлогын хүрээнд хийсэн Оролцоонд суурилсан жендэрийн үнэлгээний тайлангийн хураангуй.

<sup>46</sup> World bank. 2013. Mongolia: Improving public investment to meet the challenge of scaling up infrastructure. Poverty Reduction and Economic Management Sector Unit East Asia and Pacific Region

<sup>47</sup> EuroUN Chronicle. 2015. Goal 11-Cities Will Play an Important Role in Achieving the SDGs. UN Chronicle Vol. LI No. 4. April. <https://unchronicle.un.org/article/goal-11-cities-will-play-important-role-achieving-sdgs>

<sup>48</sup> ADB. 2017. Rapid Assessment (qualitative research) of Gender-based Violence in Urban Ger Area Communities Ulaanbaatar.

<sup>49</sup> ADB. 2018. Working paper series No. 14. Translating Women's Voices into Action in Mongolia: Addressing Gender-Based Violence through Investments in Infrastructure. Ulaanbaatar.

нэмэгдэх үед хүүхэд, эмэгтэйчүүдийн аюулгүй байдлыг хангах дэд бүтцийг эн тэргүүнд бий болгох хэрэгцээ гарч байна. 2015 онд Эрдэнэс таван толгой төрийн өмчит ХХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд Цогтцэций сумын төвийг гудамжны гэрэлтүүлэгтэй болгох санаачлага гаргасан сайн жишээ байна.

Хүн ам хамгийн ихээр төвлөрсөн Улаанбаатар хотод залуу гэр бүлүүд гол төлөв төвөөс зайдуу, жижиг талбайтай орон сууцуудад амьдарч байна. Гэтэл хүүхдийн сургууль, цэцэрлэгийн хүртээмж, чанар дүүрэг бүрт харилцан адилгүй тул хүүхдээ сургууль, цэцэрлэгт хүргэх, авахтай холбоотой зорчих хөдөлгөөн ихэсч, замын түгжээнд нөлөөлөхөөс гадна эцэг эхчүүдэд цагийн хомсдол үүсгэж байна.

### Шигтгээ 8.

#### **Сайн туршлага: Эрчим хүчний үр ашиг төслийн жендэрийн үр нөлөө**

*ХБНГУ, Швейцар улсын засгийн газрын санхүүжилттэй, Германы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (GIZ)-аас хэрэгжүүлж буй Эрчим хүчний үр ашиг төслийн хүрээнд, агаарын бохирдол ихтэй гэрхорооллын бүс нутагт хуучны сургууль, цэцэрлэгийн барилгын дулаан алдагдлыг бууруулах, эрчим хүчний хэмнэлттэй технологи ашиглан, их засварын ажлыг хийж гүйцэтгэж байна. Төслийн хүрээнд 2016 онд хийсэн нийгэм, эдийн засгийн үр өгөөжийн судалгаанаас үзэхэд хүүхдүүд, цэцэрлэгийн багш, ажилчдын өвчтэй байх нийт хугацаа 1/3-ээр багасч, айл өрхийн эм эмчилгээний жилийн зардал 65 орчим хувиар буурсан байна. Энэ нь үр шим хүртээгч өрхийн асран халамжлах үүргийг голчлон гүйцэтгэдэг эмэгтэйчүүдийн ажлын ачааллыг хөнгөвчилж, ажил эрхлэх боломжийг нь дээшлүүлсэн байна.*

*Эх үүсвэр: Нийтийн барилга байгууламж дахь эрчим хүчний хэмнэлт ба нийгэм, эдийн засаг дахь үр өгөөжийн судалгаа, 2016 он, Эрчим хүчний үр ашиг төсөл, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ)*

Монгол Улс 2001 онд санаачлан, түүнээс хойш 2 жил тутам шинэчлэн батлуулж ирсэн НҮБ-ын Ерөнхий Ассамблейн “Хөдөөгийн эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах тухай” тогтоолд тогтвортой дэд бүтэц, технологийн хүртээмжийг сайжруулж, хөдөөгийн эмэгтэйчүүд охидод тулгамдаж буй асуудлыг шийдэхэд Засгийн газруудыг уриалсан. Малчин өрхүүдийг халуун ус, боловсон жорлон, угаалгын машин, интернэттэй болгох шийдлийг олох нь ялангуяа залуу малчин эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, амьдралын чанарыг дээшлүүлэхэд амин чухал болох нь хөдөө аж ахуйн салбарын мэргэжилтнүүдийн бүлгийн ярилцлага, хэлэлцүүлгээр илэрсэн юм. Үүний дотор говь, хангайн бүсийн онцлогт нийцсэн эко ариун цэврийн байгууламж, зөөврийн ариун цэврийн төхөөрөмжүүд эн тэргүүнд хэрэгтэй байна.

### Шигтгээ 9.

#### **Ундны усны аюулгүй байдал, ариун цэврийн байгууламжийн асуудал ба жендэр**

*Ундны ус, ариун цэврийн байгууламжийн салбарт зарим үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлсэн хэдий ч Монгол Улс нь Мянган Хөгжлийн Зорилго 7-ийн “2015 он гэхэд баталгаат ундны усны хангамжгүй, сайжруулсан ариун цэврийн байгууламжид хамрагдаагүй хүн амын тоог хоёр дахин бууруулна” гэсэн зорилгод хүрч чадаагүй билээ. Энгийнээр хэлбэл, Монголчуудын дийлэнх хэсэг нь ундны усаа худгаас авдаг ба нийт хүн амын тал шахуу хувь нь нүхэн жорлонд бие засдаг гэсэн үг юм. Эдгээр тоо баримт нь Тогтвортой Хөгжлийн Зорилгуудын 6.1 ба 6.2-т “аюулгүй, эрүүл ахуйн шаардлага хангасан үйлчилгээ”-тэй холбоотой үзүүлэлтээс хавьгүй доогуур байна. 2015 оны байдлаар, нийт хүн амын зөвхөн дөрөвний нэг хэсэг нь гэртээ цоргоноос ус авдаг бол дөнгөж 13 хувь нь л бохир усны нэгдсэн сүлжээнд холбогдсон байна гэсэн үг юм.*

*Малчид мөн гадаргын цэвэр усны эх үүсвэрүүдээс ундаалдаг. Монгол орны хойд бүс нутагт хувиараа алт олборлогч иргэд ихэвчлэн зохион байгуулалтгүй, эмх замбараагүй олборлолт явуулж, гадаргын усыг химийн бодисоор бохирдуулж, улмаар энэ нь нүүдлийн аж ахуй эрхэлдэг хүн амын ундны усны чанарт муугаар нөлөөлж байна. Учир нь усанд агуулагдаж болзошгүй хүнцлийн хор нь өнгөгүй, үнэргүй тул ийнхүү бохирдсон усыг нүүдэлчин хүн ам ундандаа хэрэглэсээр байж болох юм. Иймд Монгол Улс тодорхой арга хэмжээ авч, малчин өрхүүдийн аж төрөх ёсны онцлогт тааруулан ундны усны хүртээмжийг сайжруулах, малчин биш бусад иргэдийн түвшинтэй ижил болгох шаардлагатай байна.*

*Монгол Улсын Засгийн газраас 2015 онд “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны ус, ариун цэвэр, эрүүл ахуйд тавигдах норм, шаардлага” боловсруулан гаргасан байдаг. Засгийн газраас 2015 онд хийсэн стандартын биелэлтийн шалгалтын тайланд дурдагдсанаар, сарын тэмдэг ирсэн үедээ охид гадаа жорлонд орохыг хүсдэггүй учраас хичээлээ таслах нь элбэг тохиолддог байна. Боловсон жорлонгийн асуудлаас гадна усны хангамж, халуун усанд орох боломж зэрэг охидын эрүүл ахуй, ариун цэврийн асуудалд учир дутагдалтай зүйлс байсаар байна.*

*Эх үүсвэр: НҮБ-ын хүний эрх, ундны усны аюулгүй байдал, ариун цэврийн байгууламжийн асуудал хариуцсан тусгай илтгэгч Лео Хеллер, 2018*



Монгол Улсын нэгэн адилаар хөдөөгийн эмэгтэйчүүд эрчүүдээсээ илүү боловсрол эзэмшиж, хөдөөнөөс хотыг зорих болсноор хөдөөд эрэгтэйчүүд үлдэж буй нийтлэг асуудалтай Швед, Норвеги, Дани, Финляндад дижитал дэд бүтцийг хөдөөгийн хэрэглэгчдэд хүргэн, тэдний ажил амьдралын хэрэгцээнд нийцүүлэн хөгжүүлэхийг хөдөөгийн хүн амын жендэрийн тэнцвэрт байдлыг хангах арга зам гэж үзэж байна.<sup>50</sup>

Монголд интернет хэрэглэгчдийн тоо 2005 онд хүн амын 0.8 хувь байсан бол 2018 онд 92.9 хувь болжээ. Үүрэн утасны бүртгэлтэй хэрэглэгчдийн тоо мөн хугацаанд 9.5 дахин өссөн байна. Хөдөөгийн оршин суугчид үүрэн утсаар ярих төдийгүй олон нийтийн сүлжээнд идэвхтэй орох болсон байна. Энэ нь ялангуяа хөдөөгийн эмэгтэйчүүдэд гэр орны ажлаа эрхлэнгээ мэдээллээс хоцрохгүй, нийгмийн амьдралын бүх хүрээнд оролцох, шаардлагатай мэдээллийг цаг алдалгүй авах боломж олгосон ахиц дэвшил юм. Жишээлбэл ОБЕГ-аас цаг агаарын ноцтой үзэгдлийн талаарх сэрэмжлүүлгийг гар утсаар бүх хүнд хүргэж байгаа нь гамшгаас сэргийлэх боломжийг өрхийн бүх гишүүнд олгож байна.

2017 онд батлагдсан Барилга, хот байгуулалтын салбарт жендэрийн талаар баримтлах бодлого нь хот төлөвлөлтийг жендэрийн мэдрэмжтэй байдлаар оролцоонд суурилан төлөвлөх чадавхийг бий болгох, оршин суугчид, түншлэгчдийн оролцоог дэмжсэн эрх зүйн орчныг бүрдүүлэх, амьдралын чанарын суурь стандартыг гарган бүх нийтээр дагаж мөрдөх зэрэг өргөн хүрээний үйл ажиллагааг төлөвлөсөн байна.

### **Эдийн засгийн хүрээнд жендэрийн тэгш байдлыг хангахад чиглэсэн зөвлөмж:**

#### **Урт хугацаанд:**

1. Хүтээмжтэй, тогтвортой эдийн засгийн өсөлтийг дэмжих, нийт хүн амыг бүрэн, үр бүтээмжтэй хөдөлмөр эрхлэлт, зохистой ажлын байраар хангах Тогтвортой хөгжлийн 8-р зорилгын хүрээнд эдийн засгийн хөгжлийн бүх түвшний бодлого төлөвлөлтөд нөөц баялгийг эмэгтэй эрэгтэй хүнд адил нөхцөлөөр тэгш, хүртээмжтэй хуваарилах эрх зүй, бодлогын орчныг бүрдүүлэх;
2. Эдийн засгийн төрөлжилтийг сайжруулж, түүний дотор хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрийн салбарт байгалийн нөөц баялгийг зөв зохистой зарцуулж, өртөг шингээсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлэн хот, хөдөөгийн орлого багатай эмэгтэй эрэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх;
3. Өмч хөрөнгө эзэмшилт дэх жендэрийн зөрүүтэй байдлыг арилгахад чиглэсэн өөрчлөлтийг эрх зүйн орчинд хийж, олон нийтэд тогтмол мэдээлэл хүргэн соён гэгээрүүлэх;
4. Бизнес эрхлэхэд эмэгтэй эрэгтэй хүмүүст, нийгмийн бүлгүүдэд тулгарч буй саад бэрхшээлийг судлан шинжилж арилгах. Жишээлбэл, жендэрийн мэдрэмжтэй, хүртээмжтэй банк санхүүгийн тогтолцоог бүрдүүлж, эн тэргүүнд бичил үйлдвэрлэл эрхэлж буй эмэгтэй эрэгтэйчүүдэд засгийн газраас баталгаа гарган итгэлийн зээл тэнцвэртэй олгох асуудлыг судлан шийдвэрлэх;
5. Хөдөө аж ахуйн бүх бүтээгдэхүүний үнийг Засгийн газраас тогтвортой байлгах, дотоодын зах зээлийг хамгаалах, аймаг сумын төвд борлуулалт хийх дэд бүтэц, сүлжээг хөгжүүлэх, төрийн болон хувийн хэвшлийн худалдан авалтыг дэмжих, замаар дотоодын үйлдвэрлэгчдийн ашиг орлогыг дээшлүүлэх;
6. Хөдөөгийн хот айл, малчин тариаланч өрхийн хэрэгцээнд нийцсэн хөдөлмөр хөнгөвчлөх, малын гаралтай түүхий эд, сүү цагаан идээ, хүнсний ногоо, эмийн ургамал боловсруулах, амьдралын ая тухтай орчин бүрдүүлэх техник технологийн судалгаа шинжилгээ, үйлдвэрлэлийг дэмжих;
7. Зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөдөлмөрийн зах зээл дэх ялгаварлан гадуурхлыг бууруулах, түүний дотор ОУХБ-ын конвенцийн зөвлөмжийн асуудлаарх шинжээчдийн хорооноос 111, 100, 103-р конвенциуд болон Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх;
8. ОУХБ-ын дараах конвенцуудад нэгдэн орох. Үүнд: Ажиллагчдад жендэр, гэр бүлийн хариуцлагаас үл хамааран тэгш боломж олгох, тэгш хандах тухай 156, Цагийн ажлын тухай 175, Гэр орны ажлын тухай 177, Эхчүүдийн хамгааллын тухай 183 дугаар конвенциуд;
9. Хот суурин газруудын тэгш хүртээмжтэй, аюулгүй, тогтвортой хөгжлийг дэмжих Тогтвортой хөгжлийн 11-р зорилгын хүрээнд Барилга, хот байгуулалтын салбарт жендэрийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг Зам тээвэр, Эрчим хүч, Байгаль орчны салбарын бодлого төлөвлөлт, хамтын ажиллагаагаар дэмжиж, амьдралын чанарын суурь стандартыг гарган бүх нийтээр дагаж мөрдүүлэх чиглэлээр салбар дундын зохицуулалт хийх.

**Дунд хугацаанд:**

1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр болон Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт жендэрийн талаар баримтлах бодлогын үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх зохицуулалтыг салбарын бүх түвшинд хийж, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтэд садаа болж буй бүх төрлийн ялгаварлан гадуурхлыг арилгахад чиглэсэн түншлэл хамтын ажиллагааг эрчимжүүлэх;
2. Банк, санхүүгийн байгууллагын зээл олголтын талаарх хүйсээр ангилсан мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх;
3. Газар, үл хөдлөх хөрөнгө, өмч хөрөнгө эзэмших, өвлүүлэхтэй холбоотой хүйсээр ангилсан статистик мэдээллийг сайжруулж ил тод болгох, өмч хөрөнгө эзэмшилтэй холбоотой жендэрийн харилцаанд гарч буй өөрчлөлтийг судлан шинжлэх;
4. Өмч хөрөнгийн эзэмшил, бичил болон жижиг дунд, өрхийн бизнес, үйлдвэрлэлийг дэмжсэн бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд гэр бүлийн тогтвортой, бүрэн бүтэн байдал, хамтын амьдралд учруулах эрсдлийг тооцож, харгалзах хандлагыг нэвтрүүлэх;
5. Өмч хөрөнгө өвлүүлэх талаар нийгэмд тогтсон жендэрийн хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд туслах эрх зүйн зохицуулалт бий болгох. Жишээлбэл, гэр бүлээ батлуулахдаа гэрлэлтийн гэрээ хийхийг хуульчлан хэрэгжүүлэх;
6. Шинэчлэн батлагдах Хөдөлмөрийн тухай хуулийг дагасан дүрэм журмуудыг ЖЭТБХТХуультай нийцүүлэх багц арга хэмжээг тодорхойлон хэрэгжүүлэх. Үүнд холбогдох байгууллагад зориулан аргачлал зааварчлага гаргах, ХАБ-ын дүрэм журам, стандартад бэлгийн дарамт, бусад ялгаварлан гадуурхлыг оруулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх;
7. Төр, хувийн хэвшлийн болон олон нийтийн байгууллагын удирдах ажилтнуудад эмэгтэй эрэгтэй ажилтнуудын ажил-ар гэрийн амьдралын тэнцвэрийг хангах талаар мэдлэг ойлгоц өгч, эрх зүйн зохицуулалт бий болгох;
8. Хүн амын өсөлтийг дэмжих бодлогыг хөдөлмөр эрхлэлт дэх жендэрийн тэгш байдлыг дэмжих, ялгаварлан гадуурхалтыг арилгах арга хэмжээтэй оновчтой уялдуулахын тулд эцэг эхчүүдийн хүүхэд асрах үеийн нийгмийн даатгалыг ажил олгогч төлж буй тогтолцоог өөрчлөн, төрөөс хариуцдаг болох;
9. Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг жендэрийн мэдрэмжтэй хэрэгжүүлэх арга зүйг нэвтрүүлэх;
10. ЖДҮ эрхэлж байгаа өрхүүд, эмэгтэйчүүдийн үйл ажиллагааг дэмжихэд хүн бүр, өрх бүрийг эцсийн бүтээгдэхүүн гаргах үйлдвэрлэгч болгоход зорих бус, харин тэднийг нэмүү өртгийн сүлжээгээр нэгтгэх бизнес инкубаторуудыг орон нутгийн болон үндэсний түвшинд хүртээмжтэй байгуулан ажиллуулах;
11. Ахмад настны хөдөлмөрийг дэмжих үндэсний онцлогт нийцсэн, хот хөдөөгийн эмэгтэй эрэгтэй өндөр настнуудад хүртээмжтэй бодлого арга хэмжээг хэрэгжүүлэх. Жишээ нь ач зээгээ харж асарч буй тэтгэвэрт гарсан эмэгтэйчүүдэд хувьсах зардлыг олгох асуудлыг судлан шийдвэрлэх, малчин, тариаланч, ажилчин, гар урлалч ахмадууд залуусыг дагалдуулан сургах хөтөлбөрүүд хэрэгжүүлэх;
12. Уул уурхай хөгжиж буй орон нутгийн малчдыг ажилд авах бус, малчдаас бүтээгдэхүүнийг нь худалдаж авах гэрээ хийх, тэднийг шаардлагатай мэдээлэл сургалт, техник технологиор хангахад төр, хувийн хэвшлийн байгууллагуудыг чиглүүлэх;
13. Хот, дэд бүтцийн төлөвлөлтөд хот, хөдөөгийн залуу гэр бүлүүд, хүүхэд, эмэгтэйчүүд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ялгаатай хэрэгцээ, амьдралын хэв маягийг судлан, анхаарч тусгах, эрх зүй, бодлогын орчныг сайжруулах;
14. Малчдын хэрэгцээ, амьдралын хэв маягт нийцсэн зөөврийн ахуй үйлчилгээ, халуун ус, эрүүл ахуйн шаардлага хангасан жорлон бүхий сууцны шийдлийг олж, үйлдвэрлэн нэвтрүүлж, Хөдөөгийн эмэгтэйчүүд охидын аж байдлыг сайжруулах тогтоолыг хэрэгжүүлсэн сайн жишээ болгон үндэсний болон олон улсын түвшинд түгээн дэлгэрүүлэх.

**Богино хугацаанд:**

1. Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамрагдах байгууллага, агентлагуудад хэрэгжих жендэрийн стратегийн жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг хөгжүүлэх 3-р зорилтыг хэрэгжүүлж, хөгжлийн сангуудын үйл ажиллагаанд жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн арга зүйг нэвтрүүлэх;
2. Бүртгэлтэй ажилгүй иргэд төдийгүй бүртгэлгүй ажилгүй иргэд, албан бус хөдөлмөр эрхлэгчдийн талаарх хүйсээр ангилсан статистик мэдээллийг сайжруулан, тэдэнд хүрч ажиллах орон нутагт суурилсан тогтолцоо механизмыг бий болгоход ашиглах;
3. Хүүхэд төрүүлж ажлаас завсардсан эмэгтэйчүүдийг эргэн ажилдаа орохдоо мэдээллээс хоцроогүй байх боломж, эмэгтэйчүүдэд уян хатан ажлын цагаар болон зайнаас ажиллах нөхцөл боломж бүрдүүлэх судалгаа, туршилт хийж, сайн туршлагыг нэвтрүүлэх;
4. Уул уурхай, барилга, дэд бүтцийн салбарт жасаагаар, улирлаар, мөн хөдөлмөрийн гэрээгээр гадаадад гэр бүлээсээ хол ажиллаж буй эрэгтэйчүүдийн эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдлийг бууруулах төрийн үйлчилгээний стандарт тогтоон нэвтрүүлэх;
5. Хувийн хэвшлийн байгууллагуудад жендэрийн төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх удирдамжийг нэвтрүүлэхийн зэрэгцээ эдийн засгийн хөшүүргээр дэмжих. Жишээ нь хүүхдийн цэцэрлэг, ясли, хүүхэд асрах өрөөг ажилтнууддаа, эсвэл орон нутгийнханд зориулан байгуулж ашгийн бус хэлбэрээр ажиллуулахад гаргасан зардлыг татвараас хөнгөлөх;
6. ЖДҮ-ийн ангилал хэт өргөн цар хүрээтэй байгаагаас ялангуяа эмэгтэйчүүд гол төлөв өрхийн үйлдвэрлэл, бичил бизнес эрхлэгчдэд тусламж дэмжлэг хүртээмжгүй байгааг анхаарч тусламж дэмжлэгийг ялгамжтай тодорхойлох;
7. Хот суурин газрын нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмж, хуваарьт жендэрийн үнэлгээ хийж, оршин суугчдын хүсэлтэд суурилан үйлчилгээг сайжруулах журмыг нэвтрүүлэх.





## 2 | НИЙГМИЙН БҮЛЭГ ХӨГЖИЛ БА ЖЕНДЭР

## НИЙГМИЙН ХӨГЖИЛ БА ЖЕНДЭР

Монгол Улсын хүн амын дунд хөдөлмөрийн насныхны эзлэх хувь дээд цэгтээ хүрсэн хүн амын цонхны үе 2008 оноос эхэлж 2030 он хүртэл үргэлжлэх төлөвтэй байна. Энэ нь эдийн засгийн хөгжилд таатай хэдий ч хэрэгцээнд нийцсэн зохистой ажлын байр хангалттай хэмжээгээр бий болгож чадахгүй бол нийгэмд ажилгүйдэл, ядуурал нэмэгдэх, гадаад руу чиглэсэн шилжих хөдөлгөөн улам ихсэх сөрөг үр дагавар хүлээж байна.

Хөдөөгөөс хотыг чиглэсэн шилжих хөдөлгөөн үргэлжилсээр, хөдөө орон нутгийн зарим хэсэгт хүн ам хэт цөөрч байгаа ба шилжин ирэгсдийн дунд хөдөлмөрийн насныхан, залуус, ялангуяа залуу эмэгтэйчүүд дийлэнх<sup>51</sup> байгаа нь хот хөдөөгийн хүн амын нас, хүйсийн тэнцвэрийг алдагдуулах үр дагавартай байна. Шилжих шийдвэр гаргахад эмэгтэйчүүд тухайн өрхийг тэргүүлж байгаа эсэхээс үл хамааран гол үүрэгтэй оролцож байна. Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагаас гаргасан судалгаанд 2017 оноос нийслэлд байнга оршин суух шилжилт хөдөлгөөнийг зогсоосон нь бүртгэлгүй оршин суугчдын тоог нэмэгдүүлэхэд нөлөөлж байгааг тэмдэглэсэн байна.

Нийгэм дэх мэдээллийн хүртээмж сайжирч, нийгэм, улс төрийн амьдралд иргэдийн оролцоо нэмэгдэж байгаа ч, нөгөө талаас нийгмийн хөгжлийн бодлогын хэрэгжилт иргэдийн мэдлэг чадвар, эрч хүчийг залан чиглүүлэх хүчин зүйл болж чадахгүй байгаа нь үнэт зүйлийн төөрөгдөл, ялгааг дэвэргэж, бухимдал, стресс, зөрчил, хүчирхийлэл нэмэгдэхэд нөлөөлж байна.

### А Өрх, гэр бүл

Монгол Улсын Үндсэн хуулийн (1992) 16 дугаар зүйлийн 11-д "...Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ" гэж заасан. 1999 онд Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийг батлан гаргаснаас хойш Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль зэргийг батлан, хэрэгжүүлэх арга хэмжээг иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж ирсэн. Монгол Улсын төрөөс 2003 онд "Гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлого" батлан хэрэгжүүлсэн бөгөөд 2014 онд уг бодлогыг шинэчлэн батлахдаа гэр бүлийн хөгжил, үр хүүхдээ асран хамгаалахад эцэг, эхийн жигд оролцоог хангах, гэр бүлийн өмчийн харилцаанд гишүүн бүрийг эрх тэгш оролцуулах, гэр бүлийн гишүүнийг хүчирхийлэх, эрхийг нь зөрчих явдлыг тууштай бууруулах эрх зүй, зан үйлийн эерэг орчин бүрдүүлэх зэрэг жендэрийн хувьд илүү тодорхой зорилго тавьсан байдаг.

Монгол Улсын нийт өрхийн тоо 2005 онд 611,026 байсан бол 2018 онд 894,496 болж 1.46 дахин өсчээ. Нийслэлд 2005 онд нийт өрхүүдийн 35.3 хувь амьдарч байсан бол 2018 онд 43.3 хувь болж нэмэгджээ. Ам бүлийн тоо 2010 оны Хүн ам, орон сууцны тооллогын дүнгээс үзэхэд хөдөөд 3.74, хотод 3.48 байв. Нийлмэл буюу эцэг эх, ах дүүс, садан төрлөөрөө амьдарч байгаа өрхийн тоо хотод хөдөөгөөс 2 дахин их байгаад суралцах болон бусад шалтгаанаар ирсэн хүмүүс нөлөөлж<sup>52</sup> байгаа ч залуу гэр бүлүүд өөрийн орон гэргүй (56.8 хувь), бие даан амьдрах чадваргүйн (19.8 хувь) улмаас эцэг эхтэйгээ хамт амьдарч байгаа нь гол шалтгаан болж байна. Залуус өндөр настай эцэг эхээ асрах шалтгаанаар нийлмэл гэр бүл бүрэлдэж байсан дүр зураг өөрчлөгдөж, эцэг эхийнхээ ивээлд амьдрах нь түгээмэл болж байна.

1990-2010 оны хооронд эмэгтэйчүүдийн гэрлэх дундаж нас 3.1 жилээр хойшилж 24.2, эрэгтэйчүүдийн гэрлэх нас 2.9 жилээр хойшилж 26.2 болсон байна. 2010 оны тооллогоор гэр бүлийн харилцаатай эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн 86 хувь нь хууль ёсны баталгаатай гэр бүл байна. Гэр бүлийн харилцаагаа батлуулаагүй хосуудын эзлэх хувь хөдөөд 8 хувь, хотод 16.5 хувь байна. Гэтэл зөвхөн "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай" хуулийн 3 дугаар зүйлд гэрлэлтээ хуульд заасны дагуу төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлээгүй боловч хамтын амьдралтай байгаа хүмүүсийг уг хуулийн зохицуулалтад нэгэн адил хамруулахаар заасан бөгөөд "Гэр бүлийн тухай" хуульд хамтран амьдрах хэлбэр, түүнтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг тусгаагүй байна.


2005 оноос 2018 онд нэг жил дэх гэрлэлтийн тоо улсын хэмжээнд 1.4 дахин, харин цуцлалтын тоо 2.6 дахин нэмэгджээ. Дээрх хугацаанд гэрлэлтийн тоо Улаанбаатар хотод илүү нэмэгдэж, хангайн, төвийн болон зүүн бүсүүдэд гэрлэлтийн тоо буурч байгаа нь хөдөө орон нутаг эзгүйрэх чиг хандлагыг харуулж байна. (Хүснэгт 1).

**Хүснэгт 1. Гэрлэлт ба гэр бүл цуцлалт 2005 ба 2018 онд, бүсээр**

	Гэрлэлтийн тоо		Гэр бүл цуцлалтын тоо	
	2005	2018	2005	2018
Улсын дүн	14 993	21 020	1 622	4 201
Баруун бүс	2 443	2 694	68	177
Хангайн бүс	3 735	3 344	156	601
Төвийн бүс	3 855	2 913	252	683
Зүүн бүс	1 211	1 179	76	212
Улаанбаатар	3 749	10 890	1 070	2 528

Эх үүсвэр: YCX. 1212.mn

Гэрлэлт, цуцлалтын тооны өсөлт нь хүн амын өсөлтөөс хамааралтай ч 1000 гэрлэлтэд ноогдох цуцлалтыг авч үзвэл гэр бүлийн тогтвортой байдал нийслэлээс илүүтэй бүс нутгуудад алдагдаж байгаа дүр зураг харагдаж байна (Дүрслэл 14).

**Дүрслэл 14. 1000 гэрлэлтэд ногдох цуцлалтын тоо 2005 ба 2018 онд, бүсээр**

Эх үүсвэр: YCX. 1212.mn

Ажил хөдөлмөр эрхэлдэг залуучуудын анхны гэрлэлтийн дундаж нас ажилгүй залуучуудынхаас эрт байгаа нь ажил эрхлэлт гэр бүлийн тоо нэмэгдэх, өрх, гэр бүлийн амьдралын түвшинг дээшлүүлэх анхдагч үндсэн нөхцөл болж байгааг харуулж байна.<sup>53</sup> Өнөөдөр залуу гэр бүлд амины орон сууц барих, газар тариалан, бизнес эрхлэхэд зориулан жижиг зээл олгох, залуу эцэг, эхийг дэмжин туслах эдийн засаг, эрх зүйн орчин бүрдээгүй байгаа нь бие даан амьдрах, төлөвших үйл явцад хүндрэл учруулж байна.<sup>54</sup>

Боловсролын түвшин эмэгтэй эрэгтэйчүүдийн гэрлэлтэд харилцан адилгүй нөлөөлж байна. Эрэгтэйчүүдийн хувьд боловсрол доогуур байснаар гэрлэх магадлал нь буурч байгаа бол эмэгтэйчүүдийн хувьд байдал өөр байна. 2010 оны тооллогоор дээд боловсролтой болон боловсролгүй эмэгтэйчүүдийн анхны гэрлэлт арай хожуу, дунджаар 24.6-24.8 насандаа байсан бол бага боловсролтой болон суурь боловсролтой эмэгтэйчүүдийнх арай эрт, дунджаар 22.7-22.9 насандаа гэрлэсэн байна. 2000 онд мөн ийм дүр зурагтай байжээ. Гэр бүл бүртгэх үйл ажиллагааг засаг захиргааны анхан шатны нэгжид хийх боломжтой болсон тул гэрлэх ёслол үйлдэх орчин нөхцлийг бүрдүүлэхэд анхаарч, шаардлагатай төсөв хөрөнгийг төсөвлөн зарцуулах шаардлага гарч байна.

Гэр бүл болоход мөн үндэс угсаа нөлөөлж, Хамниган, Баяд, Дөрвөд, Үзэмчин, Мянгад, Урианхай, Казак, Захчин, Торгууд, Хотон, Тува, Дархад, Халимаг, Узбек, Монголын харьяат (Орос, Хятадаас бусад) гадаад, Цаатан гэсэн үндэс угсаатанд огт гэр бүл болоогүй хүн амын эзлэх хувь улсын дунджаас дээгүүр байна (Зүүлт тайлбар 53). Үүний шалтгааныг цаашид гэр бүл судлалын хүрээнд анхаарч үзэх нь зүйтэй.

2012 онд гэр бүлийн талаар хийсэн судалгаагаар (Зүүлт тайлбар 53) гэр бүл цуцлалтын 38 хувийг гэрлэснээс

<sup>53</sup> Б.Оюун-Эрдэнэ. 2012. Монгол гэр бүлийн бүтэц хэв маяг, харилцааны онцлог, тулгамдаж буй асуудал. Улаанбаатар

<sup>54</sup> Т.Бүрэнжаргал. 2005. Гэр бүлийн социологи. Улаанбаатар.

хойш 6-7 жилийн дотор салж байгаа залуу гэр бүл эзэлж байсан ба энэ нь тэдний гэр бүлийн амьдралд бэлтгэлгүй байгаатай холбоотой гэж дүгнэж байжээ. Гэтэл 2018 оны судалгаагаар<sup>55</sup> гэрлэлтээ цуцлуулсан хосуудын 51.6 хувь нь 10-аас дээш жил, 26.5 хувь нь 7-9 жил амьдарсан хосууд байгааг гэр бүлийн тогтвортой байдал алдагдсаны илрэл гэж судлаачид дүгнэж байна. 2005 оны үед гэр бүл дэх зөрчлийн шалтгааны дунд архидалт давамгайлж, мөнгө санхүүгийн асуудал удаалж байсан бол 2012 оны судалгаагаар мөнгө санхүү зонхилох шалтгаан болсон нь харагдаж байв.

Гэр бүлийн байдал ийнхүү тогтворгүй болоход гадаадад ажиллах, жасаагаар ажиллах зэрэг амьдралын шинэ хэв маяг нөлөөлж байгааг үгүйсгэх аргагүй. Тухайлбал гадаадад ажиллагчдын дундаж нас 31.3 бөгөөд олонхи нь залуу эрэгтэйчүүд байна. Гэтэл гадаадад ажиллаж байгаа хүмүүсийн өчүүхэн хэсэг нь (2012 оны судалгаагаар 1.8 хувь) гэр бүлээрээ, хүүхэд, садан төрлийн хамт амьдарч байгаа (Зүүлт тайлбар 53) харамсалтай дүр зургийг гадаадад ажиллах хүч гаргах гэрээ хэлцлүүдэд анхаарах шаардлагатай байна. Мөн эдийн засаг, нийгмийн хамгааллын болон бусад салбарын бодлого шийдвэр гэр бүлийн харилцаанд хамгийн түрүүнд нөлөөлж байгааг анхаарч тооцох хэрэгтэй байна. Жишээлбэл шинэ гэр бүлд 500 мянган төгрөгийн урамшуулал олгох шийдвэр нь гэр бүл бүртгүүлэлт болон цуцлалтын тоо дараагийн хэдэн жилд огцом нэмэгдэхэд шууд нөлөөлж байв.

Малчдын гэр бүлийн байдал анхаарал татсан асуудал болж байна. Хөдөө аж ахуйн салбарын 2011 оны нэгдсэн бүртгэлийн тайланд мал аж ахуйн салбарын нийт ажиллагчдын 46217 буюу 13.6 хувь нь гэрлээгүй байгаа ба тэдний 32625 буюу 70.6 хувь нь эрэгтэйчүүд, 13592 буюу 29.4 хувь нь эмэгтэйчүүд байна гэжээ. Гэтэл 2017 оны мэдээгээр гэрлээгүй малчдын хүйсийн харьцаа улам дордож, 78 хувь нь эрэгтэйчүүд, 22 хувь нь эмэгтэйчүүд болсон байна. Мөн хүүхдийг 6 наснаас нь сургуульд хамруулах болсон нь хүүхдүүдэд үр шимээ өгөхөөс өмнө малчин өрхүүдийн гэр бүлийн харилцаанд нөлөөлж, хөдөөгийн гэр бүл тусдаа амьдрах гол шалтгаан болоод байна.

Гэр бүлийн харилцааны талаарх мэдлэгийг бүх насны эмэгтэй эрэгтэй хүмүүст амьдралын мөчлөг, насны онцлогт тохирсон байдлаар өгөх хэрэгтэй байна. Мөн өрх гэрүүдэд мөнгөн тэтгэмжээс илүүтэй тулгарч буй бэрхшээлээ шийдэх боломж, сонголт бий болгох, хэрэгцээнд нь нийцсэн ур чадвар олгох нь илүү үр дүнтэйг анхаарах хэрэгтэй. Залуучуудад гэр бүлийн боловсрол, түүний дотор гэр бүлийн санхүүг хөтлөх, орон сууцаа өөрсдөө барьж байгуулах, засварлах, өдөр тутмын гэр орны ажлыг хийх чадвар олгох, ахмад настнуудад мэдлэг туршлага ашиглах, хуваалцах, нийгмийн амьдралд хувь нэмэр оруулах боломж сонголтыг хүртээмжтэй болгох хэрэгцээ тулгарч байна. Мөн гэр бүл болох, цуцлахтай холбоотой эрх зүйн орчныг сайжруулах, хэрэгжилтэд мониторинг хийх шаардлагатай байна. Энэ нь гэрлэж буй Монгол Улсын иргэдтэй төдийгүй, гадаадын иргэдтэй гэр бүл болж буй монголчуудтай холбоотой юм. Гадаадын иргэдтэй гэрлэн гадаад улс оронд амьдарч буй монгол иргэдийн эрх зүйн байдлыг мөшгин судалдаг болох, мэдээлэл хүргэх механизмыг бий болгохын зэрэгцээ олон улсын холбогдох гэрээ конвенцид нэгдэн орох зэргээр тэдний эрх зүйн хамгаалалтыг сайжруулах асуудлыг судлах хэрэгтэй байна.

## Б Боловсрол

“Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-д нийгмийн тогтвортой хөгжлийн зорилт нь жендэрийн тэгш байдлыг хангах, иргэн бүрт хүртээмжтэй, чанартай боловсрол олгох, насан туршийн боловсролын үндэсний тогтолцоог бүрдүүлэхээр заасан байдаг.<sup>56</sup> Монгол орны уудам газар нутагт тархай суурьшсан хүн амыг боловсролын үйлчилгээгээр тэгш, хүртээмжтэй хангахад Засгийн газраас боловсролын салбарт ихээхэн хөрөнгө оруулж, бичиг үсэгт тайлагдалт, бага боловсролд хамрагдалтын үзүүлэлтээр (99.0 ба 97.5 хувь) дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын түвшинд хүрсэн ч боловсролын үр дүнг сайжруулах, хүртээмжийг бүх түвшинд өсгөх шаардлага байсаар байна.

Дэлхийн эдийн засгийн форумын тайланд Монгол Улс жендэрийн зөрүүтэй байдлын индексээр эзлэх байр 2006-2018 оны хооронд 42-оос 58 болж ухарсаны гол шалтгаан нь боловсролын үзүүлэлт байна. Боловсролд хамрагдалтын хувьд тэгш бус байдлын үзүүлэлт 2006 онд 0.704 байснаа 2018 онд 0.780 болж, 20-р байрнаас 70-р байр руу ухарчээ. 2006 онд охид, хөвгүүдийн харьцаа дунд боловсролын түвшинд 1.14, дээд боловсролын түвшинд 1.64 байсан бол 2018 онд тус тус 1.11 ба 1.43 болж дээшилсэн хэдий ч дэлхийн улс орнуудад гарсан эерэг өөрчлөлтийн хурдыг гүйцээгүй байна.

Сургуулийн өмнөх боловсрол, бага дунд боловсролын багш нарын дунд эмэгтэйчүүд давамгайлах нь дэлхий нийтэд түгээмэл байдаг ч бусад улс оронтой харьцуулахад манай улсын хувьд жендэрийн тэнцвэрт байдал хэт алдагдсан. 2017 оны байдлаар СӨБ-ын нийт багш, ажиллагчдын 96.0 хувь, ЕБС-ийн үндсэн багш нарын 81.2 хувь нь эмэгтэйчүүд байна. Энэ байдалд эмэгтэй эрэгтэй хүмүүсийн ажил мэргэжлийн талаарх жендэрийн хэвшмэл



ойлголт болон багш нарын цалин хөлсний хэмжээ голлон нөлөөлж байна.

Дээрх асуудлыг шийдэх зорилгоор боловсролын салбарын эрх зүй, бодлогын орчинд жендэрийн зорилтууд тусгагдаж, БСШУС-ын салбарт жендэрийн талаар баримтлах бодлого (2017-2024) батлагдан хэрэгжиж байна. Салбарын бодлого, төлөвлөлт, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээний бүх түвшинд жендэрийн тэгш байдлыг хангах үйл явцыг дэмжих зорилго бүхий тус бодлого нь суралцагчид, ажиллагчдыг хамрахаас гадна нийгэм дэх жендэрийн хэвшмэл ойлголтыг арилгахад салбарын зүгээс оруулах хувь нэмрийг тодорхойлон чиглүүлсэн байна.

**Сургуулийн өмнөх боловсрол:** Сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт нь охид хөвгүүдийг сургуульд ороход бэлтгэхээс гадна эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Монгол Улсад 3-5 насны хүүхдүүдийн 70 хувь нь СӨБ-ын албан ёсны хөтөлбөрт хамрагдаж, 10 хувь нь нүүдлийн мал аж ахуй эрхлэгчдэд зориулсан хөдөлгөөнт болон гэр цэцэрлэгт хамрагдаж байгаа нь Зүүн Европ, Латин америкийн орнуудтай дүйцэх үзүүлэлт юм. Монгол Улс нь 2030 он гэхэд СӨБ-д хамрагдалтыг 90 хувьд хүргэх зорилт тавиад байна.

Хэдийгээр охид хөвгүүд хүйсийн хувьд СӨБ-д тэгш хамрагдаж байгаа ч хотын захын хорооллын хүүхэд, малчдын хүүхэд, казах хүүхэд, орлого багатай ядуу өрхийн хүүхдийн СӨБ-д хамрагдах боломж доогуур байна.<sup>57</sup> Цэцэрлэгийн тоо болон хамрагдсан хүүхдүүдийн тооны өсөлт Улаанбаатар хотод илүү байна. СӨБ-д хамрагдсан малчдын хүүхдийн тоо (2017 онд 29 493) сүүлийн 5 жилд бараг өсөөгүй, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо 16.9 хувь өсч 1 599 болсон байна.<sup>58</sup>

СӨБ-д хувийн өмчийн эзлэх хувь нэмэгдэж (2013/2014 оны хичээлийн жилд 28.4 хувь байсан бол 2017/2018 оны хичээлийн жилд 38 хувь болсон) байгаа цэцэрлэгийн хүртээмж орлогын ялгаагаар улам хязгаарлагдах хандлагатайг харуулж байна. Өнөөдөр цэцэрлэг хүрэлцэхгүй байгаагаас хүүхдээр сугалаа сугалуулахад хүрч байгаа нь асуудлыг шийдэх оновчтой арга биш юм. Харин төрийн байгууллагууд ажилтныхаа хүүхдүүдэд зориулан, мөн хувийн хэвшлийн байгууллагууд ажилчдынхаа болон орон нутгийн хүүхдүүдэд зориулсан цэцэрлэг байгуулах чиглэлээр санаачлага гаргаж эхэлж байгаа нь цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ ажилтнуудын ажил ар гэрийн амьдралын тэнцвэрийг хангахад сайн нөлөөтэй туршлага юм.

**Бага, дунд боловсрол:** 1995 оноос хойш бага ангид элсэгчдийн дунд охид олонхи байсан ч 2011 оноос хойш хөвгүүд давамгайлж, зөрүү нь аажим нэмэгдсээр байна. 2017 онд охидын элсэлт 98.5 хувь, хөвгүүдийнх 98.7 хувь болжээ. Дунд ангид элсэгчдийн хүйсийн тэнцвэр сайжирч байгаа ч анги дэвших тусам хөвгүүдийн тоо буурдаг чиг хандлага хадгалагдсаар байна. Хөвгүүдийн эзлэх хувь дунд ангиас ахлах ангид дэвших үед огцом буурч байгааг харгалзан 2006 онд БСШУ-ны Сайдын тушаалаар хөвгүүдийг ахлах ангид дэвшүүлэхэд түр тусгай арга хэмжээг (9-р ангид дэвшигчдийн 48.0% эрэгтэй хүүхэд байх) хэрэгжүүлж эхэлсэн байна.

Статистик мэдээллээс үзэхэд 6-14 насны хөвгүүдийн сургууль завсардалтад амьдралын гачигдал болон өвчлөл голлох хүчин зүйл болж байна. Гэвч сургуульд ороод амьдралын гачигдлаас болж завсардсан хөвгүүдийн тоо охидынхоос хэт ялгаатай байгаагаас үзэхэд далд шалтгаан нь хүүхдийн хөдөлмөр эрхлэлт гэж дүгнэж болохоор байна (Хүснэгт 2). 2013 онд хийсэн хүүхдийн хөдөлмөрийн судалгаагаар<sup>59</sup> өрхөөс гадуур ажил хийж буй арван хүүхдийн найм нь хөвгүүд, хоёр нь охид бөгөөд тэдний дийлэнх нь 15-17 насныхан байжээ.

**Хүснэгт 2.** Сургууль завсардсан хүүхэд, насны бүлэг, шалтгаанаар, 2017/2018 оны хичээлийн жилд

Шалтгаан	Бүгд	Сургуульд огт ороогүй						Сургуульд ороод завсардсан					
		6 - 11 настай			12 - 14 настай			6 - 11 настай			12 - 14 настай		
		Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
<b>Бүгд</b>	<b>682</b>	<b>462</b>	<b>278</b>	<b>184</b>	<b>52</b>	<b>40</b>	<b>12</b>	<b>58</b>	<b>47</b>	<b>11</b>	<b>110</b>	<b>98</b>	<b>12</b>
Амьдралын гачигдлаас	161	98	64	34	3	3	-	15	14	1	45	41	4
Сурах хүсэлгүй	35	4	2	2	1	1	-	6	6	-	24	23	1
Ажил эрхлэхээр	9	7	4	3	-	-	-	-	0	-	2	2	-
Өвчний улмаас	222	131	74	57	40	31	9	28	20	8	23	18	5
Шалтгаан тодорхойгүй	255	222	134	88	8	5	3	9	7	2	16	14	2

Эх үүсвэр: ҮСХ. Боловсролын салбарын танилцуулга. 2017

<sup>57</sup>Rabia Ali and Pagma Genden. 2017. "Early childhood education in Mongolia – who is still excluded?". World Bank Blog. <http://blogs.worldbank.org/education/early-childhood-education-mongolia-who-still-excluded>

<sup>58</sup>ҮСХ. 2017. Боловсролын салбарын танилцуулга. Улаанбаатар.

<sup>59</sup>ҮСХ, ОУХБ. 2012. Монголын хүүхдийн хөдөлмөрийн судалгааны тайлан. Улаанбаатар.

Мөн амьдралын гачигдал гэсэн хариултыг зөвхөн ядууралтай холбон тайлбарлаж болохгүй бөгөөд нүүдэлчдийн амьдралын онцлог, түүний дотор гэрээс сургууль хүртэлх зай мөн нөлөөлж байна. 2013 онд хийсэн судалгаанд<sup>60</sup> хамрагдсан сургууль завсардсан хүүхдүүдийн тал хувийнх нь гэр, сургуулиас дунджаар 10 орчим км-ын зайд байрлаж, 56 хувь нь явган, 12.2 хувь нь машинаар, 3 хувь нь морь эсвэл тэмээгээр, 2 хувь нь мотоциклоор сургуульдаа явдаг байна. Жишээ нь говийн бүсэд 130 км-ын цаанаас сургуульдаа явж байгаа хүүхдүүд ч байна. Малчин эцэг, эхчүүд хүүхдээ байлгах айл, дотуур байр олж чадахгүй, мөн хүүхэд нь сурлагаар тааруу бол мал маллуулахыг илүүд үздэг байна.

2005 оноос сургуульд 6 настай хүүхдүүд элсэн орох болсон нь сургуулийн дотуур байрны хүртээмж, чанарт томоохон сорилт болжээ. Жишээ нь 2017 онд МУБИС-ийн судлаачдын хийсэн судалгаагаар дотуур байрны ачаалал Баян-Өлгий аймагт 45 хувь, Увс аймагт 48 хувь, Ховд аймагт 71 хувь, Дорнод аймагт 50 хувиар тус тус хэтэрсэн байна.<sup>61</sup>

**Шигтгээ 10.**


**Боловсролын бодлого ба малчин өрхийн жендэрийн харилцаа**

*Хөдөө, орон нутагт 6 настай хүүхдийн сургуульд орох асуудал болон түүнээс үүсэх жендэрийн үр дагаврын талаар бодлогын түвшинд дахин ярилцах хэрэгтэй. Баганасныхууддээ эцэг эх нь санаа зовоод аль нэг нь хамт байхгүй бол болохгүй, эсхүл сургууль завсардах асуудал яригдана. Эсвэл залуугэр бүлтусдаа амьдарч байна. Эхнэр нь хүүхдээ хараад сум, аймгийн төвд, нөхөр нь гэртээ үлдэж малаа малладаг. Зарим тохиолдолд гэр бүл салах, суурин газар дассан эмэгтэйчүүд буцаж хөдөө гарахгүй байх зэрэг үр дагаврууд гарч байна. Зайны сургалт гэж манайд нэвтэрч эхэлсэн. Явуулын багш бэлтгэх, баг, хороонд нь нүүдлийн сургалт зохион байгуулж болно шүүдээ.*

*Эх үүсвэр: Боловсролын салбарын ажилтнуудын бүлгийн ярилцлага*

Жендэрийн энэхүү дүн шинжилгээний хүрээнд 1200 хүнээс авсан судалгаанд оролцогчдын дийлэнх нь 6 настай хүүхэд сургуульд орох болсноор хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, сурлага хүмүүжлээс гадна өрхийн эдийн засаг гэр бүлийн харилцаанд сөрөг нөлөөтэй гэж хариулсан байна (Дүрслэл 15). Малчдын хүүхдүүд 8 наснаас сургуульд сурч болох боломж олгосон нь малчин эцэг эхчүүдийн хүүхдээ сургуульд хэдийд өгөхөө сонгоход дорвитой нөлөөлж чадахгүй байна.

**Дүрслэл 15.** Зургаан настай хүүхэд сургуульд орох нь малчин өрхүүдэд хэрхэн нөлөөлөх талаар судалгаанд оролцогчдын үнэлгээ



Эх үүсвэр: 2018 онд ЖДҮ эрхлэгч 1200 хүнээс авсан судалгаа

Засгийн газраас үдийн цай хөтөлбөрийг бүх нийтэд хүртээмжтэй хэрэгжүүлж, орлого багатай өрхийн хүүхдүүдийг сурах бичгээр хангаж байгаа нь тэгш бус байдлыг багасгахад хувь нэмэр оруулж байна. Гэсэн ч сургуулийн орчинд тэгш бус байдлыг үүсгэх хүчин зүйлүүд байсаар байна. Тухайлбал орлого багатай өрхийн хүүхдүүдийг сургууль завсардахад дүрэмт хувцас, хэрэглэл, сурах бичгийн үнэ төлбөр, анги тохижуулах зэрэг шалтгаанаар хураадаг мөнгө, мөн үе тэнгийнхний ялгаварлан гадуурхалт, сургуулийн орчин дахь хүчирхийлэл нөлөөлж, ялангуяа хөвгүүдийг хүүхдийн хөдөлмөр рүү түлхэж байна.

Мөн жендэрт суурилсан хүчирхийлэл, бэлгийн дарамтын талаар сурагчид ойлголт багатай, эцэг эхчүүд болон хууль сахиулагчид уг асуудалд хангалттай анхаарал хандуулахгүй байна.<sup>62</sup> 2014 онд хийсэн судалгаагаар суралцагчдын 40 хувийн биед хүсээгүй байхад нь хүрсэн, 38.6 хувьд нь таагүй эсвэл бэлгийн харилцааг илэрхийлсэн зураг, видео үзүүлсэн, 33.6 хувь нь бэлгийн хүчирхийллийн зарим хэлбэрт өртсөн, 10 хувийн биед бэлгийн харилцааны сэдлээр хүрсэн байна. Гэвч охидын хувьд сургуульд сурснаар илүү аюулгүй байдалд орж, эрт жирэмслэхээс хамгаалагдаж байна (Зүүлт тайлбар 6). Харин сургуулийн орчин дахь бие махбодийн хүчирхийлэл ялангуяа шилжин ирсэн ядуу өрхийн хөвгүүдийн суралцахад садаа болж байна.<sup>63</sup>


<sup>60</sup> Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг. 2013. Сургууль завсардсан хүүхэд. Улаанбаатар.  
<sup>61</sup> МУБИС. 2017. Сургуулийн дотуур байрны орчин нөхцөл, хүүхдийн хөгжил хамгааллын өнөөгийн байдал. Улаанбаатар.  
<sup>62</sup> Mongolia Women's Fund. 2017. "Securing State Investment for Prevention of Gender-Based Violence in Schools" project. Ulaanbaatar: Mongolia Women's Fund. <http://www2.unwomen.org/-/media/field%20office%20untf/publications/2017/final%20report%20summarymonesocompressed.pdf?la=en&vs=719>  
<sup>63</sup> Нерворт 2013 in UNESCO. 2015. Education For All 2000-2015: Achievements and Challenges. Paris, France: UNESCO. <http://unesdoc.unesco.org/images/0023/002322/232205e.pdf>

Сургуулийн орчин, сургууль гэр хоорондох замыг хүүхдэд аюулгүй болгох асуудлаар боловсролын байгууллага төдийгүй барилга хот байгуулалт, зам тээвэр, дэд бүтцийн салбарууд хамтран ажиллах шаардлагатай байна. Юуны өмнө төрийн болон хувийн хэвшлийн сургуулийн анги дүүргэлтийн ялгаа, боловсролын стандартыг жигд бус мөрдөж буй байдал нь ялгаварлан гадуурхалт, тэгш бус байдлыг арилгахад садаа болж байгааг анхаарч шийдвэрлэх нь зүйтэй. Тухайлбал улсын төсвөөс хувийн сургуулиудын хувьсах зардлыг санхүүжүүлж байгаа нь тэгш хандаж байгаа мэт боловч үнэн хэрэгтээ ялгаатай байдлыг ихэсгэхэд хувь нэмэр оруулж байгааг хүлээн зөвшөөрөх цаг болжээ. Мөн суралцагчдын ялгаатай хэрэгцээг тооцохгүй, жишээлбэл хөгжлийн бэрхшээлтэй, алс хязгаар нутагт амьдарч буй хүүхдүүдийн, жишээ нь цаатан хүүхдүүдийн сургалтын орчинг сайжруулах, сурлагын чанарыг дээшлүүлэхэд зайлшгүй шаардлагатай нэмэлт санхүүжилт хийхгүй байгааг 2013 оны судалгаа<sup>64</sup> харуулсан байна.

Боловсролын хүртээмж тэгш байхаас гадна сургалтын орчин, сургалтын агуулга, сурах бичиг хэрэглэгдэхүүн жендэрийн мэдрэмжтэй байх нь охид хөвгүүдэд боловсролын үр өгөөжийг илүү бүрэн дүүрэн, тэгш шударга хүртэх боломж олгоно. Хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт нийцсэн сургалтын хөтөлбөр, заах арга барилын талаар салбарын стандартуудад тусгагдсан ч охид хөвгүүдийн ялгаатай хэрэгцээг харгалзах тухайд ахицтай өөрчлөлт гарахгүй байна. Мөн жендэрийн мэдрэмжтэй дэд бүтэцийг сургуулиудад бий болгох асуудал тулгамдсаар байна. Охид хөвгүүдийн бие засах газрыг тусдаа болгох талаар чамгүй ажилд хийгдэж байгаа ч хөдөөгийн сургууль, дотуур байрууд гадаа бие засах газартай байгаа нь охидын эрүүл ахуйн хэрэгцээнд нийцэхгүйгээс гадна ялангуяа гэрэлтүүлэггүй бол хүчирхийлэлд өртөх эрсдлийг бий болгож байгааг цаашдын бодлого төлөвлөлтөд анхаарч тусгах нь зүйтэй. 2004 оноос хойш НҮБ-ын ЮНЕСКО-гийн дэмжлэгээр сурах бичгийн жендэрийн мэдрэмжийг судлах, боловсролын салбарт ашиглах жендэрийн шалгуур үзүүлэлтүүд боловсруулах ажлууд хийгдсэн ч үр дүнг нь боловсролын бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд ашиглахгүй байна.

**Дээд боловсрол:** Монгол Улсад их дээд сургуулийн түвшинд суралцагчдын хүйсийн тэнцвэр хэт алдагдсанаас гадна мэргэжлийн чиглэлээр хүйсийн ялгаа их байгаа нь жендэрийн хувьд таагүй үзүүлэлт болж байна. 2016 оны байдлаар эмэгтэй, эрэгтэй суралцагчдын элсэн сургалтын бохир жингийн харьцаа 1.4 байгаа нь эмэгтэйчүүдийн дээд боловсрол эзэмшихийг дэмждэг хөгжингүй орнуудынхаас (1.22) дээгүүр байжээ (Дүрслэл 16). Хэдийгээр энэ гажуудлыг эцэг эхчүүдийн охидын боловсролыг чухалчлах хандлагатай холбон тайлбарладаг ч дээд боловсролын байгууллагуудын тоо өсөхийн зэрэгцээ (өмч хөрөнгө эзэмшилт хэсгийг харах) хямд зардал, элсэлт өндөртэй бизнес, эрх зүй, нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургалт эрхлэх сонирхол давамгайлсантай холбоотой.

**Дүрслэл 16.** Их дээд сургуульд элсэгч эмэгтэй эрэгтэйчүүдийн харьцаа, Монгол Улсад болон улс орнууд дахь орлогын түвшнээр




Эх үүсвэр: Дэлхийн банк. Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүд (2018).

Боловсролын бүхий л зэргээр суралцагчдын дотор эмэгтэйчүүдийн эзлэх хувь давамгайлж байгаагаас магистрантурт суралцагч эмэгтэйчүүдийн эзлэх хувь хамгийн өндөр байна (Дүрслэл 17).

<sup>64</sup> Эдийн засгийн судалгааны хүрээлэн, Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг. 2013. Боловсролын салбарын тойм судалгаа. Улаанбаатар.

**Дүрслэл 17. Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид, хүйс, боловсролын зэргээр, дүнд эзлэх хувиар**



Эх үүсвэр: ҮСХ. Боловсролын салбарын танилцуулга- 2017

Дээд боловсролын түвшинд суралцагч эмэгтэйчүүд боловсрол (эмэгтэйчүүдийн 20 хувь, эрэгтэйчүүдийн 7 хувь), эрүүл мэнд, нийгмийн хамгаалал (эмэгтэйчүүдийн 11 хувь, эрэгтэйчүүдийн 3 хувь) болон хүмүүнлэгийн (эмэгтэйчүүдийн 10 хувь, эрэгтэйчүүдийн 6 хувь) чиглэлд хамгийн олон байна. Харин эрэгтэйчүүд инженер (эрэгтэйчүүдийн 23 хувь, эмэгтэйчүүдийн 8 хувь) болон үйлчилгээний (эрэгтэйчүүдийн 12 хувь, эмэгтэйчүүдийн 3 хувь) чиглэлээр голлон сурч байна (Зүүлт тайлбар 29). Энэ нь хөдөлмөр эрхлэлт дэх жендэрийн хэвтээ ялгарал цаашид үргэлжлэхийг харуулж байна. Гэтэл дээд боловсролын салбарын статистик, танилцуулга, инфографикуудад хүйсээр ангилсан мэдээлэл хангалтгүйн дотор төгсөгчдийн ажил эрхлэлтийг мөшгих судалгаанд жендэрийн шинжилгээ ашиглахгүй байна.


АХБ-ны санхүүжилттэй “Дээд боловсролын шинэчлэл” төслийн хүрээнд 2018 онд хийсэн судалгаанд<sup>65</sup> ойрын ирээдүйд залуучуудын их, дээд сургуульд элсэх хувь нэмэгдсэнээр чадвар багатай оюутнууд олноор их, дээд сургуульд элсэн суралцах ба ингэснээр дээд боловсролын өгөөж мэдэгдэхүйц буурч болзошгүй гэж дүгнэсэн байгаа нь суралцагчдын хүйсийн тэнцвэр алдагдсан байгаа үед хөдөлмөр эрхлэлт, цалин хөлсний жендэрийн зөрүүг улам нэмэх нөлөөтэй.

Жендэрийн тэгш эрхийн боловсролын агуулгыг дээд боловсролын хөтөлбөрт тусгах асуудлыг тусгайлан анхаарсан бодлого зохицуулалт байхгүй байна. Гэтэл дээд боловсрол эзэмшигчид жендэрийн тэгш байдал, олон янз байдлын талаар ойлголт хандлага төлөвшөөгүй, жендэрт суурилсан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтаас сэргийлэх талаар мэдлэггүй төгсөж байна. Тиймээс дээд боловсролтой иргэн хүний жендэрийн цогц чадамжийн ерөнхий хүрээг тодорхойлон, сургалтын хөтөлбөрт, тодруулбал ерөнхий суурь хичээлийн хөтөлбөрийн агуулгад тусгах шаардлагатай байна.<sup>66</sup>

**Техникийн болон мэргэжлийн боловсрол:** Техникийн болон мэргэжлийн боловсролын сургуулиуд нь зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш уналтад орж байсан ч сүүлийн 10-аад жилд үндэсний үйлдвэрлэл сэргэж эхэлснээр эрэлт хэрэгцээ нь өсч байна. 2005 онд эдгээр сургуулийн тоо 35 байсан бол 2017 онд 83 болсны дотор хувийн өмчит сургууль зонхилж байна. АХБ, Мянганы сорилтын корпораци, ШХА зэрэг донор байгууллагын хүчин чармайлтаар сургалтын хөтөлбөр шинэчлэгдэн, багш нар чадавхижиж, сургалтын орчин сайжирснаар суралцагчдын тоо нэмэгдэж, 2005-2006 оны хичээлийн жилд 7 000 хүн төгсөж байсан бол 2015-2016 оны хичээлийн жилд 19 500 хүн төгссөн байна. Харин суралцагчдын дунд эрэгтэйчүүд зонхилж, эмэгтэйчүүдийн тоо сүүлийн жилүүдэд улам буурах хандлагатай байна (Дүрслэл 18).

<sup>65</sup> БСШУСЯ. АХБ. Дээд боловсролын шинэчлэлийн төсөл. 2018. Сургалтын үйл ажиллагаа ба хөдөлмөрийн зах зээлийн судалгаа-гарын авлага. Улаанбаатар.

<sup>66</sup> БСШУСЯ. АХБ. Дээд боловсролын шинэчлэлийн төсөл 2018. Дээд боловсролын хууль эрх зүй, бодлогын баримт бичиг дэх жендэрийн дүн шинжилгээ. Улаанбаатар.

**Дүрслэл 18.** Техникийн болон мэргэжлийн боловсролын байгууллагад суралцагчид 2008-2018 онд, хүйсээр

Эх үүсвэр: YCX. 1212.mn

Суралцагчдын мэргэжил сонголтод жендэрийн ялгаа ажиглагдаж байна. Баруун бүсэд хийсэн судалгаагаар эмэгтэй суралцагчдын 40 хувь нь тогооч, оёдолчны мэргэжлээр суралцаж байхад эрэгтэйчүүд илүү олон чиглэлээр суралцаж байна.<sup>67</sup> Техникийн болон мэргэжлийн боловсрол эзэмшихэд чухал үүрэгтэй дадлагын чанар, үр өгөөжид жендэрийн ялгаа гарч байгаа бөгөөд үүний шалтгаан нь дадлагажигч хүлээн авагч байгууллагын удирдлага, ажилтнуудын жендэрийн хэвшмэл ойлголт байна. Жишээлбэл барилгын компаниудад дадлага хийсэн охидын бараг 50 хувь нь мэргэжлээрээ ажиллах бус тогооч, үйлчлэгч зэрэг ажил хийсэн байдгаас төгссөний дараа ажлын байр олоход ур чадварын хувьд гологдож байгааг МСҮТ-ийн багш нартай хийсэн бүлгийн ярилцлага харуулсан юм.

Нийгэм дэх орлогын ялгаа ихсэж, нийгмийн бүлгүүдийн хооронд соёлын ялгарал нэмэгдэж буй энэ цаг үед олон янз байдал, жендэрийн тэгш байдлыг хүлээн зөвшөөрч дэмжихүйц үнэт зүйлийн цогцыг бүрдүүлэх, өндөр ёс суртахууныг өсвөр, залуу үед төлөвшүүлэхэд боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбар шийдвэрлэх үүрэгтэй. Боловсролын салбарын бодлого, үйл ажиллагаа нийгмийн амьдралын бүх хүрээнд, түүний дотор ялангуяа хот суурин газрын орлого багатай болон хөдөөгийн айл өрхүүдийн амьдралын хэв маягт, тэдний эдийн засаг, санхүүгийн шийдвэрт нөлөөлж, хүн амын шилжих хөдөлгөөн, нягтрал суурьшилд хэрхэн нөлөөлж байгааг анхаарч судлах шаардлагатай байна.

Хүн амын дундаж наслалт нэмэгдэн, ажил эрхлэх боломжит хугацаа уртасч байгаа атал шинэ мэргэжил эзэмших, хөрвөх боломж 40-өөс дээш насныханд бага байна. Насан туршийн боловсролын тогтолцоог жендэрийн мэдрэмжтэй хөгжүүлэх шаардлага тулгамдаж байна.

### Шигтгээ 11.

#### Насан туршийн боловсрол ба хэвшмэл ойлголт

Насан туршийн боловсрол, мэргэжил эзэмших талаар амьдралдаа нэг л удаа сураад мэргэжил эзэмшвэл боллоо гэсэн хэвшмэл ойлголт, хандлагыг өөрчлөх талаар төрөөс баримталсан цэгцтэй бодлого байдаггүй. Манайд сурч боловсрох насыг 35-аас дээш бол хязгаарлан хөгшинд тооцох хандлага нийтлэг байна.

Эх үүсвэр: Сэлэнгэ аймгийн боловсролын салбарын ажилтнуудын бүлгийн ярилцлага

Эмэгтэй, эрэгтэй хүмүүст нийгэм эдийн засгийн салбарт эн тэгш хөдөлмөрлөх, тэдний эрхэлж буй ажил нийгэмд эн тэнцүү үнэлэгдэх боломжийг бүрдүүлэхийн тулд охид хөвгүүдийн мэргэжил эзэмшихэд төдийгүй “насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэйчүүдийн боловсролын түвшний зөрүүг багасгахад чиглэсэн боловсрол нөхөн олгох албан ба албан бус сургалтад хамрагдах, тасралтгүй боловсролын үйлчилгээг хүртэх тэгш боломж, нөхцөлөөр хангагдана” хэмээсэн Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн заалтыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

<sup>67</sup> Mongolkhatan, T. & S. Enkhtuvshin. 2015. *Gender survey among TVET teachers and students in the western region of Mongolia*. GFA Consulting Group, funded by the SDC. [https://www.eda.admin.ch/dam/countries/countries-content/mongolia/en/VET\\_Gender\\_Survey\\_TVET\\_2015\\_Mongolia.pdf](https://www.eda.admin.ch/dam/countries/countries-content/mongolia/en/VET_Gender_Survey_TVET_2015_Mongolia.pdf)

**В Эрүүл мэнд**

Монгол Улс Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлснээр 2030 он гэхэд ядуурлын бүх төрлийг эцэс болгож, монгол хүний эрүүл, урт удаан амьдрах нөхцөлийг ханган дундаж наслалтыг 78-д хүргэж хүний хөгжлийн өндөр үзүүлэлт бүхий улс орнуудын эгнээнд багтаж, эхний 70 орны нэг болно гэж тооцсон байна. Монгол Улсад 2005 оноос хойш дундаж наслалт 4.69 жилээр уртасч, эхийн эндэгдэл 2 дахин, нялхсын эндэгдэл 1.9 дахин буурч, В вирүст гепатитыг хяналтанд авсан зэрэг чамгүй ололт амжилттай байна. Гэвч халдварт бус өвчин, осол гэмтлийн шалтгаанаар нас баралтын түвшин бүсийн бусад орнуудтай харьцуулахад өндөр, элэгний хорт хавдрын өвчлөлөөр нас баралтын хувиар дэлхийд дээгүүр үзүүлэлттэй хэвээр, сүүлийн жилүүдэд сүрьеэгийн тархалт буурахгүй байна.

Эмэгтэй эрэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүүг багасгах, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг жигд болгохын зэрэгцээ нөхөн үржихүйн эрүүл мэндийн хүрээнд хүчин чармайлт гаргах шаардлагатай байна. Мөн хотын агаарын бохирдлын улмаас үүсч буй өвчлөл шинэ тулгамдсан асуудал болж байна. Эрүүл мэндийн салбар хүн амын тусламж үйлчилгээний эрэлт хэрэгцээнд үндэслэн бүтэц, зохион байгуулалт болон хүний нөөцийн төлөвлөлт болон төсөвлөлт хийх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд чиглүүлэхээр зорьж байгаа нь жендэрийн хувьд эерэг үр нөлөөтэй.

**Эх хүүхдийн эрүүл мэнд, эхийн хамгаалал:** Монгол Улс нь тогтвортой хөгжлийн зорилгын хүрээнд 2020 онд эхийн эндэгдлийн түвшинг 100 000 амьд төрөлтөд 25, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшинг 1 000 амьд төрөлтөд 15, нялхсын эндэгдлийн түвшинг 1 000 амьд төрөлтөд 13 болгож бууруулах зорилт дэвшүүлсэн байна. Нийгэм эдийн засгийн шилжилтийн үед эх нялхсын эрүүл мэндийн үйлчилгээнд тулгамдсан бэрхшээлийг Монгол Улс амжилттай даван туулж, 2000 -2015 оны хооронд 100 000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийг 160-аас 44 хүртэл бууруулж, ТХЗ-ын 5-р зорилтыг амжилттай хэрэгжүүлсэн 9 орны нэг болж чадсан билээ. 2015 оноос хойш эхийн эндэгдлийн хэмжээ улам буурах чиг хандлагатай, 2017 онд 22.7, 2018 оны эхний 8 сарын байдлаар 25.2<sup>68</sup> байна. Нэг эмэгтэйн амьдралынхаа туршид төрүүлэх хүүхдийн тоо 2005 онд 1.95 болтлоо буурч, Монгол Улсын түүхэн дэх хамгийн доод хэмжээнд хүрсэн байснаа аажим өссөөр 2017 онд 2.8 болоод байна.<sup>69</sup>

Дэлхийн банкнаас тодорхойлсон хөгжлийн үзүүлэлтүүдээр Монгол Улс эхийн эрүүл мэнд, нөхөн үржихүйн үзүүлэлтүүдээр бүс нутагтаа төдийгүй дэлхийн хэмжээнд сайн үзүүлэлттэй байна (Хүснэгт 3). Монгол Улс олон улсын холбогдох гэрээ конвенцид нэгдэж, Үндсэн хуулиндаа эх хүүхдийн эрүүл мэндийг тусган, ЖЭТБХТХууль болон Засгийн газрын эрүүл мэндийн талаарх бодлого хөтөлбөрт тусгах зэргээр эхийн эрүүл мэндийг дэмжих эрх зүйн хүчирхэг орчин бүрдүүлснээр эхийн эндэгдлийг бууруулж чадсан байна. Монгол эхчүүд жирэмслэлт, төрөлт болон төрсний дараах эрүүл мэндийн үйлчилгээг үнэ төлбөргүй авах боломжтойн дээр хөдөө орон нутгийн эрсдэлтэй жирэмсэн эхчүүдэд зориулсан амрах газруудыг бий болгож теле-анагаах ухааны үйлчилгээ нэвтэрч байна.


**Хүснэгт 3. Эхийн эрүүл мэнд, нөхөн үржихүйн үзүүлэлтүүд Монгол Улсад болон олон улсад (тэмдэглэснээс бусад нь 2015 оны байдлаар)**

Үзүүлэлтүүд	Монгол Улсад	Зүүн Ази, Номхон далайн бүсэд	Дэлхийд
Өсвөр насны охидын төрөлтийн хувь (1 000 төрөлтөд)	15.0	21.64	44.1
Эхийн эндэгдлийн насан туршийн эрсдэл (%)	0.13	0.11	0.56
Эхийн эндэгдлийн түвшин (100 000 амьд төрөлтөд)	44.0	59.0	216.0
Эмнэлгийн хяналтад хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүд (%)	98.7	95.1 (2012)	83.9 (2012)
Эрүүл мэндийн үйлчилгээ авч амаржсан эх (% нийт дүнд эзлэн хувь)	98.9 (2013)	93.6 (2013)	78.3 (2013)

Эх сурвалж: Дэлхийн банк. Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүд. 2017

2012 он хүртэл эхийн эндэгдэл ихэвчлэн хөдөө орон нутагт гарч байсан бол түүнээс хойш бүс нутгуудын үзүүлэлтүүд сайжирч, нийслэлийнхээс доогуур болжээ (Дүрслэл 19).

Дүрслэл 19. Эхийн эндэгдлийн түвшин 2005-2017 онд, бүсээр



Эх үүсвэр: YCX. 1212.mn

Гэвч тусламж үйлчилгээний чанарын хүрээнд анхаарах асуудал байсаар байна. YCX-ны тооцоолсноор 2013 онд жирэмсэн эхчүүдийн 37.3 хувь нь төрөхийн өмнөх тусламж үйлчилгээ авсан байна (ANC).<sup>70</sup> Харин НҮБХАС-ын тооцоогоор эхийн эндэгдлийн 45 хувь нь төрөхийн өмнөх, төрөх үеийн болон төрсний дараах чанаргүй тусламж үйлчилгээтэй холбоотой байна. Ор хүрэлцэхгүйн улмаас төрөхөөс эрт гарсан эмэгтэйчүүдийн санал гомдолд зарим байгууллага дарагдсан байна.<sup>71</sup> Эхийн эрүүл мэндэд шилжих хөдөлгөөн иргэний бүртгэлийн асуудал ихээхэн нөлөөлж байна. 2013 оны тайлангаас үзэхэд Улаанбаатар хотод шилжин суурьшсан эмэгтэйчүүдийн гуравны нэг нь эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй байсан (Зүүлт тайлбар 42) нь тэдний эмнэлгийн тусламж үйлчилгээ авахад хязгаарлалт болж байж болзошгүйг сануулж байна. ДЭМБ-ын зөвлөснөөр нийт төрөлтийн 5-15 хувь нь мэс заслын аргаар төрүүлж болно гэж үздэг. Харин манай улсын хувьд 2016 оны байдлаар харьцангуй өндөр буюу 25.4 хувь нь мэс заслын аргаар хүүхдээ төрүүлсэн<sup>72</sup> байгаагийн шалтгаан, үр дагаврыг судлах шаардлагатай байна.

Эхчүүдэд чиглэсэн үйлчилгээний чанарыг сайжруулах, жишээлбэл хөгжлийн бэрхшээлтэй эхчүүдийн тусгай хэрэгцээнд нийцсэн дэд бүтэц, хүний нөөцийн чадавхийг хөгжүүлэх шаардлагатай. Тулгуур эрхтний бэрхшээлтэй эхчүүдэд зориулсан төрөх ор байхгүй, сонсгол болон харааны бэрхшээлтэй эхчүүдийн төрөлтийг удирдах дохионы хэл эзэмшсэн эмч сувилагч байхгүй зэрэг асуудал байгааг эрүүл мэндийн салбарын хэлэлцүүлэгт оролцогчид дурьдсан юм.

Мөн зарим дүрэм журмыг нийгмийн өөрчлөлттэй холбоотой эргэн харах хэрэгцээ байна. Жишээлбэл төрөх эмэгтэй амаржих газарт түргэн тусламжаар төдийгүй өөрөө хүрэлцэн ирэх боломжтой болохыг анхаарч, харъяалал харгалзахгүй яаралтай тусламж үйлчилгээ үзүүлэх, эмнэлэгт орж ирсэн эхийг хүлээн авах, тасагт хүргэхэд чиглэсэн эмнэлгийн дотоод зохион байгуулалтын арга хэмжээ авах хэрэгтэйг 2018 онд Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд таксигаар очиж, таксин дотроо хүүхдээ төрүүлсэн эхийн тохиолдол гэрчилж байна.

**Нялхас болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл:** Сүүлийн жилүүдэд нялхсын болон тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл эрчимтэй буурсаар 2015 онд Мянганы хөгжлийн зорилтын үзүүлэлтийг хангасан. 2016 онд 1990 оны түвшинтэй харьцуулахад 1 000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдэл 3.8 дахин, тав хүртэлх насны хүүхдийн 4.2 дахин буурсан байлаа. Улаан бурхан өвчний дэгдэлтийн улмаас 2016 онд нялхсын эндэгдэл эргэн өссөн ч 2017 оны 10-р сарын эрүүл мэндийн үзүүлэлтээс харахад эргэж буурах хандлага ажиглагдаж байна. Урт хугацаанд харахад 2005 оноос 2017 он хүртэлх хугацаанд 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдэл 26.1-ээс 13.6 хүртэл, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 20.8<sup>73</sup>-аас 16.7 хүртэл буурсан байна.

Бүс нутгуудын нялхсын болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн үзүүлэлт Улаанбаатар хотын үзүүлэлттэй харьцуулахад харьцангуй өндөр байгаа ч 2005 оноос хойш бүс нутгийн ялгаа багасч байна. 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 2005 онд Зүүн, баруун бүсэд, түүний дотор илүү алслагдсан Увс, Сүхбаатар аймгуудад илүү өндөр байсан бол 2017 онд бусад орон нутгийн хэмжээнд хүрч буурсан байна. Нярай болон 5 хүртэлх насны эрэгтэй хүүхдийн эндэгдэл давамгайлж байна (Хүснэгт 4).

<sup>70</sup> MoH and UNFPA. 2018. *Global Sustainable Development Agenda and the Mongolian Sustainable Development Vision 2030: Linkages with Sexual and Reproductive Health and Rights*. Ulaanbaatar: UNFPA Mongolia.

<sup>71</sup> S. Alгаа. 2015. *Country Profile: On Universal Access to Sexual and Reproductive Health: Mongolia*. Ulaanbaatar: MONFEMNET. <http://arrow.org/my/wp-content/uploads/2015/04/Country-Profile-SRH-Mongolia.pdf>

<sup>72</sup> Эрүүл мэндийн хөгжлийн төв. 2017. *Эрүүл мэндийн үзүүлэлт-2016*. Улаанбаатар.

<sup>73</sup> UNICEF. 2009. *Монголын хүүхэд эмэгтэйчүүдийн байдал*. Улаанбаатар.

**Хүснэгт 4. Хүүхдийн эндэгдэл дэх жендэрийн зөрүүтэй байдал 2017 онд**

	Эрэгтэй	Эмэгтэй	Эндсэн эрэгтэй, эмэгтэй хүүхдийн хүйсийн харьцаа
Амьд төрсөн хүүхдийн тоо	38538	35790	1,076
Нярайн үеийн эрт эндэгдэл	282	193	1,46
Нярайн үеийн хожуу эндэгдэл	94	78	1,2
5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	693	551	1,25

Эх үүсвэр: ЭМХТ, Эрүүл мэндийн үзүүлэлт 2017

Монгол Улсад 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг зөвхөн өмнөх онтой харьцуулан тайлагнах байдал түгээмэл ба хүйсийн харьцааг тэр бүр онцолж үздэггүй. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын үзэж байгаагаар биологийн шалтгаанаар хөвгүүд перинаталь үедээ илүү эмзэг байдгаас шинэ төрсөн нярай охидын амьдрах чадвар хөвгүүдийнхээс илүү байдаг байна. Дэлхийн зарим газар нутагт охидыг ялгаварлан гадуурхах хандлагаас болж охидын эндэгдэл илүү байх тохиолдол бий. Харин Монгол Улсад 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн дотор хөвгүүд давамгайлж, хүйсийн зөрүү дэлхийн (1.22) болон бүс нутгийн (1.10) дунджаас өндөр байсан ба энэ хандлага 2005 оноос хойш хадгалагдаж<sup>74</sup> байгааг анхаарах хэрэгтэй. Энэхүү ялгаатай байдлын шалтгаан тодорхойгүй, мэдээлэл бага байна. Зүүн болон баруун бүсэд хөвгүүдийн эндэгдэл илүү өндөр (хүйсийн харьцаа 1.8) байгаа нь мал аж ахуйтай, эсвэл цэцэрлэгийн хүртээмжтэй холбоотой байж болох юм.

Тав хүртэлх настай хүүхдийн эрүүл мэндийн хяналтыг сайжруулахаас гадна эцэг эхчүүдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх шаардлага харагдаж байна. Сүүлийн жилүүдэд, тухайлбал 2015 оноос бага насны хүүхдийн шүдний цоорлын асуудал нэлээд хурцаар тавигдаж байна. 2015 онд хийсэн “Амны хөндийн эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн төгсгөлийн үнэлгээгээр зүрх судас, бөөр, хоолойны ангина гэх мэт элбэг тохиолдох өвчний суурь болдог шүдний цоорлын тархалт нийслэлийн хэмжээнд 5-6 насны хүүхдийн дунд 76.1 хувьтай байжээ.

Сүүлийн жилүүдэд эх, хүүхдийн эрүүл мэндэд онцгой хор хөнөөлтэй хүчин зүйл нь хот суурин газрын агаарын бохирдол болж байна. Агаарын бохирдол нь ургийн өсөлт саарах, хугацаанаас өмнө төрөх, зулбах, нярайн жин буурах хүчин зүйл болдог байна.<sup>75</sup> АШУҮИС-ийн НЭМС-иас Улаанбаатар хотод хийсэн судалгаагаар эрт төрөлт хотын агаарын бохирдолтой шууд холбоотой гэжээ. Мөн бронхит, астма зэрэг хүүхдийг ихээр сульдаадаг өвчлөл нь агаарын бохирдолтой холбоотой байна. Хатгаа нь 5 хүртэлх насны хүүхдийн нас баралтын гол шалтгаан болж байгаа бөгөөд ялангуяа Улаанбаатар хотын хүүхдийн уушигны үйл ажиллагаа нь хотын гадна амьдарч буй хүүхдийнхтэй харьцуулахад 40 хувь доогуур байна. Энэ нь Улаанбаатарын гэр хорооллын хүүхдүүдэд хамгийн их хамаатай байна. Гаднах агаараас гадна гэрийн доторх агаарын бохирдол гэрт, ялангуяа зуухны хажууд илүү их цаг өнгөрүүлдэг эмэгтэйчүүд, хүүхдүүдэд илүү нөлөөлж байна.

Засгийн газраас 2017 онд Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрт Улаанбаатар хотын гэр хорооллын 190 мянга гаруй өрхийн ариун цэврийн байгууламжийн 80 хувь нь стандартад нийцэхгүй, ялангуяа хүүхэд, өндөр настны дунд агаарын бохирдлоос шалтгаалсан амьсгалын замын өвчлөл улам ихэсч байгааг онцолсон байна. Айл өрхүүд хүчтэй ариутгах бодис хэрэглэх,<sup>76</sup> гэр хорооллын оршин суугчид юм угаасан усаараа шал угаах зэргээр дахин ашиглах, угаадсаа гудамж руу асгах зэрэг зуршил нь хотын агаар, хөрсний бохирдол төдийгүй гэрийн доторх агаарын бохирдолд нэрмээс болж, эх, хүүхдийн эрүүл мэндийн эрсдлийг ихэсгэж байна.

**Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд:** Эрүүл мэндийн хүрээнд жендэрийн хувьд хамгийн анхаарал татсан асуудал бол эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүү юм. Дэлхийн хэмжээнд эмэгтэйчүүд дунджаар 4.3 жилээр илүү насалж байгаа бол 2018 оны байдлаар Монгол Улсад 9.67 жил байна. Эмэгтэй эрэгтэй хүний дундаж наслалтын зөрүү 1992 онд 4.19 байжээ. Гэвч 1995-1998 онуудад эрэгтэйчүүдийн дундаж наслалт огцом буурсан нь зах зээлийн эдийн засагт шилжсэнээс үүдсэн сөрөг үр дагаварын нөлөө байна. Харин 2000 оноос хойш дундаж наслалт тууштай нэмэгдэж байгаа ч жендэрийн зөрүү нь ихэссээр байна (Дүрслэл 20).


<sup>74</sup> Тэмдэглэл: Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүд дэх нялхсын болон тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн хувь үндэсний статистикийн мэдээллээс өндөр байна.

<sup>75</sup> Davy, P. L., G. Gunchin and A. Markwitz. 2011. *Air Particulate Matter Pollution in Ulaanbaatar, Mongolia: Determination of Composition, Source Contributions and Source Locations*. *Atmospheric Pollution Research*, 2, 126-137.

<sup>76</sup> Sayed M. N. Uddin et. al. 2015a. *Opportunities and Challenges for Greywater Treatment and Reuse in Mongolia: Lessons Learnt fro Piloted Systems*. In ACF, Sustainable sanitation for vulnerable population in periurban areas of Ulaanbaatar, Mongolia. Compendium of 14 thematic papers.



Дүрслэл 20. Дундаж наслалт 1992-2018 онд, хүйсээр



Эх үүсвэр: YCX. 1212.mn

Эмэгтэй эрэгтэй хүний дундаж наслалт болон түүн дэх жендэрийн зөрүү газарзүйн байршилтай холбоотойгоор ихээхэн ялгаатай байна (Хүснэгт 5).

Хүснэгт 5. Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүү 2005 ба 2018 онд, аймгаар

	Эрэгтэй		Эмэгтэй		Эрэгтэй эмэгтэйчүүдийн дундаж наслалтын зөрүү	
	2005	2018	2005	2018	2005 он	2018 он
Улсын дүн	62,11	66,11	68,61	75,78	-6,5	-9,67
Баян-Өлгий	65,34	70,31	69,54	75,36	-4,2	-5,0
Говь-Алтай	60,31	65,09	66,24	74,34	-5,93	-9,32
Завхан	61,6	67,92	65,72	73,27	-4,12	-5,35
Увс	59,72	64,31	66,08	73,3	-6,36	-8,99
Ховд	63,01	69,2	69,2	75,42	-6,19	-6,22
Архангай	62,78	68,63	67,33	73,08	-4,55	-4,45
Баянхонгор	60,37	66,98	64,58	71,85	-4,21	-4,82
Булган	64,24	68,76	69,67	76,41	-5,43	-7,65
Орхон	64,48	70,77	73,6	82,51	-9,12	-11,74
Өвөрхангай	62,89	67,83	67,41	73,43	-4,52	-5,6
Хөвсгөл	58,69	63,52	63,33	71,62	-4,64	-8,1
Говьсүмбэр	66,28	72,6	71,07	76,29	-4,79	-3,69
Дархан-Уул	59,24	64,37	67,09	74,59	-7,85	-10,22
Дорноговь	60,43	66,55	69,02	77,29	-8,59	-10,77
Дундговь	65,2	70,82	71,39	78,62	-6,19	-7,8
Өмнөговь	62,9	68,08	69,15	77,23	-6,25	-9,15
Сэлэнгэ	62,39	67,67	70,66	78,49	-8,27	-10,62

Төв	64,44	70,44	70,09	75,21	-5,65	-4,77
Дорнод	57,8	65,25	64,9	73,89	-7,1	-8,64
Сүхбаатар	61,75	67,58	70,84	77,75	-9,09	-10,17
Хэнтий	62,97	69,3	68,16	76,29	-5,19	-6,99
Улаанбаатар	61,25	66,83	68,95	75,05	-7,7	-8,22

Эх үүсвэр: YCX. 1212.mn

2018 оны байдлаар эмэгтэйчүүд Говь-Алтай, Увс, Ховд, Архангай, Баянхонгор, Өвөрхангай, Хөвсгөл, Сүхбаатар аймгуудад, харин эрэгтэйчүүд Говь-Алтай, Увс, Хөвсгөл, Дархан-уул, Дорнод аймгуудад улсын дунджаас доогуур насалж байна.

Дундаж наслалт дахь жендерийн зөрүү хамгийн өндөр наслалт бүхий Орхон аймагт хамгийн өндөр (11,74 жил) байгаа ба, Дорноговь, Дундговь, Сэлэнгэ, Сүхбаатар аймгуудад 10 жилээс дээш байна. Дундаж наслалтын зөрүү орон нутгаар ийнхүү ялгаатай байгаагийн шалтгааныг нарийвчлан судлах шаардлага харагдаж байна.

Эрэгтэйчүүдийн дундаж наслалт ийнхүү богино байгаа нь архи тамхины хэт хэрэглээ, амьдралын эрүүл бус хэв маяг, түүний дотор буруу хооллолт, дасгал хөдөлгөөний дутагдал, аюул осолд илүү өртөмтгий байдлаар голлон тайлбарлагдаж байна. Монголын эрэгтэйчүүдийн холбоо болон Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн тайлангаас үзэхэд эрэгтэйчүүдийн тал шахуу хувь нь архинаас ямар нэг хэмжээгээр хамааралтай, 45 хувь нь тамхи татдаг байна.<sup>77</sup> Гэвч эдгээр тоо мэдээллийн цаана архинд донтох, амиа хорлох, хүчирхийлэл үйлдэхэд хүргэж буй сэтгэцийн эрүүл мэнд, түүнд нөлөөлж буй хүчин зүйлс байгааг анхаарах нь зүйтэй байна. Хамгийн сүүлд 2013 онд хийсэн судалгаагаар<sup>78</sup> Монгол Улсад арван жилийн дотор архинд донтох эмгэг 25 дахин, сэтгэл түгших эмгэг 8 дахин, сэтгэл гутрах эмгэг 7 дахин өсч, судалгаанд хамрагдсан нийт хүн амын 65 хувьд нь сэтгэцийн тулгамдсан асуудал (сэтгэл түгшилт 18.5 хувь, нойргүйдэл 17.1 хувь, архаг ядаргаа 16.2 хувь, сэтгэл гутрал 6.6 хувь, архинд донтох эмгэг 6.2 хувь) байгаа нь сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал манайд эрчтэй явагдаж байгааг харуулж байна. Судалгааны үр дүн нийгмийн хүчин зүйлсийн шалтгаант, стрессийн гаралтай сэтгэцийн эмгэг ихсэх хандлагатайг харуулжээ. “Эрчүүд-эрүүл гэр бүл төв” ТББ-ын 2014-2016 онуудад хийсэн фокус бүлгийн ярилцлагад оролцогчид архи уух шалтгааны дотор гомдох, уурлах, сэтгэлээр унах, бухимдах зэрэг сэтгэл хөдлөлийг түгээмэл нэрлэсэн байна. Манай улс Ази, Номхон далайн орнуудаас сэтгэл гутралд өртөж буй эмгэгээр 7-рт, бусад төрлөөр 3-рт эрэмбэлэгджээ. Гэтэл Монгол Улсад сэтгэцийн тулгамдсан асуудалтай хүмүүст үйлчилдэг эрүүл мэндийн тогтолцоо сул, сэтгэцийн эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх туршлага дутмаг байна. Сүүлийн үед компьютер тоглоомд хөвгүүд донтох явдал газар авч байгаа нь дээрх чиглэлийн тусламж үйлчилгээг яаралтай сайжруулахаас гадна холбогдох салбарууд хамтран ажиллаж шийдлийг олох шаардлагатай байна.

2016 онд зүрх-судасны тогтолцооны шалтгаант нас баралтын түвшин 10 000 эрэгтэй хүн амд 20.54, 10 000 эмэгтэй хүн амд 14.46 ногдож байгаа ба 2007 онтой харьцуулахад дээрх шалтгааны улмаас үүссэн эрэгтэйчүүдийн нас баралт буурах хандлагатай байна. Гэвч 45-64 насны эрэгтэйчүүдийн дунд зүрхний ишемийн өвчний шалтгаант нас баралт эмэгтэйчүүдийнхээс 4.7 дахин, тархинд цус харвалтын өвчний шалтгаант нас баралт 2.0 дахин, цусны даралт ихсэх өвчний шалтгаант нас баралт 1.4 дахин их байна (Зүүлт тайлбар 80). Гэтэл эрүүл мэндийн байгууллагад хандаж буй эрэгтэйчүүдийн тоо эмэгтэйчүүдийнхээс 2.3 дахин доогуур байна.<sup>79</sup> Мөн монгол эрэгтэйчүүдийн осол гэмтэл, гадны бусад нөлөө (24.9 хувь), хавдрын шалтгаант нас баралт (19.4 хувь) дэлхийн дунджаас дээгүүр байна (Зүүлт тайлбар 73). Амиа хорлолт болон зам тээврийн осолтой холбоотой нас баралтын түвшин Монгол Улсад өндөр бөгөөд эрэгтэйчүүд илүү өртөж байна. 2015 онд ДЭМБ-аас хийсэн судалгааны дүнгээс харахад амиа хорлолтоор Монгол Улс дэлхийд гуравдугаар байранд орж байгаагийн дотор амиа хорлогчдын 86 хувь нь эрэгтэйчүүд байна.<sup>80</sup>

Архины хэрэглээ нь эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөөд зогсохгүй хөдөлмөр эрхлэхэд садаа болж, гэр бүлийн хүчирхийллийг нэмэгдүүлж, хүүхдийн аюулгүй байдалд ноцтой нөлөөлөх хүчин зүйл болжээ. Ядуу өрхийн хүүхдүүд дундаас архины хамааралтай эцэг эхийн хүүхдүүд илүүтэй сургууль завсардаж, хүүхдийн хөдөлмөрт мөлжүүлж, гуйлга гуйж байна (Зүүлт тайлбар 16). Гэвч харамсалтай нь Засгийн газраас энэ байдлыг залруулах тууштай арга хэмжээ авахгүй байгаа нь УИХ-ын гишүүдийн дунд архи, согтууруулах ундаа үйлдвэрлэгчид олон, мөн төсвийн нилээд хэсгийг архины татвараас бүрдүүлдгээс үүдсэн ашиг сонирхлын зөрчлөөс үүдэлтэй байна.<sup>81</sup>

<sup>77</sup> Tsengel, K. 2017. "Can helping men in Mongolia improve life for women?" Global Post. 20 December. <https://www.pri.org/stories/2017-12-20/can-helping-men-mongolia-improve-life-women>

<sup>78</sup> ДЭМБ. 2013. Хүн амын дунд зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэгийн тархалт. Улаанбаатар.

<sup>79</sup> Б.Цолмон, А.Долгион. 2014. Монгол улс дахь жендерийн эрх тэгш байдал: (Нөхцөл байдлын товч үнэлгээ, Баримт бичгийн судалгаа). Улаанбаатар.

<sup>80</sup> Alyson Brody and S. Sharkuu. 2018. *Mongolia Country Gender Profile*. The European Union Economic Governance for Equitable Growth (EG4EG) Project Mongolia. Ulaanbaatar.

<sup>81</sup> Armstrong, S. and B. Tsogtbaatar. 2010. *The dual nature of alcohol use and abuse in Mongolia: Reflections through policy*. Asia Pacific Journal Public Health 22(3). Hong Kong.

**Шигтгээ 12.**

**Архины хэрэглээ ба эрэгтэйчүүд**

Манай гэрийн өмнө нийтийн эзэмшлийн талбай бий. Дотуур байранд амьдардаг оюутан залуус энд олон байдаг. Тэд гол төлөв архи ууснаас болж хэрэлдэж маргах нь элбэг. Би энд насаараа амьдарч байна. Олон эмэгтэйчүүдээс амьдралынхаа төлөв зүтгэж, буланд өдөржин зогсож юм зарж байгааг нь сонсдог. Эрчүүд сайндаа л хүүхдээ хардаг. Нөхрүүдээрээ юм заруулаач гэхэд “Үгүй ээ үгүй, тэд бүгдийг нь уучихна” гэдэг юм. Архидалт хэт их байна. (55 орчим насны эмэгтэй)

Ажилгүй эрчүүдэд гэрт хийх юм олдохгүй. Бусад ажилгүйчүүдтэйгээ нийлэн цуглаж, байгаа мөнгөө цуглуулж архи аваад өдөржин уудаг. Орой нь гэртээ согтуу хариад эхнэр хүүхдэдээ гай болно. (55 орчим насны эрэгтэй)

Эх үүсвэр: ADB. 2017. Rapid Assessment of Gender-Based Violence in Urban Ger Area Communities. TA Consultant's report


УИХ-ын эмэгтэй гишүүдийн санаачлан батлуулсан Тамхины хяналтын тухай хуулийн (2015) тамхи худалдаалах цэгийг сургууль, цэцэрлэгээс тодорхой зайд байлгах, нийтийн эзэмшлийн орчинд тамхи татахгүй байх зэрэг үр дүнтэй хэрэгжиж буй заалтууд нийгэмд эерэг нөлөөтэй байна. Гэвч харамсалтай нь 2015 онд уг хуульд орсон нэмэлт өөрчлөлтөөр тамхи татах цэг байгуулахыг зөвшөөрсөн нь Монгол Улсын нэгдэн орсон ДЭМБ-ын Тамхины хяналтын суурь конвенцийг зөрчсөн байна.

Монгол Улсад үйлдвэрлэлийн осол ялангуяа барилга, уул уурхай, зам тээврийн салбарт өндөр байна. 2016 оны байдлаар ажлын байран дахь осол гэмтлийн улмаас нас барагсдын 100 000 ажилчинд эзлэх хувь 21 орны дунджаар 3.3 байсан бол Монгол Улсад 4.7 байжээ.<sup>82</sup> 2017 онд ажлын байранд осол гэмтэл авсан хүмүүсийн 68.4 хувь нь эрэгтэйчүүд байжээ (Зүүлт тайлбар 29). Монгол Улс нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн талаарх 155-р конвенцид нэгдсэн боловч үйлдвэрлэлийн осол гэмтлийг бүртгэх, тэмдэглэх, нийтлэх талаарх 2002-р Протокол болон 1947 оны Хөдөлмөрийн хяналт шалгалтын талаарх 81-р конвенцид нэгдээгүй байна. Эрэгтэйчүүдийн дунд түрүү булчирхайн үрэвсэл болон бэлгийн замын халдварт өвчлөл ихэсч байгаа талаар нийгэмд мэдээлэл их тарж байгаа ч бодитой тоо баримт, мэдээлэл хомс байна.

2018 оны эхний 11 сарын байдлаар ХДХВ/ДОХ-ын нийт 267 тохиолдол бүртгэгдсэний 20.6 хувь нь хөдөө, 79.4 хувь нь Улаанбаатарын харьяат иргэд байжээ. Бүртгэгдсэн тохиолдлууд бүгд бэлгийн замаар дамжсан нь тогтоогдсон байна. Нийт бүртгэгдсэн тохиолдлын 20 хувийг 15-24 насны, 40 хувийг 25-34 насныхан эзэлж байгаа юм. ХДХВ/ДОХ-ын нийт бүртгэгдсэн тохиолдлын 18.4 хувийг эмэгтэйчүүд, 81 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна.

**Бэлгийн ба нөхөн үржихүйн эрүүл мэнд ба эрх:** Үр хөндөлтийн тоо 2005 онтой харьцуулахад 2017 онд зонхилон Улаанбаатар хотод бараг 2 дахин нэмэгдсэн байна. 15-19 насны охидын үр хөндөлт 2011 онд огцом буюу 40 хувь нэмэгдсэн боловч 2012 оноос хойш 2017 он хүртэл 60 хувь буурчээ. Бусад насны бүлэгт ч үр хөндөлт сүүлийн 2-3 жилд буурах хандлага ажиглагдаж байна (Дүрслэл 21). Гэвч үр хөндөлтийн тоо ийнхүү буурч байгаад жирэмслэлтээс хамгаалах “72 цагийн эм”-ийн хэрэглээ нөлөөлж байж болзошгүйг цаашид анхааран судлах хэрэгтэй.

**Дүрслэл 21. Үр хөндөлтийн тоо 2005-2017 онд, насны бүлгээр**



Эх үүсвэр: YCX. 1212.mn

1998-2012 онд ажилгүй болон гэрийн ажилтай эмэгтэйчүүд, харин 2012 оноос хойш ажилтай эмэгтэйчүүд илүү үр хөндүүлж байна. Үр хөндүүлсэн малчин эмэгтэйчүүдийн эзлэх хувь тасралтгүй буурах хандлагатай болжээ.<sup>83</sup> Харин хувийн эмнэлэгт хийгдэж буй үр хөндөлтийн тоо нэмэгдэх хандлагатай байгааг анхаарах шаардлагатай байна. Үр хөндүүлсэн эмэгтэйчүүдтэй хийсэн ганцаарчилсан ярилцлагаас үзэхэд ажил, орлогоо хадгалж зээлээ төлөх хэрэгцээ, үргэлжлүүлэн суралцах шаардлага, төрөлт хоорондын зай хэтэрхий ойртсон, нялх хүүхэд харах хүнгүй, гэр бүл болон нөхрийн зүгээс халамж дэмжлэг сул, нөхөр\хамтран амьдрагчийн харилцаа таагүй, тохиолдлын бэлгийн харилцаанаас шалтгаалан жирэмсэлсэн зэрэг шалтгаантай байна.<sup>84</sup>

2016 оны байдлаар 15-49 насны эмэгтэйчүүдийн 54.0 хувь нь ямар нэг жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэглэж байна. Өсвөр насны охидын төрөлтийн түвшин 2000 оноос 2016 оны хооронд бага зэрэг хэлбэлзсээр 25.5-аас 24.3 хүртэл буурсан байна.<sup>85</sup> 2013 онд хүүхэд төрүүлсэн охидын 50 хувь нь боловсролгүй, 25 хувь нь "санхүүгийн бэрхшээлтэй" байжээ.

**Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж:** Монгол Улс нь эмнэлгийн ор болон эмнэлгийн ажилтны хүртээмжийн үзүүлэлтээр Зүүн Ази, Номхон далайн бүс, түүнчлэн дэлхийн дунджаас ч дээгүүр байна (Зүүлт тайлбар 88). Гэвч эрүүл мэндийн салбарт зарцуулж буй төсвийн хэмжээ хангалтгүй байна. 2014 онд Зүүн Ази, Номхон далайн орнуудын нэг хүнд ногдох эрүүл мэндийн төсөв дунджаар 893 ам.доллар байхад Монгол Улсын хувьд 565 ам. доллар байна. Гэтэл хувь хүнээс гарсан зардалын эзлэх хувиар дэлхийн дунджаас дээгүүр байгаа нь эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж үйлчлүүлэгчийн төлбөрийн чадвараас ихээхэн хамааралтайг харуулж байна.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр (2017) болон Эрүүл мэндийн салбарын жендэрийн тэгш байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө (2017)-д эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн өвөрмөц хэрэгцээнд нийцсэн тусламж үйлчилгээ үзүүлэх ажилтныг бэлтгэх, улмаар аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгүүдэд эрэгтэйчүүдийн кабинет ажиллуулахаар төлөвлөсөн. Гэвч эрэгтэйчүүдийн эмч нарыг нэн даруй бэлтгэх, ялангуяа хөдөө орон нутагт эрэгтэйчүүдийн эрэгтэй эмч байх зайлшгүй хэрэгцээг анхаарч, шаардагдах санхүүжилтийг төсөвлөх хэрэгцээ тулгамдаж байна.

### Шигтгээ 13.

#### Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн үйлчилгээний хэрэгцээ

*Бэлгийн замын халдварт өвчний гаралт Орхон аймагт өндөр байгааг Эрүүл мэндийн газраас гаргасан судалгаанаас харж болно. Дийлэнх нь 18-45 насны эрчүүд байгаа ч эрэгтэйчүүдийн эмнэлэг байхгүйгээс эмэгтэйчүүдийн эмнэлэгт ханддаг. Хувийн лабораторид ихэнх эрчүүд шинжилгээ өгөхөөр очдог ч эрэгтэйчүүдийн өвчлөлөөр мэргэжсэн эмч байхгүй тул нөхөн үржихүй, эмэгтэйчүүдийн эмнэлгийг зааж өгөөд явуулдаг. Орхон аймагт 3 жилийн өмнө эрэгтэйчүүдийн нэг эмч ажилладаг байсан, тэтгэвэрт сууснаар энэ төрлийн үйлчилгээ үзүүлдэг газар одоог хүртэл дахин нээгдээгүй байна.*

*Эх үүсвэр: «Онош» лабораторийн эмч Л.Байгалмаагийн ярилцлага, 2018*  
*erdenetpost.mn/show/180400008*

ЭМЯ олон улсын түншлэгчидтэй хамтран Улаанбаатар хотын Баянгол дүүрэгт өсвөр үе, залууст ээлтэй клиник байгуулах, бэлгийн эрүүл мэндийн талаар оюутнуудад зориулсан хөтөлбөр боловсруулах зэрэг санаачлага хэрэгжиж байгаа ч цар хүрээ нь хангалтгүй, ялангуяа алслагдсан хөдөө орон нутгийн хүүхэд залууст хүртээмжгүй байна.

## Г Улс төр, шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн манлайлал

Монгол Улсын иргэд хүйсээсээ үл хамааран шийдвэр гаргах түвшинд ялангуяа үндэсний, орон нутгийн хууль тогтоох дээд байгууллагад сонгох, сонгогдох тэгш эрхтэй, эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны эрхийг дэлхийн олон орноос эрт, 1924 онд Үндсэн хуулиар баталгаажуулсан атал өнөөдөр тэдний оролцоо улс төр, шийдвэр гаргах түвшинд бага хэвээр байна.

**Үндэсний болон орон нутгийн парламент дахь эмэгтэйчүүдийн манлайлал.** 2005 оноос УИХ-д нэр дэвших эмэгтэйчүүдийн тоо тасралтгүй өсч нийт нэр дэвшигчдийн 32 хувьд хүрч эмэгтэй гишүүдийн тоо 3-аас 13 болж нэмэгдсэн хэдий ч улс төр, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог 30.0 хувь болгох МХЗ-ын зорилтоо 2015 онд хангаж чадаагүй. 2016 онд УИХ-д сонгогдсон эмэгтэйчүүдийн эзлэх хувь 17.1 хувь болж түүхэндээ

<sup>83</sup> УСХ. 2018. Эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэнд. Улаанбаатар.


<sup>84</sup> ЭМЯ, НҮБХАС. 2018. Монгол улс дахь гэр бүл төлөвлөлтийн чанарын судалгаа. Улаанбаатар.

<sup>85</sup> World Bank. 2018. World Development Indicators. <https://datacatalog.worldbank.org/dataset/world-development-indicators>. Washington D.C.

өндөр үзүүлэлтэнд хүрсэн ч энэ нь дэлхийн дунджаас (2017 онд 23.7 хувь) болон Зүүн Ази, Номхон далайн бүсийн дунджаас (2017 онд 19.7 хувь) доогуур хэвээр байна. 2017 оны Жендэрийн зөрүүтэй байдлын тайланд улс төрийн эрх мэдлийн үзүүлэлтээр Монгол Улс 144 орноос 107-д эрэмбэлэгдсэн байна (Зүүлт тайлбар 2).

Эмэгтэйчүүдийн улс төр дэх оролцооны талаарх нийгэмд тогтсон жендэрийн хэвшмэл ойлголтыг өөрчлөх чиглэлээр Жендэрийн үндэсний хороо, ТББ-ууд, олон улсын байгууллагуудаас ухуулга сурталчилгаа, нөлөөллийн ажлуудыг сүүлийн 16 жилд тасралтгүй явуулснаар Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуульд нам эвслээс нэр дэвшүүлэх эмэгтэйчүүдийн тооны доод хязгаар (20.0 хувь)-ыг тусгаж чадсан билээ. Энэ тууштай үйл ажиллагаа нь эмэгтэйчүүдийг урамшуулан зоригжуулснаар УИХ-д нэр дэвшигчдийн дунд эзлэх хувь нь нэмэгдсэнийг үгүйсгэх аргагүй (Дүрслэл 22). Мөн Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль батлагдсаны дараах 2013 оны ерөнхийлөгчийн сонгуульд анх удаа эмэгтэй (Н.Удвал) хүн нэрээ дэвшүүлж өрсөлдөхөд ч дээрх хүчин чармайлт нөлөөлж, 2011 онд батлагдсан Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль дэмжлэг болсон нь лавтай.

**Дүрслэл 22. Улсын Их Хуралд нэр дэвшигчид болон сонгогдсон гишүүдэд эмэгтэйчүүдийн эзлэх хувь, сонгуулийн жилээр**



Эх үүсвэр: Монгол улсын Сонгуулийн ерөнхий хороо. 2016

Гэхдээ нам эвслээс нэр дэвшигч эмэгтэйчүүдийн квотыг олон улсын тэргүүн туршлагад тулгуурлан 30 хувиар анх тогтоосон боловч нэр дэвших эмэгтэйчүүд хангалттай бус гэсэн шалтгаанаар сонгуулийн өмнө бууруулж, сонгуулийн дараа сэргээх явдал 2012 ба 2016 онуудад ахин дахин давтагдаж байв. Улс төрд эмэгтэйчүүдийн оролцоог дэмжихэд улс төрийн намуудын нөлөөгөөр ийнхүү туйлбаргүй хандсан нь жендэрийн тэгш байдлын төлөө ажилладаг иргэний нийгмийн байгууллагууд болон нэр дэвшихийг хүсэгч эмэгтэйчүүдэд цохилт болж, эргэлзээ төрүүлж байсныг тэмдэглэх нь зүйтэй.


Сонгуулийн тухай хуулинд 2016 оны 5 дугаар сарын 5-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулж Нам, эвслээс нэр дэвшигчийн 20-иос доошгүй хувь нь аль нэг хүйсийн нэр дэвшигч байна (126.2.) гэж заасан нь ЖЭТБХТХ-ийн агуулга, үзэл санаатай илүү нийцсэн байдаг. Гэвч уг заалтыг хэрэгжүүлээгүй, мөн хүлээх хариуцлагын механизмыг тодорхой тусгаагүй тохиолдолд квот нь бэлгэдлийн зүйл болж хувирдагийг өмнөх сонгуулиудын сургамж харуулж байна. Мөн жил ирэх тутам монголын улс төр “булингтартай” болж, сонгуулийн зардал өссөөр байгаа нь эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог илүүтэй хязгаарлаж байгааг эрх зүйн орчны хүрээнд цаашид анхаарах шаардлагатай. УИХ-ын 2008 оны сонгуульд 7.8 тэрбум төгрөг, 2012 онд 35.6 тэрбум төгрөг<sup>86</sup>, 2016 онд хэвлэл мэдээллийн хэрэгслийн мэдээлснээр 34.3 тэрбум төгрөг зарцуулжээ.

Өнөөдөр УИХ-д сууж буй эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэх нь чухал ч эмэгтэй улс төрчдөөс нийгмийн зүгээс улс төрийн чанартай оролцоог буюу нийгэмд шударга ёс тогтоох, жендэрийн тэгш байдлыг хангах, хөгжлийн үр шим тэгш хуваарилагдаж, айл өрх, хүн бүрийн амьдралд мэдрэгдэж байхуйц бодит хувь нэмэр оруулахыг хүсэн хүлээх хандлагыг анхаарах хэрэгтэй байна. Энэ нь нийгэм дэх орлогын түвшин улам ялгаатай болж байгаа цаг үед нийгмээс тэдэнд үзүүлэх итгэл, хүлээлтэд сөргөөр нөлөөлж, эмэгтэйчүүдийн улс төр дэх оролцоог хязгаарлаж болзошгүй. Энэ байдлыг улс төрийн шийдвэр гаргах түвшинд ажиллаж буй эмэгтэйчүүдийг чадавхижуулахад анхаарахын зэрэгцээ УИХ-ын болон орон нутгийн сонгуульд нэр дэвшүүлэх, суудал хадгалах, намын бүтэц зохион байгуулалтын бүхий л шатанд эмэгтэйчүүдийг дэмжих квот тогтоох, сонгуулийн санхүүжилт болон тогтолцоог жендэрийн хувьд тэгш шударга болгохыг чиглэсэн үйл ажиллагаанд харгалзан үзэх хэрэгцээ үүсч байна.

<sup>86</sup> Сонгуулийн Ерөнхий Хороо. 2019. Намуудын сонгуулийн нэгдсэн зардал. <http://gec.gov.mn/news/309/359>

Орон нутгийн сонгуульд нэр дэвшүүлэхэд УИХ-д нэр дэвшихтэй адил квот хэрэглэхгүй байгаа ч 2016 оны орон нутгийн сонгуулийн үр дүнд аймаг, сум, нийслэл, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчдийн 26.7 хувь, тэргүүлэгчдийн 27.8 хувь, хурлын даргын 13.8 хувьд эмэгтэйчүүд сонгогджээ (Дүрслэл 23). Харин аймаг, нийслэлийн дарга болон ИТХ-ын даргаар ажилласан нэг ч эмэгтэй байхгүй байна.

**Дүрслэл 23.** Аймаг, сум, нийслэл, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргад эмэгтэйчүүдийн эзлэх хувь, 2016-2020 оны сонгуулийн жилүүдэд




Эх үүсвэр: Сонгуулийн ерөнхий хорооны мэдээлэл. 2016

Гэхдээ шийдвэр гаргахад эмэгтэйчүүдийн оролцооны бодит дүр зургийг гаргахын тулд улс төрийн дээд түвшинд байгаа цөөхөн эмэгтэйг тоолж, тэднээр эмэгтэйчүүдийг төлөөлүүлэн дүгнэхээс илүүтэй хойч үеийн эмэгтэй манлайлагчдыг бэлтгэх, хөгжүүлэх нь чухал байна. МХЗ-ын эмэгтэйчүүдийн улс төр, шийдвэр гаргах түвшин дэх оролцооны талаар тавьсан зорилгын хэрэгжилт хангагдаагүй гэж тайлагнагдсан нь УИХ-д нэр дэвшсэн болон сонгогдсон эмэгтэйчүүдийн эзлэх хувийг үзүүлэлт болгон авсантай холбоотой. Гэтэл төрийн захиргааны шийдвэр гаргах түвшинд ажиллагчдын дунд эмэгтэйчүүд 2005 онд 33.7 хувь байсан байна. Энэ үзүүлэлт 2015 онд бүтэц, орон тооны цомхотголын нөлөөгөөр 25.2 хувь болсон боловч 2016 оны сонгуулийн дараа эргэн өсч, 2017 оны байдлаар 34.3 хувь болоод байна.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн “аль нэг хүйсийн төлөөлөл яамдын ТНБД, Засгийн газрын агентлагийн даргын 15 хувиас, яамдын газар, хэлтсийн даргын 30 хувиас ... доошгүй байх” заалт (10.1.2) нь төрийн захиргааны удирдлагын түвшин дэх жендэрийн тэнцвэрт байдлыг хангах зорилготой. Төрийн захиргааны тэргүүн түшмэлд эмэгтэйчүүдийн эзлэх хувь 2012 оноос хойш аажим нэмэгдэж 2017 оны байдлаар 24.0 хувь болжээ. Төрийн захиргааны эрхэлсэн түшмэлийн түвшинд ажиллаж буй эмэгтэйчүүдийн эзлэх хувь 2012 онд 28.9 хувь байснаа Засгийн газрын бүтэц, орон тооны өөрчлөлтийн дараа 2016 онд 25.8 хувь болж буурсан байна. Харин 2016 оноос хойш эмэгтэйчүүдийн эзлэх хувь нэмэгдсээр өнөөдөр эрхэлсэн түшмэлийн түвшинд ажиллагчдын 38.7 хувь нь болоод байна (Дүрслэл 24).

**Дүрслэл 24.** Төрийн захиргааны тэргүүн, эрхэлсэн түшмэл 2005-2017 онд, хүйсээр



Эх үүсвэр: УСХ. Монгол улсын төрийн албан хаагчдын тоо, бүтэц, өөрчлөлт 1995-2017.2018

Гэвч төрийн захиргааны байгууллагуудын тогтолцоо, бүтэц зохион байгуулалт тогтвортой бус, сонгуулийн 4 жил тутамд өөрчлөгдөж байгаа, удирдах албан тушаалд улс төрийн шинжтэй томилгоо хийгдэж байгаа нь эмэгтэйчүүдийн удирдах албан тушаалд дэвшиж, тогтвортой ажиллахад саад болж байна. Харин 2019 оны 1-р сарын 1-нээс хэрэгжиж эхэлж буй Төрийн албаны тухай хууль (2017)-д төрийн албанд сонгон шалгаруулж

томилох, чөлөөлөх, ажлын гүйцэтгэлийг нь үнэлэх, дэвшүүлэх, шагнаж урамшуулах асуудлыг шийдвэрлэхдээ хувь хүний мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага, ажлын үр дүнд тулгуурлах “чадахуйн зарчим (мерит)” баримтлахаар заасан нь мэргэжлээрээ тогтвортой ажиллаж буй эмэгтэйчүүдийн удирдах албан тушаалд дэвших боломжийг нэмэгдүүлнэ гэсэн хүлээлттэй байна.

## Д Жендэрт суурилсан хүчирхийлэл

Монгол Улсын Засгийн газраас Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр (2002)-ийг хэрэгжүүлэхдээ жендэрийн тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх эрх зүйн орчныг бүрдүүлэхэд анхаарч ирсэн байдаг. Мөн олон улсын байгууллагуудын дэмжлэг, үндэсний эмэгтэйчүүдийн ТББ-ын идэвхтэнүүдийн хүчин чармайлтын үр дүнд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (2004), Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль (2011), Хүн худалдаалахтэй тэмцэх тухай хууль (2012)-иуд батлагдсанаар ЖСХ-тэй тэмцэх, таслан зогсоох, шалтгаан нөхцлийг нь тогтоон арилгах, хохирогчийн эрхийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулах эрх зүйн орчин тодорхой болсон. ЖСХ-ийг эрх зүйн хүрээнд “жендэрээс үүдэлтэйгээр бусдад бие махбодийн, бэлгийн, сэтгэл санааны гэм хор, эдийн хохирол учруулсан, учруулж болзошгүй үйлдэл, эс үйлдэхүйг” хэлнэ хэмээн тодорхойлж байна.<sup>87</sup>

2005 оноос өмнө Хүчирхийллийн эсрэг үндэсний төв (ТББ)<sup>88</sup>-ийн харъяа гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогчийг түр хамгаалах 2 байр нийслэлд болон Дундговь аймагт ажиллаж байсан бол одоо төр, ТББ-ын харъяанд хүүхдийн эсрэг хүчирхийлэл, гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид зориулсан нийт 8 хамгаалах байр, 14 нэг цэгийн үйлчилгээний төв ажиллаж байна.<sup>89</sup> 2005 оноос түр байршуулан асрамжлах үйлчилгээг нийгмийн халамжийн үйлчилгээний төрөл, хамрах хүрээнд багтааж, нэг хүнд ногдох үйлчилгээний хувьсах зардлын хэмжээг тогтоон, улмаар 2009 онд хамгаалах байрны үйлчилгээний стандартыг батлан хэрэгжүүлж ирсэн.

ЖСХ-тэй тэмцэхэд мэдээлэл, мэдээллийн сангийн нэгдмэл байдал чухал үүрэгтэй. 2008 оноос эхлэн цагдаагийн гэмт хэрэг, зөрчлийн статистик бүртгэлд гэр бүлийн хүчирхийллийг тусгайлан бүртгэж эхэлсэн бол одоо цагдаагийн байгууллагад төвлөрсөн гэр бүлийн хүчирхийллийн цахим мэдээллийн нэгдсэн сантай болоод байна. Гэвч хохирогчдод үйлчилгээ үзүүлдэг бүх байгууллагуудын мэдээлэл уг санд одоогоор төвлөрч чадаагүй байна.

Үндэсний статистикийн хорооноос олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аргачлалын дагуу “Хүчирхийллийн нүцгэн үнэн-Жендэрт суурилсан хүчирхийллийн судалгаа-2017”-г үндэсний хэмжээнд анх удаа хийж, үр дүнг 2018 онд танилцуулсанаар ЖСХ-ийн өнөөдрийн дүр зургийг бүхлээр нь харах боломж олголоо. Уг судалгаанд эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдэж буй бие махбодын, бэлгийн, сэтгэл санааны, эдийн засгийн хүчирхийлэлд монгол эмэгтэйчүүдийн талаас илүү хувь нь (59.7) өртдөг гэж мэдээлжээ.<sup>90</sup> Энэ нь 2005 онд хийсэн судалгаагаар эмэгтэйчүүдийн 36.0 хувь хүчирхийлэлд өртсөн үр дүн гарч байсантай харьцуулахад илүү өндөр үзүүлэлт байна.<sup>91</sup>

Өнөөг хүртэл Монгол Улсад ЖСХ-ийн гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн дарамт, хүчингийн болон хүн худалдаалах гэмт хэргийн төрлүүд зонхилон үйлдэгдэж ирсэн. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хамгийн хор хөнөөлтэй хэлбэрүүд болох гэр бүлийн хүчирхийлэл, хүн худалдаалах болон бэлгийн дарамт буураагүй байна. ЖСХ-тэй тэмцэх анхдагч эрх зүйн орчин бүрэлдэн бий болсон ч бүртгэл мэдээллийн тогтолцоо боловсронгуй бус, салбар дундын зохицуулалтаар ажиллах чадавхи сул, урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах механизм бүх түвшиндээ тогтвортой ажиллахгүй байна. Ялангуяа ЖСХ-ийн хохирогч хамгаалал, тэдэнд чиглэсэн тусламж үйлчилгээг хөгжүүлэх асуудал тулгамдсан хэрэгцээ болж байна.

**Гэр бүлийн хүчирхийлэл.** Монгол Улсад үйлдэгдэж буй гэр бүлийн хүчирхийллийн 88.3 хувь нь эмэгтэйчүүдэд, 64.6 хувь нь хүүхдүүдэд чиглэж, хүүхдүүдийн тал хувь, өндөр настны дөрөвний нэг нь өртөж байна.<sup>92</sup> НҮБХАС-ын дүгнэснээр “Гэр бүлийн хүчирхийлэл нь Монгол Улс дахь хамгийн ноцтой, хамгийн түгээмэл, байнга үйлдэгдсээр буй хүний эрхийн зөрчлийн нэг болж байна (Зүүлт тайлбар 85). Монгол Улсад Гэр бүлийн хүчирхийллийн асуудал байгаа эсэхийг асуусан асуултад хариулагчдын 48 хувь нь бүрэн зөвшөөрсөн, 32 хувь нь “зарим талаар” зөвшөөрсөн хариулт өгсөн байна.<sup>93</sup>

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль хүчирхийллийн энэ төрлийн улмаас хохирсон, амь насаа алдсан эмэгтэйчүүд, хүүхдүүд, тэдний ойр дотнын хүмүүсийн гашуун зовлон, хуулийн хэрэгжилттэй холбоотой сургамжид суурилан шинэчлэгдэн бичигдэж, УИХ-аар 2016 оны 12 сард батлагдлаа. Ийнхүү ГБХ-ийг өрх гэр бүл, нийгэмд

<sup>87</sup> ЖЭТБХТХ, 4.1.8

<sup>88</sup> Тэмдэглэл: Хүчирхийллийн эсрэг үндэсний төв нь 1995 оноос эмэгтэйчүүд, хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй бэлгийн болон гэр бүлийн хүчирхийллийг ариглах зорилгоор байгуулагдан ажиллаж буй анхдагч, мэргэшсэн ТББ. Монгол улсад анх удаа тус байгууллага нь дэргэдээ нээн ажиллуулсан байдаг.

<sup>89</sup> Тэмдэглэл: ХЗДХЯ-ны Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн түр хамгаалах байрны нэгдсэн мэдээлэл нэг цэгийн үйлчилгээний төв 6, түр хамгаалах байр 11 байна.

<sup>90</sup> УСХ, НҮБХАС. 2018. Хүчирхийллийн нүцгэн үнэн - ЖСХ-ийн судалгаа. Улаанбаатар.

<sup>91</sup> ЭМЯ, ЭМХГ, НҮБ-ын Хүүхдийн Сан. 2005. Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл судалгаа. Улаанбаатар.

<sup>92</sup> UNFPA. 2016. *Mongolian Parliament Approves Domestic Violence Law*. <https://mongolia.unfpa.org/mn/node/14513>

<sup>93</sup> Center for Insights in Survey Research. Government of Canada 2016. *National Survey of Mongolian Public Opinion*. Ulaanbaatar.

асар их хэмжээний хохирол учруулж буй эрх мэдлийн тэгш бус харилцаан дээр суурилан санаатай үйлдэгддэг гэмт хэрэг гэдгийг хүлээн зөвшөөрөв. Шинээр батлагдсан хуулийн гол үзэл баримтлал нь ГБХ-тэй тэмцэх салбар дундын зохицуулалт нь юм. Уг хууль нь ГБХ-ээс урьдчилан сэргийлэхэд илүүтэй анхаарсан бөгөөд ХЗДХЯ-ны дэргэдэх Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл хуулийн хэрэгжилтийг үндэсний түвшинд зохицуулахаар болсон. Шинэчилсэн хуулийн хүрээнд ГБХ-ээс урьдчилан сэргийлэх, эрт шатанд илрүүлэх, таслан зогсоох, хохирогчийг хамгаалах цогц тогтолцооны эрх зүйн орчин бүх түвшинд хэрэгжих боломж бүрдсэнээр бүх аймаг, дүүргийн цагдаагийн хэлтэст гэр бүлийн хүчирхийллийн асуудал хариуцсан орон тоо бий болж, засаг захиргааны анхан шатны нэгж болгон дээр "Хамтарсан баг" ажиллаж байгаа нь тогтолцооны хувьд сайн суурь бүрэлдэж буйн илэрхийлэл юм. Гэсэн хэдий ч Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай шинэчилсэн хуулинд хариуцлагын тогтолцоо суларсан нь ГБХ-ийн бүртгэгдэх байдалд нөлөөлж байна гэж уг асуудлаар ажилладаг мэргэжилтнүүд дүгнэж байна (Дүрслэл 25).

#### Шигтгээ 14.

##### **Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хоёр дахь давалгаа**

"Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг анх батлуулахад амар байгаагүй. УИХ-ын хэлэлцүүлгийн шатанд "авгайгаа ганц алгасаны төлөө ийм хууль гаргах гэлээ" гэсэн хүчтэй эсэргүүцэлтэй хүртэл тулсны эцэст бусад хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтүүдийг үлдээн, хуулийг дангаар нь баталсан. Гэр бүлийн тухай хуульд орсон ганц нэг заалтаас өөр гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалах зохицуулалт манай эрхзүйн тогтолцоонд огт тусгаагаагүй байсан тул эхний ээлжинд бие даасан хуультай болох нь чухал байлаа. Хууль батлагдан хэрэгжиж эхэлсэн тэр үеэс эхлэн хохирогчийг хамгаалах цогц тогтолцоог бий болгоход чиглэсэн нөлөөллийн ажлыг Хүчирхийллийн эсрэг үндэсний төвөөс эхлүүлсэн бөгөөд нотолгоонд суурилсан, тууштай нөлөөллийн ажлын үр дүнд 12 жилийн дараа Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (2016) шинэчлэн батлагдсан. Гэр бүлийн хүчирхийллийг зөвхөн маргааны түвшинд авч үздэг байсныг өөрчилж, амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулсан, учруулж болзошгүй үйлдлүүдийг гэмт хэрэг, харин бие махбодид халдаагүй, хохирол шаардахгүй үйлдлүүдийг зөрчилд тооцох болсон. Мөн хохирогчийг хамгаалах тогтолцоо (хууль, бодлого, хэрэгжүүлэх бүтэц, механизм, цогц үйлчилгээ, журам, стандарт, цахим мэдээллийн сан) бүрдэж, салбар дундын зохицуулалт хийгдэж эхэлсэн.

Хэдийгээр дээрх ахиц, дэвшилүүд бий болсон ч хүчирхийлэл үйлдэгчдэд хүлээлгэх хариуцлагын хувьд ухралт гарсан юм. Хохирогчийг хамгаалах цогц зохицуулалт бий болгох үүднээс Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай шинэ хууль нь Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиудтай нягт уялдаатай боловсруулагдан батлагдсан байсан. Гвч эрүүгийн эрхзүйн тогтолцооны эдгээр гол хуулиуд болон Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулийг "Төрийн мэдээлэл" эмхэтгэлд нийтлээгүй, ёсчлоогүй үндэслэлээр буцаасан. Тодорхой хугацааны дараа УИХ-аар дахин хэлэлцэж, эцэслэн батлахдаа хорихоос өөр төрлийн ял болох Зорчих эрхийг хязгаарлах (өөрийн оришин суух газраас явахыг хориглох, тодорхой газар очихыг хориглох, шүүхээс тогтоосон чиглэлээр зорчих, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгөөр оришин суух газраа өөрчлөх) ялыг 2019 он хүртэл хэрэгжих хугацааг нь хойшуулсан. Уг хугацааг дахин 2021 он хүртэл сунгах хуулийн<sup>94</sup> төслийг УИХ-ын Хуульзүйн байнгын хороогоор хэлэлцэж, УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэхээр дэмжсэн байна.

Ингэснээр гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгт хорихоос өөр төрлийн ял оноох боломжгүй байна. Хариуцлагын энэ оновчгүй байдал нь гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг цагдаагийн байгууллагад хандах, хуулийн хамгаалалт авахаас зайлсхийхэд хүргэж болзошгүй..

Эх үүсвэр: Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай анхны бие даасан хууль (2004) болон уг хуулийг шинэчлэн батлуулахад нөлөөлж, хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийн гишүүнээр ажилласан, Жендэрийн үндэсний шинжээч Д.Энхжаргалтай хийсэн ярилцлага

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас амь насаа алдсан тохиолдол 2017 онд 12, 2018 онд 9 бүртгэгдсэн. Энэ нь хууль шинэчлэгдэн батлагдахаас өмнөх жилүүдэд 24-26 байсантай харьцуулахад буурсан үзүүлэлт хэдий ч цаашид өндөр эрсдэлд байгаа хохирогчийн аюулгүй байдлыг яаралтай хамгаалах ажлыг эрчимжүүлэх шаардлага байгааг харуулж байна.



**Шигтгээ 15.**


**Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн эмгэнэлт кейс**

22 настай залуу бүсгүй Г нь шүүх хурал руу очих замдаа 2012 оны 4-р сард нөхөртөө 12 удаа хутгалуулан амиа алдсан юм. Тэрээр 2004 онд батлагдан хэрэгжиж байсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн дагуу амь нас, эрүүл мэндээ хамгаалуулахаар цагдаагийн байгууллагад удаа дараа хандсан ч нөхрийг нь эрүүлжүүлэх байранд нэг хонуулаад л гаргачихдаг, хуулийн хариуцлага хүлээлгэдэггүй байв. Г нь гэрлэлтээ цуцлуулахаар шүүхэд хандсан боловч шүүх эвлэрэх шаардлагатай гэж үзэж, гэрлэлт цуцлах нэхэмжлэлийг 2 сарын хугацаагаар түдгэлзүүлэх шийдвэр гаргасан юм.

Нөхрийнх нь дарамт улам ихэсч, байнга мөрдөн мөшигж, амь насыг нь хөнөөхөөр заналхийлж байсан тул Г цагдаагийн байгууллагад дахин хандсан ч “гэрлэлтээ цуцлуулах өргөдөл гаргасан юм бол шүүхдээ ханд” гээд гомдлыг нь хүлээж аваагүй байна. Тиймээс тэр “тусдаа амьдрахыг даалгах” эрх хязгаарлах арга хэмжээ авахуулахаар шүүхэд хандсан бөгөөд нэг цэгийн үйлчилгээний төв болон хамгаалах байрны нийгмийн ажилтны хийсэн Нөхцөл байдлын үнэлгээгээр Г-г амь насаа алдах өндөр эрсдэлд байгааг анхааруулсан ч шүүх “нотлогдоогүй” үндэслэлээр хүсэлтийг хангахаас татгалзсан билээ. Эвлэрүүлэхээр түдгэлзүүлсэн 2 сарын хугацаа дуусмагц Г гэрлэлтээ цуцлуулахаар шүүхэд дахин хандсан ч бүсгүй шүүх рүү явах замдаа буюу шүүх хурал эхлэхээс 30-хан минутын өмнө нөхрийнхөө гарт амь насаа алдаж, 3 настай хүү нь өнчрөн үлдэж, 6 сарын дараа ээж нь сэтгэлийн шаналлаа даалгүй нас барсан.

Эх үүсвэр: Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн баримтаас

**Дүрслэл 25.** Гэр бүлийн хүчирхийллийн бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, 2006-2018 он




Эх үүсвэр: УЦХ. 1212.mn

ГБХ-ийн улмаас цагдаад хандан бүртгэгдсэн гэмт хэргээс харахад 2017 оны байдлаар хохирсон иргэдийн 93.0 хувь нь эмэгтэйчүүд, 7.0 хувь нь 18 хүртэлх насны хүүхдүүд байна. Үүний дотор 53.5 хувийг хүчирхийлэл үйлдэгчдийн эхнэр нь, 17.1 хувийг хамтран амьдрагч нь, 3.4 хувийг төрсөн хүүхэд нь, 3.5 хувийг дагавар хүүхэд нь эзэлж байна. Хохирогчдын 20 орчим хувь нь 1-3 жилийн туршид хүчирхийлэлд автаж байсан ба 60 хувь нь 1-2 удаа, 2 хувь нь байнга хүчирхийлэлд автдаг байна. Хүчирхийлэлд өртөгсдийн 46.1 хувь нь ажилгүй хүмүүс байжээ.

Гэвч дээрх тоон мэдээлэл нь зөвхөн цагдаагийн байгууллагад хандсан хүмүүстэй холбоотой бөгөөд цагдаад хандаагүй болон хандах боломжгүй, тусламж үйлчилгээ авч чадахгүй, алслагдмал нутагт амьдарч байгаа охид эмэгтэйчүүд олон байна. ХЭҮТ-өөр үйлчлүүлэгчдийн тоо цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэргийн тооноос өндөр байгаа нь үүнийг гэрчилж байна (Дүрслэл 26).

**Дүрслэл 26.** ХЭҮТ-өөр үйлчлүүлэгчдийн тоо (анх удаа хандсанаар), 1995-2018 онд



Эх үүсвэр: ХЭҮТ-ийн үйлчлүүлэгчдийн статистик тоон мэдээлэл

2015 онд хийсэн судалгаагаар малчин өрхүүдийн 15 хувь гэр бүлийн хүчирхийллийн асуудалтай бөгөөд тэдний дунд 35-49 насны гэр бүлүүд зонхилж байна гэжээ. Гэхдээ эмэгтэйчүүдээс тусад нь асуулга авч чадаагүй учраас энэ нь бодит байдлаас доогуур үзүүлэлт байж болзошгүй гэж судлаачид үзсэн байна (Зүүлт тайлбар 7). Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгчдөд чиглэсэн тусламж үйлчилгээг нүүдлийн мал ахуй эрхлэгчдийн, түүний дотор малчин эмэгтэйчүүдийн онцлог нөхцөл байдалд нийцүүлэх шаардлагатай байна.

**Шигтгээ 16.**


**Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн малчин эмэгтэйчүүдийн асуудал**

Гэр бүлийн хүчирхийллийн дуудлага өгөхөд Эрдэнэт авч явж хонуулаад 100 мянган төгрөг авдаг. Тэгэхээр ийм өрөнд орж байснаас өөрөө хүүхдээ дагуулж гарч явсан нь дээр болдог. Өвөл хамгийн хэцүү. Ер нь малчин эмэгтэй гэр бүлийн хүчирхийлэлд өртөхөд яах вэ гэдэг маш хэцүү асуудал.

Эх үүсвэр: Орхон аймгийн малчин эмэгтэйчүүдтэй хийсэн бүлгийн ярилцлага

Хүчирхийллийн дүр зураг эмэгтэйчүүдийн насны бүлгээр ялгаатай (Дүрслэл 27), 40-44 насны эмэгтэйчүүд бие махбодийн болон бэлгийн хүчирхийлэлд илүү өртөж байгаа бол 15-19 насны залуу охид хянаж цагдаа хүчирхийлэлд илүү өртөж байна.

**Дүрслэл 27.** Бие махбодийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн хувь, насны бүлгээр



Эх үүсвэр: ҮСХ, НҮБХАС. Хүчирхийллийн нүцгэн үнэн. Жендэрт суурилсан хүчирхийллийн судалгааны тайлан -2017

Хэдийгээр эрх зүйн орчин бүрдэж, олон нийтийн ойлголт сайжирч байгаа ч хүчирхийллийг тэвчих хандлага эмэгтэйчүүдийн дунд байсаар байна. Энэ хандлага хөдөөд илүү, мөн эмэгтэйчүүдийн нас ахих тусам ихэсч, харин боловсролын түвшин дээшлэх тусам багасч байна. Хүчирхийлэлд өртөж байсан эмэгтэйчүүдийн 62.2 хувь нь архийг, 36.2 хувь нь хардалтыг, 13.1 хувь нь дуулгаваргүй байснаа хүчирхийллийн шалтаг болсон гэж үзжээ. 2014 онд бичигдсэн тайлангаас (Зүүлт тайлбар 80) үзэхэд бэлгийн болон бие махбодийн хүчирхийллийг тэвчих хандлага хөдөөгийн эмэгтэйчүүдийн дунд илүү байгаагаас гадна ийм хандлага эмэгтэйчүүдийн боловсролын түвшин дээшлэх тусам багасч, харин нас ахих тусам нэмэгдэж байна. ГБХ-ийн үр дагавар нь ноцтой байна. Бие махбодийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн 42.8 хувь нь бэртэж гэмтсэний дотор тэдний 71.6 хувь нь ноцтой гэмтэл бэртэл авчээ. Бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн 35.5 хувь, бие махбодийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн 20.5 хувь, харин аль алинд нь өртсөн эмэгтэйчүүдийн 36.5 хувь нь амиа хорлохыг хүссэн,

харин 27.4 хувь нь амиа хорлохыг завдсан байна (Зүүлт тайлбар 94).

Гэр бүлийн хүчирхийлэл нь гол төлөв эмэгтэйчүүд охидын эсрэг үйлдэгдэж байгаа ч гол хохирогчид нь хүүхдүүд болж байна. Сүүлийн жилүүдэд гэр бүлийн хүчирхийлэлд өртөж буй хүүхдийн тоо нэмэгдэж байгаа ч тэднийг хүүхэд хүчирхийлэлд өртсөн тохиолдолд хүчирхийлэл үйлдэгчээс хүүхдийг авах, хамгаалах, сэтгэл зүйн болоод эмнэлгийн ямар тусламж үйлчилгээ үзүүлэх, мөн эцэг, эхчүүдийг сургах асуудал хуулиар зохицуулагдаагүй хэвээр байна. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчдэд зориулсан албадан сургалтын агуулгыг тодорхойлж журамлаагүйгээс зан үйлийг өөрчлөх бодитой үр нөлөөгүй, гал унтраасан арга хэмжээ болж байгааг мэргэжилтнүүд онцолж байна.

#### Шигтгээ 17.

##### Гэр бүлийн хүчирхийлэл ба хүүхэд

Манай улсын хувьд хүүхдийн эсрэг үйлдэгдээд байгаа гэмт хэрэг хүчирхийллийн 90 орчим хувь нь гэр бүлийн хүчирхийлэл байдаг

Эх үүсвэр: Хүүхдийн төлөө үндэсний газрын Хүүхэд хамгаалал үйлчилгээний газрын дарга Б.Жавзанхүүгийн ярилцлагаас, 2013 он

**Ажлын байр дахь бэлгийн дарамт.** ЖЭТБХТ-д “бэлгийн дарамтыг бусдыг хүсээгүй байхад нь бэлгийн сэдлээ үг хэлээр, биеэр буюу өөр хэлбэрээр илэрхийлсэн, бэлгийн сэдлийн улмаас ажил, албан тушаал, эд материал, сэтгэл санааны болон бусад хохироох үр дагавар бүхий тэвчишгүй орчин үүсгэх, айлган сүрдүүлэх тулган шаардах зэрэг үйлдэл, эс үйлдэл” хэмээн тодорхойлж өгсөн. Мөн хуульд ажлын байранд бэлгийн дарамтыг хориглож, энэ талаар ажил олгогчийн эрх үүргийг зааж өгсөн. Гэвч ажлын байранд дарамт үзүүлсэн этгээдэд хэн, ямар хариуцлага хэрхэн тооцох нь тодорхойгүй учир уг заалтыг тунхаг төдий бөгөөд Хөдөлмөрийн тухай болон Зөрчлийн тухай хуульд хэд хэдэн өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлагатай гэж АББД-тай тэмцэх ТББ-ын эвсэл үзэж байна.

Бэлгийн дарамт Эрүүгийн гэмт хэргийн тухай хуульд тусгагдсан байсан ч 2017 онд хийсэн нэмэлт өөрчлөлтөөр хассанаар гэмт хэргийн тооноос хасагдаж, ямар нэг торгууль шийтгэл ногдуулах, хохирлыг барагдуулах аргагүй болжээ. Мөн одоогоор ажлын байрны бэлгийн дарамтын талаар мэдээлээгүй тохиолдолд шийтгэл ногдуулах эрх зүйн зохицуулалт байхгүй байна.

#### Шигтгээ 18.

##### Ажлын байрны бэлгийн дарамтын хохирогч хамгааллын асуудал

10 гаруй жилийн өмнө 300 хүний дунд судалгаа явуулахад ажлын байран дахь бэлгийн дарамтад таван хүн тутмын нэг нь өртөж байсан бол гурван хүн тутмын нэг нь ийм байдалд орсон нэгнийг мэддэг гэж хариулсан. Тэднээс холбогдох байгууллагад хандаж, асуудлаа шийдвэрлүүлсэн ганцхан хүн байсан. Өнгөрсөн онд бид үүнтэй адил судалгааг дахин явуулахад үр дүн нь өөрчлөгдөөгүй. Хохирогчийг хамгаалах асуудал өдийг хүртэл иргэний нийгмийн байгууллагуудын нуруун дээр байна.

Эх үүсвэр: Хүйсийн тэгш эрхийн төвийн тэргүүн Г.Ганбаясгахын ярилцлагаас

Бэлгийн дарамтад өртөгч нь ХЭҮК-т гомдол гаргах боломжтой ч энэ нь ховор байна. ХЭҮК-д 2008-2017 онд хөдөлмөрлөх эрхтэй холбоотой гомдол 240 ирсэн бол ажлын байран дахь бэлгийн дарамттай холбоотой гомдол сүүлийн дөрвөн жилд 21 ирсэн байна. Мөн бэлгийн дарамтын тохиолдолд ХЭҮК нь арга хэмжээ авах эрх мэдлийн хувьд хязгаарлагдмал байна.

#### Шигтгээ 19.

##### Ажлын байрны бэлгийн дарамт ба ХЭҮК

ХЭҮК-т өргөдлөө өгснөөр хохирогч болон гэрч, дарамт үйлдэгчээс мэдүүлэг тайлбар авна. Бэлгийн дарамт мөн гэж үзвэл тухайн байгууллагын албан тушаалтанд шаардлага, зөвлөмж хүргүүлж, 7-30 хоногийн дотор хэрэгжүүлсэн эсэхэд хяналт тавьдаг. ХЭҮК-оос дарамт үзүүлсэн албан тушаалтанд хариуцлага тооцуулах шаардлагыг дээд удирдлагад нь хүргүүлдэг. Хэрэв бэлгийн дарамт нь гэмт хэргийн шинжтэй буюу хүч хэрэглэсэн байвал хууль хяналтын байгууллага нь шалгадаг.

Эх үүсвэр: ХЭҮК-ын ахлах референт З.Өнөржаргалын ярилцлагаас

ХЭҮК нь 2014 онд 24 байгууллагад 500 гаруй хүнийг хамарсан судалгаа хийхэд бэлгийн дарамтын талаар, мөн авах хариу үйлдлийн талаар ойлголт мэдлэг дутмаг, асуудлыг магадлан шалгах механизм байхгүй нь харагджээ. Үүний зэрэгцээ хохирогчид гомдол гаргахаас айдгаас ажлын байран дахь бэлгийн дарамт илрэх нь бага байна гэж ХЭҮК үзэж байгаа бөгөөд Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад уг асуудлыг тусгах зөвлөмж өгөөд байна.

### Шигтгээ 20.

**Ажлын байран дахь бэлгийн дарамтыг Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад тусгахаар хэлэлцүүлэгдэж буй хувилбар**

**Наймдугаар зүйл. Ажил мэргэжил, хөдөлмөрийн харилцаанд дарамтыг хориглох**

8.1. Хөдөлмөрийн харилцаа үүсэх, хөдөлмөр эрхлэх болон мэргэжлийн сургалтын явцад ажил олгогч, түүнд оролцогч гуравдагч этгээдээс ажилтан, буюу хувь хүнд, түүнчлэн ажилтан буюу хувь хүнээс ажил олгогч, гуравдагч этгээд, бусад ажилтанд дарамт үзүүлэхийг хориглоно.

8.2. Ажил олгогч, ажилтан, гуравдагч этгээд хүсээгүй байхад бэлгийн сэдлээ үгээр, биеэр буюу өөр хэлбэрээр илэрхийлж Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд заасан бэлгийн дарамт үзүүлэхийг хориглоно.

8.3. Ажил мэргэжил, хөдөлмөрийн харилцааны хүрээнд дарамтад өртсөн гэж үзсэн хүн Хүний эрхийн үндэсний комисст гомдлоо гаргах эрхтэй.

8.4. Ажил олгогч нь ажлын байранд дарамт гарахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, гарсан гомдлыг шийдвэрлэх асуудлыг хөдөлмөрийн дотоод журамд тусгаж хэрэгжүүлнэ.

Эх үүсвэр: Монголын Үйлдвэрчний эвлэлийн танилцуулгаас

Монгол Улсад ажлын байр дахь бэлгийн дарамтыг таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэх асуудлаар ИНБ-ууд хүчтэй дуу хоолой болдог. Монголын эмэгтэйчүүдийн сангаас 2016 онд хийсэн онлайн судалгаагаар АББД-д өртсөн хохирогчдын 97.5 хувь нь эмэгтэйчүүд, 2.5 хувь нь эрэгтэйчүүд байна. Мөн уг судалгаагаар бэлгийн дарамт үйлдэгчийн 97.5 хувь нь эрэгтэйчүүд, 87.4 хувь нь дээд боловсролтой, 69.1 хувь нь удирдах ажилтнууд гэжээ. МОНЭС 2016 онд 753 дээд боловсролтой ажиллагчдаас (87 хувь нь эмэгтэйчүүд) судалгаа авсан байна. Судалгаанд оролцогчид ажлын байран дахь бэлгийн дарамтыг түгээмэл гэж үзсэн бөгөөд эмэгтэйчүүдийн 97 хувь нь ажлын байрандаа буюу их дээд сургуульд сурч байхдаа бэлгийн дарамтад өртөж байсан гэсэн бол эрэгтэйчүүдийн 2 хувь нь ажил олгогч болон удирдах албан тушаалтай эмэгтэйчүүдийн зүгээс бэлгийн дарамтад өртөж байсан гэж хариулжээ. Тэд бэлгийн дарамтыг эсэргүүцсэнээр халагдсан, албан тушаал дэвшиж чадаагүй, эсвэл ажлын ачаалал нэмэгдсэн талаар дурьджээ.<sup>95</sup>

ЖЭТБХТХ-д заасны дагуу ажил олгогч ажлын байранд бэлгийн дарамт гарахаас урьдчилан сэргийлэх, бэлгийн дарамтыг үл тэвчих орчныг бүрдүүлэх талаар төр, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдийн аль алинд нь ойлголт хангалтгүй байгаа нь АББД-аас урьдчилан сэргийлэхэд саад болж байна. Ялангуяа хөдөлмөрийн харилцаа нь зөвхөн ажлын байранд өрнөхгүй, томилт, тухайн байгууллагын чиг үүрэгтэй холбоотойгоор өөр газарт ажиллаж байх үед, дадлагажигч, зөвлөх, хөлсний болон гэрээт ажилтан хүртэл бэлгийн дарамтад өртөх магадлалтайг үл анзаарч, зөвхөн ажилтан ажил олгогч хоёрын хооронд л бэлгийн дарамт үйлдэгдэх боломжтой мэт ташаа ойлгож буй байдал ажиглагдаж байна. Сүүлийн жилүүдэд төрийн байгууллагууд ажлын байрны бэлгийн дарамтын талаар хөдөлмөрийн дотоод журамдаа тусгах ажил эхэлсэн бөгөөд ЖҮХАА-наас “Хувийн хэвшлийн байгууллагад жендэрийн тэгш байдлыг хангах төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх удирамж”<sup>96</sup> гарган, Монголын Үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо болон Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимтэй хамтран аж ахуй нэгж, байгууллагуудад танилцуулах ажлыг эхлүүлж байгаа нь сайшаалтай.

Монгол Улсын боловсролын байгууллагуудад ажлын байран дахь бэлгийн дарамтын талаар бодлого, арга хэмжээ хэрэгжүүлэх шаардлагатай байна. 2008 онд ТББ-ын хийсэн судалгаагаар дунд сургуулийн сурагчдын 50 илүү хувь нь бэлгийн дарамтад өртдөг гэсэн дүн гарчээ. Тэдний дийлэнх нь охид байна. Мөн их дээд сургуульд бэлгийн дарамт ноцтой асуудал болоод байгаа ч байгууллагын зүгээс ямар нэг арга хэмжээ авахгүй байна. Одоогоор МУИС л ёс зүйн дүрэмдээ уг асуудлыг тусгасан ч зөвхөн хориглосноор урьдчилан сэргийлэх болон мэдээлэх, шалгах, шийтгэл ноогдуулах асуудал орхигдож, хохирогч гомдол гаргасан ч “энэ асуудлаар баримтлах бодлого байхгүй” гэсэн хариу авахад хүрч байна.<sup>97</sup>


Сургуулийн орчинд бэлгийн дарамт байгаагаас охид сургуулиасаа гарч, бүр цаашлаад сургуулийн болон байшингийн дээвэр дээрээс үсэрч амь насаа хохироосон тохиолдол гарсан байна. Сургалтын орчноос гадна дараагийн санаа зовоох талбар нь театр, урлаг, спортын газрын бэлтгэл сургуулиалтын үед охид, эмэгтэйчүүд бэлгийн дарамтанд өртөж авъяас чадвараа олон нийтэд хүргэж чадахгүй орхиход хүргэж байгаа, цахим орчин дахь нийгмийн сүлжээгээр 18-24 насны эмэгтэйчүүдийн 25 хувь, эрэгтэйчүүдийн 13 хувь бэлгийн дарамтанд

өртсөн болохыг АББД-тай тэмцэх ТББ-ын сүлжээний мэдээлэлд тусгажээ.<sup>98</sup>

**Хүн худалдаалах гэмт хэрэг.** Монгол Улс хүний наймааны эсрэг олон улсын гэрээнүүдэд нэгдэн орсноор уг гэмт үзэгдэлтэй тууштай тэмцэх үүргийг дэлхийн хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн билээ. Хүний наймаанд өртөх өндөр эрсдэлтэй орны тоонд багтаж буйн хувьд ийм төрлийн гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажлыг төрийн хууль тогтоох бодлогын хүрээнд зохицуулж, тодорхой алхамуудыг хийж эхлээд цөөнгүй жилийг үдэж байгаа ч ХХГХ-тэй тэмцэх, түүнийг таслан зогсоох нь Монгол Улсад тулгамдсан асуудлын нэг хэвээр байна.

Монгол Улсад 2001 онд хүн худалдаалах гэмт хэргийн 1 тохиолдол бүртгэгдсэн бол 2018 оныг хүртэл нийт 300 гаруй хэрэг бүртгэгдэж, шалгагдаад байна. Хүн худалдаалах гэмт хэргийн талаарх хуулийн байгууллагын 2001-2017 оны статистик мэдээллээс үзэхэд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 113 дугаар зүйлд заасан Хүн худалдаалах (113 дугаар зүйл) 161 гэмт хэрэг, Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах (124 дүгээр зүйл) 227 гэмт хэрэг тус тус цагдаагийн байгууллагад бүртгэгдэн шалгагдсан<sup>99</sup> (Дүрслэл 28).

**Дүрслэл 28. Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн хүн худалдаалах, биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийн тоо, 2000-2017 он**



Эх үүсвэр: Цагдаагийн ерөнхий газар

Монгол Улсын өмнөд хэсэгт өрнөж буй уул уурхайн салбарын хөгжил дотоодын болон олон улсын шилжилт хөдөлгөөнийг эрчимжүүлсэн нь ялангуяа Хятад-Монголын хилийн эргэн тойронд хүн худалдаалах гэмт хэргийн эрсдлийг өсөн нэмэгдүүлж байгааг АНУ-ын Төрийн департаментийн 2018 оны тайланд дурьджээ.<sup>100</sup>

Хүн худалдаалах гэмт хэрэг нь нууц, далд аргаар үйлдэгддэг, хохирогчийг хамгаалах тогтолцоо сул байгаагаас гэмт хэргийн хохирогч нь уг гэмт хэргийн талаар мэдээлдэггүй зэргээс шалтгаалан хуулийн байгууллагаар шийдвэрлэгдэж байгаа хэргийн тоо цөөн, гэмт хэргийн статистик тоо бодит бус байна.<sup>101</sup> Мөн энэ төрлийн гэмт хэргийн талаар нэг мөр ойлголтгүй, гэмт хэргийг мөрдөх арга зүй дутмаг, хохирогч, гэрчийг хамгаалах тогтолцоо бүрдээгүй зэргээс шалтгаалан хүн худалдаалах гэмт хэрэг цагдаагийн байгууллагад бүртгэгдэхгүй, бүртгэгдсэн ч шүүхээр хянан шийдвэрлэгдэхгүй, улмаар хэрэгсэхгүй болох, шүүхээс хэргийн зүйлчлэлийг өөрчилж, Эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйлээр хянан шийдвэрлэх тохиолдол цөөнгүй байна. Учир нь хүн худалдаалах хэргүүдээс үзэхэд, эмэгтэйчүүдийг биеийг нь үнэлүүлэх болон бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөгт ашигласан байдаг учраас практикт энэ төрлийн гэмт хэргийг биеэ үнэлэхэд бусдыг татан оруулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргээс ялган зүйлчлэхэд хүндрэл гардаг.<sup>102</sup>

Цагдаагийн байгууллагад бүртгэгдэж шалгагдсан хэргийн багахан хэсэг нь шүүхээр шийдвэрлэгдэж байна (Дүрслэл 29). 2005-2017 онд цагдаагийн байгууллага 127 хүн худалдаалах гэмт хэргийг илрүүлэн шалгасан ч шүүхээр 26 хэргийг л эцэслэн шийдвэрлэжээ.

<sup>98</sup> Н.Чинчулуун. 2017. *Ажлын байр дахь бэлгийн дарамт гэж юу вэ, хөдөлмөр эрхлэлт, боловсрол, соёлын талбарт хэрхэн урьдчилан сэргийлж таслан зогсоох вэ?* Улаанбаатар.


<sup>99</sup> Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл. 2018. *Монгол Улсын гэмт хэргийн цагаан ном-2017*. Улаанбаатар.

<sup>100</sup> <https://mn.usembassy.gov/mn/our-relationship-mn/official-reports-mn/2018-trafficking-persons-report-mn/>

<sup>101</sup> <https://www.legalinfo.mn/annex/details/7908?lawid=12751>

<sup>102</sup> Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл. 2017. *Монгол Улсын гэмт хэргийн цагаан ном-2016*. Улаанбаатар.


**Дүрслэл 29.** Хүн худалдаалах гэмт хэргийн шийдвэрлэлт, 2000-2017 он



Эх үүсвэр: ЦЕГ, ШЕЗ-ийн мэдээлэл

Хүйсийн тэгш эрхийн төвийн мэдээлснээр 2003 онд хүний наймааны 3 хохирогчид туслалцаа үзүүлж байсан бол 2003-2018 оны байдлаар туслалцаа авсан хохирогчийн тоо 731 болжээ (Дүрслэл 30).

**Дүрслэл 30.** Хүйсийн тэгш эрхийн төвөөр үйлчлүүлсэн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн тоо, 2003-2018



Эх үүсвэр: Хүйсийн тэгш эрхийн төвийн тоон мэдээ

Манай улсад хүн худалдаалах гэмт хэрэг нь хөдөлмөрийн мөлжлөг, бэлгийн мөлжлөг, хүний эд эрхтний наймаа, гэр бүл болоход зуучлах, хүүхэд хууль бусаар үрчлэх зэрэг арга, хэлбэрээр үйлдэгдэж байгаа бөгөөд Хууль сахиулахын их сургуулийн Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэнгээс хүн худалдаалах гэмт хэргийн талаар хийсэн судалгааны үр дүнгээс үзэхэд тус гэмт хэрэгт бэлгийн мөлжлөгийн хэлбэр зонхилж байна. Мөн ХТЭТ-өөр үйлчлүүлэгчдийн тоо мэдээнээс үзэхэд хүн худалдаалах гэмт хэргийн ойролцоогоор 71 хувийг бэлгийн мөлжлөг, 22 хувийг хөдөлмөрийн мөлжлөг, 7 хувийг зуучлалын захиалгат гэрлэлт эзэлж байна.

**Бэлгийн мөлжлөг ба хүн худалдаалах гэмт хэрэг:** Олон нийтийн газраас үйлчлүүлэгч олох, саун, массажны газарт массажист нэрээр халхавчлах болон цэнгээний газар ширээнд үйлчлэн орлого оруулах хэлбэрээр биеэ үнэлэх, үнэлүүлэх ажлыг зохион байгуулах, цахим орчинд зар байршуулан дуудлагаар секс үйлчилгээ үзүүлэх замаар хүн худалдаалах гэмт хэргийг үйлдэх явдал түгээмэл болсон байна. Мөн гадаадад өндөр цалинтай ажилд зуучлах, сургуульд тэтгэлэгтэй суралцуулах, гадаадын иргэнтэй гэр бүл болоход зуучлах зэргээр зар гаргаж, охид, эмэгтэйчүүдийг хуурч мэхлэн гадаад улсад гарган биеийг үнэлүүлж, хилийн чанадад гэмт хэргийн хохирогч болгосон тохиолдлууд цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн байна.

Бэлгийн мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалах гэмт хэрэгт ихэвчлэн охид, залуу эмэгтэйчүүд өртдөг байна. Манай улс дотроо 13-18 насны насанд хүрээгүй охидыг зохион байгуулалттайгаар биеийг нь үнэлүүлэх,

18-35 насны эмэгтэйчүүдийг хилийн чанадад бэлгийн мөлжлөгт өртүүлж байна.

Хүний наймаанд гол төлөв орлого багатай ядуу айл, эсвэл өнчин, араас нь эрж хайх татлаа түлхээгүй, хөөцөлдөж явах боломжгүй, архидалт, хүчирхийлэлтэй гэр бүлийн 16-35 насны охид, эмэгтэйчүүд өртөж байна. Насанд хүрээгүй хүмүүс, залуу эмэгтэйчүүдийн дотор ядуу өрхийн хүүхдүүд, ялангуяа хөдөөнөөс хотод шилжин ирэгчид илүү эмзэг байна.<sup>103</sup> Эмэгтэйчүүд, охид уул уурхайн компаниудыг Хятадын хилтэй холбодог нүүрс тээвэрлэх зам бэлгийн мөлжлөгт өртөх эрсдэл өндөр, мөн уул уурхайд ажиллагчид урт хугацааны ээлжийн гарааны үеэр үр хүүхдээ гэртээ орхисноор тэд бэлгийн мөлжлөгт өртөх өндөр эрсдэлд орж байна.<sup>104</sup>

**Албадан хөдөлмөрлүүлж мөлжих:** Хөдөлмөрийн мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалах гэмт хэрэгт эмэгтэйчүүдээс гадна эрэгтэйчүүд өртөх хандлагатай байна. Иргэдийг хуурамч зар сурталчилгаанаас гадна ажиллах хүч зуучлах нэртэй компани болон хувь хүн иргэдийг хил давуулан бүлгээр нь хөдөлмөрийг нь мөлжих зорилгоор дотоодод болон хөрш орнуудаар дамжуулан гуравдагч улс орнууд руу худалдаалах хэрэг гарч байна.<sup>105</sup> 2003-2018 оны байдлаар ХТЭТ-д 158 хүн хөдөлмөрийн мөлжлөгийн хэлбэрээр хүн худалдаалах гэмт хэрэгт өртөн, туслалцаа дэмжлэг авсны 74.6% (118) эрэгтэй, 2.6% (4) насанд хүрээгүй эрэгтэй хүүхэд байсан байна.

Мөн хүүхдийг албан бус секторт хүчээр хөдөлмөр эрхлүүлж хурдан морь унуулах, уран нугараачаар ажиллуулах, гэрийн үйлчлэгч хийлгэх, мал маллуулах, гуйлга гуйлгах, хог түүлгэх гэх мэт хөдөлмөр мөлжлөгийн хэргүүд бүртгэгдэж байгаа ч шүүхээр ХХГХ бус, өөр төрлийн гэмт хэргээр зүйлчилж ял шийтгэл оногдуулдаг. Монгол Улсад өнөөг хүртэл албадан хөдөлмөрлүүлж мөлжих зорилгоор хүн худалдаалсан хэрэг шүүхээр нэг ч шийдвэрлэгдээгүй бөгөөд энэ талаар хийгдсэн судалгаа, мэдээлэл ч хомс байна.

**Зуучлалын захиалгат гэрлэлт:** Монгол Улсад “Гэр бүл зуучлал”-ын нэрийдлээр охид, эмэгтэйчүүдийг гадаадын иргэдтэй тодорхой төлбөртэйгээр гэрлүүлэх үйл ажиллагаа 2003 оноос эхлэн өрнөж, хууль бус гэрлэлт зуучлалын компани, хувь хүмүүсээр зуучлуулсан иргэдийн олонхи нь харийн нутагт очиж, хүчирхийлэл дарамтад өртөж, байнгын боолчлолын байдалд орсон байна. Хүйсийн тэгш эрхийн төвд 45, Хүний эрх, хөгжил төвд 2 иргэн зуучлалын захиалгат гэрлэлт хэлбэрээр хүн худалдаалах гэмт хэрэгт өртөж, туслалцаа дэмжлэг авчээ.

2002 онд Эрүүгийн хуульд хүн худалдаалах зүйлчлэлийг тусгасан ч 2002-2008 онд зургаан хэрэг л шүүхээр шийдвэрлэгдсэн байна.<sup>106</sup> Харин 2008 оноос НҮБ-ын Палермогийн протоколд дөхүүлсэн өөрчлөлтийг Эрүүгийн хуульд оруулснаар бага зэргийн ахиц гарч 2009-2017 онд 20 хэргийг шүүхээр шийдвэрлэжээ.

Монгол Улс 2011 онд хүн худалдаалахтай холбоотой бие даасан хууль, 2006 оноос эхлэн 2 дахь удаагийн Үндэсний хөтөлбөр батлан хэрэгжүүлж байна. Төрийн зүгээс эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр анхаарч байгаа боловч энэ төрлийн хохирогчдод үзүүлэх хамгаалах үйлчилгээг бүрэн үзүүлэх нөөц боломж хязгаарлагдмал хэвээр байна. Хохирогчдод үзүүлэх хамгаалах үйлчилгээний дийлэнхийг ТББ-ууд хариуцан гүйцэтгэсээр байна. Улсын хэмжээнд хохирогчдод үзүүлэх үйлчилгээг 2007 оноос эхлэн өнөөдрийг хүртэл Хүйсийн тэгш эрхийн төв (ХТЭТ) ТББ-ын ажиллуулдаг хоёр хамгаалах байрт даатгасан хэвээр<sup>107</sup> атлаа санхүүгийн дэмжлэг маш хязгаарлагдмал байна. ХТЭТ ТББ-ын хамгаалах байранд төрөөс 2011 онд 5 сая, 2012 онд 7 сая төгрөгийн дэмжлэг үзүүлжээ. 2007-2013 оны байдлаар улсын хэмжээнд ажиллаж байгаа хоёр хамгаалах байр давхардсан тоогоор 514 хүнд үйлчилсэн байна.

2014 оноос Гэрч хохирогчийг хамгаалах хуулийг батлан хэрэгжүүлж байгаа хэдий ч Эрүүгийн хуулиар хэрэг үүсэх хүртэл хохирогч энэ хуулийн дагуу дэмжлэг тусламж авах боломжгүй болгосноос гадна шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийг батлах явцад шалгагдаж байсан хүний наймааны 26 хэрэг хэрэгсэхгүй болсон нь гашуун туршлага юм. Мөн бэлгийн мөлжлөг ба хүн худалдаалах гэсэн ойлголтуудыг Эрүүгийн хуулийн 12.3 ба 13.1-р зүйлүүдэд тусад нь тодорхойлсноор хэргийг шийдвэрлэхэд түвэгтэй болсон, Эрүүгийн болон Иргэний хуулиудын нийцгүй байдлаас Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 15-р зүйлд заасан хохирогчийн эд хөрөнгө, нэр төр, алдар хүнд, сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрийг гэм буруутай этгээдээс шаардах эрх хэрэгжихгүй, шүүхийн практикт сэтгэл санааны хохирлыг тооцохгүй хэвээр, “Засгийн газрын тусгай сангийн хууль”-ийн гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангаас хүний наймааны хохирогчдод нөхөн олговор өгөх заалтыг хассан зэрэг эрх зүйн хүрээний олон шийдэгдээгүй асуудал байна.

Хүн худалдаалах гэмт хэргийн гаралт, шалтгаан нөхцөл буурахгүй байгаа нь хуулийн хэрэгжилтийг хангах байгууллагуудын хэрэгжүүлэх үйл ажиллагаа тодорхой бус, албан хаагчид нь энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх талаар нэгдмэл ойлголтгүй, байгууллага хоорондын хамтын ажиллагаа байхгүй, гадаад улс, олон улсын байгууллагатай хамтран ажиллах эрх зүйн байдал дутмаг байгаатай холбоотой байна. Хүн худалдаалах гэмт хэргээс урьчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх, хүн худалдаалах

<sup>103</sup>HSPSC. 2012. *Final Report: Program to Combat Human Trafficking in Mongolia*. Supported by SDC. January.

<sup>104</sup><https://mn.usembassy.gov/mn/our-relationship-mn/official-reports-mn/2018-trafficking-persons-report-mn/>

<sup>105</sup>Хүйсийн тэгш эрхийн төв. Швейцарийн хөгжлийн агентлэг, Хүний аюулгүй байдлын судалгааны төв, Нийслэлийн тагнуулын газар. 2009

<sup>106</sup>Хүйсийн тэгш эрх төв, ШХА. 2010. *Монгол улс дахь ХХГХ-ийн зуралал*. Улаанбаатар.

<sup>107</sup>US Department of State. 2018b. *Trafficking in Persons Report 2018*. Washington, D.C.

гэмт хэргийн шалтгаан нөхцөл, нөлөөлж байгаа хүчин зүйлсийг судлан тогтоосны үндсэн дээр уг гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцоо, арга хэлбэрийг шинэчлэх шаардлагатай байна.<sup>108</sup>

ЖСХ-тэй тэмцэх эрх зүйн орчин нь ХБ эмэгтэйчүүд, ЛГБТ хүмүүс, өндөр настан, эрэгтэйчүүдийн өвөрмөц хэрэгцээг тусгаагүй байна. ЖСХ-ийн талаар мэдээлэл цуглуулах аргачлал дээрх хүмүүсийг орхигдуулж, нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдэд л чиглэсэн байна. Олон нийт ЖСХ-ийн талаар ойлголт багатайн зэрэгцээ хохирогчдод сөрөг байдлаар хандах явдал байсаар байна. Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд хохирогчдын хувийн мэдээллийг түгээж, тэдний хувцаслалт, зан байдал, мөн олон нийтийн тодорхой газруудад байсныг нь буруутгах зэргээр дээрх сөрөг хандлагыг өөгшүүлэх явдал гарсаар байна.

## Нийгмийн хүрээнд жендэрийн тэгш байдлыг хангахад чиглэсэн зөвлөмж:

### Урт хугацаанд:

1. Залуу гэр бүлийн бие даан амьдрах, төлөвших үйл явцад тулгарч буй сорилт бэрхшээлийг нийгмийн салбарын бодлого төлөвлөлтөд тусгаж, орон нутгийн онцлогт нийцүүлэн хэрэгжүүлэх. Тухайлбал хот хөдөөгийн залуу гэр бүлд амины орон сууц барих, газар тариалан, бизнес эрхлэхэд зориулан хөнгөлөлттэй зээл, мэдлэг боловсрол олгох;
2. Гэр бүлийн харилцааны талаарх мэдлэгийг бүх насны эмэгтэй эрэгтэй хүмүүст амьдралын мөчлөг, насны онцлогт тохирсон байдлаар олгох механизмыг хөгжүүлэх;
3. БСШУС-ын салбарт жендэрийн талаар баримтлах бодлогын зорилтуудыг салбарын хүрээнд шинээр гарч буй эрх зүй, бодлогын баримт бичгүүдэд уялдуулан тусгаж, төлөвлөлт, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээнд нэгтгэх;
4. Дээд боловсролын өртөг ба үр өгөөжид эдийн засгийн тооцоо судалгааг тогтмол жендэрийн мэдрэмжтэй хийж, их дээд сургуулийн төлбөрийн хэмжээ, стандартыг тогтооход ашиглаж хэвших. Жишээлбэл Их сургууль хотхонтой байх стандарт гаргах;
5. Насан туршийн боловсролын тогтолцоог орчин үеийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан хөгжүүлж, насанд хүрсэн, түүний дотор дундаас дээш насны эрэгтэй, эмэгтэйчүүдэд шинэ мэргэжил эзэмшүүлэх албан ба албан бус сургалтын хүртээмжийг сайжруулж, олон нийтэд сурталчлах;
6. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг өргөжүүлэн, эрэгтэй эмэгтэй хүмүүсийн насны онцлог, хэрэгцээнд нийцсэн мэдээлэл сурталчилгааг бүх түвшинд хэрэгжүүлэх чадавхийг үндэсний хэмжээнд бүрдүүлэх;
7. Эрэгтэйчүүдийн дундаж наслалтыг богиносгож буй хорт зуршилтай тэмцэхийн зэрэгцээ түүнийг өдөөж буй нийгмийн хүчин зүйлсийг судлан шинжилж, стрессийн гаралтай сэтгэцийн эмгэг, хөвгүүдийн компьютерт донтолтын асуудлыг эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбарын хүрээнд хэлэлцэн, салбар дундын тусгайлсан бодлого хөтөлбөр хэрэгжүүлэх;
8. Агаарын бохирдлоос бууруулахад чиглэсэн төсөвт агаарын бохирдлын улмаас эрүүл мэндийн хувьд хамгийн өндөр эрсдэлд орж буй жирэмсэн эхчүүд, нярай, бага насны хүүхдүүдийн эрүүл мэндийг хамгаалах зардлыг тусгах;
9. Шийдвэр гаргахад эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд улс төрийн хүчин, төрийн алба, бизнесийн болон иргэний нийгмийн байгууллагууд залуу манлайлагч эмэгтэйчүүдийг бэлтгэх сургалтын байнгын тогтолцоо бүрдүүлж, дагалдуулан сургах (менторшип) хөтөлбөрийг хэрэгжүүлэх;
10. ЖСХ, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх, хүний наймаа, гэр бүлийн хүчирхийлэл, жендэрт суурилсан бусад хүчирхийллийн бүх хэлбэрийг устгах чиглэлээрх хуулиудыг хэрэгжүүлэхэд төрийн болон орон нутгийн байгууллагуудад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх ажлыг эрчимжүүлэх, хуулийг хэрэгжүүлэгчдийн хамтын ажиллагаа, чадавхийг бэхжүүлэх;
11. Салбар, орон нутгийн анхан шатны нэгжүүдэд ЖСХ-ээс сэргийлэх чадавхийг бүрдүүлэх. Тухайлбал хүүхдийн эрхийн байцаагчдыг охид хөвгүүд жендэрийн ялгаварлан гадуурхалтад өртсөн тохиолдолд зөвлөн туслах, шийдвэрлэх чиглэлээр сургах, мөн амьжиргаа дэмжих зөвлөлийн гишүүдийг чадавхижуулах сургалтын хөтөлбөрт ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх агуулга оруулах.



**Дунд хугацаанд:**

1. Өрх, гэр бүлийн бүтэц, гэр бүлийн харилцаанд гарч буй өөрчлөлтийг судалж, эрх зүйн орчныг орчин үеийн нийгмийн хэрэгцээнд илүү уялдуулахад ашиглах. Тухайлбал “Гэр бүлийн тухай” хуульд хамтран амьдрах хэлбэр, түүнтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг тусгах;
2. Гэр бүлийн хамт амьдрах хэрэгцээг хөдөлмөр эрхлэлтийн бодлого төлөвлөлт, байгууллагуудын үйл ажиллагаанд анхаарч тусгах эрх зүйн орчныг бий болгох. Юуны өмнө гадаадад ажиллах хүч гаргах гэрээ хэлцлүүдэд тусгах;
3. Хүүхэд бүрт амьдарч буй газарзүйн байршил, гэр бүлийн орлогын түвшнээс үл хамааран СӨБ-д хамрагдах адил тэгш боломж бүрдүүлэхэд чиглэсэн төлөвлөлт хийж, төр, хувийн хэвшил, орон нутгийн оршин суугчдын тэнцвэртэй оролцоогоор дамжуулан хэрэгжүүлэх;
4. Төр, хувийн хэвшлийн үйлдвэрлэлийн газрууд ажилчдынхаа болон орон нутгийн хүүхдүүдэд зориулсан цэцэрлэг байгуулахыг дэмжсэн санхүү, татварын хөшүүрэг нэвтрүүлэх;
5. Анги дэвших тусам хөвгүүдийн тоо буурах чиг хандлагыг залруулахын тулд сургуулийн орчинд гарч буй үе тэнгийгнхний ялгаварлан гадуурхалт, бусад төрлийн хүчирхийлэл, хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийг таслан зогсоохоос гадна дотуур байрны хүртээмжийг нэмэгдүүлж, хөвгүүдийн онцлог хэрэгцээнд нийцсэн сургалтын хөтөлбөр, арга барилыг нэвтрүүлэх;
6. Эрүүл мэндийн салбарт урт хугацаанд жендэрийн асуудлаар баримтлах бодлогыг боловсруулан хэрэгжүүлэх;
7. Тав хүртэлх настай хүүхдийн эрүүл мэндийн хяналтыг сайжруулж, хүйсээр ангилсан мэдээлэл шинжилгээг өргөжүүлэхийн зэрэгцээ бага насны хүүхдийн хүйсийн онцлог хэрэгцээг харгалзан шүдний цооролт гэх мэт өвчлөлөөс сэргийлэх талаар эцэг эхчүүдийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх чиглэлээр хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран кампанит ажлуудыг тогтмол өрнүүлэх;
8. Агаар, хөрсний бохирдолд нөлөөлж, эрүүл мэндэд эрсдэл учруулж буй ахуйн дадал зуршлыг өөрчлөх, түүний дотор ариутгах бодисын зохистой хэрэглээг эзэмшүүлэхэд чиглэсэн сургалт мэдээллийг нийгмийн эрүүл мэндийн боловсролын хөтөлбөрүүдийн хүрээнд өрхийн эрүүл мэндийн төвүүдээр дамжуулан жендэрийн мэдрэмжтэй хүргэх;
9. ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээг Залуучуудын хөгжлийн төв болон гэр бүлийнхөгжлийн төвүүдээр дамжуулан тогтмол хэрэгжүүлэх. Үүний дотор ЖСХ-ийн талаар гомдол хүлээн авах, хянан шийдвэрлэх механизмыг хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран олон нийтэд таниулан сурталчлах;
10. Хүний наймааны хохирогчид зориулсан эрх зүйн болон эрүүл мэнд, сэтгэл зүйн тусламж үйлчилгээг жендэрийн мэдрэмжтэй хөгжүүлж, орон нутгийн удирдлага, байгууллагуудын Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх ажлыг эрчимжүүлэх.

**Богино хугацаанд:**

1. Залуучуудын хөгжлийг дэмжих сангийн үйл ажиллагааг залуу гэр бүлийн сайн сайхан, тогтвортой байдлыг хангахад чиглүүлэх;
2. Гэр бүл цуцлахтай холбоотой эрхзүйн орчныг сайжруулах, хэрэгжилтэд мониторинг хийх;
3. ХАХНХ болон БСШУС-ын салбарт жендэрийн талаар баримтлах бодлогыг дэмжих салбар хоорондын зохицуулалт, хамтын ажиллагааны хэрэгцээг тодорхойлон, санхүүжилт хуваарилах;
4. Дээд боловсрол, техникийн болон мэргэжлийн боловсролыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулах замаар хөдөлмөр эрхлэлт дэх жендэрийн хэвтээ ялгаралыг бууруулахад чиглэсэн хүйсээр ангилсан мэдээлэл, жендэрийн шинжилгээ судалгааг хөгжүүлж, хэлэлцүүлгийг өрнүүлэн, салбар хоорондын зохицуулалт, хамтын ажиллагааг сайжруулах;
5. ЭМЯ, БСШУСЯ-ны хамтран боловсруулж буй бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн хөтөлбөрт ХБИ ба ЛГБТ асуудлыг нэгтгэх замаар тэднийг ялгаварлан гадуурхахтай тэмцэж, оролцоог нь дэмжих;
6. Эхчүүдэд чиглэсэн үйлчилгээний чанарыг сайжруулж, холбогдох дүрэм журмыг нийгмийн өөрчлөлтөд нийцүүлэн сайжруулах;
7. Сонгуулийн ерөнхий хороо намуудын хөтөлбөрийг хүлээж авахдаа ЖЭТБХТХуулийн заалтыг тусгаж, уг хуулийн хэрэгжилтийг дэмжих үйл ажиллагаа төлөвлөсөн эсэхийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг

албажуулан хэрэглэх;

8. УИХ-ын болон орон нутгийн сонгуульд нэр дэвшүүлэх, суудал хадгалах, намын бүтэц зохион байгуулалтын бүхий л шатанд эмэгтэйчүүдийг дэмжих квот тогтоох, сонгуулийн санхүүжилт болон тогтолцоог жендэрийн хувьд тэгш шударга болгох. Тухайлбал УИХ-ын Сонгуулийн тухай хуульд улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор нэр дэвшигчдийн 20-иос доошгүй хувь нь эмэгтэй нэр дэвшигч байх хязгаарыг 40 хувь болгон өөрчлөх, улмаар хууль тогтоох дээд байгууллагад суудал хадгалах хувийн доод хязгаарыг хуульчлан тогтоох;
9. Засаг захиргааны анхан шатны нэгж дээр ажиллаж байгаа Хамтарсан багийн зардлыг улсын болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлэх;
10. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэхээр гарсан журмуудыг хуулийн үзэл баримтлал, агуулгын үүднээс дүн шинжилгээ хийх, хуулиас давсан хэм хэмжээ бий болгосон зохицуулалтыг хүчингүй болгох, давхардал, хийдлийг арилгах;
11. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлыг нэгдсэн удирдлагаар хангах, салбар дундын хамтын ажиллагааг уялдуулахдаа хохирогчдод шууд үйлчилгээ үзүүлдэг мэргэжилтнүүд, ТББ-ын оролцоог түлхүү хангах;
12. Хөдөлмөрийн тухай хуульд ажил мэргэжил, хөдөлмөрийн харилцаанд дарамтыг хориглох, түүний дотор ажлын байран дахь бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх тэмцэх талаар заалтууд оруулах.







**3**  
БҮЛЭГ

## БАЙГАЛЬ ОРЧИН БА ЖЕНДЭР

## БАЙГАЛЬ ОРЧИН БА ЖЕНДЭР

Жендэрийн тэгш байдлын асуудлыг нийгэм, эдийн засгийн хүрээнд голлон ярьж байсан бол өнөөдөр тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын дагуу байгаль орчны хүрээнд зайлшгүй анхаарч үзэх асуудлын нэг болжээ. Монгол Улс Ногоон хөгжлийн бодлогоо (2014) Rio+20 болон дэлхийн эдийн засгийн хөгжлийн санаачлагуудтай уялдуулан тодорхойлж<sup>109</sup>, Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалдаа экологийн тэнцвэртэй байдлыг хадгалж, ногоон эдийн засгийн үзүүлэлтээр дэлхийн эхний 30 орны нэг болох өндөр зорилгод чиглэж байна. Засгийн газар болон түншлэгчдээс дээрх зорилгуудыг хангах хүчин чармайлт гаргасаар байгаа нь Монгол Улсад байгалийн баялгийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулсан хөрөнгийн хэмжээ 2005 оноос 2017 оны хооронд 11.15 дахин өссөнөөс харагдана.

Гэвч сүүлийн жилүүдэд дэлхийн уур амьсгалын өөрчлөлт болон хүний хүчин зүйлийн нөлөөгөөр байгаль орчны асуудал улам хурцадсаар хүн амын бүлгүүдэд харилцан адилгүй тусаж, айл өрхийн амьдралын хэв маяг, хөдөлмөр эрхлэлтийг өөрчлөн, орон нутаг, улс орны тогтвортой хөгжлийг хязгаарлах гол хүчин зүйл болоод байна.

### Шигтгээ 21.

#### Байгаль орчны доройтол ба уур амьсгалын өөрчлөлт

Монгол Улсын хурдацтай хөгжил, хатуу ширүүн цаг агаар, өвөрмөц газарзүй, байгалийн гамшигийн эрсдлийг бууруулах чиг хандлага нь уул уурхай болон нүүдлийн мал ахуйн эдийн засаг дахь давамгайлалтай хослоод байгаль орчны ноцтой сорилтыг үүсгэж, Монгол Улсын оролцоот, тогтвортой хөгжлийн хүчин чармайлтад ихээхэн ярвигтай байдлыг бий болгож байна. Эдгээр сорилтод 2010 оноос хойш улам ихээр мэдрэгдэж буй уур амьсгалын өөрчлөлт нэрмээс болж байна.

Эх үүсвэр: АХБ. Монгол Улсын хүртээмжтэй, тогтвортой өсөлтийн үнэлгээ. 2017

2013 онд БОНХЯ-ны тооцоолсноор Монгол Улсын газар нутгийн 80 хувь цөлжилтөнд өртөж, үлдсэн хэсэг нь эмзэг байна.<sup>110</sup> 2007 оноос 2017 оны хооронд нийт гол мөрний 16 хувь, булаг шандын 21.8 хувь, нуур тойрмын 28 хувь ширгэж үгүй болсон байна. 2010 оноос 2015 оны хооронд 9.9 хувь цөлжилтөд ямар нэг хэмжээгээр өртсөн газар нутгийн хэмжээнд ноцтой өөрчлөлт ороогүй харагдаж байгаа ч хүчтэй цөлжсөн газар 6.7 хувиас 17 хувь болтол өсчээ. Сүүлийн 10 жилд хур тунадас багасаж, +30°C-ээс давсан халуун өдрийн тоо эрс нэмэгдэж монгол оронд урьд өмнө буюу сүүлийн 75 жилд тохиолдож байгаагүй их хуурайшилт явагдсан. Агаар мандлын гаралтай аюултай болон гамшигт үзэгдлийн тоо ихсэж, 1990-2000 онд жилд дунджаар 30 орчим аюултай үзэгдэл ажиглагддаг байсан бол 2001-2016 онд даруй 2 дахин нэмэгджээ.<sup>111</sup> Ойн талбай 2000 оноос хойш жилд дунджаар 0.7 хувиар багасаж байгаа нь дэлхийн дунджаас (0.1 хувь) өндөр байна.<sup>112</sup>

2005-2018 онуудад уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг тооцох, түүнд дасан зохицох, даван туулах асуудалд бүх түвшинд илүүтэй анхаарч эхэлсний нэг илрэл нь 2011 онд баталсан уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр юм. Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөрт дулааралтын улмаас хүнсний бүтээгдэхүүний хадгалалтын горим алдагдах, хэт халуун өдрийн тоо нэмэгдсэнээр ходоод, гэдэсний болон суулгалт, зүрх судасны өвчлөл өсөх болон өвлийн улиралд ханиад томуу ихсэх хандлагатай байгааг онцолсон. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд иргэд олон нийтийн оролцоог дэмжих, шударга, ил тод байдлыг хангах, хүний эрх, жендэрийн тэгш байдлыг эрхэмлэх зарчмыг баримтлахаар заажээ.

Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030-д байгаль орчны тогтвортой хөгжлийг хангахад цэвэр технологийг дэмжих, хаягдал багатай тогтвортой үйлдвэрлэл, хэрэглээ, олон улсын стандартын түвшинд хийгдэх байгаль орчны нөхөн сэргээлтийг анхаарахын зэрэгцээ нутгийн иргэд, олон нийтийн оролцоо, байгалийн нөөц баялгийг хэмнэлттэй, үр ашигтай, зохистой ашиглалт, байгальд ээлтэй хандлага, зөв дадлыг гол зарчим болгон тодорхойлжээ.

2013 онд батлагдсан Байгаль орчны салбарын жендэрийн стратеги (2014-2030) нь эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн, нийгмийн бүлгүүдийн жендэрийн ялгаатай хэрэгцээг бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд эн тэнцүү харгалзан үзэж, тэднийг хөгжлийн хөдөлгөгч хүч хэмээсэн нь тогтвортой хөгжлийн дээрх зарчмуудыг хэрэгжүүлэх арга зам, байгаль орчны асуудлыг шийдэхэд чиглэсэн салбар дундын үйл ажиллагааны нэгэн гарцыг тодорхойлсоноороо ач холбогдолтой. Тус стратегийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд байгаль орчны асуудлыг жендэрийн өнцгөөс судлан шинжлэх, тоо мэдээлэл бүрдүүлэх, бодлого төлөвлөлтөд ашиглах, нөгөө талаас хот хөдөөгийн айл өрх, эмэгтэй эрэгтэйчүүдийн идэвхитэй оролцоог ялгаатай мэдлэг туршлага, нөөц боломжид нь түшиглэн дэмжин чиглүүлэх үйл ажиллагааг тодорхой төлөвлөсөн.

<sup>109</sup> УИХ. 2008. Монгол улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого.

<sup>110</sup> Zoljargal 2013 in PAGE. 2014. Mongolia's transition to a Green Economy. A stocktaking report. UNEP.

<sup>111</sup> Trankmann, B. 2016. "Steppes under Strain." Our Perspectives Articles. UNDP Mongolia.

<sup>112</sup> UNEP. PAGE. 2014. Mongolia's transition to a Green Economy: A stocktaking report. Ulaanbaatar.

Харамсалтай нь уг стратеги хэрэгжихгүй, байгаль орчны салбарт хүйсээр ангилсан мэдээлэл байхгүй, жендэрийн дүн шинжилгээ хийх, бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд ашиглах Засгийн газар болон иргэний нийгмийн байгууллагуудын чадавхи бүрдэхгүй байна. Ингэснээр уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг хот, хөдөөгийн байгаль орчинд гарч буй өөрчлөлтөөс харж байгаа хэдий ч, өрх гэр бүлийн харилцаа, амьдрал ахуй, эрэгтэй эмэгтэй хүмүүсийн гэр бүл, нийгэмд гүйцэтгэх үүрэг, үнэлэмжинд хэр нөлөөлж байгааг тооцох боломжгүй байна.

## А Хөдөөгийн байгаль орчны асуудал

Хөдөөгийн байгаль орчны асуудлыг жендэрийн өнцгөөс авч үзэх нь нэг талаас тэнд амьдарч, ажиллаж буй эмэгтэй эрэгтэй хүмүүст ялгаатай нөлөөлөх байдал, нөгөө талаас тэдний байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг хамгаалахад оролцож буй байдал болон хувь нэмэр оруулах боломжийг шинжилнэ гэсэн ойлголт юм. Өнөөдөр дүн шинжилгээ хийх хангалттай мэдээлэл бүрдээгүй байгаа ч малчдын асуудлыг гол жишээ болгон авч үзлээ. Учир нь монголын тал нутгийн байгалийн нөөцийн гол ашиглагч, хамгаалагч, экологийн тэнцвэрт байдлыг хадгалагч нь нүүдлийн мал аж ахуй эрхлэгч малчин эмэгтэй эрэгтэйчүүд билээ. 2017 оны байдлаар хөдөө аж ахуйн салбарын 84.9 хувийг нүүдлийн мал аж ахуй бүрдүүлж байгаа ба монголын нийт өрхийн 19.2 хувийг малчин эзэлж өрх байна.<sup>113</sup> Хөдөөгийн малчин гэр бүлд эрэгтэй, эмэгтэйчүүдийн үүрэг оролцоо хөдөлмөрийн уламжлалт хуваарьт тулгуурладаг ч ач холбогдол, үнэ цэнэ нь тэнцүү байж ирсэн нь монголчуудын жендэрийн харьцангуй тэгш, жам ёсны харилцаа, эмэгтэйчүүдийн эрх чөлөөт байдлын үндэс болдог. Малчин эмэгтэй эрэгтэйчүүд өдөр тутам хийж буй ажлаараа байгаль орчныг хамгаалахад оролцож байдаг. Тухайлбал малчин эмэгтэйчүүд гэр бүлийн гишүүдийн хоол ундыг бэлтгэх, гэр доторх болон ойр орчмын газар нутгаа хамгаалах, хүүхдүүдээ өсгөх, тэднийг малчин ахуйд болон аж амьдралын тулгуур болсон байгалиа хайрлан хамгаалах талаарх өвөг дээдсийн туршлагаа өвлүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Малчин эрэгтэйчүүд мал хариулах, худаг ус гаргах, хашаа хороо барих засах, байгаль орчны нөхцөл байдлыг үнэлэх, аж ахуйгаа хөтлөх зэрэг гэрээс гадуурх өрхийн ажлыг хийхээс гадна байгалийн нөөц ашиглах асуудалд илүү анхаарч нутгийн захиргаанаас явуулдаг хурал, цуглаанд оролцож, орон нутгийн хэмжээнд шийдвэр гаргахад илүү үүрэг гүйцэтгэдэг. Харин шийдвэр гаргахад эмэгтэйчүүдийн оролцоо хангалтгүй байна.

Малчин өрхүүдийн хувьд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр улам хатуу ширүүн болж буй ган, зуд зэрэг байгалийн гамшгаас гадна бэлчээрийн доройтол, усны хомсдол тулгамдсан асуудлын нэг болжээ. Бэлчээрийн талхдалт, хомсдолоос үүдэлтэй дотоодын шилжих хөдөлгөөн ихэсч, бүр цаашилбал малчдын дунд бэлчээр, газрын маргаан үүсч байна.

### Шигтгээ 22.

#### Уур амьсгалын өөрчлөлтийн гэрч Марушийн ярианаас



Миний нэр Наранхүүгийн Маруш. Энэ жил нас сүүдэр 67 хүрч байна. Миний уугуул болоод суугуул нутаг Ховд аймгийн Чандмань сумын Цагаан гол хэмээх энэ газар. Хэзээнээс нааш манай өвөг дээдэс энэ нутагт мал аж ахуй эрхлэн аж төрж ирсэн. Би эхээс төрсөн цагаасаа энэ нутагтаа малчин явсан. Сургууль соёлд яваагүй. Би 14 хүүхэд төрүүлсэн. Дөрвөн хүүхэд маань малчин болсон, бусад нь хот суурин газар бий.

Намайг залуу байхад манай нутаг их сайхан байсан. Ногоо цагаа элбэг дэлбэг, зунлага сайхан, өвөл, хавар, намар ч дэлгэр байдаг байлаа. Хар-Ус нуур сүүлийн дөрөв, таван жилийн дотор л огцом ширгэж байна. Гар худагнууд ч ширгэж байна. Энэ Хар-Ус нуурын үүгээр жаахан жаахан цойрмог цөөрмүүд байсан юм. Тэр бүгд байхгүй. Энэ гэр барьчихсан байгаа газар чинь нэл ус байсан газар.

Ойрын дөрөв, таван жил их хүндрэлтэй байна. Энэ байгалийн нөхцөлд мал туранги. Ногоо гарахгүй болохоор бид чинь яг л энэ байгальдаа захирагдах юм даа. Энэ хэдэн мал зөвхөн голынхоо хөвөөгөөр ногоо хазаж байгаа болохоор даацаа дийлэхээ болихоос ч аргагүй. Энд бэлчээр байлаа гэхэд мал услах нөхцөл байхгүй. Ойр орчимд булаг шанд байдаггүй. Нуурын ус татаад шавар болчихсон. Малтай улсууд нуур луугаа шахаж нуурын арал дээр бууж байгаа нь усны эрхшээлд л орсон хэрэг шүү дээ.

Би ч нас дээр гарлаа. Харин энэ ард түмэн, үр хүүхэд минь хэдэн малтайгаа байх юм уу, байхгүй юм уу гэдэг дээрээ тулчихаад байхад төр засгаас их л зөв арга хэмжээ авах хэрэгтэй байна даа. Ус чийгийг яаж нэмэгдүүлдэг юм, яаж энэ хуурайшилтыг зогсоодог юм бүү мэд. Харин хоорондоо эе эвээ ололцож энэ хүнд байдлаас гарахад манай гадна дотны төсөл хөтөлбөрийн олон ажил хийгдэж байдаг юм. Жишээ нь манай Цагаан голд “Жаргалант оргил” гэдэг байгаль хамгаалах нөхөрлөл бий. Тэд малынхаа тооны араас хөөх биш харин малынхаа үс ноосоор сайхан бүтээлүүд хийж байгаа.

Эх үүсвэр: ДБХС (WWF) Уур амьсгалын гэрч, 2012

2017 оны байдлаар 66.2 сая толгой мал бүхий 169.7 мянган малчин өрх бэлчээр ашиглаж байна. Нэг га талбайд ногдох малын тоо 2005 оноос өмнө 100-400 хонин толгой байсан бол 2015 он гэхэд энэ үзүүлэлт 400-500 хонин толгой болж өсчээ. Бэлчээрийн даац хэтрэхэд нөлөөлж байгаа олон тооны мал эзэмших сонирхолтой бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаа малчин өрхүүдийн аж амьдралд, түүний дотор эмэгтэй эрэгтэйчүүдийн ажил амьдралын дүр зурагт хэрхэн нөлөөлж байгааг ч судлах шаардлага гарч байна. Малын тоо толгой өссөнөөр малчдын амьжиргаа сайжирч байгаа хэдий ч нөгөө талаас бэлчээрийн даац ихэссэн нь бэлчээрийн талхлагдлыг илүүтэйгээр үүсгэжээ. Бэлчээрийн ургац муудахын зэрэгцээ ургацын бүтцэд өөрчлөлт орж, хадлангийн хэмжээ буурсан, зуны улиралд хэт халуун болж мал бэлчих цаг багасаж байгаа нь цаашдаа малын бие давжаарах, ашиг шим муудах нөхцлийг бүрдүүлж байна.<sup>114</sup>

Мал сүргийн бүтэц ч үүнд чухал нөлөөтэй. Дөрвөн бог мал тутмын гурав нь хонь, нэг нь ямаа гэсэн харьцаатай өсгөн үржүүлж ирсэн олон жилийн уламжлал сүүлийн 10 жилийн дунджаар авч үзэхэд 2 хонь, 2 ямаа гэсэн харьцаатай болж өөрчлөгдсөн байгааг ноолуур малчдын орлогын гол эх үүсвэр болж байгаагаар тайлбарлаж болох ч энэ нь байгаль орчиндоо хамгийн хор хөнөөлтэй, богино хугацааны ашиг хөөсөн хандлага юм. Мөн нутаг усаа хамгаалж хайрлах, үр хойчдоо байгаа чигээр нь өвлүүлэх уламжлалт сэтгэлгээ, малынхаа ашиг шимийг бүрэн ашиглан өрхийн хэрэгцээгээ хангаж хог хаягдал бараг гаргахгүй байгаль орчиндоо ээлтэй амьдардаг нүүдлийн соёлын давуу чанар алдагдаж эхэлж байгаа харамсалтай дүр зураг ажиглагдаж байна. Ямааны ноолуураас олж байгаа ашиг малчдын нутагтаа ажиллаж амьдрах орчин нөхцлийг сайжруулах, дор хаяж ариун цэврийн шаардлага хангасан жорлон, худаг, халуун устай болох, мал аж ахуйн түүхий эдээр хийсэн бүтээгдэхүүнийг хөгжүүлэхэд бус, хувийн голцуу дээд сургуульд орлого оруулж хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцээгүй мэргэжлээр хүүхдүүдээ сургах, ирээдүйд нутгаа орхин хот руу шилжин суурьшихад зарцуулагдаж байна.

### Шигтгээ 23.

#### Малчин өрхүүдийн ноолуураас олох орлогын зарцуулалт

Ноолуурынхаа мөнгөөр 2 машин авлаа. 4 хүүхдээ дээд боловсролтой болголоо. Бас хүүхдүүдээ хот оруулж амьдруулах гээд ноолуурынхаа мөнгөөр байр авсан. Хүүхдүүдээ хотод төвхнүүлчихвэл алсдаа өөрсдөө араас нь очиж сууна гэж боддог. Энэ жил ноолуурын үнэ овоо өсөх сурагтай байна.

Эх үүсвэр: Төв аймгийн малчин эрэгтэйн ярилцлагаас

Ийнхүү “хэрэглээний сэтгэхүй” дэлгэрэхэд малчин өрхийн эмэгтэй эрэгтэйчүүд өөр өөрсдийн жендэрийн үүргээ гүйцэтгэх байдлаараа дамжуулан хувь нэмэр оруулж байна. Тухайлбал өрхийн өдөр тутмын хэрэглээний сонголтыг эмэгтэйчүүд голчлон хийдэг бөгөөд дэд бүтэц хөгжиж худалдаа арилжаа орон нутгийн гүнд хүрснээс малчин эмэгтэйчүүд урьдынх шиг өрхийн хэрэгцээний бүтээгдэхүүнийг өөрсдөө үйлдвэрлэхийг эрмэлзэхээ больж бэлэн бүтээгдэхүүн худалдан авч хэрэглэх нь ихсэж байна. Жишээлбэл боов боорцог, тасалсан гурил, лаазалсан нөөшилсэн хүнсний зүйлийг малчид худалдан авч хэрэглэх нь ихэсч байна. Гутал хувцас ч мөн адил гадаадад дахин боловсруулах аргаар үйлдвэрлэсэн, татвар төлөөгүй учраас хямд барааг авч хэрэглэж байгаа нь юуны өмнө хог хаягдал их гарч байгаль орчныг бохирдуулах нөлөөтэй.

### Шигтгээ 24.

#### Малчин залуусын боловсролын ялгаатай хэрэгцээ

Малаа сааж, сүү цагаан идээгээ боловсруулах нь багасаж байгаад сэтгэл түгшдэг. Нутаг нутгийн брэнд гаргах боломж цагаан идээнд л бий. Гэтэл сүү цагаан идээ боловсруулахыг залуус сурахгүй байна. Хөвгүүдэд чөдөр ногт зангидах, охидод ааруул эззгий хийх технологийг зааж сургах газар алга. Малын тоо өссөөр атал сүү цагаан идээний боловсруулалт буурч байна. Дунд сургуульд охидод үүнийг заах, МСҮТ-д тусгай анги бий болгох хэрэгтэй байна.

Эх үүсвэр: Дорноговь аймгийн удирдах ажилтан эрэгтэйн ярилцлагаас

Залуу малчин эрэгтэйчүүд нийгмийн өөрчлөлтөд дасан зохицох чадвар бага, уламжлалт соёл гэхээс илүүтэй бизнесийн сэдлээр морь уях, уралдуулахад цаг их зарж, горьг нь өвөл хавар амсдаг болсон талаар Дорноговь аймагт хийсэн хэлэлцүүлэгт оролцогчид ярилаа. Мөн зарим малчин эрэгтэйчүүд боловсролын хоцрогдлоос шалтгаалан уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдээллийг аж амьдралаа урт хугацаанд төлөвлөхөд ашиглаж чадахгүй байгааг Хэнтий, Булган аймагт хийсэн “Гамшгийн эрсдлийн жендэрийн дүн шинжилгээ”-нд<sup>115</sup> дурьдсан байдаг. Мөн үнэлгээгээр сумын хөгжлийн бодлого төлөвлөлтөд ч энэ асуудал зохистой тусгагдахгүй байгаагаас орон нутгийн малчид амьдрал, аж ахуйгаа зөв, харилцан уялдаатай төлөвлөн хөгжүүлэх талаар бодохгүй, “байгаа дээр нь ашиглаад, болохгүй бол нүүгээд явчихна” гэх хандлагатай байгааг онцолсон байна.



Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үйл явцыг оршин суугчдын бүлэгт суурилсан хэлбэрээр өрнүүлэх, үүний тулд орон нутгийн хүмүүсийн оролцоогоор дамжуулан нийгмийн сүлжээ, хамтын ажиллагааг дэмжих жендэрийн мэдрэмжтэй бодлого боловсруулж хэрэгжүүлэхийг судлаачид зөвлөж байна.<sup>116</sup> Байгалийн тодорхой төрлийн баялгийг хариуцан хамгаалах, ашиглах, эзэмших иргэдийн нөхөрлөл байгуулах тухай 2010 онд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын баталсан журмын дагуу малчдын болон ойн нөхөрлөлүүд байгуулагдан орон нутаг, байгаль орчноо хамгаалахад гүйцэтгэх үүргээ орон нутгийнхан ойлгож, малаас өөр эх үүсвэрээс орлого олох боломжид суралцах сайн туршлагауд гарч байна. Эдгээр нөхөрлөлийн үйл ажиллагаанд малчин эмэгтэйчүүд идэвхтэй оролцож, малын бүтээгдэхүүнд нэмүү өртөг шингээхийн зэрэгцээ байгаль хамгаалах хамтын менежментэд суралцаж байгаа нь таатай мэдээ байна. Энэ сайн туршлага нь орон нутгийн иргэдийг эко аялал жуулчлалын чиглэлээр чадавхижуулахад хөрс суурь болж байна.

2018 оны 6-р сард Улаанбаатар хотод хуралдсан “Тогтвортой хөгжлийн зорилт: Жендэр ба хөгжил” олон улсын бага хурлаас гарсан “Улаанбаатарын тунхаглал” -ын хүрээнд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, эрсдлийг бууруулах, хөдөөгийн охид эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулахад чиглэсэн багц уриалга гаргасан (Хавсралт 1). Үүний дотор тал нутгийн экологийн тэнцвэрийг хадгалах, уур амьсгалын өөрчлөлтийн нүүдлийн уламжлалт амьдралын хэв маягт үзүүлж буй сөрөг нөлөөг бууруулах стратегийг малчдын, түүний дотор байгаль орчноо хамгаалах, байгалийн нөөцийг хадгалахад эмэгтэйчүүдийн гүйцэтгэж ирсэн түүхэн үүргийг харгалзан, жендэрийн мэдрэмжтэй байдлаар нэн даруй боловсруулан хэрэгжүүлэхээр уриалсан.

Эрхэлж буй ажил, амьдралын хэв маягаараа хөдөөгийн байгаль орчинд нөлөөлж буй өөр нэг бүлэг бол хувиараа ашигт малтмал олборлогчид байна. 2016 оны байдлаар 16 аймгийн 34 сумын нутаг 1637.71 га талбай бүхий 96 нэгжид бичил уурхайн олборлолт явагдаж байна. Швейцарийн хөгжлийн агентлагаас явуулсан судалгаагаар (2013) гар аргаар олборлогчдын 71 хувь нь эрэгтэйчүүд, 29 хувь нь эмэгтэйчүүд байжээ. Эхэн үедээ энэ ажлыг голцуу эрэгтэйчүүд нь хийдэг байсан бол оргил үедээ эмэгтэйчүүд, хүүхдүүд тэдний гэр бүл оролцох болж, хүчирхийлэл, хөдөлмөрийн мөлжлөг гарах талбар болсон байдаг. Бичил уурхайчдын сүйтгэсэн газар нутгийг нөхөн сэргээхэд төсвийн хөрөнгийг зарцуулж байгаа ч тэдний алт угаах шатандаа мөнгөн ус ашиглан хүнд металаар бохирдуулсан гол мөрөн, худгийн уснаас нутгийн эмэгтэй эрэгтэйчүүд, хүүхдүүд хэрэглэснээс гарах үр дагаврыг одоогоор төсөөлж тооцож ч чадахгүй байна. Засгийн газраас зохион байгуулалтад оруулах, тодорхой газрыг зөвшөөрлөөр олгож олборлолт эрхлүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлсэн ч үр дүнд хүрч чадаагүй байна. Бичил уурхай эрхлэгчид гэж үзээд байгаа “Нинжа” нарын үйл ажиллагаа цаашид хөдөөгийн байгаль орчин, хүмүүсийн амьдралд ямар үр нөлөө бий болохыг жендэрийн өнцгөөс судлан шинжилж дүгнэх шаардлагатай.

## Б Хотын амьдрах орчны асуудал

2005 оноос хойш хотын хүн ам нэг дахин өсөж, Монгол Улсын нийт хүн амын 46 хувь нь нийслэлд амьдарч байна. Хагас нүүдэлчин ахуйгаас суурин ахуйд шилжин амьдрахад эрэгтэй, эмэгтэй хүмүүст тулгарч буй сорилт бэрхшээл нь хотын амьдрах орчны асуудлын нэг хэсэг болж байна.

Хот төлөвлөлт, зохицуулалт муу байгаагаас хотжих үйл явц нь ихэвчлэн гэр хороолол тэлэх байдлаар явагдаж байна. Нийслэлийн гэр хорооллын эзлэх талбайн хэмжээ жилд дунджаар 5.7 мянган га-гаар нэмэгдэж байна. Гэр хорооллын оршин суугчид нийслэлийн хүн амын бараг тал хувийг эзэлж, 790 000 хүн ундны усны баталгаат хангамж, сайжруулсан ариун цэврийн байгууламжгүй нөхцөлд амьдарч байна. Тэдгээр өрхүүд өвлийн улиралд (10-р сараас 3-р сар буюу жилийн 6 сард) түүхий нүүрс түлж байгаа нь агаарын бохирдлын 80 хувийг үүсгэхэд нөлөөлж байна гэж үзэж байна. Хүхэрлэг хий (SO<sub>2</sub>) төдийгүй автомашины тоо нэмэгдсэнээс шалтгаалан азотын давхар исэл (NO<sub>2</sub>) улам бүр нэмэгдэж, хотод утаа, тоосжилт, агаарын бохирдол ноцтой асуудал болж, цаашид хөрсний бохирдол, усан хангамжийн асуудал хурцдах төлөвтэй байна. Хатуу хог хаягдлын хэмжээ улам нэмэгдсээр байгаа атал оршин суугчдад хог хаягдлаа ангилан хаях дадал эзэмшүүлэхэд чиглэсэн арга хэмжээ дутагдсаар байна. 1996-2000 онд Улаанбаатар хотын нэг иргэн жилд дунджаар 200 кг ахуйн хог хаягдал ноогдож байсан бол 2018 онд энэ тоо 360 кг болжээ. Монгол Улсад хот суурингийн хог хаягдлын 70 хувь, хөдөөгийн хог хаягдлын 40 орчим хувийг л цуглуулж,<sup>117</sup> үлдсэн хог хаягдал нь байгаль орчныг бохирдуулан үлдэж байна.

2007 оноос эхлэн нийслэлийн агаарын бохирдол “Агаарын чанарын стандарт”-аас давах үед төрөөс төсөв гаргаж, мөн олон улсын байгууллагууд (ДБ, ЖАЙКА, АХБ, КОЙКА, ГХАН)-ын санхүүгийн дэмжлэгтэйгээр зорилтот төслүүдийг хэрэгжүүлж эхэлсэн байдаг. Улмаар 2011 онд УИХ-аас Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хууль баталж олон улсын (Монголын мянганы сорилтын сан, ДБ, АХБ, ЖАЙКА зэрэг байгууллагуудаас ойролцоогоор 60 сая ам.долларын төсөл хэрэгжүүлсэн) дэмжлэг авах нөхцлийг бүрдүүлсэн. Гэвч өнөөг хүртэл хийгдсэн Засгийн газрын болон хөрөнгө оруулагчдын агаарын бохирдлыг бууруулах ажлын үр дүнг үндэсний

<sup>116</sup> Chandan Kumar et al. 2017. *Migration as adaptation strategy to cope with climate change: A study of farmers' migration in rural India*. International Journal of Climate Change Strategies and Management.

<sup>117</sup> НҮБ-ын ЕЗЭК. 2018. *Монгол улс. Байгаль орчны гүйцэтгэлийн тайлан*. Женев.

хэмжээнд нэгтгэн харуулах боломжгүй байсаар байна. 2013 он гэхэд агаарт ялгарч буй нүүрсхүчлийн давхар ислийн нэг хүнд ноогдох хэмжээ дээд цэгтээ буюу 13.5 тн хүрсэн нь хамгийн их хөрөнгө зарж, төсөл хөтөлбөр хэрэгжүүлж байсан үетэй таарч байгаа нь эдгээрийн үр нөлөөнд эргэлзэх сэтгэгдлийг иргэдэд төрүүлж эхэлсэн талаар иргэний нийгмийн байгууллагууд хөндөж, шүүмжлэлтэй хандах болсон.<sup>118</sup>

Өнөөдөр нийслэлийн орчны бохирдол аюултай түвшинд хүрч, Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага (ДЭМБ)-ын олон улсын стандартад заасан жилийн дундаж нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) зөвлөмж хэмжээнээс 7 дахин их, Монгол Улсын үндэсний стандартад заасан жилийн дундаж зөвшөөрөгдөх дээд түвшингээс буюу 25 µg/m3-ээс 3 дахин өндөр бохирдолд хотын хүн ам өртөж байна. Ялангуяа гэр хороололд өвлийн улиралд PM2.5 агууламж тогтоосон 24 цагт зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс даруй 100 дахин илүү байна.<sup>119</sup>

Сүүлийн 10 жилийн хугацаанд зөвхөн нийслэл төдийгүй 10 мянгаас дээш хүн амтай аймгийн төвд орчны бохирдол тулгамдсан асуудал болж, Засгийн газраас гамшгийн хэмжээнд хүрсэн талаар албан ёсоор зарлаагүй ч иргэдийн эрүүл мэндэд, тэр дундаа жирэмсэн эмэгтэй, бага насны хүүхдийн эрүүл мэнд аюулын түвшинд хүрснийг хүлээн зөвшөөрөөд байна. Өвлийн улиралд улам ноцтой болдог утааны улмаас 10,000 хүнд ногдох амьсгалын замын өвчлөл огцом нэмэгдэж 2.7 дахин өсч, уушгины үрэвсэл 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн хоёр дахь шалтгаан болж, ургийн эндэгдлийн өвөл, зуны улирлын хоорондох ялгаа 3.5 дахин зөрүүтэй байдалд хүрээд байна.

Сүүлийн жилүүдэд жирэмсэн эмэгтэйд болон ургийн жин, амьгүй дутуу төрөлтөд үзүүлж буй орчны бохирдлын нөлөөллийн талаар эрдэмтэн судлаачид анхаарал хандуулахыг сануулсаар байна. Амьгүй төрөлтийг судлахад жирэмсэн эмэгтэйчүүдийн ихэнх нь гэр хорооллын дүүргүүдийн харъяалалтай, дутуу төрөлтийн түвшин 1000 амьд төрөлтөд 15.5 байсан ба хаврын улиралд ихсэж байгаа нь ажиглагдсан байна.<sup>120</sup> Хүхрийн давхар ислийн агууламж тээлтийн эхний, дунд, сүүлийн сард 10 нэгжээр ихсэхэд ураг амьгүй болох эрсдлийг нэмэгдүүлдэг байхад нүүрсний дутуу исэл тээлтийн бүх хугацаанд нөлөөлснөөр эрсдлийг нэг дахин нэмэгдүүлж байна. Орчны бохирдлын урагт нөлөөлөх асуудлыг эн тэргүүнд анхааран судалж байгаа ч үр нөлөө нь үүгээр хязгаарлагдахгүй юм. Гэвч хүн амын бүлгүүдийн эрүүл мэндэд хэрхэн нөлөөлж байгааг нас, хүйсээр, газарзүйн байршлаар нарийвчлан харуулсан мэдээлэл байхгүй байна. 2014 оны байдлаар 0-5 хүртэлх насны хүүхдийн нийт нас баралтын шалтгааны 33 хувийг эзэлсэн амьсгалын замын халдвар нь PM2.5 нөлөөллийн агаарын бохирдлоос шалтгаалсан гэж үзсэн байна.<sup>121</sup>

Улаанбаатар хотын агаарын бохирдлын нөлөөгөөр хүний эрүүл мэндэд учирсан өвчлөлийг эмчлэхэд жилд 147 сая ам доллар зарцуулсан нь Улаанбаатар хотын ДНБ-ний 8.0 хувь, улсын ДНБ-ний 3.8 хувь юм. Түүнчлэн гэр хорооллын амьжиргааны түвшин багатай өрхүүдэд түлшний зардал дээрээс нь утаанаас үүдэлтэй өвчлөлийн эмчилгээний зардал нэмэлт хүндрэл үүсгэх болжээ.

### Байгаль орчны хүрээнд жендэрийн тэгш байдлыг хангахад чиглэсэн зөвлөмж

#### Урт хугацаанд:

1. Байгаль орчны асуудал, тэр дундаа жил ирэх тутам улам эмзэг болж буй хөдөөгийн байгаль орчны асуудалд орон нутгийн иргэдийн оролцоог бодитойгоор хангаж, үүрэг оролцоог нь дээшлүүлэх чиглэлээр бусад улс орнууд болон бүс нутаг, хөрш зэргэлдээ орнуудын сайн туршлагыг судлах, хамтран ажиллах;
2. Хот суурин газар, хөдөө орон нутгийн янз бүрийн амьдралын хэв маягтай өрхүүд, эмэгтэй эрэгтэй хүмүүсийн жендэрийн үүрэг, хэрэгцээнд тохируулан уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, гамшгаас сэргийлэх чиглэлээр мэдээлэл, зааварчилгааг боловсруулан түгээх чадавхи бүрдүүлэх;
3. Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, нөхөн сэргээлтийн үйл явцад нутгийн эрэгтэй, эмэгтэй хүмүүс, нийгмийн бүлгүүдийн оролцоо, эрх мэдлийг нэмэгдүүлэх;

#### Дунд хугацаанд:

1. Байгаль орчны салбарын жендэрийн стратегийн хэрэгжилтийг эрчимжүүлэхэд жендэрийн салбар зөвлөлөөс уриалга гарган салбар хоорондын баг байгуулан хамтын ажиллагааны төлөвлөгөө гарган ажиллах;

<sup>118</sup> Монголын тандан судлаачдын холбоо ТББ. 2018. Агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр 2011 оноос хойш хийгдсэн судалгаа, хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн эмхэтгэл. Улаанбаатар.

<sup>119</sup> Дэлхийн банк. 2011. Улаанбаатар хотын агаарын чанарын дүн шинжилгээ-Эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулахын тулд агаарын чанарыг сайжруулах нь судалгаа. Улаанбаатар.

<sup>120</sup> Д.Гантуяа. 2018. "Агаарын бохирдлын ургийн жин, амьгүй ба дутуу төрөлтөнд үзүүлж буй нөлөөлөл" судалгаа. АУШУҮИС-ийн НЭМС-ийн Эпидемиологи биостатистикийн тэнхим.

<sup>121</sup> ДЭМБ, НҮБ-ын түнш байгууллагуудын гаргасан улс орны статистик тоо, дэлхийн эрүүл мэндийн судалгаа (January 2015) <http://www.who.int/gho/countries/mng.pdf?ua=1>

2. Малчин, тариаланч өрхийн, орон нутгийн бүлгүүдийн хэрэгцээнд нийцсэн, түүхий эдэд нь түшиглэсэн, байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологи нэвтрүүлэх ажлыг жендэрийн мэдрэмжтэй болгох.

**Богино хугацаанд:**

1. Байгаль орчны салбарт хүйсээр ангилсан мэдээлэл бий болгон ашиглаж, жендэрийн шалгуур үзүүлэлтүүдийг байгаль орчны чиглэлийн үнэлгээнүүдэд нэвтрүүлэх;
2. Хот, суурин газар, тэр дундаа нийслэл хотын өвлийн улиралд үүсэх агаарын бохирдолоос жирэмсэн эмэгтэйчүүд, бага насны хүүхдүүдийг хамгаалах ажлыг жирэмсний хяналтын хөтөлбөр, бага насны асаргааны хөтөлбөрүүдэд тусгах;
3. Хотын соёлд суралцаж, агаарын бохирдолд хувь нэмрээ оруулахгүй байх, гудамж талбайд биеэ зөв авч явах талаарх мэдээллийг жендэрийн мэдрэмжтэй хүргэх талаар хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудыг сургаж, хамтран ажиллах;
4. Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах, хөрс, ус, ариун цэврийн байгууламжийг сайжруулах хүрээнд айл өрхүүдийн хэрэглээнд нэвтрүүлж буй шинэ технологийн ач тусыг өрхийн залуу, хөгшин эрэгтэй эмэгтэй хүмүүс, охид хөвгүүдэд тэгш хүргэхүйц нөлөөллийг ажлыг тусгайлан хийх заалтыг хөтөлбөр, төслүүдэд тусгах.





**4**  
БҮЛЭГ

**ЖЕНДЭРИЙН ТЭГЦ БАЙДЛЫГ  
ХАНГАХ ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦОО**

## ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦОО

Монгол Улс эмэгтэй эрэгтэй хүмүүст тэгш шударга хандах үзэл санааг 1924, 1940, 1960, 1992 онуудад баталсан 4 удаагийн Үндсэн хуулиндаа тусгаж, холбогдох олон улсын гэрээ, конвенцуудад нэгдэн орсон орон билээ. Жендэрийн тэгш байдлыг хангах эрх зүй, бодлогын орчин, түүнийг хэрэгжүүлэх тогтолцоог бүрдүүлэхэд Засгийн газар, түншлэгчдийн хамтын хүчин чармайлт гол үүрэг гүйцэтгэж ирсэн. Монгол Улс нь Жендэрийн тэгш байдлыг хангахад чиглэсэн бодлого болон тогтолцоонд хийсэн үнэлгээгээр 2005-2010 онд 3.5 оноо, 2018 онд 4 оноо авсан нь Зүүн Ази, Номхон далайн орнуудын дундаж (3.3)-аас дээгүүр байна (Зүүлт тайлбар 96).

### Шигтгээ 25.

#### Монгол Улсын Үндсэн хууль (1992) ба жендэрийн тэгш байдал

- *Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” (14 дүгээр зүйлийн 14.1),*
- *“Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно” (14 дүгээр зүйлийн 14.2),*
- *“Хүн бүр эрх зүйн этгээд байна” (14 дүгээр зүйлийн 14.2),*
- *“Улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. (16 дугаар зүйлийн 16.11),*
- *Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ, Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална” (16 дугаар зүйлийн 16.11).*

### А Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний тогтолцооны хөгжил, ололт амжилт ба сургамж

Монгол Улсын Засгийн газраас 1996 онд шилжилтийн үед эмэгтэйчүүдэд тулгамдсан асуудлыг шийдэх зорилгоор баталсан “Эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах үндэсний хөтөлбөр-1996-2001” нь жендэрийн асуудлаар үндэсний түвшинд баримтлах бодлогын орчны эхлэл байлаа. Тус хөтөлбөр хэрэгжих хугацаанд үндэсний түвшинд өрнөсөн хэлэлцүүлгүүдээс “Жендэр ба Хөгжил” хандлагыг бодлогын түвшинд баримтлан охид, хөвгүүд, эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн асуудлыг эн тэгш анхаарах хэрэгцээ урган гарсан билээ. Тиймээс 2002 онд Монгол Улсын жендэрийн асуудлын онцлогийг тусгасан “Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг (2002-2015) боловсруулахад Жендэр ба хөгжил хандлагыг голлон баримталсан.

Монгол Улсын Ерөнхий сайдын удирдлага дор 2005 онд Жендэрийн тэгш байдлын үндэсний хороог байгуулан ажиллуулж эхэлснээр жендэрийн эрх, тэгш байдлыг хангах үндэсний тогтолцоо бүрэлдэн тогтох үйл явц өрнөсөн. Тус хорооны дүрмийн дагуу 2006 оноос төрийн захиргааны төв байгууллагуудад салбар зөвлөл, орон нутгуудад салбар хороод үүсгэн байгуулагдаж, жендэрийн асуудлыг хариуцсан орон тооны бус ажилтнууд яамдад ажиллаж эхэлсэн. Улмаар 2013 он гэхэд яамд төдийгүй нийслэл, аймагт жендэрийн мэргэжилтэн томилон ажиллуулсан нь ЖҮХ-ны хувьд салбар, орон нутгуудад үйл ажиллагаагаа хүргэх гол хүний нөөц болжээ.

2011 онд ЖҮХ, жендэр, эмэгтэйчүүдийн асуудлаар ажилладаг ТББ-ууд, олон улсын хөгжлийн байгууллагуудын хамтын хүчин чармайлтаар Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай бие даасан хууль батлагдсанаар Монгол Улсад жендэрийн тэгш байдлыг хангах эрх зүйн орчин бий болж жендэрийн асуудлаар баримтлах үндсэн зарчим тодорхойлогдон үндэсний тогтолцоо баталгаажсан билээ. Уг хууль нь жендэрийн тэгш байдлыг хангах төрийн байгууллагуудын гүйцэтгэх чиг үүргийг нарийвчлан зааж өгснөөрөө ач холбогдолтой. 2011 оны Засгийн газрын 323-р тогтоолоор Жендэрийн үндэсний хороог шинэчлэн байгуулж, хорооны дүрэм, бүрэлдэхүүн, ажлын албаны орон тоог баталсан.

**Шигтгээ 26.****Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, 2011**

Тус хууль нь Үндсэн хууль (1992)-ийн эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрхийг хангах заалтуудыг баталгаажуулж, жендэрийн тэгш байдлыг хангах үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, хуулийг хэрэгжүүлэгч байгууллагуудын эрх үүрэг, хүлээлгэх хариуцлагыг эрх зүйн хүрээнд тодорхойлсон. Тус хууль нь 6 бүлэг, 27 зүйлтэй. “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндсэн зарчим, бодлого”-ын талаарх дараах зүйл нь бүх хүрээ, түвшин бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг нэвтрүүлэх, үндэсний болон салбар, орон нутгийн жендэрийн бодлого төлөвлөлт хийх, хэрэгжүүлэхэд чухал үүрэгтэй.

**5.1. Жендэрийн эрх тэгш байдал дараахь үндсэн зарчимд тулгуурлана:**

5.1.1. жендэрийн тэгш эрхийн зарчим: эрэгтэй, эмэгтэй хүн бүр улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, гэр бүлийн ба бусад харилцаанд тэгш эрхтэй байх, нийгмийн амьдралд адил оролцох, хөгжлийн үр шим, нийгмийн баялгаас тэнцүү ашиг хүртэх боломж, нөхцөлийг хангах;

5.1.2. ялгаварлан гадуурхахгүй байх зарчим: эрэгтэй, эмэгтэй хүн бүр нас, хүйс, ажил, албан тушаал, үзэл бодол, гэрлэлтийн байдал, боловсролын ялгаа зэргийг үл харгалзан ялгаварлан гадуурхалт, хязгаарлалтгүйгээр хүний эрх, эрх чөлөөг эдлэх;

5.1.3. төрийн хариуцлагын зарчим: төр эрэгтэй, эмэгтэй хүний эрх тэгш байдлыг хангах талаар Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжоор ногдуулсан үүргээ биелүүлэх, түүний үр дүнгийн төлөө хариуцлага хүлээх;

5.1.4. жендэрийн мэдрэмжтэй бодлогын зарчим: хууль тогтоомж, төрийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, төсөлд жендэрийн үзэл баримтлалыг тусгах замаар хөгжлийн бодлогыг жендэрийн агуулгатай болгох;

5.1.5. жендэрийн мэдээлэл хүртээмжтэй байх зарчим: хүйсээр ангилсан албан ёсны статистикийн болон бусад мэдээллийн ил тод, нээлттэй, хүртээмжтэй байдлыг хангах.

5.2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах төрийн бодлого нь эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг хангах нөхцөлийг бүрдүүлэх, жендэрийн ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх, түүнийг арилгахад чиглэнэ.

ЖЭТБХТХуульд заасан жендэрийн эрх тэгш байдлын баталгаа нь өнөөдөр Гэр бүлийн, Хөдөлмөрийн, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, Боловсролын, Эрүүл мэндийн, Хүүхэд хамгааллын, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, Сонгуулийн тухай хуулиудад тусгагдан хэрэгжиж байна.

Үндэсний тогтолцоог бэхжүүлэх хүрээнд бүх нийтийн жендэрийн боловсролыг дээшлүүлэх, жендэрийн бодлогыг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилготой эрдэмтэн, судлаач, багш нараас бүрдсэн Жендэрийн консорциум 2012 онд байгуулагдсан. Тус консорциум нь ЖҮХАА-тай хамтран жил бүр жендэрийн асуудлаар эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулж, их дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт жендэрийн асуудлыг тусгуулах нөлөөллийн болон чадавх бэхжүүлэх ажлыг хийж гүйцэтгэж байна.

2014 онд жендэрийн асуудлаар ажиллаж мэргэшсэн бие даасан шинжээчид нэгдэн ЖҮХ-ны дэргэд ажиллаж Жендэрийн үндэсний шинжээчдийн бүлэг байгуулсан. Тус бүлэг нь Монгол Улсад жендэрийн эрх тэгш байдлыг хангахад гарч буй хүндрэл бэрхшээлийг судлан шинжлэх, жендэрийн аудит хийх, бодлогын зөвлөмж гаргах эрх бүхий, жендэрийн эрх тэгш байдал, хүний эрхийн асуудлаар мэргэшсэн шинжээчдээс бүрддэг. Одоогоор үндэсний 7 шинжээч ажиллаж байна.

ЖЭТБХТХуулийг хэрэгжүүлэх Засгийн газрын дунд хугацааны стратеги баримт бичгийг 2013 онд баталж, салбар хороо, зөвлөлүүдийн чадавхийг бэхжүүлэхэд голлон анхаарч иржээ. 2016 онд уг стратегийн хэрэгжилтэд гүйцэтгэлийн үнэлгээ хийсэн нь жендэрийн тэгш байдлыг хангахад чиглэсэн эрх зүй, бодлогын орчны хэрэгжилтэд хийсэн анхны үнэлгээ болсон байна. Засгийн газрын мониторинг үнэлгээний аргачлалд тулгуурлан хийсэн уг хөндлөнгийн үнэлгээгээр стратегийн хүрээнд төлөвлөсөн үйл ажиллагаа 60.1 хувийн амжилттай хэрэгжсэн хэмээн дүгнэсэн. ЖҮХАА-наас дээрх үнэлгээний үр дүнд суурилан Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр (2017-2021)-ийг боловсруулж Засгийн газрын 2017 оны 129 дүгээр тогтоолоор батлуулан хэрэгжүүлж байна. Уг Үндэсний хөтөлбөрийн хүрээнд жендэрийн статистик, дүн шинжилгээг хөгжүүлэн, жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг салбарын, орон нутгийн болон байгууллагын түвшинд нэвтрүүлэх, жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг бүх шатандаа эрчимжүүлэхийг зорьж байна.

Засгийн газрын 2015 оны 46 дугаар тогтоолоор Жендэрийн асуудлыг төрийн захиргааны төв байгууллагын эрхлэх асуудалд шилжүүлснээр Жендэрийн үндэсний хорооны ажлын алба ХНХЯ-ны Хүн амын хөгжлийн газрын харьяанд ажиллаж эхэлсэн. Уг өөрчлөлтийг иргэний нийгэм, олон улсын түншлэгчдийн зүгээс жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний тогтолцоонд гарсан ухралт гэж үзсэн юм. ХЭҮК-оос жендэрийн асуудлаар салбар дундын зохицуулалт хийх боломж бүрдүүлэхийн тулд ЖҮХАА-г бие даасан бүтэцтэйгээр дахин зохион байгуулж, үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулах нөхцөл бололцоог бүрэн дүүрэн хангахыг зөвлөсөн. Мөн ХЭҮК нь 2017 онд ЖЭТБХТХуулийг хэрэгжүүлэх талаар төрийн холбогдох байгууллагын үйл ажиллагааны төлөв байдалд үнэлгээ хийж, хуулиар үүрэг хүлээгч төрийн байгууллагуудын чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй, идэвх санаачлага дутмаг байна хэмээн дүгнэсэн байна.

Монгол Улс нь ЭЯГБХУТК-д нэгдэн орж, конвенцийн дагуу авсан арга хэмжээний талаарх улс орны илтгэлийг тогтвортойгоор тайлагнан, ээлжит 8, 9 –р илтгэлээ 2016 онд Конвенцийн хороогоор хэлэлцүүлсэн байна. Уг хорооноос эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхах явдлыг устгах, эрхийг нь баталгаажуулах явцыг түргэсгэх зорилгоор бодлогын орчныг сайжруулсан ЖЭТБХТ хуулийг баталсан хүчин чармайлтыг сайшаан үнэлжээ. Мөн жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний тогтолцоо, ЖҮХ-г бэхжүүлэх, ахиц дэвшлээ тогтмол үнэлэх хяналт шинжилгээ, үнэлгээний арга механизмыг бий болгох, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллахыг зөвлөсөн байна. Засгийн газраас тус зөвлөмжийн хэрэгжилтийг хангахын тулд ХНХ-ын дэд сайдаар ахлуулсан салбар дундын ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.

Монгол Улсын ерөнхий сайд, Жендэрийн үндэсний хорооны даргын санаачилгаар Засгийн газрын 2018 оны 111 ба 285 дугаар тогтоолоор ЖҮХ-ны ажлын албыг бие даасан байдлаар Монгол Улсын Ерөнхий сайдын дэргэд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын харьяанд ажиллуулахаар шийдвэрлэж, орон тоог нэмэгдүүлж, улсын төсөвт урсгал зардлыг тусгасан нь өмнөх ухралтыг залруулж, ЖЭТБХТ хууль, үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд таатай боломж бүрдүүллээ. Улмаар ЖҮХ-ны дүрмийг үндэслэн Жендэрийн үндэсний хорооны 2018 оны 02 дугаар тогтоолоор Хэвлэл мэдээллийн зөвлөл, 03 дугаар тогтоолоор Жендэрийн үндэсний шинжээчдийн бүлэг, 04 дүгээр тогтоолоор Эрдэмтэн судлаачдын бүлгийг (Жендэрийн консорциум) тус тус шинэчлэн байгуулсан. Өнөөдөр ЖҮХ нь төр, иргэний нийгмийн байгууллагуудын тэнцүү оролцоог хангасан орон тооны бус 26 гишүүнтэй, аймаг, нийслэл, нийслэлийн 9 дүүрэгт 31 салбар хороо, төрийн захиргааны төв байгууллага (яамд)-д 13 салбар зөвлөлтэй, бие даасан Ажлын албатай ажиллаж байна.

### Шигтгээ 27.

#### Сайн туршилага: Жендэрийн тэгш байдлыг дэмжсэн төсвийн хуваарилалт

ЖҮХ-ны Ажлын албаны үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж жендэрийн хууль батлагдахын өмнө 2010 онд 43.1 сая төгрөг, 2013 онд Засгийн газрын дунд хугацааны стратеги батлагдах үед 111 сая төгрөгийн төсвийг зөвхөн ажлын албаны үйл ажиллагаа (ажилтнуудын цалин, байрны түрээс, бичиг хэрэг, шуудан холбоо)-ны зардалд зориулан санхүүжүүлж байсан бол 2019 оны жилийн төсөвт хөтөлбөр хэрэгжүүлэх зардлын хамт 706.8 сая төгрөгийг баталсан байна.

Эх үүсвэр: ЖҮХАА-ны тайлан мэдээ

**Салбар, орон нутгийн жендэрийн бодлого төлөвлөлт:** Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд салбар, орон нутгийн жендэрийн бодлого төлөвлөлт сүүлийн жилүүдэд эрчимтэй хөгжиж байна. 2013 онд Байгаль орчины салбарын жендэрийн стратеги, 2015 онд Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамрагдах байгууллага, агентлагт хэрэгжих жендэрийн стратеги, 2016 онд Хууль сахиулах байгууллагуудад хэрэгжих жендэрийн стратеги батлагдсан. Эдгээр стратеги нь жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг салбарын үйл ажиллагаанд нэгтгэх эхний алхмууд болсон.

2017-2018 онуудад өмнөх туршлагадаа тулгуурлан нэгдсэн аргачлал, удирдамжийн дагуу 4 салбар жендэрийн бодлого боловсруулан баталжээ. Үүнд:

- Барилга, хот байгууллалтын салбарт баримтлах жендэрийн бодлого 2017-2024, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө,
- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарт жендэрийн талаар баримтлах бодлого 2017-2024, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө,
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт жендэрийн талаар баримтлах бодлого 2018-2025, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө,



- Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт жендэрийн талаар баримтлах бодлого 2018-2024, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө.


Эдгээр жендэрийн бодлого төлөвлөлт нь салбарын удирдлага, ажилтан албан хаагчдын оролцоонд тулгуурлан хийгдсэн бөгөөд бодлогыг боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах явцад салбар тус бүрээс 500 гаруй хүн оролцжээ. Эдгээр ажилтнууд салбарын жендэрийн бодлого боловсруулахад оролцсоноор жендэрийн тэгш байдлыг хангах талаар зөвшилцөлд хүрч, жендэрийн асуудлаар “хийнгээ суралцсан” байна.

Салбаруудын бодлого нь юуны өмнө ажилтан, албан хаагчдын жендэрийн мэдлэг туршлагыг дээшлүүлэх, тэдний ажлын орчин нөхцлийг жендэрийн мэдрэмжтэй болгоход чиглэж байна. Мөн салбар тус бүр бодлого төлөвлөлт, түүний хэрэгжилт, хяналт үнэлгээгээр дамжуулан жендэрийн тэгш байдлыг хангахад хувь нэмэр оруулах арга замыг тодорхойлж, цогц арга хэмжээг төлөвлөж чадсан юм. 2019 онд эрүүл мэнд, батлан хамгаалах, гадаад харилцаа, уул уурхайн салбарууд жендэрийн бодлоготой болохоор төлөвлөн ажиллаж байна.

Аймаг, нийслэл, дүүрэг нь жендэрийн тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр батлан хэрэгжүүлж байна. ЖҮХАА-наас 2018 онд орон нутгийн жендэрийн дэд хөтөлбөр боловсруулах нэгдсэн удирдамж гарган бүх салбар хороодод хүргүүлснээр 14 аймаг, 2 дүүрэг дэд хөтөлбөртэй болсон байна. 2019 онд нийслэлийн 7 дүүрэг, 7 аймаг жендэрийн дэд хөтөлбөртэй болох зорилт тавин ажиллаж байна. Жендэрийн бодлого төлөвлөлтийг хөхүүлэн дэмжих зорилгоор ЖҮХАА-аас жил бүр шилдэг салбар зөвлөл, хороодыг шалгаруулж байна. Тухайлбал 2017 онд Барилга хот байгуулалтын яамны жендэрийн салбар зөвлөл, Дорноговь аймгийн жендэрийн салбар хороо, 2018 онд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны жендэрийн салбар зөвлөл, Баянхонгор, Дорнод аймгийн жендэрийн салбар зөвлөл шалгарсан байна.

### Шигтгээ 28.

#### Сайн туршлага: Орон нутгийн жендэрийн бодлого төлөвлөлт дэх ИНБ-ын оролцоо



жендэрийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтэнд мониторинг хийх чадавхи сайжирч, бусад аймаг, нийслэл, дүүрэгт сайн жишээ болж байна.

Засгийн газрын дунд хугацааны стратеги төлөвлөгөө (2013)-ний хэрэгжилтэд хийсэн үнэлгээгээр ЖЭТБХТ хуулийг хэрэгжүүлэхэд салбар, орон нутаг ИНБ-уудтай хамтран ажиллаагүй, жендэрийн бодлогын хэрэгжилтэнд мониторинг хийлгээгүй нь харагдсан юм. Тиймээс орон нутгийн жендэрийн дэд хөтөлбөрүүдийг боловсруулахад шаардагдах нөхцөл байдлын үнэлгээг тухайн орон нутгийн ИНБ-аар гүйцэтгүүлэх удирдамжийг ЖҮХАА-аас өгсөн билээ. Энэхүү удирдамжийг Дорноговь, Сэлэнгэ аймгийн ИНБ-ууд туршин хэрэгжүүлж, жендэрийн нөхцөл байдлын үнэлгээг хийснээр орон нутагтаа жендэрийн чиглэлээр ажиллах, түүний дотор



**Жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн:** 2014 онд Салбар, аймгууд жендэрийн бодлого төлөвлөлтөө боловсруулан хэрэгжүүлж эхэлснээр жендэрийн мэргэжилтний үүрэг хариуцлага, ажлын ачаалал, цар хүрээ эрс нэмэгдсэн боловч тэдний өмнө багагүй сорилт бэрхшээл тулгамдаж байна. Тухайлбал жендэрийн мэргэжилтний үүрэг нь тодорхой бус, албажаагүй, жендэрийн асуудлаар мэргэших боломж хязгаарлагдмал байгааг АХБ-аас 2016 онд хийсэн “Монгол Улсын Засгийн газрын Жендэрийн үндэсний хорооны бүтцэд хийсэн институцийн дүн шинжилгээ”-ний тайланд онцолсон байна.

Дүн шинжилгээний хүрээнд салбар, орон нутгийн жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн дунд явуулсан асуулга судалгаанд жендэрийн 44 мэргэжилтэн оролцсон. Жендэрийн мэргэжилтнүүд уг асуудлыг дунджаар 3.8 жил хариуцан ажилласан бөгөөд дунджаар 40 настай, дийлэнх олонх нь (93.0 хувь) эмэгтэй байна. Тэд жендэрийн асуудлыг үндсэн ажлынхаа хажуугаар хавсран гүйцэтгэж, сард дунджаар ажлын 4 өдрийг зарцуулж байна. Тэдний дунд томилогдохоос өмнө жендэрийн асуудлаар системтэй мэдлэг мэдээлэл авсан хүн байхгүй, харин ажиллах явцдаа сургалт хэлэлцүүлэгт хамрагдаж мэдээлэл авдаг байна. Жендэрийн асуудлаарх мэдээлэл авах гол эх үүсвэр нь ЖҮХАА-наас зохион байгуулж буй сургалт хэлэлцүүлгүүд байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд салбарын жендэрийн бодлого, орон нутгийн жендэрийн дэд хөтөлбөр боловсруулахад үндэсний шинжээчидтэй хамтран ажилласан нь мэдлэг туршлагаа нэмэгдүүлэхэд чухал дэмжлэг болсон гэж үзжээ. ЖҮХАА-аас жендэрийн сургагч багшийг үе шаттай бэлтгэх бодлого баримталж, 2018 онд НҮБХАС, ШХА-ийн дэмжлэгтэйгээр сургагч багшид зориулсан жендэрийн сургалтын модуль боловсруулж, 21 аймаг, нийслэл, нийслэлийн 9 дүүргийн жендэрийн мэргэжилтнийг багшаар бэлтгээд байна.

Мэргэжилтнүүдийн 50 гаруй хувь нь сүүлийн 2 жилийн дотор шинээр томилогдсон байгаа нь тогтвортой ажиллаж чадахгүй байгааг харуулж байна. Удирдах албан тушаалтны зүгээс жендэрийн мэргэжилтэнийг албан ёсны тушаал шийдвэрээр томилоогүй амаар томилох байдал одоог хүртэл үргэлжилсээр байна. Өнөөгийн практикаас харахад жендэрийн мэргэжилтнүүд олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх болон тайлан бэлтгэх, тоо баримт цуглуулах чиглэлээр голлон ажиллаж, харин бодлого төлөвлөлт хийх, жендэрийн ялгаварлан гадуурхалтаас сэргийлэх, гомдол хүлээн авч шийдвэрлэх, үнэлгээ хийх чиглэлээр хангалттай ажиллахгүй байна. Цаашид энэ байдал хэвээр үргэлжилбэл салбар, орон нутгийн бодлого төлөвлөлтийн хэрэгжилтэд эрсдэл тулгарах, чадавч бүрдэхгүй нөхцөл байдал үүсч байна (Дүрслэл 31).

**Дүрслэл 31. Жендэрийн мэргэжилтний жендэрийн чиг үүргээ хэрэгжүүлж буй байдал**



Эх үүсвэр: Дүн шинжилгээний хүрээнд ЖМ-үүдээс авсан асуулга

Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний тогтолцооны үр ашгийг дээшлүүлэхийн тулд салбар орон нутаг, байгууллага нь жендэрийн асуудал хариуцсан орон тооны мэргэжилтэн ажиллуулах, мэргэжилтэн нь байгууллагынхаа бодлого төлөвлөлт хариуцсан нэгжид ажилладаг байх шаардлагатай гэж мэргэжилтнүүд санал болгосныг анхаарах хэрэгтэй байна.

## Шигтгээ 29.

Сайн туризлаг: “Тогтвортой хөгжлийн зорилт: Жендэр ба Хөгжил” олон улсын бага хурал ба “Улаанбаатарын тунхаглал”, 2018



Монгол Улсын Засгийн газар нь жендэрийн тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүд охидыг чадавхижуулах НҮБ-ын Ерөнхий ассамблейн 2015 оны “Эх дэлхийгээ шинэчилье: 2030 он хүртэлх ТХЗ-ууд болон түүний 5-р зорилтыг хангахад даяаршлаас үүдэлтэй эдийн засгийн харилцан хамаарал, улам хурдасч буй уур амьсгалын өөрчлөлтийн жендэрийн үр нөлөөг анхаарч тооцох, бодлого үйл ажиллагаандаа тусгах чиглэлээр улс орнуудад туризлагаа солилцох, хамран ажиллах боломжийг бүрдүүлэх зорилгын дор 2018 оны 6 дугаар сард “Тогтвортой хөгжлийн зорилт: Жендэр ба Хөгжил” олон улсын бага хурлыг санаачлан зохион байгуулж, бүс нутгийн төдийгүй олон улсын хэмжээнд илүү нээлттэй, үр ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэхүйц “Улаанбаатар тунхаглал”-ыг манлайлан ажиллахаа илэрхийлээд байна

## Б Хуулийн дагуу үүрэг хүлээгчид болон түншлэгчдийн оруулж буй хувь нэмэр, анхаарах асуудал

**УИХ, түүний дэргэдэх байгууллагууд:** УИХ нь үндэсний хэмжээнд жендэрийн эрх тэгш байдлыг хангахад гарч буй ололт, амжилт, Засгийн газраас хэрэгжүүлсэн ажлын үр дүнг сонсох замаар жендэрийн эрх тэгш байдлыг хангах, хууль эрх зүйн орчинг сайжруулах, санхүүжилтийн хувьд дэмжин ажиллах чухал субъект юм. Хуульд заасны дагуу хоёр жил тутамд Засгийн газраас жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнгийн тайланг хэлэлцэн, дүгнэлт гаргах бүрэн эрх нь байгаа ч өнөөг хүртэл нэг ч удаа тайлан илтгэлийг сонсоогүй байна.

УИХ-ын дэргэдэх **Хүний эрхийн үндэсний комисс** нь жендэрийн эрх тэгш байдал зөрчигдсөн, ажлын байрны бэлгийн дарамт (АББД) учруулсан, ялгаварлан гадуурхсан гомдлыг хүлээн авч, хянан шийдвэрлэх, **Төрийн албаны зөвлөл** нь төрийн албыг жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байлгах, **Үндэсний Статистикийн Хороо** нь хүйсээр ангилсан статистик мэдээллийг бүрдүүлэх, жендэрийн дүн шинжилгээ хийж, хэрэглэгч болон олон нийтэд хүргэх нөхцлийг бүрдүүлэх үүрэгтэй. Гэвч хуулиар баталгаажсан энэхүү хүчирхэг механизм нь ЖСХ-ийг бууруулахад хангалттай нөлөөлж чадахгүй байна.

ҮСХ нь 1990-ээд оноос эхлэн Цаг ашиглалтын судалгааг 5 жил тутам хийж ирсэн нь жендэрийн мэдээлэл судалгааг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулсан. ЖЭТБХТХуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх Монгол Улсын Засгийн газрын дунд хугацааны стратеги (2013-2016)-д бүх шатны бодлого төлөвлөлт, үйл ажиллагааг жендэрийн статистик, дүн шинжилгээнд тулгуурлан хийхээр заасан бөгөөд салбарын жендэрийн мэдээллийн санг бүрдүүлэхийг үүрэг болгосон. Үүний дагуу Үндэсний статистикийн хорооны даргын 2013 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн 1/104 тоот тушаалаар Монгол Улсын жендэрийн статистикийн суурь үзүүлэлтүүдийг баталсан ба хоёр жил тутамд 216 үзүүлэлт бүхий жендэрийн статистикийн эмхэтгэлийг “Жендэрийн мэдээлэл” нэрээр гаргах ажил эхлээд байна.

ЖҮХ, ҮСХ хамтран ЖЭТБХТХууль болон Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрт заасан хүйсээр ангилсан албан ёсны статистикийн болон бусад мэдээллийн ил тод, нээлттэй, хүртээмжтэй байдлыг хангах, жендэрийн мэдээллийн сан байгуулах, салбар, орон нутгийн хэмжээнд хүйсээр ангилсан статистикийн мэдээллийг бүрдүүлэх, бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд ашиглах аргачлал боловсруулах зорилгоор 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр харилцан ойлголцлын санамж бичиг байгуулан ажиллаж байна. Сүүлийн жилүүдэд ҮСХ-оос жендэрийн асуудлаар сэдэвчилсэн судалгаа шинжилгээг хийж байгаа нь сайшаалтай.

Гэвч нутгийн захиргааны байгууллагын түвшинд хүйсээр ангилсан мэдээллийн сан болон уг сангийн талаарх мэдлэг хангалтгүй, бодлого төлөвлөлтөд ашиглах чадавх бүрдээгүй байгаа нь ноцтой саад бэрхшээл болж байна.<sup>122</sup>

<sup>122</sup> ХЭҮК. 2017. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл. Улаанбаатар.

**Нутгийн өөрийн удирдлагын байгууллагууд:** Орон нутгийн хурлууд нь харъяа нутаг дэвсгэрийн хэмжээнд жендэрийн тэгш байдлыг хангах бодлогыг батлах, санхүүжүүлэх, түншлэл хамтын ажиллагааг дэмжин ажиллах бүрэн эрхийг хэрэгжүүлдэг. 2018 оны байдлаар зарим аймгууд жендэрийн тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийг АИТХ-аар батлан, санхүүжүүлэх эхлэл тавигдаж байна. ЖҮХАА-аас дэд хөтөлбөрийг боловсруулах удирдамж боловсруулан аймаг, нийслэл, дүүргүүдэд хүргүүлсэн нь үндэсний хөтөлбөрийг нэгдмэл бодлогоор дэмжсэн, орон нутгийн хэрэгцээнд нийцсэн байх боломжийг бүрдүүлжээ.

**Иргэний нийгмийн байгууллагууд, эмэгтэйчүүдийн хөдөлгөөн:** 1990-ээд оны дунд үеэс өрнөж эхэлсэн монголын эмэгтэйчүүдийн эрхийг хангахын төлөөх хөдөлгөөн нь жендэрийн асуудлыг монголын нийгэмд ил гаргаж, түүнийг төрийн бодлого болгоход чухал нөлөө үзүүлснийг энэхүү тайланд дурьдахгүй байхын аргагүй юм. Эмэгтэйчүүдийн байгууллагууд Монгол Улсад идэвхитэй үйл ажиллагаа явуулж буй 7000 гаруй иргэний нийгмийн байгууллагуудыг манлайлагчдын тоонд зүй ёсоор ордог. Тухайлбал: 1995 оноос эхлэн гэр бүлийн болон эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх, хохирогч хамгаалах үндэсний сүлжээг бүрдүүлэх чиглэлээр тууштай ажиллаж ирсэн Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болон Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг боловсруулах, батлуулахад нөлөөлөх ажлыг 1994 оноос эхлэн 10 гаруй жил тууштай хийсэн Монголын хуульч эмэгтэйчүүдийн холбоо, 2000 оноос жендэрт суурилсан хүчирхийлэл, хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, түүний хохирогчид тусламж үйлчилгээ үзүүлж буй Хүйсийн тэгш эрхийн төв, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, жендэрийн шударга ёсны төлөө тэдний дуу хоолойг нийгэмд хүргэж, Монгол Улсын нэгдэн орсон ЭЯГБХУТК-ийн хэрэгжилтээр сүүдрийн илтгэл бичиж, Засгийн газарт нөлөөлж буй МОНФЕМНЕТ (MONFEMNET) үндэсний сүлжээ, эмэгтэйчүүдийг чадавхжуулах, ажлын байрны бэлгийн дарамтын эсрэг сүлжээний үйл ажиллагааг дэмжин санхүүжүүлж буй Монголын эмэгтэйчүүдийн сан (MONES) зэрэг байгууллагууд өнөөг хүртэл идэвхтэй ажилласаар байна.

Монголын эмэгтэйчүүдийн хөдөлгөөн шинэ залуу эмэгтэйчүүдээр хүчээ сэлбэж, залуу эмэгтэйчүүд өнөөгийн нийгмийн тулгамдсан асуудлыг шийдэхэд хувь нэмрээ оруулж байгаагийн нэг илрэл нь Өөрчлөлтийн төлөөх эмэгтэйчүүд ТББ нь залуу эмэгтэйчүүдийн манлайлах ур чадварыг дэмжих, менторуудаас болон бие биенээсээ суралцах боломж олгосон хөтөлбөр хэрэгжүүлж байгаа явдал юм. Мөн “Гүнж” төв нь охидын төрөлт болон эхийн эндэгдлийн дийлэнх хувийг 18 нас хүрээгүй охид эзэлж, хөгжлийн бэрхшээлтэй, дотуур байранд амьдардаг, гэр оронгүй, асран хамгаалах хүнгүй охид бүхэлдээ бодлогын гадна үлдэж байгааг анхаарч, тэдэнд туслах хөдөлгөөн өрнүүлж иржээ.

Эмэгтэйчүүдийн ТББ-ууд нийгэмд орхигдсон болон бэлгийн цөөнх эмэгтэйчүүд ялгаварлан гадуурхагдаж, илүү эмзэг байгаа талаар сүүлийн жилүүдэд хөндөх болжээ. Түүнчлэн 2015 оноос жендэрийн асуудалд эрэгтэйчүүдийн оролцоо нэмэгдэж, эрэгтэйчүүдийн асуудлыг анхаарах, эмэгтэйчүүдийн хүчирхийллийн эсрэг тэдний оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр байгууллагууд байгуулагдан, тодорхой асуудлаар мэргэшин ажиллаж эхэлсэн байна. Сүүлийн жилүүдэд олон улсад жил бүр тэмдэглэн өнгөрүүлдэг “Цагаан туузтаны хөдөлгөөн”-ийг “Эрчүүд гэр бүлийн хөгжлийн нийгэмлэг” ТББ-аас манлайлан зохион байгуулж, жендэрт суурилсан хүчирхийллийг бууруулахад эрэгтэйчүүдийн оролцоо, хувь нэмрийг олон нийтэд сурталчлах, жендэрийн хэвшмэл ойлголтыг залруулах чиглэлээр ажиллаж байна.

Жендэрийн болон эмэгтэйчүүдийн асуудлаар хүчтэй нөлөө бүхий ТББ-ууд нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн хөдөлгөөн болж үндэсний төдийгүй бүс нутаг, олон улсын санаачлагуудад<sup>123</sup> нэгдэн идэвхитэй үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр байгууллагуудад орон нутагт хүрч ажиллах, орон нутгийн ИНБ-уудын үйл ажиллагааг идэвхжүүлэх, тэднийг чадавхжуулах асуудалд анхааран ажиллах хэрэгцээ нэмэгдэж байна. Эдгээр байгууллагууд нь салбар, орон нутгийн жендэрийн бодлого төлөвлөлтийг хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцохын тулд чадавхаа нэмэгдүүлж, түншлэлийн хүрээгээ өргөжүүлэх асуудал тулгамдаж байна. Засгийн газраас ЖЭТБХТ үндэсний Хөтөлбөрийн хэрэгжилтэд ТББ-аар мониторинг үнэлгээ хийлгэхээр төлөвлөсөн боловч өнөөг хүртэл үндэсний болон орон нутгийн түвшинд энэ ажил орхигдож байгааг анхаарах шаардлагатай.

**Түншлэгчид, хандивлагчдын дэмжлэг:** Жендэрийн асуудлаар Монгол Улсын Засгийн газартай хамтран ажиллаж буй олон улсын байгууллагуудын дэмжлэг туслалцаа, үйл ажиллагааг дараах хоёр хүрээнд багтаан хамруулж болно. Үүнд.

### 1. Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний тогтолцоог шууд дэмжсэн үйл ажиллагаа.

2005 оноос хойш жендэрийн талаарх олон нийтийн ойлголт, хэвшмэл ойлголт өөрчлөх, гэр бүлийн хүчирхийлэл, хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, жендэрийн тэгш байдлыг хангах эрх зүйн орчныг бүрдүүлэх, жендэрийн бодлогыг хэрэгжүүлэх үндэсний чадавхыг бэхжүүлэхэд НҮБ-ын Хүн амын сан, Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк, Германы хамтын ажиллагааны нийгэмлэг, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Олон улсын хөдөлмөрийн байгууллага гол түншлэгч байж иржээ.

## 2. Өөрийн байгууллага, төслийн үйл ажиллагааны хүрээнд эмэгтэйчүүдийн оролцоог дэмжсэн үйл ажиллагаа.

Монгол Улсад үйл ажиллагааг явуулж буй ихэнх донор байгууллагууд нь өөрийн байгууллагын үйл ажиллагааны хүрээнд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх төслүүдийг дэмжин хэрэгжүүлж ирсэн байна. Тухайлбал, Швейцарийн хөгжлийн агентлаг, Канад сан, Австралийн хөгжлийн агентлаг, Дэлхийн зөн, АНУ-ын Азийн сан, ЖАЙКА, НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд болон бусад хамтын ажиллагааны нийгэмлэг, олон улсын ТББ-ыг нэрлэж болно.

Гэвч өнгөрсөн жилүүдэд Монгол Улсын жендэрийн тэгш байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлэхэд олон улсын байгууллага, доноруудын оруулсан санхүүжилтийн дэмжлэгийг бүрэн дүүрэн, үр өгөөжтэй ашиглаж хараахан чадсангүй. Жендэрийн тэгш байдлыг хангахад чиглэсэн төсвийн санхүүжилттэй харьцуулахад хандивлагчдын зарцуулсан санхүүжилт харьцангуй илүү байсан ч жендэрийн тэгш байдлыг хангахад оруулсан тэдний хувь нэмэр, түүнд зарцуулсан санхүүжилтийн хэмжээний талаарх мэдээлэл тодорхой бус байсаар байна.

Энэ нь Засгийн газраас жендэрийн талаар баримталж буй бодлого, төлөвлөлтөө олон улсын байгууллага, донор улсуудад хангалттай сайн танилцуулан ойлгуулж чадаагүйтэй холбоотой байж болзошгүй. Үүнээс үүдэн жендэрийн асуудлаарх олон улсын байгууллагуудын хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр, үйл ажиллагаа давхардах, хэдхэн асуудал дээр төвлөрөх байдал ажиглагдаж байна. Тиймээс цаашид олон улсын байгууллага, доноруудын жендэрийн асуудлаар хэрэгжүүлэх үйл ажиллагаа, санхүүжилтийг өөрийн бодлого хөтөлбөртэй уялдуулах үүднээс ЖҮХ-оос жендэрийн бодлогын зорилт, үр дүнг хангахад чиглэсэн нэмэлт санхүүжилтийг бүрдүүлэх нэгдсэн стратегийг боловсруулан хэрэгжүүлэх боломж бий.

### Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний тогтолцоо, түншлэл хамтын ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөмж

#### Урт хугацаанд:

1. Хүний эрхийн үндэсний комисс жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх гомдолыг хүлээн авах, хянан шийдвэрлэх механизмыг бүрдүүлэх, олон нийтэд таниулан сурталчлах;
2. Төрийн албаны зөвлөл төрийн албан хаагчдын жендэрийн мэдлэг, ур чадвар, манлайллыг дээшлүүлэх чиглэлээрх сургалтын тогтолцоо, хөтөлбөрийг хөгжүүлэх, төрийн албан хаагчдын хүйсийн тэнцвэрт байдлын судалгааг төрийн байгууллагын хүний нөөцийн хөгжлийн болон жендэрийн бодлого төлөвлөлтөд ашиглах боломжийг бүрдүүлэх.

#### Дунд хугацаанд:

1. Монгол Улсын Их хурал Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хуулийн хэрэгжилтийн төлөв байдал, Засгийн газрын үйл ажиллагааны үр дүнгийн хэрэгжилт, төрийн албан дахь жендэрийн эрх тэгш байдлын талаарх тайлан, ЭЯГБХУТК-ийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын ээлжит тайланг 2 жил тутамд танилцуулахыг холбогдох байгууллагуудад үүрэг болгож, хэрэгжилтэд хяналт тавих, хууль тогтоомжийн тухай хуульд зааснаар аливаа хууль тогтоомжийн төслийг боловсруулахдаа жендэрийн үр нөлөөг үнэлэх аргачлалын хэрэглээг сайжруулахад дэмжлэг үзүүлэх;
2. Жендэрийн салбар зөвлөл, салбар хороодын салбар, орон нутгийн жендэрийн бодлого төлөвлөлтийг хэрэгжүүлэх хариуцлагыг сайжруулж, гишүүдийн ажил үүргийн хуваарийг нарийвчлан тодорхойлох. Эн тэргүүнд жендэрийн асуудал хариуцсан орон тооны мэргэжилтэн томилон ажиллуулах;
3. ЖҮХ-ны Ажлын албаны мэргэжилтнүүдийг жендэрийн дүн шинжилгээ хийх, бодлого төлөвлөлт, шалгуур үзүүлэлт боловсруулах, ашиглах чадавхийг нэмэгдүүлэх, энэ чиглэлээр орон тоог бий болгох;
4. Үндэсний статистикийн хороо жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр, салбарын бодлого, орон нутгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлж хэмжихэд ашиглах тоон болон чанарын статистик мэдээллээр хангах, жендэрийн статистик мэдээллийн ашиглалтыг сайжруулах чиглэлээр цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
5. Олон улсын байгууллага, донорууд жендэрийн асуудлаар хэрэгжүүлэх үйл ажиллагаа, санхүүжилтийг ЖҮХ-ны Ажлын алба, жендэрийн салбар зөвлөл, хороодын үйл ажиллагааны төлөвлөлттэй илүү сайн уялдуулах замаар үр өгөөжийг нь нэмэгдүүлэх.

**Богино хугацаанд:**

1. Жендэрийн үндэсний хорооны гишүүдийн жендэрийн тэгш байдлыг хангахад, түүний дотор салбаруудын жендэрийн бодлогын хэрэгжилтийг дэмжих, салбар хоорондын зохицуулалтыг сайжруулахад манлайлан ажиллах чиг үүрэг, хариуцлагыг тодорхой болгож, хариуцлагын тогтолцоог сайжруулах;
2. ТББ-ыг салбар, орон нутгийн жендэрийн бодлого төлөвлөлтийг хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцуулах, ТББ-аар мониторинг үнэлгээ хийлгэхэд шаардагдах эрх зүйн зохицуулалтыг хийж, чадавхийг бүрдүүлэх, түншлэлийн хүрээгээ өргөжүүлэхэд нь Засгийн газраас болон хандивлагчдаас санхүүгийн болон мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

**МОНГОЛ ХЭЛЭЭР:****Эрх зүйн баримт бичгүүд:**

- Монгол Улсын Үндсэн хууль, 1992
- Хөдөлмөрийн тухай хууль, 1999
- Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, 2012
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 2016
- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, 2011

**Бодлогын баримт бичгүүд:**

- Монгол Улсын Засгийн газар. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр (2017-2021)
- Монгол Улсын Засгийн газар. Хүн Худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр 2016-2020
- УИХ. 2008. Монгол улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого
- УИХ. 2016. Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030. 2.2 дахь заалт.

**Хэвлэгдсэн материал:**

- АХБ, БОНХЯ, 2014. Монгол улсын бэлчээрийн тогтвортой байдал, малчдын амьжиргаа ба уур амьсгалын өөрчлөлт. Улаанбаатар.
- Ахим Шмилэн, Нина-Вейман Сандиг. 2018. Хөдөлмөр эрхлэлтийн баталгаагүй байдлын дүр зураг: Монгол Улсын хөдөлмөрийн зах зээл дэх жендэрийн тэгш бус байдлын талаарх чанарын судалгаа. Вашингтон. Дэлхийн банк.
- Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх статистикийн хэлтэс. 2014. Баянхонгор аймгийн ажил эрхлэлт. Баянхонгор.
- Б.Оюун-Эрдэнэ. 2012. Монгол гэр бүлийн бүтэц хэв маяг, харилцааны онцлог, тулгамдаж буй асуудал. Улаанбаатар.
- Б.Цолмон, А.Долгион. 2014. Монгол улс дахь жендэрийн эрх тэгш байдал: (Нөхцөл байдлын товч үнэлгээ, Баримт бичгийн судалгаа) . ШХА, IRIM судалгааны хүрээлэн.
- Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг. 2013. Сургууль завсардсан хүүхэд. Улаанбаатар.
- БСШУСЯ. АХБ. Дээд боловсролын шинэчлэлийн төсөл. 2018. Сургалтын үйл ажиллагаа ба хөдөлмөрийн зах зээлийн судалгаа-гарын авлага. Улаанбаатар.
- БСШУСЯ. 2018. Дээд боловсролын хууль эрх зүй, бодлогын баримт бичиг дэх жендэрийн дүн шинжилгээ. Улаанбаатар.
- Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Дэлхийн зөн Монгол ОУБ, Нийгмийн бодлого, хөгжлийн судалгааны хүрээлэн. 2018. Монгол гэр бүлийн өнөөгийн нөхцөл байдал, тулгамдсан асуудлууд, үйлчилгээний хэрэгцээ. Улаанбаатар.
- Дэлхийн банк. 2011. Улаанбаатар хотын агаарын чанарын дүн шинжилгээ-Эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулахын тулд агаарын чанарыг сайжруулах нь" судалгаа. Улаанбаатар.
- ДЭМБ. 2013. Хүн амын дунд зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэгийн тархалт. Улаанбаатар.
- Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл. 2017. Монгол Улсын гэмт хэргийн цагаан ном-2016. Улаанбаатар.
- Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл. 2018. Монгол Улсын гэмт хэргийн цагаан ном-2017. Улаанбаатар.
- Монголын тандан судлаачдын холбоо ТББ. 2018. Агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр 2011 оноос хойш хийгдсэн судалгаа, хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн эмхэтгэл. Улаанбаатар.
- МУБИС. 2017. Сургуулийн дотуур байрны орчин нөхцөл, хүүхдийн хөгжил хамгааллын өнөөгийн байдал. Улаанбаатар.
- МУИС. ЭЗС-ийн Статистикийн тэнхим. 2010. Эрх, гэр бүлийн байдал: Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын үр дүнгээр бэлтгэсэн сэдэвчилсэн судалгаа. Улаанбаатар.
- МУХЭҮК. 2017. Жижиг дунд үйлдвэр дэх хөдөлмөрлөх эрхийн зарим асуудал: Худалдаа үйлчилгээ, ноос ноолуурын салбар. Улаанбаатар.

- МХАҮТ. 2017. Монголын бизнесийн орчны үнэлгээ. Улаанбаатар.
- Н.Чинчулуун. 2017. Ажлын байр дахь бэлгийн дарамт гэж юу вэ, хөдөлмөр эрхлэлт, боловсрол, соёлын талбарт хэрхэн урьдчилан сэргийлж таслан зогсоох вэ?. Улаанбаатар.
- НҮБ-ын ЕЭЗК. 2018. Монгол улс. Байгаль орчны гүйцэтгэлийн тайлан. Улаанбаатар.
- Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага. 2018. Монгол улс. Хүн амын дотоод шилжих хөдөлгөөний судалгаа. Улаанбаатар.
- Санхүүгийн зохицуулах хороо, Монгол Улсын Компанийн засаглалын үндэсний зөвлөл. 2015. Монгол улсын компанийн засаглалын үндэсний тайлан. Улаанбаатар.
- Т.Бүрэнжаргал. 2005. Гэр бүлийн социологи. Улаанбаатар.
- Увс аймгийн Засаг даргын дэргэдэх статистикийн хэлтэс. 2014. Увс аймгийн ажил эрхлэлтийн танилцуулга. Улаангом.
- Улсын бүртгэл статистикийн ерөнхий газар. 2016. Хөдөлмөрийн зах зээлийн үндсэн үзүүлэлтүүд. Улаанбаатар.
- ҮСХ. 2017. Аж ахуйн нэгж, байгууллагын тоо, бүтцийн өөрчлөлтийн дүн шинжилгээ. Улаанбаатар.
- ҮСХ. 2017. Боловсролын салбарын танилцуулга. Улаанбаатар.
- ҮСХ. 2018. Аж ахуйн нэгж байгууллагын ажиллагчдын дундаж цалин-2017. Улаанбаатар.
- ҮСХ. 2018. Ажиллах хүчний судалгаа- 2018 оны 4-р улирал. Улаанбаатар.
- ҮСХ. 2018. Ахмад настны нийгэм эдийн засгийн зарим үзүүлэлтийн судалгаа. Улаанбаатар.
- ҮСХ. 2018. Хөдөө аж ахуйн салбарын танилцуулга-2017. Улаанбаатар.
- ҮСХ. 2018. Эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэнд. Улаанбаатар.
- ҮСХ, НХХЯ, ОУХБ. 2010. Цалин хөлсний бүтцийн туршилтын судалгаа. Улаанбаатар.
- ҮСХ, НҮБХАС. 2018. Хүчирхийллийн нүцгэн үнэн - ЖСХ-ийн судалгаа. Улаанбаатар.
- ҮСХ, ОУХБ. 2012. Монголын хүүхдийн хөдөлмөрийн судалгааны тайлан. Улаанбаатар.
- Хүйсийн тэгш эрхийн төв, Швейцарийн хөгжлийн агентлаг. 2010. Монгол улс дахь ХХГХ-ийн зураглал. Улаанбаатар.
- Хүний хөгжил судалгаа сургалтын төв ТТБ. 2018. Монгол Улсын хөгжлийн санхүүжилтийн үнэлгээ: Тогтвортой хөгжлийн санхүүжилтийг төрөлжүүлэх нь. Улаанбаатар.
- ХЭҮК. 2014. Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 13 дахь илтгэл. Улаанбаатар.
- Эдийн засгийн судалгааны хүрээлэн, Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг. 2013. Боловсролын салбарын тойм судалгаа. Улаанбаатар.
- Эрүүл мэндийн хөгжлийн төв. 2018. Эрүүл мэндийн статистикийн мэдээлэл-2018 оны эхний 8 сарын байдлаар. Улаанбаатар.
- Эрүүл мэндийн хөгжлийн төв. 2017. Эрүүл мэндийн үзүүлэлт-2016. Улаанбаатар.
- Эрүүл мэндийн хөгжлийн төв. 2017. Эрүүл мэндийн үзүүлэлт-2016. Улаанбаатар.
- ЭМХТ. 2017. Эрүүл мэндийн үзүүлэлт -2016. Улаанбаатар.
- ЭМЯ, НҮБХАС. 2018. Монгол улс дахь гэр бүл төлөвлөлтийн чанарын судалгаа. Улаанбаатар.
- ЭМЯ, ЭМХГ, НҮБ-ын Хүүхдийн Сан. 2005. Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл судалгаа. Улаанбаатар.

**Хэвлэгдээгүй тайлан:**

- Д.Гантуяа. 2018. " Агаарын бохирдлын ургийн жин, амьгүй ба дутуу төрөлтөнд үзүүлж буй нөлөөлөл" судалгаа. АУШУҮИС-ийн НЭМС-ийн Эпидемиологи биостатистикийн тэнхим.
- Хөгжлийн замнал сан. 2018. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт жендэрийн талаар баримтлах бодлогын хүрээнд хийсэн Оролцоонд суурилсан жендэрийн үнэлгээний тайлангийн хураангуй.



**АНГЛИ ХЭЛЭЭР:****Бодлогын баримт бичгүүд:**

European Bank for Reconstruction and Development (EBRD). 2017. Strategy for Mongolia. EBRD. Ulaanbaatar.  
 MoH and WHO. 2017. Mongolia-WHO Cooperation Strategy 2017-2021. World Health Organization. Ulaanbaatar.

**Хэвлэгдсэн материал:**

ADB. 2014. Gender Toolkit for Micro, Small, and Medium-Sized Enterprise Finance and Development. Manila.  
 ADB. 2016. Technical Assistance on Gender-responsive Sector and Local Development Policies and Actions, financed by the Government of Japan. Manila  
 ADB. 2017. Rapid Assessment (qualitative research) of Gender-based Violence in Urban Ger Area Communities. Ulaanbaatar.  
 ADB. 2018. Working paper series No. 14. Translating Women's Voices into Action in Mongolia: Addressing Gender-Based Violence through Investments in Infrastructure. Ulaanbaatar.  
 ADB. 2018. Measuring asset ownership and entrepreneurship from a gender perspective. Methodology and Results of Pilot Surveys in Georgia, Mongolia, and the Philippines. Manila.  
 Alгаа, S. 2015. Country Profile. On Universal Access to Sexual and Reproductive Health: Mongolia. Ulaanbaatar: MONFEMNET.  
 Armstrong, S. and B. Tsogtbaatar. 2010. The dual nature of alcohol use and abuse in Mongolia: Reflections through policy. Asia Pacific Journal Public Health 22(3). Hong Kong.  
 Bock, F. 2015. Water Supply, Sanitation and Hygiene in Mongolia: An Institutional Analysis. Ulaanbaatar: Action Contre La Faim.  
 Bradley, O. 2017. Education in Mongolia. The Blog. The Borden Project, October.  
 Center for Insights in Survey Research. 2016. National Survey of Mongolian Public Opinion. Government of Canada  
 Chandan Kumar and others. 2017. Migration as adaptation strategy to cope with climate change: A study of farmers' migration in rural India. International Journal of Climate Change Strategies and Management. Emerald Publishing Limited.  
 Christian Gonzales, Sonali Jain-Chandra, kalpana Kochhar and Monique Newiak. 2015. Fair Play: More Equal Laws Boost Female Labor Force Participation. IMF Working Paper. February.  
 Davy, P. L., G. Gunchin and A. Markwitz. 2011. Air Particulate Matter Pollution in Ulaanbaatar, Mongolia: Determination of Composition, Source Contributions and Source Locations. Atmospheric Pollution Research, 2.  
 EAP Gender. 2018. The Gender Pension Gap in the Aging Societies of East Asia.  
 European Bank for Reconstruction and Development (EBRD). 2017. Strategy for Mongolia. EBRD.  
 Hepworth 2013 in UNESCO. 2015. Education For All 2000-2015: Achievements and Challenges. Paris, France: UNESCO.  
 ILO. 2014. Application of International Labour Standards 2014 (I). Report III (part 1A). Reports Convention 103rd Session App of International Standards 2014-103-1A. Geneva.  
 ILO. 2017. World Employment and Social Outlook: Trends for women 2017. Geneva: ILO.  
 International Labor Organization. ILOStat (accessed January 2018).  
 JICA. 2013. Country Gender Profile: Mongolia. Final Report. JICA and Intem Consulting.  
 Jonathan Woetzel. 2015. The Power of Parity: How Advancing Women's Equality can add \$12 Trillion to Global Growth. McKinsey & Company.  
 Makhene, M. 2010. Honey Pot in Africa's Missing Middle- Investing in SMEs. Skoll Foundation Archives, September 23.  
 Millenium challenge account Mongolia. 2014. Strengthening Women's Land Ownership in Mongolia: A Survey of Impacts on Women's Voice, Bargaining Power and Household Well-being. Ulaanbaatar.  
 MoH and UNFPA. 2018. Global Sustainable Development Agenda and the Mongolian Sustainable Development

- Vision 2030- Linkages with Sexual and Productive Health and Rights. Ulaanbaatar: UNFPA Mongolia. MoH and WHO. 2017. Mongolia-WHO Cooperation Strategy 2017-2021. World Health Organization
- Mongolia Women's Fund. 2017. "Securing State Investment for Prevention of Gender-Based Violence in Schools" project. Ulaanbaatar: Mongolia Women's Fund.
- Mongolkhatan, T. & S. Enkhtusvshin. 2015. Gender survey among TVET teachers and students in the western region of Mongolia. GFA Consulting Group, funded by the SDC. OECD. 2016. East Asia and the Pacific SIGI Regional Report. OECD.
- O'Keefe, P.B. and A. Chłoń-Domińczak. 2016. The "gender pension-gap" in the aging societies of East Asia : a policy note from the East Asia and Pacific umbrella facility for gender equality. Washington, D.C.: World Bank Group.
- OPIC. 2017. "OPIC, IFC, and XacBank. Supporting Women-owned Businesses in Mongolia. Opic Media. June.
- PAGE. 2014. Mongolia's transition to a Green Economy: A stocktaking report. UNEP.
- Rabia Ali and Pagma Genden. 2017. "Early childhood education in Mongolia – who is still excluded?". World Bank Blog.
- Romina Kazandjian, Lisa L Kolovich, Kalpana Kochhar, Monique Newiak. 2016. Gender Equality and Economic Diversification. IMF Working Paper 16/140. July.
- Sayed M. N. Uddin et. al. 2015a. Opportunities and Challenges for Greywater Treatment and Reuse in Mongolia: Lessons Learnt fro Piloted Systems. In ACF, Sustainable sanitation for vulnerable population in periurban areas of Ulaanbaatar, Mongolia. Compendium of 14 thematic papers.
- SDC. 2015. Gender analysis in pastoral livestock herding in Mongolia. Ulaanbaatar
- Singh, G. 2017. Urban Poverty In Ulaanbaatar: Understanding the Dimensions and Addressing the Challenges. Washington, D.C.: World Bank.
- Suren, U. 2014. Gender equality and decent work priority and capacity review of ILO constituents and gender and human rights organizations in Mongolia. ILO Consultant Report.
- Trankmann, B. 2016. "Steppes under Strain." Our Perspectives Articles. UNDP Mongolia.
- Tsengel, K. 2017. "Can helping men in Mongolia improve life for women?" Global Post. 20 December.
- UN Chronicle. 2015. Goal 11-Cities Will Play an Important Role in Achieving the SDGs. UN Chronicle Vol. LI No. 4. April
- UN-PAGE. 2016. Gender Mainstreaming in Green Development Policy of Mongolia.
- UN-REDD Programme. 2017. Analysis of Social Inclusion and Gender Dynamic for MLSP. 2017. The Law on Promotion of Gender Equality, National Program on Gender Equality and its Action Plan (2017-2021). Ulaanbaatar.
- UNFPA. 2016. Mongolian Parliament Approves Domestic Violence Law. Ulaanbaatar.
- UNICEF. 2009. Монголын хүүхэд эмэгтэйчүүдийн байдал. Улаанбаатар.
- US Department of State. 2018b. Trafficking in Persons Report 2018. Washington, D.C.: US Department of State Publication.
- World Bank. 2013. Mongolia: Improving public investment to meet the challenge of scaling up infrastructure. Poverty Reduction and Economic Management Sector Unit East Asia and Pacific Region
- World Bank. 2018. Perceptions of Precariousness: A Qualitative Study of Constraints Underlying Gender Disparities in Mongolia's Labor Market. Ulaanbaatar.
- World Bank. 2018. World Development Indicators. Washington D.C.
- World Economic Forum. 2017. Global Gender Gap Report 2017. Geneva.

#### Хэвлэгдээгүй материал:

- Alison Brody and S. Sharkuu. 2018. Mongolia Country Gender Profile. The European Union Economic Governance for Equitable Growth (EG4EG) Project Mongolia.

## ХАВСРАЛТ 1. УЛААНБААТАРЫН ТУНХАГЛАЛ

Жендэрийн тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийг чадавхжуулах асуудлаар 1995 онд Бээжин хотноо чуулсан Дэлхийн эмэгтэйчүүдийн 4-р бага хурлын тунхаглалыг НҮБ-ын гишүүн орнууд хүлээн зөвшөөрч, өөрийн орны бодлого, хөтөлбөртэй уялдуулан хэрэгжүүлснээр дэлхий дахинд эмэгтэйчүүдийн манлайлал дээшилж, охид, хөвгүүдийн боловсролд хамрагдалт нэмэгдэж, эх нялхсын эндэгдэл буурч, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох аян хүчтэй өрнөж, нийгэм, соёлын олон янз, ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, хамтран шийдэх орон зай, боломж нээгдсэн билээ.

Өнөөдөр дэлхий нийтээрээ жендэрийн тэгш байдлыг хангаж, эмэгтэйчүүд охидыг чадавхжуулах болон жендэрийн агуулга бүхий бусад бүх зорилгуудыг НҮБ-ын Ерөнхий ассамблейн 2015 оны “Эх дэлхийгээ шинэчилье: 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөр”-ийн хүрээнд (Зорилт 5) дэвшүүлэн тавиад байгаа нь Бээжингийн тунхаглал үргэлжлэн хэрэгжиж буйн илрэл юм. Тогтвортой хөгжлийн зорилтууд түүний дотор хүний халдашгүй эрх болон хөгжлийн үйл явцын салшгүй хэсэг болох жендэрийн тэгш байдлыг хангах, охид эмэгтэйчүүдийг чадавхжуулах 5-р зорилтыг хангахад даяаршлаас үүдэлтэй эдийн засгийн харилцан хамаарал, улам хурдасч буй уур амьсгалын өөрчлөлтийн жендэрийн үр нөлөөг анхаарч тооцох, бодлого, үйл ажиллагаандаа тусгах чиглэлээр улс орнууд туршлага солилцох, хамтран ажиллах шаардлага тулгарч байна.

Монгол Улсын Засгийн газар, Жендэрийн үндэсний хорооноос “Жендэр ба Хөгжил” хандлагын хүрээнд улс орнуудын туршлагыг солилцох боломж бүрдүүлэн, жендэрийн тэгш байдлыг хангах зорилтыг хэрэгжүүлэхэд олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилгоор “Тогтвортой хөгжлийн зорилго: Жендэр ба хөгжил” олон улсын бага хурлыг Азийн Хөгжлийн Банкны дэмжлэгтэйгээр 2018 оны 6-р сарын 27-28-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулж, чуулганд Монгол, Австрали, АНУ, БНСУ, Канад, Япон улсын 350 гаруй төлөөлөгчид оролцлоо.

**БАГА ХУРЛЫН ОРОЛЦОГЧИД БИД,** жендэрийн тэгш байдлыг хангах нь шударга, эрх тэгш, нээлттэй, нийгмийн оролцоог хангасан, хамгийн эмзэг бүлгийн хэрэгцээг харгалзсан дэлхий ертөнцийг бий болгох, хөгжлийн үйл явцад хэнийг ч орхигдуулахгүй байх гол арга зам бөгөөд Тогтвортой хөгжлийн амин чухал бүрэлдэхүүн хэсэг болохыг хамтаар хүлээн зөвшөөрч байна. Дэлхийн улс орнуудын жендэрийн тэгш байдлыг хангах бодлого, үйл ажиллагаанд Жендэр ба Хөгжил хандлагыг баримталж, эмэгтэй эрэгтэй хүмүүс, нийгмийн бүлгүүдийн ялгаатай хэрэгцээг судлан бодлого төлөвлөлтөд тусгах, төсөв хөрөнгө хуваарилах замаар тэдэнд хөгжлийн үйл явцад тэгш оролцох, үр ашгийг тэгш хүртэх боломж олгоход зорьж ирсэн бөгөөд цаашид ч тууштай ажиллах болно.

Бид өнгөрсөн хугацаанд жендэрийн тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийг чадавхжуулахад олсон ололт амжилт, сайн туршлагадаа тулгуурлан бүс нутгийн болон олон улсын хэмжээнд илүү нээлттэй, үр ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэхийн тулд **2030 он хүртэл** дараах үүргийг хүлээж байна.

**Зохистой хөдөлмөр эрхлэлт, хүртээмжтэй эдийн засгийн өсөлтийг, ялангуяа эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхжилтыг дэмжих жендэрийн түншлэл хамтын ажиллагааны хүрээнд:**

1. Олон улсын, бүс нутгийн, үндэсний түвшин дэх жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт, төсөвлөлт, хяналт үнэлгээ, жендэрийн тэгш байдлыг хангахад чиглэсэн салбар хоорондын зохицуулалт болон эдийн засгийн өсөлтийн үр шимийг хүртээмжтэй болгох чиглэлээр туршлага солилцох, ялангуяа өрх толгойлсон эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, шилжин ажиллагчид болон бусад ялгаварлан гадуурхалтад өртөж буй хүмүүст зохистой хөдөлмөр эрхлэлтийн сонголтыг бий болгох;
2. Эдийн засгийн болон үйлдвэрлэлийн бүх хүрээн дэх жендэрийн тэгш бус байдлыг илрүүлэх, цогц хандлагаар шийдвэрлэхэд чиглэсэн хамтарсан судалгаа шинжилгээг хөгжүүлэх;
3. Гэр бүлийн үүрэг хариуцлага бүхий ажиллагчдын хэрэгцээнд нийцсэн уян хатан ажлын нөхцөл, сонголт бүхий зохистой ажлын байрыг бий болгож, хөдөлмөр эрхлэлт дэх жендэрийн тэгш байдлыг дэмжих;
4. Ижил үнэ цэнэ бүхий ажилд эмэгтэй эрэгтэй хүмүүс адил тэгш цалин хөлс авах эрхийг хүлээн зөвшөөрөх;
5. Эмэгтэй, эрэгтэй ажиллагчдын ажлын байран дахь аюулгүй байдлыг хангах, жендэрийн ялгаварлан гадуурхалт, ажлын байран дахь бэлгийн дарамтыг үл тэвчих бодлого, механизмыг бий болгох;
6. Хөдөлмөр эрхлэх зорилгоор улс хооронд болон улс дотор өрнөж буй шилжих хөдөлгөөний жендэрийн сөрөг үр нөлөөг арилгах, шилжин ажиллагчдын хүний эрхийг хүндэтгэн хамгаалах;
7. Хөдөөгийн эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхжилт, дэлхий дахины нэмүү өртгийн сүлжээн дэх оролцоог олон улсын худалдааны жендэрийн мэдрэмжтэй бодлогоор дэмжих, үр дүнд мониторинг хийх чиглэлээр хамтран ажиллах;
8. Жендэрийн тэгш байдлыг хангахад чиглэсэн хөрөнгө оруулалт, санхүүжилтийг дэлхийн хэмжээнд өрнөж буй тогтвортой санхүүжилтийн нэг чухал зарчим болгож, эх үүсвэр, хүртээмжийг нэмэгдүүлэх;
9. Өрхийн үйлдвэрлэл, эмэгтэйчүүдийн бичил бизнес эрхлэх боломжийг нэмэгдүүлэх тэдний онцлог, хэрэгцээнд нийцсэн санхүү зээлийн тогтолцоог бүрдүүлэх;
10. Үндэстэн дамнасан компаниудын, ялангуяа барилга, дэд бүтэц, олборлох үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудын нийгмийн хариуцлагын хүрээнд жендэрийн тэгш байдлыг дэмжих, ядуурлыг бууруулах, эмэгтэйчүүдийг чадавхжуулахад чиглэсэн санаачлагуудыг дэмжих, санхүүжилтийг нэмэгдүүлэх.

**Амьдралын чанарт гарч буй өөрчлөлтийг хэмжих жендэрийн шалгуур үзүүлэлтүүдийг үндэсний болон олон улсын түвшинд нэвтрүүлэн ашиглах хүрээнд:**

1. Хувь хүмүүсийн, айл өрхүүдийн амьдралын чанарт гарч буй өөрчлөлтийг хэмжих жендэрийн шалгуур үзүүлэлтийг боловсруулан нэвтрүүлэх;
2. Улс орнуудын тогтвортой хөгжлийн зорилгын жендэрийн агуулга/үр нөлөөний талаар мэдээлэл өгөх, салбар, орон нутгийн түвшинд мониторинг хийхэд ашиглах жендэрийн тоон болон чанарын шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулан ашиглах талаар улс орнуудын Засгийн газар, статистикийн байгууллагууд хамтран ажиллах;
3. Олон улсын, бүсийн болон улс орнуудын түвшинд ашиглаж буй жендэрийн шалгуур үзүүлэлтүүд, статистик мэдээллийг Тогтвортой хөгжлийн зорилгын хүрээнд баяжуулах;
4. Амьдралын чанарыг тодорхойлогч барилга хот байгуулалт, зам тээвэр, эрчим хүч, уул уурхай, аж үйлдвэр, хөдөө аж ахуй зэрэг салбаруудад жендэрийн чиглэлээр хамтын ажиллагааг бүх түвшинд хөгжүүлэх;
5. Эмэгтэй ажиллагчдын бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндэд хохирол учруулахаас хамгаалсан бодлого, эрх зүйн орчинг боловсронгуй болгох.

**Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, эрсдлийг бууруулах, хөдөөгийн охид эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах хүрээнд:**

1. Хөдөөгийн охид эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах НҮБ-ын тогтоолыг хэрэгжүүлэх хамтын ажиллагааг улс орны Засгийн газар, ИНБ, орон нутгийн түвшинд хөхүүлэн дэмжих;
2. Эмэгтэйчүүд олноор ажиллаж буй албан бус салбар, хөдөө аж ахуйн салбарт зохистой хөдөлмөр эрхлэлт, ногоон ажлын байрыг дэмжин нэвтрүүлэх чиглэлээр хамтран ажиллах;
3. Ногоон ажлын байрны тоо, хамрах хүрээг нэмэгдүүлэх, эмэгтэй эрэгтэй хүмүүсийн ажлын орчин нөхцөл, бүтээмжийг сайжруулахад туслах техник технологийг дамжуулахад хамтран ажиллах;
4. Хөдөөгийн хөгжил дэх жендэрийн тулгамдсан асуудал, түүний дотор малчин, тариаланчдын залуу халааг бэлтгэх, хүйсийн тэнцвэрийг сайжруулах чиглэлээр туршлага солилцож хамтран ажиллах;
5. Эдийн засгийн эрх чөлөө, хүнсний аюулгүй байдал, эрчим хүчний хүртээмж, байгаль орчны тогтвортой байдал, хүний болон өмч хөрөнгийн халдашгүй байдал, эрхийн хэрэгжилтийг тэгш шударгаар хангах сорилт дэлхий дахинд тулгарч байгааг анхаарч, хот хөдөөгийн эмэгтэй эрэгтэй хүний эрүүл мэнд боловсрол болон бусад байдлаар ялгаатай хүмүүсийг эрх тэгш оролцуулах нийгмийн оролцоот, хүртээмжит хөгжлийн хандлагыг бүх түвшинд нэвтрүүлэх;
6. Тал нутгийн экологийн тэнцвэрийг хадгалах, уур амьсгалын өөрчлөлтийн нүүдлийн уламжлалт амьдралын хэв маягт үзүүлж буй сөрөг нөлөөг бууруулах стратегийг

малчдын, түүний дотор байгаль орчноо хамгаалах, байгалийн нөөцийг хадгалахад эмэгтэйчүүдийн гүйцэтгэж ирсэн түүхэн үүргийг харгалзан жендэрийн мэдрэмжтэй байдлаар нэн даруй боловсруулан хэрэгжүүлэх.

Дээрх чиглэлээр улс орнуудтай үр бүтээлтэй, хамтран ажиллахад саад болох жендэрийн хэвшмэл ойлголтыг арилгахад анхаарч, ялгаварлан гадуурхалт, хүчирхийллээс сэргийлэх талаарх олон нийтийн боловсролыг нэмэгдүүлэхэд хамтран ажиллах болно.

*ОЛОН УЛСЫН БАГА ХУРАЛД ОРОЛЦОГЧИД БИД, энэхүү тунхаглалыг хэрэгжүүлэхэд сэтгэл зүрх, оюун ухаанаа зориулан ажиллахаа илэрхийлж байна.*

**“ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО: ЖЕНДЭР БА ХӨГЖИЛ”  
ОЛОН УЛСЫН БАГА ХУРАЛД ОРОЛЦОГЧИД**

**Улаанбаатар хот  
2018 оны 6 дугаар сарын 28**

